

FATF



АРГАЧЛАЛ

**ФАТФ-ЫН ЗӨВЛӨМЖИЙН ТЕХНИКИЙН
ХЭРЭГЖИЛТИЙГ ҮНЭЛЭХ БОЛОН МӨНГӨ УГААХ,
ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ
ТОГТОЛЦООНЫ ҮР ДҮНТЭЙ БАЙДЛЫГ
ДҮГНЭХЭД АШИГЛАГДАНА.**

САНХҮҮГИЙН АРГА ХЭМЖЭЭ АВАХ БҮЛЭГ

ФАТФ нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсгийг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх дэлхий нийтийн санхүүгийн системийг хамгаалах бодлогыг боловсруулж, дэлгэрүүлэх үүрэг бүхий засгийн газар хоорондын, хараат бус бүлэг юм. ФАТФ-ын зөвлөмж нь дэлхий нийтийн мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стандарт гэж хүлээн зөвшөөрөгдсөн.

ФАТФ-тай холбоотой нэмэлт мэдээллийг доорх цахим хаягаас авна уу.

www.fatf-gafi.org

©2013 ФАТФ/ЭЗХАХБ. Зохиогчийн эрх хуулиар хамгаалагдсан.
Урьдчилсан бичгээр зөвшөөрөл аваагүй тохиолдолд энэ хэвлэлийг
хуулбарлах, орчуулахыг хориглоно.
Бүх болон хэсэгчилсэн хэвлэлтэй холбоотой зөвшөөрөл хүссэн өргөдлийг
ФАТФ-ын Нарийн бичгийн дарга нарын газарт хүлээн авна.
2 Рью Андре Паскал 75775 Парис хот Цедекс 16, Франц Улс
(Факс: +33 1 44 30 61 37, э- мэйл: contact@fatf-gafi.org)

Хавтасны зураг: ©Thinkstock
Орчуулгыг: Санхүүгийн мэдээллийн алба. 2015.09.21

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ	4
ОРШИЛ.....	5
ЗӨВЛӨМЖИЙН ТЕХНИКИЙН ХЭРЭГЖИЛТ.....	11
ҮР ДҮНТЭЙ БАЙДАЛ.....	13
ТЕХНИКИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ	20
ҮР ДҮНТЭЙ БАЙДЛЫН ҮНЭЛЭХ	85
ХАВСРАЛТ 1: УЛС ҮНДЭСТНЭЭС ГАДУУР ҮНЭЛЭХ.....	114
ХАВСРАЛТ 2: ХАМТЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАНГИЙН ЗАГВАР	115
[УЛС]-ЫН ХАРИЛЦАН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН.....	123
ФАТФ-ЫН ГАРЫН АВЛАГА	137
САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА, САНХҮҮГИЙН БУС БАЙГУУЛЛАГА БОЛОН МЭРГЭЖЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧ НАРТ ШААРДЛАГА ТАВИХ ЭРХ ЗҮЙН ҮНДЭСЛЭЛ.....	138
НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР	140

ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ

AML/CFT	МУТСТ	Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх
BNI	СХ	Санхүүгийн хэрэгслүүд (чек вексель г.м.)
CDD	ХТМ	Харилцагчийг таньж мэдэх
CFT	ТСТ	Терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх
DNFBP	СББМҮҮ	Санхүүгийн бус бизнес болон мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч
FATF	ФАТФ	Санхүүгийн арга хэмжээ авах бүлэг
FSRB	ФТБНБ	ФАТФ-ын төрлийн бүс нутгийн байгууллага
FIU	СМА	Санхүүгийн мэдээллийн алба
IO	ШХ	Шууд хэрэгжилт
IN	ТХ	Тайлбар хэсэг
ML	МУ	Мөнгө угаах
MOU	ХОСБ	Харилцан ойлголцлын санамж бичиг
MVTS	МҮБЗШҮ	Мөнгө болон үнэ бүхий зүйл шилжүүлэх үйлчилгээ
NPO	ТББ	Төрийн бус байгууллага
Palermo Convention	Палермогийн конвенц	Палермогийн конвенц
PEP	УТНБЭ	Улс төрд нөлөө бүхий этгээд
R	З	Зөвлөмж
RBA	ЭС	Эрсдэлд суурилсан аргачлал
SRB	СДЗБ	Сайн дурын зохицуулалттай байгууллагууд
STR	СГТ	Сэжигтэй гүйлгээний тайлан
TCSP	ТКУҮ	Траст, компанийн үйлчилгээ үзүүлэгч
Terrorist Financing Convention	Терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх конвенц	Терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай 1999 оны конвенц
TF	ТС	Терроризмыг санхүүжүүлэх
UN	НҮБ	Нэгдсэн Үндэсний Байгууллага
UNSCR	НҮБ/АЗ	Нэгдсэн Үндэсний Байгууллагын Аюулгүйн Зөвлөл
WB	ДБ	Дэлхийн банк
IMF	ОУВС	Олон улсын валютын сан
Vienna convention	Венийн конвенц	НҮБ-ын Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бодисын хууль бус эргэлтийн эсрэг конвенц 1988

ОРШИЛ

1. Энэ аргачлал нь 2012 оны 2 дугаар сард батлагдсан ФАТФ-ын шинэ зөвлөмжийн дагуу Техникийн хэрэгжилтийг үнэлэх суурь болж тухайн улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцооны үр дүнтэй байдлыг дүгнэхэд ашиглагдах бөгөөд гурван хэсгээс бүрдэнэ. Эхний Оршил хэсэгт аргачлалын¹ ерөнхий ойлголт, түүний үндэс суурь мөн үнэлгээнд хэрхэн ашиглагдахыг тайлбарлана. Хоёр дахь хэсэгт ФАТФ-ын зөвлөмжийн заалт тус бүрт Техникийн хэрэгжилтийг үнэлэх шалгууруудыг тусгасан. Гурав дахь хэсэгт ФАТФ-ын зөвлөмжийн хэрэгжилтийн Үр дүнтэй байдлыг үнэлэхэд ашиглагдах дүгнэлт, үзүүлэлт, мэдээлэл болон бусад хүчин зүйлсийг тусгасан. Хамтын үнэлгээ хийх үйл явц, үе шатыг тус бүрт нь баримт бичиг болгон тусгасан.

2. Дөрөв дэх удаагийн Хамтын үнэлгээнд ФАТФ нь зөвлөмжийн Техникийн хэрэгжилтийг үнэлэхээс гадна мөн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцооны Үр дүнтэй байдлыг давхар үнэлэх болсон. Иймээс аргачлал хоёр хэсгээс бүрдэнэ. Үүнд:

- Техникийн хэрэгжилтийг үнэлэх нь ФАТФ-ын зөвлөмжид тусгасан тодорхой заалт тус бүр хууль, эрх зүй, байгууллагын тогтолцооны хүрээнд хэрхэн шийдэгдэж эрх бүхий байгууллагын эрх мэдэл, үйл ажиллагаатай хэрхэн холбогдож байгааг дүгнэнэ. Эдгээр нь МУТСТ тогтолцооны үндэс суурь нь юм.
- Үр дүнтэй байдлыг дүгнэх нь Техникийн хэрэгжилтийг үнэлэхээс эрс өөр бөгөөд ФАТФ-ын зөвлөмжийг хэрхэн оновчтой хэрэгжүүлж байгаа, МУТСТ тогтолцооны зорилготой хэрхэн нийцэж байгааг дүгнэхэд чиглэнэ. Ийм учраас Үр дүнтэй байдлыг дүгнэх нь хууль, эрх зүй, байгууллагын тогтолцоо нь шаардлагатай үр дүнд хэрхэн хүрч байгааг харуулахад чиглэсэн.

3. Техникийн хэрэгжилт болон мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцооны Үр дүнтэй байдлыг хамтад нь үнэлснээр тухайн улс ФАТФ-ын зөвлөмжийг хэрхэн биелүүлж байгаа болон МУТСТ тогтолцоо нь хэрхэн бэхжиж сайжирч байгааг харуулсан цогц анализ болдог.

4. Энэ аргачлал нь үнэлгээчдэд тухайн улсыг олон улсын МУТСТ стандартыг хэрхэн биелүүлж байгааг үнэлэхэд тусламж болох хэрэгсэл юм. Энэ баримт бичигт олон улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхтэй тэмцэх стандарт болох ФАТФ-ын Зөвлөмж, түүний тайлбар хэсгийн шаардлагуудыг тусгасан бөгөөд зөвлөмжийн хүрээнээс илүү шаардлагыг тусгаагүй болно. Олон төрлийн хууль, эрх зүйн тогтолцоо болон санхүүгийн зохицуулалттай улс орнуудын МУТСТ тогтолцоо, үйл ажиллагааг нь тодорхойлоход үнэлгээчдэд туслалцаа үзүүлэхээс гадна тухайн улс орнууд өөрсдийн тогтолцоог үнэлэх болон техник туслалцаа авах хэрэгцээ шаардлагыг тодорхойлоход мөн ашиглаж болно. Энэ аргачлалыг бэлтгэхэд ФАТФ, ФАТФ-ын төрлийн бүс нутгийн байгууллагууд (ФТБНБ), ОУВС болон Дэлхийн банкны ФАТФ-ын хуучин зөвлөмжид тулгуурлан хийсэн Хамтын үнэлгээний туршлагыг ашигласан болно.

Эрсдэл болон орчин нөхцөл

5. Хамтын үнэлгээ хийх үнэлгээчдийн эхний алхам бол тухайн улсын эрсдэл болон орчин нөхцлийг ойлгох явдал юм. Үүнд:

- Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн төрөл болон түвшин;

¹ “Үнэлэх”, “дүгнэх” болон үүнтэй холбоотой үгнүүд нь энэ баримт бичигт дурдагдахдаа ФАТФ, ФТБНБ болон бусад гуравдагч (ОУВС, ДБ) байгууллагын хийсэн хамтын үнэлгээг хэлж байгаа болно.

- Тухайн улсын нөхцөл байдалд Зөвлөмжийн заалт бодитоор нөлөөлөх нөлөөлөл (эдийн засаг, санхүүгийн системийн бүтэц г.м);
- МУТСТ системийн үндэс суурийн бүрэлдэхүүн хэсгүүд;
- Бусад МУТСТ арга хэмжээнд нөлөөлж болох хүчин зүйлсийг хэрхэн хэрэгжүүлсэн болон түүний үр дүнтэй байдал.

6. МУТС эрсдэл нь Зөвлөмж 1-ийн болон бусад зөвлөмжийн эрсдэлийн бүрэлдэхүүн хэсгүүдийн Техникийн хэрэгжилт болон Үр дүнтэй байдлыг дүгнэх хамгийн гол үзүүлэлт юм. Үнэлгээчид нь үнэлгээний эхэнд болон үнэлгээг хийх явцад тухайн улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн төрөл болон түвшинг байнга тооцож байх шаардлагатай. Үүнд нөлөөлж болох хүчин зүйлсүүд нь тухайн улсад үйлдэгддэг орлого олдог гэмт хэргийн төрөл болон түвшин, тухайн улсад үйл ажиллагаа явуулдаг болон хөрөнгө хуримтлуулдаг террорист байгууллагууд, хил дамнасан гэмт хэргийн болон хууль бус хөрөнгийн урсгалд өртөмтгий байдал зэрэг байж болно.

7. Үнэлгээчид нь улс орнуудын өөрсдийн эрсдэлийг үнэлсэн үнэлгээг тухайн улсын эрсдэлийн түвшингийн тухай ойлголт авах зорилгоор ашиглаж болох ч энэ нь тухайн үнэлгээг хүлээн зөвшөөрөх, гарсан дүгнэлттэй санал нийлэх үндэслэл болохгүй. Үнэлгээчид нь 15 дугаар хэсэгт байгаа Зөвлөмж 1 болон Шууд хэрэгжилт 1-ийн хүрээнд эрсдэлийг хэрхэн үнэлэх зааварчилгаанд анхаарал хандуулах шаардлагатай. Тухайн улсын хийсэн үнэлгээ нь дүгнэлт гаргахад шаардлага хангахгүй, дутагдалтай болон огт хийгдээгүй байх тохиолдолтой учирч болзошгүй. Энэ тохиолдолд тухайн улсын холбогдох эрх бүхий байгууллагуудтай зөвлөлдөж тулгарч байгаа үндсэн эрсдэл юу болох талаар хамтын нэгдсэн ойлголтод хүрэх шаардлагатай. Хэрэв харилцан ойлголцолд хүрч чадахгүй эсвэл үнэлгээ нь дүгнэлт гаргахад шаардлага хангах түвшинд хүрэхгүй байх тохиолдолд зөрүүтэй ойлгож байгаа зүйлс, шалтгааныг Хамтын үнэлгээний тайланд (ХҮТ) тодорхой тайлбарлаж өгөх шаардлагатай бөгөөд өөрсдийн эрсдэл гэж үзэж байгаа зүйлсийг бусад эрсдэлийн хүчин зүйлсийг (эрсдэлд суурилсан хяналт шалгалт г.м) үнэлэхэд ашиглана.

8. Үнэлгээчид нь бодит байдал болон ач холбогдлыг авч үзэх шаардлагатай. Жишээ нь: санхүүгийн систем болон СББМҮҮ нарын оролцогч талуудын оролцооны ач холбогдол, санхүүгийн зах зээлийн хэмжээ, нэгдсэн байдал, санхүүгийн олон төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээ болон байгууллагын ач холбогдол, дотоод болон гадаад зах зээл дээрх үйл ажиллагааны цар хүрээ, эдийн засагт эргэлдэх бэлэн мөнгөний хэмжээ, далд эдийн засаг болон албан бус салбар зэрэг нь эдийн засагт хэрхэн нөлөөлдөг зэрэг байж болно. Үнэлгээчид нь улс орны хүн амын хэмжээ, хөгжлийн түвшин, газарзүйн хүчин зүйлс, худалдааны болон соёлын хоорондын хамаарлыг авч үзэх шаардлагатай. Мөн Техникийн хэрэгжилт болон Үр дүнтэй байдлыг үнэлэхдээ олон төрлийн салбаруудын ач холбогдол болон тулгарч байгаа хүндрэлүүдийг авч үзэх шаардлагатай. Техникийн хэрэгжилтийг дүгнэхдээ тухайн улсад ач холбогдолтой, чухал асуудалд, Үр дүнтэй байдлыг дүгнэхдээ хамгийн чухал хэсэгт илүү их анхаарал хандуулна.

9. Үр дүнтэй МУТСТ тогтолцоог бүрдүүлэхийн тулд тодорхой суурь хүчин зүйлсүүдийг бий болгосон байх шаардлагатай. Жишээ нь: улс төрийн тогтвортой байдал; МУТСТ асуудалд төрийн дээд түвшний удирдлагуудын хандах хандлага; хяналттай, тогтвортой, ил тод төрийн байгууллагатай байх; хуулиар олгогдсон эрх; ур чадвартай, хараат бус, үр дүнтэй шүүх засаглалтай байх зэрэг орно. Эдгээр хүчин зүйлс нь бүрдээгүй эсвэл сул болон дутуу байх тохиолдолд үр дүнтэй МУТСТ тогтолцоог бий болгоход саад болж болно. Хэрэв үнэлгээчид зөвлөмжийн эрсдэлийн Техникийн хэрэгжилт мөн Үр дүнтэй байдлын шалгуур хангалтгүй байгааг тогтоовол үүний шалтгаан нь дээрх хүчин зүйлстэй холбоотой байх магадлалтай бөгөөд энэ талаар хэрэгцээтэй үед Хамтын үнэлгээний тайланд тусгах шаардлагатай.

10. Бусад орчны хүчин зүйлс Үр дүнтэй МУТСТ тогтолцоог үүсгэхэд саад тотгор болж болно. Жишээ нь: тухайн улсын хяналт шалгалтын тогтолцооны тогтвортой байдал; нарийвчилсан хяналт шалгалт хийх чадвар; авлигын түвшин, түүнтэй тэмцэх талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ; санхүүгийн үйлчилгээний хүртээмжтэй байдал зэрэг байж болно. Эдгээр хүчин зүйлс нь МУТС эрсдэлд нөлөөлөхөөс гадна МУТСТ арга хэмжээний үр дүнтэй байдалд эерэг болон сөргөөр нөлөөлөх магадлалтай.

11. Үнэлгээчид нь тухайн улсын МУТСТ тогтолцоог ямар орчинд үйл ажиллагаа явуулж байгаа талаар ерөнхий ойлголт авахын тулд дээрх орчны хүчин зүйлс дээр эрсдэл, ач холбогдол, тогтолцооны болон бусад орчны хүчин зүйлсийг оролцуулан тооцох шаардлагатай. Эдгээр хүчин зүйлсийг тооцооноор тулгамдаж байгаа ямар асуудлыг өндөр эрсдэлтэй, ач холбогдолтой гэж үзэх болон үнэлгээг хийх явцад ямар асуудалд анхаарлаа хандуулах шаардлагатай байгаа чигийг тодорхойлоход дөхөм болно. Энэ аргачлалын Үр дүнтэй байдлын Шууд хэрэгжилт хэсэгт зарим чухал орчны хүчин зүйлсийн талаар тусгайлан дурдсан. Үнэлгээчид нь гарах дүгнэлт болон тухайн улсын эрсдэл, орчны хүчин зүйлст нөлөөлж болох мэдээллийг ашиглахдаа хянамгай хандах хэрэгтэй. Түүнчлэн тухайн орны баримталж байгаа байр суурийг харгалзан үзэх шаардлагатай боловч тэдгээрт шүүмжлэлтэй хандаж, төрөл бүрийн мэдээллийн эх үүсвэр тухайлбал олонд танигдсан, бодит мэдээлэл гаргадаг олон улсын байгууллагууд болон нэр хүндтэй байгууллагын хэвлэл мэдээллийн суваг зэргийг ашиглах нь зүйтэй. Эдгээр хүчин зүйлс дээр тулгуурлан тухайн улсад байгаа МУТСТ системийн талаар өөрийн дүгнэлтийг хийж, дүгнэлтээ тодорхой, ойлгомжтой байдлаар ХҮТ-нд тусгах шаардлагатай.

12. Улс орны эрсдэл, ач холбогдол, бүтцийн болон орчны хүчин зүйлс нь тухайн улс зөвлөмжийн заалтыг хэрхэн хангаж байгаа болон яагаад үр дүн сайн эсвэл муу байгааг харуулдаг. Эдгээр хүчин зүйлс нь зөвлөмжийн шаардлагыг ямар учраас сайн болон муу хангаж байгаа шалтгааныг харуулах гол чухал шинж чанар болох бөгөөд үр дүнг сайжруулах талаарх үнэлгээчдийн зөвлөмжийн тулгуур хэсэг болно. Техникийн хэрэгжилт болон Үр дүнгийн үнэлгээ нь улс орон бүрт ижил нэг ерөнхий стандартаар дүгнэгдэнэ. Тодорхой хүчин зүйлс дутагдалтай байх нь (бүтцийн нэг хэсэг дутуу байх г.м) шалгуур болон үр дүнд сөргөөр нөлөөлнө. Гэхдээ эрсдэл, ач холбогдол болон бусад хүчин зүйлс нь ФАТФ-ын зөвлөмжийг хангалтгүй болон бүрэн хэрэгжүүлэхгүй байх шалтгаан, тайлбар болох ёсгүй. Үнэлгээчид нь ХҮТ-нд ямар хүчин зүйлсийг яагаад сонгон авсан болон мэдээллийн ямар эх үүсвэр ашигласнаа тодорхой дурдах шаардлагатай.

Ерөнхий тайлбар болон зааварчилгаа

13. ФАТФ-ын зөвлөмжид ашигласан нэр томъёоны тайлбар Зөвлөмжийн нэр томъёоны тайлбар хэсэгт байгаа бөгөөд үнэлгээчид нь бусад ерөнхий тайлбарт энэ аргачлалыг ашиглах нь асуудлыг зүй зохистой, системтэй шийдэхэд чухал ач холбогдолтой.

14. **Санхүүгийн байгууллагууд** – Үнэлгээчид нь нэр томъёоны тайлбарт тусгасан *санхүүгийн байгууллага* гэсэн тодорхойлолтод хамаарагдах бүх төрлийн этгээдүүдийн талаар нарийн ойлголттой байх шаардлагатай. Улс орон бүрт эдгээр санхүүгийн үйл ажиллагааг өөр өөр ерөнхий нэрээр (жн: “банк”) явуулдаг учир үнэлгээчид нь тухайн этгээдэд оноосон нэрнээс илүү явуулж байгаа үйл ажиллагааг нь чухалчилж үзэх шаардлагатай.

15. **Улс орны эрсдэлийн үнэлгээг дүгнэх** – Зөвлөмж 1, Шууд хэрэгжилт 1-ийн дагуу Хамтын үнэлгээг хийхдээ үнэлгээчид нь тухайн улсын эрсдэлийн үнэлгээг бие даан хийхгүй ч тухайн улсын өөрсдийн хийсэн эрсдэлийн үнэлгээг туйлын үнэн гэж хүлээн зөвшөөрөх шаардлагагүй. Эрсдэлийн үнэлгээг дүгнэхдээ үнэлгээчид холбогдох журам, дэс дарааллыг нягт мөрдсөн байдал; өгсөн үнэлгээ нь үндэслэлтэй эсэх (байгаа мэдээлэл болон дүн шинжилгээ нь гарсан дүгнэлттэй хэр нийцэж, зохицож байгаа эсэх)-ийг нягталж үзэх шаардлагатай. Үнэлгээчид нь жижиг зүйлсээс илүү чухал ач холбогдолтой зүйлст анхаарал хандуулах шаардлагатай бөгөөд гарсан үр дүн хэр зохистой байгаа талаар бодлоготой хандах хэрэгтэй.

Шаардлагатай гэж үзсэн тохиолдолд үнэлгээчид нь зарчмын зөрүүтэй асуудал үүсэхээс сэргийлж тухайн улс орны тухай олонд танигдсан, үнэн бодит мэдээллийн эх үүсвэрээс мэдээлэл ашиглаж болно. Хэрэв үнэлгээчдийн баг тухайн улс орны өөрсдийн хийсэн эрсдэлийн үнэлгээг шаардлага хангах хэмжээнд байна гэж үзвэл аргачлалын эрсдэлийн хүчин зүйлсийг уг баримтанд тулгуурлан хийж болно.

16. Зөвлөмж 1-ийг үнэлэхдээ үнэлгээчид нь дараах хүчин зүйлст анхаарлаа хандуулах шаардлагатай. Үүнд: (1) эрсдэлийн үнэлгээ хийх, зохицуулах журам, заавар, үйл явц байгаа эсэх; (2) эрсдэлийн үнэлгээ үндэслэлтэй эсэх; (3) эрсдэлд суурилсан аргачлал нь тодорхойлсон эрсдэлтэй зохицсон эсэх (жн: хамр ахгүй, бага болон өндөр эрсдэлтэй тохиолдлууд).

17. Эрсдэлийн үнэлгээний зохистой байдалд тулгуурлан Шууд хэрэгжилт 1-ийг үнэлэхдээ эрх бүхий байгууллагууд бодлого боловсруулах болон эрсдэл бууруулах үйл ажиллагаанд эрсдэлийн ойлголтыг хэрхэн зөв хэрэглэж байгаад анхаарлаа хандуулах шаардлагатай.

18. **Эрсдэлд суурилсан шалгуур** – Санхүүгийн байгууллага болон санхүүгийн бус бизнес болон мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч (СББМҮҮ) нарт тодорхой арга хэмжээ авахыг шаардсан зөвлөмжийн заалт бүрийг нэг бүрчлэн биелүүлэх шаардлагатай гэж үзэн хэрэгжилтийг үнэлнэ. Гэхдээ үнэлгээчид нь ФАТФ-ын зөвлөмжийн гол үндэс болох тухайн төрлийн байгууллага, бизнес, үйлчилгээ, харилцагч, бүтээгдэхүүн, гүйлгээ болон улс орны мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн түвшинг чухалчилж авч үзэх шаардлагатай. Ийм учраас улс орнууд зөвлөмжийн заалтыг хэрэгжүүлэхдээ эрсдэлийг тооцон хэрэгжүүлж болох бөгөөд үнэлгээчид тухайн улсын урьдчилан сэргийлэх арга хэмжээ болон ач холбогдлыг үнэлэхдээ эрсдэл болон түүнд суурилсан аргачлалын уян хатан байдлыг тооцох шаардлагатай. ФАТФ-ын зөвлөмжөөр өндөр эрсдэлтэй үйл ажиллагаанд нэмэгдүүлсэн болон тусгай нэмэлт арга хэмжээ авах шаардлагатай бөгөөд эдгээр арга хэмжээний шалгуур нь эрсдэлийн түвшингээс хамаарч харилцан адилгүй байна.

19. **Бага эрсдэлтэй үед хамаарахгүй байх** – Улс орнууд өөрсдийн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэл бага байна гэж үзвэл санхүүгийн байгууллага болон СББМҮҮ нарт Зөвлөмжийн заалтын дагуу хэрэгжүүлэх шаардлагатай тодорхой арга хэмжээг хэрэгжүүлэхгүй байхаар зарим тохиолдолд шийдэж болно. Зөвлөмжийн зарим заалтыг хэрэгжүүлэхгүй байхаар шийдсэн тохиолдолд тухайн улс орнууд үнэлгээчдэд энэ шийдвэрийг гаргах болсон дүгнэлт, нотлох баримтыг гаргаж өгөх шаардлагатай.

20. **Санхүүгийн байгууллагууд, СББМҮҮ нар болон улс орнуудад тавигдах шаардлага** - ФАТФ-ын зөвлөмжид санхүүгийн байгууллага болон СББМҮҮ нар нь шаардлагатай арга хэмжээг авах эсвэл авсан байх шаардлагатай бөгөөд улс орнууд нь тодорхой арга хэмжээг санхүүгийн байгууллага, СББМҮҮ болон бусад хувь хүн, этгээдүүд хэрэгжүүлж буй эсэхийг хянана. Нэгдмэл нэг ойлголттой байхын тулд энэ аргачлалын холбогдох хэсэгт *“санхүүгийн байгууллага болон СББМҮҮ нар нь арга хэмжээг авсан байх шаардлагатай”* гэдэг нэр томъёог ашиглах болно.

21. **Хууль болон хэрэгжилтийг хангах хэрэгсэл** - *Санхүүгийн байгууллага болон СББМҮҮ нарт шаардлага тавих эрх зүйн үндэслэлд* (ФАТФ-ын зөвлөмжийн тайлбар хэсэгт үзнэ үү) холбогдох арга хэмжээг хэрэгжүүлэх хууль, эрх зүйн үндсийг тусгаж өгсөн. Тодорхой зөвлөмжийн заалтыг хэрэгжүүлэхээр тусгасан арга хэлбэр нь зөвлөмжийн тайлбар хэсэгт тусгасан *хэрэгжилтийг хангах* гэдэг шаардлагатай нийцэж байгаа эсэхийг үнэлгээчид анхаарч үзэх шаардлагатай. Зөвлөмжийн бусад заалтууд хуулинд болон хэрэгжилтийг хангуулах арга хэрэгсэлд тусгагдсан байж болох ч Зөвлөмжийн 10, 11, 20 дахь хэсгийн заалтууд нь хуулинд зайлшгүй тусгагдсан байх шаардлагатай гэдгийг үнэлгээчид мэдэж байх ёстой. Авсан арга хэмжээ, баримт бичиг нь хэрэгжилтийг хангах хэрэгсэл гэдэгт хамаарахгүй байсан ч Үр дүнтэй байдалд зэрэгээр нөлөөлөх тохиолдол байж болох бөгөөд ийм тохиолдолд зөвлөмжийн Техникийн хэрэгжилтийг хангахгүй боловч Үр дүнтэй байдлыг үнэлэхэд тооцогдож болно (жн:

хувийн хэвшлийн холбоодоос гаргасан сайн дурын мөрдөх дүрэм, хяналт шалгалтын байгууллагаас гаргасан зөвлөмж г.м.).

22. **СББМҮҮ нарыг үнэлэх** – Зөвлөмжийн 22, 23, 28 (мөн Зөвлөмж 6, 7-ийн зарим хэсэг)-д заасны дагуу СББМҮҮ болон холбогдох зохицуулах (эсвэл сайн дурын зохицуулалттай байгууллага) байгууллагууд тодорхой арга хэмжээ авсан байхыг шаардсан. Зөвлөмжийн Техникийн хэрэгжилтийг зөвхөн эдгээр зөвлөмжийн заалтаар үнэлэх бөгөөд санхүүгийн байгууллагатай холбоотой зөвлөмжийн шаардлагыг хамаатуулж болохгүй. Гэхдээ Үр дүнтэй байдлыг үнэлэхдээ санхүүгийн байгууллага болон СББМҮҮ нарыг хамтад нь хамруулан дүгнэлт гаргах шаардлагатай.

23. **Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх** – ФАТФ-ын стандартын үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй холбоотой заалт нь зөвхөн Зөвлөмж 7 (“Зорилтот санхүүгийн хориг арга хэмжээ”), Зөвлөмж 2 (“Үндэсний хэмжээний хамтын ажиллагаа, уялдаа холбоо”) хэсэгт хамаарна. Шууд хэрэгжилт 11 хэсэгт үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй холбоотой Үр дүнтэй байдлыг үнэлэх шаардлагууд байгаа бөгөөд Шууд хэрэгжилт 1 хэсэгт үндэсний хэмжээний уялдаа холбоо, хамтын ажиллагаатай холбоотой шаардлагууд тусгагдсан. Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй холбоотой асуудлуудыг зөвхөн эдгээр зөвлөмжөөр үнэлэх бөгөөд үнэлгээний бусад хэсэгт хамаатуулж болохгүй.

24. **Олон улсын, тухайн улсын болон орон нутгийн түвшний арга хэмжээ** – Зарим улс орнуудад МУТСТ асуудлыг зөвхөн үндэсний Засгийн Газрын хэмжээнд бус муж улсын, орон нутгийн засаг захиргааны түвшинд авч үздэг. Ийм учраас үнэлгээ хийх явцад муж улс, орон нутгийн засаг захиргааны түвшинд хэрэгжүүлж байгаа МУТСТ арга хэмжээг судлах шаардлагатай. Мөн үнэлгээчид нь тухайн улсад хүлээн зөвшөөрөгдсөн олон улсын хууль, дүрэм журмыг авч үзэх хэрэгтэй бөгөөд Хавсралт 1-т дурдагдсан зарим зөвлөмжүүдийн хэрэгжилтийг тус дүрэм журмын дагуу үнэлэх нь зүйтэй.

25. **Санхүүгийн хяналт шалгалт** – МУТСТ шаардлагыг банк, даатгалын салбар, үнэт цаасны зах зээлд хууль болон хэрэгжилтийг хангах бусад арга хэрэгслээр нэвтрүүлж, хяналт шалгалтаар хэрэгжилтийг хянах шаардлагатай. Базелийн хороо, Олон улсын даатгалын салбарын хянагч нарын холбоо (IAIS), Олон улсын үнэт цаасны зах зээлийг хянагч нарын холбоо (IOSCO)-ноос гаргасан хяналт шалгалт хийх үндсэн зарчмуудыг дээр дурдсан салбаруудад нэвтрүүлж мөрдүүлэх шаардлагатай. Зарим асуудалд дээрх зарчмууд нь ФАТФ-ын зөвлөмжтэй давхцах буюу зөвлөмжийн нэмэлт шаардлага байх болно. Үнэлгээчид нь хяналт шалгалтын үндсэн зарчим болон бусад холбогдох хяналт шалгалт хийдэг байгууллагаас гаргасан стандарт, үндсэн зарчимтай холбоотой үнэлгээ, дүгнэлтийн талаар мэдээлэлтэй байх шаардлагатай. Бусад төрлийн санхүүгийн байгууллагын хувьд, хууль болон хэрэгжилтийг хангах арга хэрэгслүүдийг хянан шалгах, зохицуулалтын төрөл бүрийн аргаар улс орон бүр өөр өөрсдийнхөөрөө зохицуулдаг.

26. **Хариуцлагын арга хэмжээ** – Зөвлөмжийн зарим заалтууд МУТСТ талаарх шаардлагыг биелүүлээгүй бол “үр нөлөөтэй, үйлдсэн зөрчилтэй нь дүйцэхүйц, гэмт хэрэг давтан үйлдэхээс сэргийлсэн” хариуцлагын арга хэмжээг улс орнууд авахыг шаардсан байдаг. Эдгээр заалтын хэсэг тус бүрийг Техникийн хэрэгжилт болон Үр дүнтэй байдлыг дүгнэх хүрээнд үнэлнэ. Үнэлгээчид нь Техникийн хэрэгжилтээр зөрчлийн үед² тухайн улсын хууль болон хэрэгжилтийг

² Хариуцлагын арга хэмжээний төрлүүд: албан бичгээр сануулга өгөх; тодорхой зүйлийг биелүүлэхийг шаардсан мэдэгдэл өгөх (биелүүлээгүй хугацаанд торгуультай байж болно); авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар тогтмол хугацаанд мэдэгдэж байх шаардлага хүргүүлэх; шаардлага биелүүлээгүйн улмаас торгох; хувь хүмүүсийг тухайн салбар үйл ажиллагаа явуулахыг хориглох; дээд шатны болон гүйцэтгэх удирдлага, хяналтын багц эзэмшигчийн үйл ажиллагааг хязгаарлах болон солих; тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хураах, цуцлах болон боломжтой бол эрүүгийн хариуцлагад татах.

ФАТФ-ын зөвлөмжийн техникийн хэрэгжилт болон МУТСТ тогтолцооны үр дүнтэй байдлыг үнэлэх

хангах хэрэгслүүд нь гаргасан зөрчлийн хэмжээнээс хамаарсан олон төрлийн, тохирсон хариуцлага тооцдог тогтолцоотой эсэхийг үнэлнэ. Үр дүнтэй байдлыг дүгнэхдээ авсан хариуцлагын арга хэмжээ нь зөрчил гаргасан этгээдэд цаашид шаардлагын заалтыг биелүүлэхэд нөлөөлж байгаа эсэх, бусдыг энэ үйлдлийг үйлдэхээс сэргийлж чадсан эсэхээр дүгнэнэ.

27. **Олон улсын хамтын ажиллагаа** – Энэ аргачлалд олон улсын хамтын ажиллагааг хэд хэдэн зөвлөмж болон Шууд хэрэгжилтийн (голчлон Зөвлөмж 36-40 болон Шууд хэрэгжилт 2) заалтаар дүгнэнэ. Үнэлгээчид тухайн улсын олон улсын хамтын ажиллагаанд оролцох чадвар болон хүсэл зорилго нь бусад Зөвлөмж, Шууд хэрэгжилт (жн: улс дамнасан гэмт хэргийг шалгахад, олон улсын нэгдэл компанид хяналт шалгалт хийхэд)-д хэрхэн нөлөөлөх талаар ойлголттой байж, зөвлөмжийн хэрэгжилт болон Үр дүнтэй байдалд эерэг болон сөргөөр нөлөөлж байгаа тохиолдол бүрийг тодорхой тусгах шаардлагатай.

28. **Хуулийн төсөл, санал боловсруулах** – Үнэлгээчид тухайн улсад айлчлал хийж дуусах үед хүчин төгөлдөр, мөрдөгдөж байгаа хууль, журам бусад эрх зүйн баримтуудыг үнэлгээндээ ашиглах шаардлагатай. Мөн үнэлгээчдэд танилцуулсан “боловсруулсан” төсөл, саналыг үнэлгээний тайланд тусгаж болох боловч дүгнэлт хийх, үнэлгээ өгөхдөө ашиглахгүй байх нь зүйтэй.

29. **ФАТФ-ын зааварчилгаа** – ФАТФ-аас гаргасан зааварчилгааг үнэлгээчид улс орнууд зөвлөмжийн тодорхой заалтуудыг хэрхэн хэрэгжүүлж болох талаар мэдээлэл авах зорилгоор ашиглаж болно. ФАТФ-аас гаргасан зааварчилгааны бүрэн жагсаалтыг энэ баримт бичгийн ард хавсралтад дурдсан. Дээрх зааварчилгаанууд нь үнэлгээчдэд ФАТФ-ын зөвлөмжийг амьдрал дээр хэрхэн хэрэгжүүлж болох талаар ойлголт өгөх материал болох боловч зааварчилгааг хэрхэн ашиглаж байгаа нь үнэлгээнд хамаарахгүй.

ЗӨВЛӨМЖИЙН ТЕХНИКИЙН ХЭРЭГЖИЛТ

30. ФАТФ-ын зөвлөмжийн Техникийн хэрэгжилт нь ФАТФ-ын зөвлөмжийн заалтыг хэрхэн хэрэгжүүлж байгааг хууль болон хэрэгжилтийг хангах арга хэрэгслүүд; эрх бүхий байгууллага байгаа эсэх, түүний эрх, үйл ажиллагаа зэргийг тооцон үнэлнэ. Ихэнх тохиолдолд зөвлөмжийн Үр дүнтэй байдалтай холбоотой хэсгийг энд дүгнэхгүй бөгөөд уг хэсгийг аргачлалын Үр дүнтэй байдлыг үнэлэх хэсэгт тусад нь авч үзнэ.

31. ФАТФ-ын зөвлөмж нь дэлхий нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн бүх улс орнууд хэрэгжүүлэх шаардлагатай олон улсын стандарт хэдий ч улс орон бүрийн МУТСТ хуулийн, төрийн байгуулалтын, хяналт шалгалтын тогтолцоо өөр хоорондоо ялгаатай байдгийг үнэлгээчид анхаарах шаардлагатай. ФАТФ-ын стандартыг³ хэрэгжүүлэхдээ улс орнууд өөрийн хуулийн болон төрийн байгуулалтын тогтолцоонд нийцүүлэн олон төрлийн арга замаар хэрэгжүүлж болохыг хүлээн зөвшөөрсөн байдаг. Ийм учраас үнэлгээчид тухайн улсын эрсдэл, бүтцийн болон хэв шинжийн хүчин зүйлсийг тооцож байх шаардлагатай.

32. Аргачлалын Техникийн хэрэгжилт хэсэг нь зөвлөмжийн заалтуудын шалгуур тус бүрээр жагсаалт гаргадаг бөгөөд энэ жагсаалтад байгаа шалгуурууд нь зөвлөмжийн заалтыг бүрэн хангасанд тооцогдох бүрэлдэхүүн хэсэг элемент болно. Зөвлөмжийн заалт тус бүрийн шалгуурыг дараалуулан дугаарласан байдаг бөгөөд энэ дугаарлалт нь ач холбогдлоор нь эрэмбэлээгүй болно. Зарим тохиолдолд үнэлгээний ач холбогдолтой хэсгийг тодорхойлох зорилгоор (шалгуурын доор дурдсан) дэлгэрүүлэн задаргаа хийгдсэн байгаа. Ийм тохиолдолд шалгуурыг бүрэн биелүүлж байгааг дүгнэхийн тулд үнэлгээчид дэлгэрүүлэн задалсан шалгуурын элемент бүрийг хангаж байгаа эсэхээс хамаарна.

Зөвлөмжийн хэрэгжилтийн зэрэглэл

33. Зөвлөмжийн заалт тус бүрээр үнэлгээчид тухайн улс стандартын заалтыг ямар түвшинд биелүүлж байгааг үнэлсэн дүгнэлтэд хүрэх шаардлагатай. Зөвлөмжийн биелэлтийг дөрвөн түвшингээр зэрэглэл тогтоож үнэлж дүгнэнэ. Үүнд: биелүүлсэн, ихэнхдээ биелүүлсэн, хэсэгчлэн биелүүлсэн болон биелүүлээгүй. Зарим онцгой тохиолдолд зөвлөмжийн заалтыг хэрэгжүүлэх боломжгүй гэж дүгнэж болно. Эдгээр зэрэглэлүүд нь Техникийн хэрэгжилтийг дүгнэх шалгуур дээр суурилсан бөгөөд дараах байдлаар тодорхойлогдоно. Үүнд:

Зөвлөмжийн Техникийн хэрэгжилтийн зэрэглэл		
Биелүүлсэн /Compliant/	C	Сул тал, доголдол байхгүй
Ихэнхдээ биелүүлсэн /Largely compliant/	LC	Бага зэргийн доголдолтой
Хэсэгчлэн биелүүлсэн /Partially compliant/	PC	Дунд зэргийн доголдолтой
Биелүүлээгүй /Non-compliant/	NC	Их хэмжээний доголдолтой
Хэрэгжүүлэх боломжгүй /Not applicable/	NA	Тухайн орны хууль эрх зүйн, төрийн байгуулалтын болон бүтцийн тогтолцооны онцлогоос хамааран зөвлөмжийн заалтыг хэрэгжүүлэх боломжгүй

Зөвлөмжийн заалтын сул болон доголдлын түвшнийг тодорхойлохдоо үнэлгээчид тухайн орны онцлог шинж чанар, заалтын шалгууруудын хэрэгжсэн тоо, хэрэгжүүлээгүй үлдсэн шалгуурын тоо болон ач холбогдлыг дүгнэж үзэх шаардлагатай.

³ ФАТФ-ын стандарт нь ФАТФ-ын зөвлөмж түүний тайлбар хэсгээс бүрдэнэ

34. Тухайн улсын МУТСТ тогтолцоог Зөвлөмжийн заалтуудтай хэрхэн нийцэж байгаа талаар танилцуулах нь тус улсын өөрийнх нь үүрэг гэдгийг онцлон тэмдэглэх шаардлагатай. Зөвлөмжийн заалт тус бүрт үнэлгээ өгөхдөө үнэлгээчид нь хууль болон бусад хэрэгжилтийг хангах арга хэрэгслүүд ФАТФ-ын зөвлөмжид хэрхэн нийцэж байгааг үнэлэхээс гадна төрийн зохион байгуулалтын бүтэц оршиж байгаа эсэхийг үнэлэх шаардлагатай.

35. **Харьцуулах** – Зөвлөмжийн заалтыг үнэлэхэд ашиглагдаж байгаа шалгуур тус бүр ижил ач холбогдолтой биш бөгөөд олон шалгуурыг хангаж байгаа нь Зөвлөмжийн заалтыг хангалттай биелүүлж байна гэж үзэхгүй. Үнэлгээчид нь Зөвлөмжийн заалт тус бүрийг үнэлэхдээ тухайн улсын нөхцөл байдалд тохируулан шалгуурын ач холбогдлыг тодорхойлно. Мөн үнэлгээчид нь тухайн улсын эрсдэл, бүтцийн болон бусад нөхцөл байдалд (жн: эрсдэл өндөртэй хэсгийн эсвэл голлох санхүүгийн салбарын тухай) дутагдалтай байгаа зүйлс нь хэр ач холбогдолтой болохыг тооцох шаардлагатай. Зарим тохиолдолд зөвхөн ганцхан шалгуурыг хангаагүй үед NC зэрэглэлд оруулах шалтгаан байж болно. Мөн эрсдэл багатай эсвэл өргөн хэрэглэгддэггүй санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой дутагдал байх нь зөвлөмжийн биелэлтийн ерөнхий үнэлгээнд бага зэрэг нөлөө үзүүлж болох жишээтэй.

36. **Зөвлөмжийн заалтуудын давхцал** – Ихэнх тохиолдолд суурь доголдол нь бусад зөвлөмжийн заалтыг үнэлэхэд мөн дам нөлөө үзүүлж болно. Жишээ нь: Эрсдэлийн үнэлгээг хангалтгүй хийх нь МУТСТ тогтолцооны эрсдэлд суурилсан үнэлгээтэй холбоотой бүх заалтад нөлөөлж түүнчлэн нэг төрлийн санхүүгийн байгууллага, СББМҮҮ-д МУТСТ-тэй холбоотой зохицуулалтыг хэрэгжүүлэхгүй байх нь санхүүгийн байгууллага эсвэл СББМҮҮ нарт холбоотой зөвлөмжийн заалт тус бүрийн үнэлгээнд нөлөөлнө. Ийм тохиолдолд үнэлгээчид хамаарах зөвлөмжийн заалт бүрт дутагдалтай байгаа үндсэн хүчин зүйлийг тодорхой болгож шаардлагатай бол холбогдох зэрэглэлийг тогтоож, Хамтын үнэлгээний тайланд зөвлөмжийн заалт тус бүрт нөлөөлж байгаа хүчин зүйлсийг тодорхой дурдах шаардлагатай.

37. **Өмнөх зэрэглэлтэй харьцуулах** – ФАТФ-ын 2012 оны Дөчин зөвлөмж болон Тусгай есөн зөвлөмжид орсон нэмэлт өөрчлөлт болон Техникийн хэрэгжилт, Үр дүнтэй байдлын үнэлгээг тусад нь үнэлэх болсон зэргээс шалтгаалж энэ аргачлалын дагуу гаргасан зэрэглэлийг 2004 оны аргачлалын дагуу гарсан зэрэглэлтэй шууд харьцуулах боломжгүй болсон.

ҮР ДҮНТЭЙ БАЙДАЛ

38. МУТСТ тогтолцооны үр дүнтэй байдлыг үнэлэх нь ФАТФ-ын стандартын дагуу Техникийн хэрэгжилтийг үнэлэхтэй адил чухал ач холбогдолтой. Үр дүнтэй байдлыг үнэлэх нь дараах зорилготой: (а) ФАТФ үр дүнд илүү анхаарал хандуулна; (b) улс орнуудын үндэсний МУТСТ тогтолцоо ФАТФ-ын стандартын зорилгыг хэрхэн биелүүлж байгаа болон тогтолцооны дутагдалтай талыг илрүүлнэ; (с) өөрсдийн тогтолцоог сайжруулахад шийдэх шаардлагатай асуудлуудын эрэмбийг тогтооход тусална. Энэ аргачлалд Үр дүнтэй байдлыг “томъёолсон үр дүнд хүрсэн түвшин” гэж тодорхойлсон.

39. МУТСТ хүрээнд Үр дүнтэй байдал гэдэг нь тухайн улсын эдийн засаг, санхүүгийн систем нь мөнгө угаах, терроризм болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх эрсдэлийг бууруулж байгаа түвшин юм. Энэ нь дараах зүйлстэй холбоотой үр дүнгүүд байж болно. Үүнд: (а) төрийн бодлого, хууль бусад хэрэгжилтийг хангах хэрэгслүүд; (b) хууль сахиулах, хяналт шалгалт болон тагнуулын үйл ажиллагаатай холбоотой хөтөлбөрүүд; (с) мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг бууруулах, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэхтэй холбоотой тусгай арга хэмжээ авах зэрэг болно.

40. Үр дүнтэй байдлыг үнэлэх нь тухайн улсын МУТСТ тогтолцоог цогцоор нь хэрхэн сайн ажиллаж байгааг бодитоор үнэлэхэд оршино. Мөн Зөвлөмжийн Техникийн хэрэгжилтийг үнэлэхээс тэс өөр арга барил дээр суурилдаг бөгөөд Зөвлөмжийн заалт нэг бүрийг биелүүлсэн болон заалтын шалгуур элемент бүр байгаа эсэхийг авч үздэггүй. Энэ нь зорьсон зорилгодоо хэрхэн хүрч байгаа талаар, өөрөөр хэлбэл ФАТФ-ын стандартын дагуу МУТСТ тогтолцооны үндсэн зорилгууд бодит байдал дээр хэрхэн биелэгдэж байна гэдгийг авч үзнэ. Үнэлгээний энэ хэсэг нь үнэлүүлж байгаа улстай хамтран ажиллаж байгаа үнэлгээчдийн үнэлэмжин дээр суурилна.

41. Үнэлүүлж байгаа улс орнууд МУТСТ өөрийн тогтолцоог үр дүнтэй байгаа гэдгээ харуулах үүрэгтэй гэдгийг тэмдэглэх хэрэгтэй бөгөөд хэрэв хангалттай нотлох баримт гаргаж өгөхгүй бол үнэлгээчид үр дүн муутай тогтолцоотой гэж дүгнэлт гаргах эрхтэй.

ҮР ДҮНТЭЙ БАЙДЛЫГ ҮНЭЛЭХ ХҮРЭЭ

42. Үр дүнтэй байдлыг үнэлэхэд зориулж ФАТФ-аас тодорхой үр дүнгээр жагсаасан, шатлалтай аргыг нэвтрүүлсэн. МУТСТ арга хэмжээний зорилгын хамгийн дээд түвшинд “Нийт эдийн засаг болон санхүүгийн систем нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх заналхийлэлээс сэргийлэгдсэн бөгөөд санхүүгийн системийн цогц байдал хадгалагдсанаар аюулгүй болон найдвартай байдалд хувь нэмэр болно.” Тухайн улсын МУТСТ тогтолцооны Үр дүнтэй байдлын тухай цогц ойлголт авах болон түүний бүрэлдэхүүн хэсэг бүр хэрхэн үүргээ гүйцэтгэж байгаад тохирох үнэлгээг өгч тэнцвэржүүлэхийн тулд ФАТФ-аас үр дүнгийн үнэлгээнд үндсэн *Арван нэгэн шууд хэрэгжилт*-ийг ашигладаг. Эдгээр нь тус бүртгээ үр дүнтэй МУТСТ тогтолцоонд байх шаардлагатай үндсэн зорилт бөгөөд МУТСТ тогтолцооны үндсэн *Явцын хэрэгжилтийн гурван* хэсэгт хувирна. Энэ арга нь Зөвлөмжийн заалт бүрийг тухайн улс, тодорхой нэг байгууллага болон аж ахуйн нэгж хэрхэн биелүүлж байгаагаар үр дүнг үнэлэхгүй. Үнэлгээчдээс өндөр дээд түвшний зорилго болон Явцын хэрэгжилтийг үнэл гэж шаардахгүй боловч эдгээрийг үнэлэх нь Хамтын үнэлгээний тайланг бэлтгэх болон улс орны нийт ерөнхий түвшний хэрэгжилтийг дүгнэж бичихэд тустай.

43. Өндөр дээд түвшний зорилго, Явцын хэрэгжилт болон Шууд хэрэгжилтийн хоорондын хамаарлыг доорх схемээр харуулав.

Өндөр дээд түвшний зорилго

Нийт эдийн засаг болон санхүүгийн систем мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх заналхийлэлээс сэргийлэгдсэн байх бөгөөд
--

санхүүгийн системийн цогц байдал хадгалагдсанаар аюулгүй болон найдвартай байдалд хувь нэмэр болно.	
Явцын хэрэгжилт	Шууд хэрэгжилт
Бодлого, уялдаа холбоо болон хамтын ажиллагаа нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг бууруулдаг байх.	1. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг ойлгодог, шаардлагатай үед мөнгө угаах, терроризм болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр үндэсний хэмжээний үйл ажиллагаа зохион байгуулдаг байх.
	2. Олон улсын хамтын ажиллагаа нь гэмт хэрэгтэн болон тэдний хөрөнгийн талаар шаардлагатай мэдээ, санхүүгийн мэдээлэл болон нотлох баримтыг олох боломж олгодог байх.
Гэмт хэргийн замаар олсон болон терроризмыг дэмжих хөрөнгө мөнгийг санхүүгийн болон бусад салбарт нэвтэрхээс сэргийлдэг болон дээрх байгууллагууд өөрсдөө илрүүлж, мэдээлдэг байх.	3. Хянан шалгагч нар санхүүгийн байгууллага болон СББМҮҮ нарыг шаардлагатай түвшинд эрсдэлээс нь хамааруулан МУТСТ үүргээ хэрхэн биелүүлж байгааг хянадаг, зохицуулдаг байх.
	4. Санхүүгийн байгууллага, СББМҮҮ нар нь эрсдэлээс хамаарсан МУТСТ урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч хэрэгжүүлж, сэжигтэй гүйлгээг мэдээлдэг байх.
	5. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх хууль бус үйлдлээс хуулийн этгээд болон эрх зүйн бусад зохицуулалт бүхий этгээдийг урьдчилан сэргийлсэн, эрх бүхий байгууллага нь тэдгээрийн эцсийн өмчлөгчийн тухай мэдээллийг саадгүй авах боломжтой байх.
Мөнгө угаах оролдлогыг илрүүлдэг, таслан зогсоодог, гэмт хэрэгтнүүдэд хариуцлага хүлээлгэдэг болон хууль бус орлогыг хураан авдаг байх. Терроризмыг санхүүжүүлэх оролдлогыг илрүүлдэг, таслан зогсоодог, террористуудын эх үүсвэрийг таслан зогсоодог болон терроризмыг санхүүжүүлсэн этгээдүүдэд хариуцлага хүлээлгэдэг нь террорист үйлдэл үйлдэгдэхээс сэргийлдэг байх.	6. Эрх бүхий байгууллага нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх үйлдлийг шалгахдаа санхүүгийн мэдээлэл болон бусад холбогдох мэдээллийг зүй зохистой ашигладаг байх.
	7. Мөнгө угаахтай холбоотой үйлдэл болон гэмт хэрэгт мөрдөн шалгах үйл ажиллагаа явагддаг болон буруутай этгээдүүдэд үр нөлөөтэй, үйлдсэн зөрчилтэй нь дүйцэхүйц, гэмт хэрэг давтан үйлдэхээс сэргийлсэн хариуцлага хүлээлгэдэг байх.
	8. Гэмт хэргээс олсон орлого болон үйлдэхэд ашиглагдсан хэрэгсэл зэргийг хураан авдаг байх.
	9. Терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой үйлдэл болон гэмт хэрэгт мөрдөн шалгах үйл ажиллагаа явуулдаг байх, буруутай этгээдүүдэд үр дүнтэй

	нөлөөлөх, гаргасан зөрчилтэй нь дүйцэхүйц, давтан үйлдэхээс сэргийлсэн хариуцлага хүлээлгэдэг байх.
	10. Террорист, террорист байгууллага болон терроризмыг санхүүжүүлэгч нарыг хөрөнгө мөнгө цуглуулах, шилжүүлэх, ашиглахаас урьдчилан сэргийлэх, хууль бус үйл ажиллагаанд ТББ-ыг урвуулан ашиглах боломжгүй болгох.
	11. НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн тогтоолд заасны дагуу үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх үйл ажиллагаатай холбоотой хувь хүн, этгээдүүдийг хөрөнгө цуглуулах, шилжүүлэх, ашиглахаас урьдчилан сэргийлэх.

Судлах шаардлагатай асуудлуудыг тодорхойлох

44. Үнэлгээчид нь арван нэгэн шууд хэрэгжилтийн бүгдийг үнэлэх шаардлагатай. Гэхдээ тухайн улсад айлчлал хийхээс өмнө 5-аас 10 хүртэлх хэсэгт тусгагдсан эрсдэл бусад хүчин зүйлсийг хамруулсан судлах шаардлагатай асуудлуудыг үнэлүүлж байгаа улстай санал солилцон тодорхойлох шаардлагатай. Түүнчлэн үнэлгээчид үнэлүүлж байгаа улстай санал солилцон өндөр эрсдэлтэй асуудлуудыг тодорхойлон үнэлгээ хийх үед уг асуудлуудыг нарийвчлан үнэлж, эцсийн тайланд тусгах бөгөөд илүү нарийвчлан судлах шаардлагагүй, бага эрсдэлтэй хэсгийг мөн тогтооно. Үнэлгээ хийж байх хугацаандаа үнэлгээчид тухайн улстай хамтран Үр дүнтэй байдлын талаарх хийсэн анхны дүгнэлтэд шаардлагатай эргэн харах асуудлуудыг судалж мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх гол эрсдэлүүдийг хамруулан Үр дүнтэй байдлыг сайжруулж болох асуудалтай хэсэгт зорилгоо чиглүүлэх хэрэгтэй.

Техникийн хэрэгжилттэй холбогдох

45. Үр дүнтэй байдлыг дүгнэхэд тухайн улсын Техникийн хэрэгжилт нөлөөлнө. Үнэлгээчид Техникийн хэрэгжилтийн түвшинг судлах шаардлагатай асуудлын нэг хэсэг гэж үзнэ. Техникийн хэрэгжилтийн үнэлгээ нь үр дүнтэй МУТСТ тогтолцооны хууль, эрх зүйн болон байгууллагын тогтолцооны суурийг хэрхэн бүрдүүлсэн байгааг үнэлдэг. ФАТФ-ын зөвлөмжийн Техникийн хэрэгжилтийг хангалтгүй биелүүлж байгаа улс орон үр дүнтэй МУТСТ тогтолцоотой байх боломж багатай (гэхдээ Техникийн хэрэгжилтийг хангалттай биелүүлж байгаа улс орон бүр үр дүнтэй байна гэж дүгнэж болохгүй). Ихэнх тохиолдолд үр дүн муу байх гол шалтгаан нь Зөвлөмжийн Техникийн хэрэгжилтийн элементүүдийг маш муу нэвтрүүлснээс болно.

46. Үр дүнтэй байдлыг үнэлэхдээ үнэлгээчид тухайн улсын хамаарах Зөвлөмжийн заалтын Техникийн хэрэгжилтийн нөлөөллөөс шалтгаалан ямар учраас тухайн улс орон үр дүнтэй (эсвэл үр дүн муутай) байгааг тогтоож үр дүнг хэрхэн сайжруулах талаар зөвлөгөө өгнө. Зарим онцгой тохиолдолд зөвлөмжийн Техникийн хэрэгжилт маш муу байхад тодорхой хэмжээний үр дүнтэй байна гэж үнэлгээчид дүгнэлт хийж болно (Тухайлбал: тухайн улсын онцлогтой холбоотойгоор эрсдэл нь бага байх, бусад бүтцийн, бодит болон бусад хэв шинжийн хүчин зүйлсээс хамаарч; тухай улсын эрх зүйн болон төрийн байгууллагын тогтолцооноос хамаарч; ФАТФ-ын зөвлөмжтэй тэнцэхүйц бусад МУТСТ арга хэмжээ авдаг байх). Энэ тохиолдолд үнэлгээчид ХҮТ-нд өөрийн гаргасан шийдвэрийг бүрэн тайлбарлан, зөвлөмжийн Техникийн хэрэгжилт доогуур байхад тодорхой хэмжээний үр дүнтэй байна гэж дүгнэх болсон тодорхой шалгаан, хүчин зүйлсийг зайлшгүй дурдах хэрэгтэй.

Үр дүнтэй байдлын аргачлалыг хэрэглэх нь

47. Үр дүнтэй байдлын үнэлгээ нь Арван нэгэн шууд хэрэгжилтийг тус бүрд нь дүгнэх бөгөөд Явцын хэрэгжилт болон Өндөр дээд түвшний зорилгыг шууд хамруулж үзэхгүй. Шууд хэрэгжилт тус бүрийг дүгнэх явцад үнэлгээчид дараах үндсэн хоёр асуултад хариулахыг хичээх хэрэгтэй. Үүнд:

- **Хэрэгжилт ямар биелэлттэй байна вэ?** Үнэлгээчид тухайн улс Шууд хэрэгжилттэй холбоотой ямар үр дүнтэй байгааг үнэлнэ (жн: тогтвортой сайн үүргээ гүйцэтгэж байгаа МУТСТ тогтолцоог бий болгосноор тухайн улс хүлээж буй үр дүндээ хүрч байгаа эсэх). Дүгнэлтээ Техникийн хэрэгжилт, бусад орчны хүчин зүйлсийг анхааран *Үндсэн асуудлууд* дээр тулгуурлаж холбогдох мэдээлэл болон бусад хүчин зүйлсээр баталгаажуулан гаргана.
- **Үр дүнтэй байдлыг нэмэгдүүлэхэд юу хийх шаардлагатай вэ?** Тухайн улсын үр дүн ямар шалтгааны улмаас сайн гарсангүй вэ гэдгийг тогтоох шаардлагатай бөгөөд тодорхой үр дүнд хүрэхийн тулд зарим чадавхийг сайжруулах талаар зөвлөгөө өгч болно. Дүгнэлт, зөвлөгөөг гаргахдаа үндсэн асуудлууд болон түүнийг дүгнэхэд ашиглагдах үйл ажиллагаа, процес, нөөц, дэд бүтэц гэх мэт тодорхой хүчин зүйлс дээр тулгуурлан гаргана. Үр дүнтэй байдалд нөлөөлж байгаа техникийн хүчин зүйлсийн дутагдал болон холбогдох орчны хүчин зүйлсийн нөлөөг тусгах шаардлагатай. Үнэлгээчид Үр дүнтэй байдал өндөр түвшинд байна гэж дүгнэж байвал үр дүнтэй байдлыг нэмэгдүүлэх талаарх зөвлөгөөг дэлгэрэнгүй авч үзэх шаардлагагүй (гэхдээ сайн туршлага, цаашид сайжруулах шаардлага, өндөр үр дүнгээ хадгалахын тулд хүчин чармайлтаа хэвээр хадгалах зэрэг асуудлуудыг чухалчлах хэрэгтэй).

Үр дүнтэй тогтолцооны шинж чанар

48. Шууд хэрэгжилтийн дээд талд байх хайрцагласан зурваст үр дүнтэй тогтолцооны гол шинж, хэрэгжилтийг тусгасан байгаа. Эдгээр нь тухайн улс ямар тохиолдолд үр дүнтэй байх талаар чиглэл өгөх бөгөөд үнэлгээний үзүүлэлт болно.

Хэрэгжилт хангагдсан эсэхийг тодорхойлох Үндсэн асуудлууд

49. Хоёр дахь хэсэгт үнэлгээчдэд хэрэгжилт ямар түвшинд байгааг дүгнэх суурийг тодорхойлж өгсөн бөгөөд *Үндсэн асуудлууд* нь хэрэгжилт тус бүрийн үр дүн ямар байгааг тодорхойлоход үнэлгээчдийн зайлшгүй хариулах шаардлагатай асуудлууд байх болно. Тухайн улс ямар үр дүнтэй байгаа талаарх үнэлгээчдийн дүгнэлтийг хэрэгжилт бүрийн үр дүнг Үндсэн асуудлуудтай харьцуулан гаргаж ирнэ.

50. Үнэлгээчид нь эрсдэлийн түвшин, тухайн улсад тулгарч байгаа бодит асуудлуудын ач холбогдлоос хамаарч дэлгэрэнгүй авч үзэх асуудлыг тодорхойлох боловч хэрэгжилт тус бүрийг авч үзэхдээ Үндсэн асуудлуудыг хамтад нь судална. Онцгой тохиолдолд үнэлгээчид бусад нэмэлт асуудлуудыг Үр дүнтэй байдалд шууд нөлөөлөх асуудал гэж үзэн судалж болно. (жн: Үндсэн асуудлууд, нэмэлт мэдээлэл болон бусад хүчин зүйлд тусгагдаагүй тухайн улсын МУТСТ тогтолцооны онцлогт тохирсон өөр бусад арга хэмжээ). Үндсэн асуудал гэж үзэх болсон асуудлуудыг хэзээ, ямар учир шалтгаанаас хэрэглэсэн болохыг тодорхой болгох шаардлагатай.

Үндсэн асуудлуудын талаар дүгнэлт хийхэд тусламж болох мэдээллийн жишээ

51. *Мэдээллийн жишээ* хэсэгт хэрэгжилт бүрийн үр дүнг үнэлэх, ойлгоход нэн шаардлагатай мэдээллийн төрөл, эх үүсвэрийг мөн Үндсэн асуудлуудыг үнэлэхэд судлах шаардлагатай мэдээллийн сувгийг тодорхойлж өгсөн байгаа. Нэмэлт туслах мэдээлэл болон бусад мэдээлэл нь үнэлгээчдэд Үндсэн асуудлуудыг хэрхэн ойлгосноо шалгах, баталгаажуулах, хэрэгжилтийг хэрхэн сайн нэвтрүүлж байгаа батлах тоо, баримт болно.

52. Нэмэлт туслах болон бусад мэдээллийн жагсаалт нь бүгдийг хамарсан, зайлшгүй шаардлагатай зүйлс биш юм. Мэдээ, статистик мэдээлэл болон бусад материалууд улс орон бүрийн онцлогоос хамаарч өөр өөр байх бөгөөд үнэлгээчид тухайн улсад байгаа мэдээлэл бүрийг ашиглан өөрийн дүгнэлтээ хийх шаардлагатай.

53. Үр дүнтэй байдлыг дүгнэх нь статистик гаргахтай адилгүй. Хэрхэн үр дүнд хүрч байгааг үнэлэхдээ үнэлгээчид статистик мэдээлэл болон бусад тоон мэдээлэл дээр тулгуурлан дүгнэлтээ гаргах боловч мэдээллийг тухайн улсын нөхцөл байдлаас хамаарч шууд шалгаж, баталгаажуулахгүйгээр авч ашиглаж болохгүй. Үнэлгээчид боловсруулаагүй мэдээлэлд (өргөн хүрээнд шууд ашиглах, зөрчилтэй дүгнэлт гаргаж болох) гол анхаарлаа хандуулах бус харин тухайн үнэлүүлж буй улсын нөхцөл байдалд тохирсон, үр дүнд хүрсэн эсэхийг үнэлэхэд шаардагдах баталгаажсан мэдээлэл, анализд гол анхаарлаа хандуулах нь зүйтэй. Үр дүнтэй байдлыг дүгнэхдээ бусад улсын тоон мэдээллийг харьцуулан ашиглах гэж байгаа бол тухайн улсын нөхцөл байдал болон МУТСТ тогтолцоо, мэдээлэл цуглуулах байдал зэрэг нь хоорондоо эрс ялгаатай байх магадлалтай тул маш хянамгай хандах хэрэгтэй. Богино хугацааны хооронд гарсан түр зуурын үр дүнгүүд зорьсон зорилгод тэр бүр эерэг үр дүн авчирдаггүй болохыг үнэлгээчид анхаарах шаардлагатай.

Үндсэн асуудлуудын талаар дүгнэлт хийхэд дэмжлэг болох тусгай хүчин зүйлсийн жишээ

54. Аргачлалын хүчин зүйлс хэсэгт хэрэгжилт тус бүрт харгалзах бүрэлдэхүүн хэсгүүдийн жишээг тусгаж өгсөн байгаа. Гэхдээ энэ нь бүх хүчин зүйлсийг бүхэлд нь хамарсан жагсаалт гэж ойлгож болохгүй бөгөөд тухайн улс ямар учраас тодорхой нэг үр дүнд хүрч чадаж эсвэл чадахгүй байгааг дүгнэхэд тусламж болох зорилготой (нэг хүчин зүйлсийг бүрэлдүүлээгүй учраас байж болно). Ихэнх тохиолдолд тодорхой нэг хэрэгжилтийн заалтын талаар эцсийн дүгнэлт хийхэд үнэлгээчид хүчин зүйлсийг судлах шаардлагатай болно. Энэ хэсэгт жагсаасан үйл ажиллагаа, авах арга хэмжээ нь МУТСТ тогтолцооны цор ганц байж болох загвар биш бөгөөд зөвхөн түгээмэл хэрэглэгддэг захиргааны зохион байгуулалтыг харуулна. Тухайн улс үр дүнгүй байгаа шалтгаан нь дээрх хүчин зүйлсүүдээр хязгаарлагдахгүй. Үүнд үнэлгээчид хүчин зүйлсийн ард байгаа үйл ажиллагаа, явцад биш чанарт нь гол анхаарлаа хандуулах шаардлагатай.

55. Үнэлгээчдээс тухай бүрт бүх хүчин зүйлсийг авч үзэхийг шаардахгүй. Хэрэв тухайн улсын тодорхой нэг хэсэгт үр дүн сайтай байвал ямар учир шалтгаанаас сайн байгааг товч тэмдэглэж аргачлалын жишээ болгосон хүчин зүйлс тус бүрийг шалгах шаардлагагүй. Харин тухайн улс суурь тогтолцооны дутагдлаас (жн: чухал техникийн шалгуурыг биелүүлээгүй) шалтгаалж үр дүнгүй байвал үнэлгээчид нь ямар учир шалтгааны улмаас үр дүн муутайг тогтоохын тулд нарийвчлан шалгах шаардлагагүй.

56. Зарим хэрэгжилт олон шатлалтай, дэс дараалсан болон шат ахих тусам шаардлага өндөрсөх арга хэмжээнээс хамаарч үр дүнд хүрч болохыг үнэлгээчид мэдэж байх шаардлагатай (жн: Шууд хэрэгжилт 7 нь хэрэг бүртгэл, мөрдөн байцаалт болон хариуцлагын арга хэмжээ гэсэн дараалалтай байна). Ийм тохиолдолд зарим шатандаа үр дүнтэй боловч нэг шатандаа дутагдалтайгаас болж эцсийн хэрэгжилт үр дүнгүй байж болно.

57. Үнэлгээчид ач холбогдолтой эсвэл эрсдэл өндөртэй, гарах үр дагавар ихтэй орчны хүчин зүйлст анхаарлаа хандуулах хэрэгтэй. Эдгээр хүчин зүйлс нь тухайн улс ямар учир шалтгааны улмаас үр дүнтэй эсвэл үр дүн муутай байгаа болон үр дүнд нэмэгдүүлэхэд юу хийж болохыг тусгасан үнэлгээчдийн зөвлөмжийн нэг чухал хэсэг болж болно. Гэхдээ эдгээр нь ФАТФ-ын зөвлөмжийг учир дутагдалтай хангалтгүй нэвтрүүлэх хүндэтгэх шалтгаан болох ёсгүй.

Хоорондоо холбогдсон асуудлууд

58. Шууд хэрэгжилтийн хэсэг нь тус тусдаа бие даасан зүйлс биш юм. Ихэнх тохиолдолд нэг хэрэгжилтэд авч үзсэн асуудал өөр бусад хэрэгжилтийн заалтад шууд нөлөө үзүүлж болдог. Тухайлбал *Шууд хэрэгжилт 1* болон *Шууд хэрэгжилт 2-ын* доор үнэлэгдэх хүчин зүйлс болох

(а) тухайн улсын эрсдэлийн үнэлгээ, эрсдэлд суурилсан аргачлал, (б) олон улсын хамтын ажиллагаа, оролцоо гэсэн хүчин зүйлс нь бусад олон хүчин зүйлст нөлөөлнө (жн: эрсдэлийн үнэлгээ нь *Шууд үр дүн 4* эрсдэлд тулгуурласан арга хэмжээнд болон бусад эрх бүхий байгууллага өөрийн нөөцөө хэрхэн хуваарилж байгаад нөлөөлнө; олон улсын хамтын ажиллагаа нь дотоодын мөнгө угаах гэмт хэргийг мөрдөн шалгах болон хөрөнгө хураан авах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх *Хэрэгжилт 7 болон 8-д* нөлөөлнө). Ийм учраас *Шууд хэрэгжилт 1* болон *Шууд хэрэгжилт 2 нь бусад Шууд хэрэгжилтийн* үр дүнгийн түвшинд хэрхэн нөлөөлж болохыг мэддэг байх хэрэгтэй. Хоорондоо холбогдох асуудлуудыг *Шууд хэрэгжилт* тус бүрийн доор байх *Үнэлгээчдэд өгөх зааварчилгаанд* тусгаж өгсөн.

Үр дүнтэй байдлын талаар дүгнэлт хийх

59. Үнэлгээчид тухайн улс ямар үр дүнтэй (үр дүн муутай) байгааг Шууд хэрэгжилтийн заалт тус бүрээр дүгнэнэ. Тухайн улсыг үр дүн тааруу байгаа гэж дүгнэвэл үнэлгээчид ямар учраас дээрх дүгнэлт гаргах болсон шалтгааныг дурдаж үр дүнд хүрэхийн тулд чадавхийг бэхжүүлэх талаар зөвлөмж өгнө.

60. **Үр дүнтэй байдлыг үнэлэх нь зөвлөмжийн Техникийн хэрэгжилтийг үнэлэхээс үндсээрээ өөр зүйл юм.** Үнэлгээчид тухайн улсын хэрэгжилт ямар түвшинд байгааг үндэслэж үр дүнг үнэлнэ. **Үндсэн асуудлууд нь шалгууруудыг шалгах жагсаалт гэж ойлгож болохгүй** бөгөөд Шууд хэрэгжилтийн заалт тус бүрээр тухайн улс үр дүнтэй байгааг үнэлэхэд тус болох асуултын жагсаалт юм. Үндсэн асуудлуудын ач холбогдол нь бүгд ижил түвшинд байхгүй бөгөөд тухайн улсын нөхцөл байдал МУТС эрсдэл, холбогдох бүтцийн хүчин зүйлс зэргээс шалтгаалан улс орон бүрийн хувьд харилцан адилгүй ач холбогдолтой байна. Тийм учраас үнэлгээчид дүгнэлт хийхдээ уян хатан байж өөрсдийн үнэлэх чадвар, туршлага дээрээ тулгуурлах шаардлагатай.

61. Үнэлгээчдийн дүгнэлт нь тухайн хэрэгжилт үр дүнтэй байна уу үгүй юу гэдгийг л илэрхийлсэн байна. Үнэлгээчид нь өөрсдийн илүүд үздэг үр дүнд хүрэх хамгийн сайн арга зам болон өөрийн улсын туршлагын нөлөөг дүгнэлтэндээ хэт тусгахаас зайлсхийх хэрэгтэй. Мөн цөөн тооны дутагдал нь чухал ач холбогдолгүй болон бусад давуу талууд нь тухайн дутагдлыг нөхөх чадвартай улс орон өндөр түвшний үр дүнтэй байж болох тул үнэлгээчид тухайн илэрсэн цөөн тооны дутагдал, асуудалтай байгаа зүйлс дээр тулгуурлаж дүгнэлт гаргахаас зайлсхийх хэрэгтэй.

62. **Үнэлгээчдийн Үр дүнтэй байдлын дүгнэлт ерөнхий тайлбарлан бичсэн хэлбэртэй байна.**

Хэрэгжилтийг ерөнхийд нь ямар түвшинд байгааг, зарим нэг хэсэгт сайн, муу, хэлбэлзэлтэй байгааг онцлон тодорхой бичих шаардлагатай. Өөрсдийн дүгнэлт хийх болсон шалтгаан болон үр дүнг муу гэж гаргах болсон асуудалтай хэсэг болон сул талууд; чухал ач холбогдолтой Үндсэн асуудлууд, мэдээлэл; мэдээ мэдээллийг хэрхэн ашиглаж дүгнэсэн; үнэлгээний аль хэсэгт нь илүү ач холбогдол өгсөн зэргийг тодорхой тайлбарлах шаардлагатай. Мөн үнэхээр үр дүн сайтай байгаа болон бусад сайн засаглалын жишээ болох хэсгийг тодорхойлох шаардлагатай.

63. Үнэлгээчид нь хооронд нь харьцуулж болох, тодорхой үнэлгээ хийхийн тулд дүгнэлтээ зэрэглэл тогтоох хэлбэрээр гаргана. Шууд хэрэгжилтийн заалт тус бүрийг Үндсэн асуудлууд болон хэв шинжийг хэрхэн үр дүнтэй хэрэгжүүлж байгаагаар дөрвөн боломжит үнэлгээний зэрэглэлд ангилна. Үүнд: маш өндөр үр дүнтэй, өндөр үр дүнтэй, дунд зэргийн үр дүнтэй, бага зэргийн үр дүнтэй. Эдгээр зэрэглэлийг доорх зүйлсийг харгалзаж үзэсний үндсэн дээр гаргана.

Үр дүнтэй байдлын зэрэглэл	
Маш өндөр үр дүнтэй	Шууд хэрэгжилт бүрэн дүүрэн хэрэгжиж байгаа

	Сайжруулах зүйл бага зэрэг байж болно.
Өндөр үр дүнтэй	Шууд хэрэгжилт ихэнх тохиолдолд хэрэгжиж байгаа Сайжруулах зүйл байгаа.
Дунд зэргийн үр дүнтэй	Шууд хэрэгжилт зарим тохиолдолд хэрэгжиж байгаа Их хэмжээний сайжруулах зүйл байгаа.
Бага зэргийн үр дүнтэй	Шууд хэрэгжилт огт хэрэгжээгүй буюу маш бага тохиолдолд хэрэгжиж байгаа Үндсээр нь сайжруулах хэрэгтэй.

МУТСТ тогтолцоог сайжруулах зөвлөгөө

64. Үнэлгээчдийн тухайн улсад өгөх зөвлөмж нь хамтын үнэлгээний бас нэг чухал хэсэг юм. Өөрсдийн хийсэн үнэлгээний дүгнэлтийг үндэслэн тухайн улс орон үр дүнтэй байдал болон Техникийн хэрэгжилтийн түвшинг хэрхэн сайжруулж цаашид МУТСТ тогтолцоог бэхжүүлэх арга хэмжээний талаар зөвлөгөө өгнө. Зөвлөгөө нь тухайн улсын нөхцөл байдал, хүчин чадал, үр дүнтэй байгаа хэрэгжилтийн түвшин зэргийг харгалзан үзэж дутагдлыг засч сайжруулах зүйлс дээр гол анхаарлаа хандуулах шаардлагатай. Үнэлгээчдийн өгсөн зөвлөмж нь илрүүлсэн сул тал, дутагдал бүрт анхаарал хандуулах бус тухайн улсад тулгарч байгаа эрсдэлийг бууруулах хамгийн үр дүнтэй, нэн тэргүүнд хэрэгжүүлэх арга хэмжээг бий болгох талаар тусгасан байх хэрэгтэй. Хэрэв ач холбогдол өндөртэй, нэн түрүүнд хэрэгжүүлж болох бодит зөвлөмжийг санал болгосон тохиолдолд хялбар, өргөн хүрээг хамарсан үр дүнд хүрэх бололцоо бий болно.

65. МУТСТ тогтолцоо сайжруулах олон төрлийн арга замууд байдаг бөгөөд үнэлгээчдийн сонгон авсан арга зам нь тухайн үнэлүүж буй улсын нөхцөл байдалд тохирохгүй байх тохиолдол гарах магадлалтай тул зөвлөмжийг өгөхдөө тус улсын нөхцөл байдал, хууль, эрх зүйн болон төрийн байгууллагын тогтолцоог хянуур авч үзэх хэрэгтэй.

66. Авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулах зорилгоор үнэлгээчид нь зорилгодоо хүрэхийн тулд зайлшгүй хэрэгжүүлэх арга хэмжээний шаардлагатай хэсгийг тодорхой зааж өгөх шаардлагатай. Авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулахад түлхэц болохын тулд үнэлгээчид өөрсдийн зөвлөмжид авах арга хэмжээ болон яаралтай биелүүлэх үүрэг даалгаврыг хэрхэн биелүүлэх боломжтой эсэхийг тодорхой дурдаж оруулах. Харин зарим хэсэгт илүү уян хатан байж болох талаар тусгаж өгөх хэрэгтэй. Үнэлгээчид нь тухайн улсын зөвлөмжийн заалтыг өөрийн нөхцөлд бүрэн тохируулан хэрэгжүүлэх ажилд саад болохгүйн тулд хэт хатуу зөвлөмж өгөхөөс зайлсхийх шаардлагатай (жн: зарим арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаа тавих г.м).

67. Тухайн улсын үр дүнтэй байдлын түвшин өндөр байна гэдэг нь цаашид сайжруулах зүйлс байхгүй гэсэн үг биш бөгөөд учирч болох эрсдэлтэй үр дүнтэй тэмцэхийн тулд авах арга хэмжээ байж болно. Хэрвээ өндөр үр дүнтэй байгаа хэсэгт цаашид хэрэгжүүлж болох арга хэмжээг тодорхойлж чадвал үүнийгээ зөвлөгөөндөө тусгах шаардлагатай.

Тусламж авах

68. Хэрвээ үнэлгээчид аргачлалыг хэрхэн ашиглах, ФАТФ-ын стандартыг хэрхэн ойлгох талаар эргэлзээтэй зүйл гарвал ФАТФ-ын Нарийн бичгийн дарга нарын газар болон ФАТФ-ын төрлийн бүс нутгийн байгууллагын Нарийн бичгийн дарга нарын газарт хандаж болно.

ТЕХНИКИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ**ЗӨВЛӨМЖ 1****ЭРСДЭЛИЙГ ҮНЭЛЭХ, ЭРСДЭЛД СУУРИЛСАН АРГАЧЛАЛЫГ⁴ ХЭРЭГЖҮҮЛЭХ НЬ***УЛС ОРНУУДЫН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ БОЛОН ШИЙДВЭР ГАРГАЛТ**Эрсдэлийн үнэлгээ*

- 1.1 Улс орнууд⁵ өөрсдийн МУТС-тэй холбоотой эрсдэлийг тодорхойлж үнэлнэ.
- 1.2 Эрсдэлийг үнэлэх үйл ажиллагааг зохицуулах механизм болон гүйцэтгэх эрх бүхий байгууллагыг тодорхойлж өгнө.
- 1.3 Улс орнууд эрсдэлийн үнэлгээг тогтмол шинэчилж байна.
- 1.4 Улс орон эрсдэлийн үнэлгээний үр дүнгийн талаар холбогдох эрх бүхий байгууллагууд, сайн дурын зохицуулалттай байгууллагууд, санхүүгийн байгууллагууд болон СББМҮҮ нарыг мэдээллээр хангах тогтолцоотой байна.

Эрсдэлийг бууруулах

- 1.5 Тухайн улс орон нь эрсдэлийн тухай ойлголтод үндэслэн эрсдэлд суурилсан аргачлалыг ашиглан нөөцийг хуваарилах, МУТС-ээс урьдчилан сэргийлэх эсвэл бууруулах арга хэмжээ авна.
- 1.6 Санхүүгийн байгууллагууд болон СББМҮҮ нараас тодорхой арга хэмжээ авах шаардлага тавихдаа ФАТФ-ын зарим зөвлөмжүүдийг хамаарахгүй байхаар шийдсэн бол дараах нөхцөл бүрдсэнийг батлах шаардлагатай. Үүнд:
 - (a) МУТС эрсдэл бага гэдэг нь батлагдсан; хамаарахгүй байх нөхцөл нь заасан тодорхой төрлийн хязгаарт батлагдсан нөхцөлд үүсэх бөгөөд зөвхөн тодорхой төрлийн санхүүгийн байгууллага, үйл ажиллагаа эсвэл СББМҮҮ-д хамаарна.
 - (b) хувь хүн эсвэл хуулийн этгээд нь санхүүгийн үйл ажиллагааг (мөнгө, үнэ бүхий зүйл шилжүүлэхээс бусад) цөөн тохиолдолд хязгаарлагдмал хүрээнд хийгддэг тул МУТС эрсдэл бага байдаг.
- 1.7 Улс орнууд нь МУТС эрсдэл өндөр гэж тогтоовол МУТС-тэй тэмцэх тогтолцоо нь дараах зүйлийг шаардана. Үүнд: (a) санхүүгийн байгууллага болон СББМҮҮ нараас эрсдэлийг удирдах болон бууруулах талаар нэмэлт арга хэмжээ авах; эсвэл (b) санхүүгийн байгууллага болон СББМҮҮ нараас дээрх мэдээллийг эрсдэлийн үнэлгээнд нь оруулах.

⁴ Энэ зөвлөмжид тусгагдсан шаардлагуудыг бусад зөвлөмжид суурилан илүү нарийвлан авч үзэх хэрэгтэй. Илүү онцгой эрсдэлүүдийг Зөвлөмж 1-ийн дагуу үнэлгээ хийж буй үнэлгээчид нь бусад зөвлөмжүүдэд заасны дагуу улс орны, тодорхой санхүүгийн байгууллага/СББМҮҮ нарын эрсдэлийн үнэлгээ, эрсдэл бууруулах арга хэмжээний талаар ерөнхий дүнэлт хийх бөгөөд бусад зөвлөмжүүдэд заасан эрсдэлд суурилсан арга хэмжээний нарийвчилсан үнэлгээг давтахгүй. Үнэлгээчид нь улс орны эрсдэлийн үнэлгээнд гүнзгийрүүлсэн судалгаа хийхгүй. Үнэлгээчид нь тухайн улс орны эрсдэлийн үнэлгээндээ ашиглаж буй процесс, механизм, мэдээлийн эх үүсвэр, мөн бусад нөхцөл байдал, хийсэн үнэлгээ нь хэр бодитой байгаа зэрэгт анхаарлаа хандуулна.

⁵ Энэ үүрэг хэрэгжиж буй эсэхэд дүнэлт өгөхөд зарим тохиолдолд үндэсний хэмжээнд МУТС эрсдэлийн үнэлгээг анхаарч үзэх шаардлагатай болдог.

ФАТФ-ын зөвлөмжийн техникийн хэрэгжилт болон МУТСТ тогтолцооны үр дүнтэй байдлыг үнэлэх

- 1.8 Эрсдэл бага тохиолдолд, энэ нь тухайн улс орны өөрсдийн хийсэн эрсдэлийн үнэлгээтэй нийцэж байвал санхүүгийн байгууллага болон СББМҮҮ нарт ФАТФ-ын зарим зөвлөмжийн хялбаршуулсан арга хэмжээг хэрэгжүүлэхийг зөвшөөрч болно⁶.
- 1.9 Хянан шалгагч болон сайн дурын зохицуулалттай байгууллагууд нь санхүүгийн байгууллага болон СББМҮҮ нарт Зөвлөмж 1-ийн дагуу үүргээ хэрхэн биелүүлж байгаад хяналт тавина⁷.

САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА БОЛОН СББМҮҮ НАРЫН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ БОЛОН ШИЙДВЭР ГАРГАЛТ

Эрсдэлийн үнэлгээ

- 1.10 Санхүүгийн байгууллага болон СББМҮҮ нар нь өөрсдийн МУТС эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, таньж мэдэх (үүнд: харилцагч, улс орон, газар зүйн бүс нутаг, бүтээгдэхүүн, үйлчилгээ, гүйлгээ болон хүргэх сувгуудын)⁸ талаар дараах алхмуудыг хийх шаардлагатай. Үүнд:

- (a) Эрсдэлийн үнэлгээг баримтжуулах;
- (b) Эрсдэлийн ерөнхий түвшин, зохистой түвшин, эрсдэлийг бууруулах арга замыг тодорхойлохоос өмнө бүх холбогдох эрсдэлийн хүчин зүйлсийг анхаарч үзэх;
- (c) Эрсдэлийн үнэлгээг тогтмол шинэчилж байх;
- (d) Эрсдэлийн үнэлгээний үр дүнг холбогдох эрх бүхий байгууллагууд болон сайн дурын зохицуулалттай байгууллагуудад мэдэгдэх механизмтай байх.

Эрсдэлийг бууруулах

- 1.11 Санхүүгийн байгууллага болон СББМҮҮ нарт дараах шаардлагыг тавина. Үүнд:

- (a) Тодорхойлсон эрсдэлийг (санхүүгийн байгууллага, СББМҮҮ нарын түвшинд эсвэл улс орны хэмжээнд) удирдах, бууруулах боломжтой бодлого, журам, зааврыг бий болгож, дээд шатны удирдлагуудаар баталгаажуулсан байх;
- (b) Дээрх хяналтын хэрэгжилтийг хянах, шаардлагатай тохиолдолд сайжруулах;
- (c) Эрсдэл өндөр гэж тодорхойлогдсон бол эрсдэлийг удирдах, бууруулах талаар нэмэгдүүлсэн арга хэмжээг авах;

- 1.12 Зөвхөн МУТС эрсдэл бага бөгөөд 1.9-өөс 1.11 дүгээрт заасан шаардлагууд хангагдсан тохиолдолд санхүүгийн байгууллага болон СББМҮҮ нарт хялбаршуулсан арга хэмжээ авахыг зөвшөөрч болно. МУТС-тэй холбоотой ямар нэгэн таамаглал байгаа бол хялбаршуулсан арга хэмжээ авахыг зөвшөөрөхгүй.

⁶ ФАТФ зөвлөмжийн сайжруулсан, арга хэмжээ авах шаардлагатай өндөр эрсдэлтэй тохиолдолд улс орнууд нь тухайн арга хэмжээг зайлшгүй авах шаардлагатай бөгөөд эрсдэлийн түвшингээс хамаарч хамрах хүрээг өөрөөр тогтоож болно.

⁷ Энэ заалтад тавигдсан шаардлагын хэрэгжилтийг Зөвлөмж 26 болон 28-ын үр дүнтэй холбож үнэлнэ.

⁸ МУТС эрсдэлийн үнэлгээний мөн чанар, цар хүрээ нь тухайн бизнесийн мөн чанар, хэмжээнээс хамаарна. Санхүүгийн байгууллага болон СББМҮҮ нь тухайн секторын суурь эрсдэлийг тодорхойлж, өөрийн МУТС эрсдэлийн талаар сайн ойлголттой тохиолдолд эрх бүхий байгууллага эсвэл Сайн дурын зохицуулалттай байгууллагууд нь өөрсдийн эрсдэлийн үнэлгээ хийхийг шаардахгүй байж болно.

ЗӨВЛӨМЖ 2**ҮНДЭСНИЙ ХАМТЫН АЖИЛЛАГАА БОЛОН УЯЛДАА ХОЛБОО**

- 2.1 Улс орнууд нь тодорхойлсон эрсдэлд суурилсан үндэсний хэмжээний МУТС-тэй тэмцэх бодлоготой байх бөгөөд тогтмол шинэчилж байх хэрэгтэй.
- 2.2 Улс орон нь үндэсний хэмжээний МУТС-тэй тэмцэх бодлогыг хариуцах эрх бүхий байгууллага, холбогдох зохицуулалт болон бусад механизмыг бий болгоно.
- 2.3 Энэ механизм нь бодлого тодорхойлогчид, Санхүүгийн мэдээллийн алба (СМА), хууль хэрэгжүүлэх байгууллага, хянан шалгагчид болон бусад эрх бүхий байгууллагууд нь МУТС-тэй тэмцэх бодлого болон үйл ажиллагааны хэрэгжилт, боловсруулалт дээр хамтран ажиллуулахаар зохицуулагдсан байх бөгөөд бодлого тодорхойлох болон үйл ажиллагааны түвшинд хэрэгжүүлнэ.
- 2.4 Эрх бүхий байгууллагууд нь үй олноор нь хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх асуудлаар дээр дурдсантай ижил хамтран ажиллах, зохицуулах механизмтай байна.

ЗӨВЛӨМЖ 3**МӨНГӨ УГААХ ГЭМТ ХЭРЭГ**

- 3.1 Улс орнууд мөнгө угаах үйл ажиллагааг Венийн болон Палермогийн конвенцийн (Венийн Конвенцийн 3(1)(b),(c) заалтууд, мөн Палермогийн Конвенцийн 6(1) заалтыг харна уу)⁹ дагуу гэмт хэрэгт тооцно.
- 3.2 Олон төрлийн суурь гэмт хэргийг хамруулах зорилгоор МУ-тай холбоотой суурь гэмт хэрэгт бүх хүнд гэмт хэргийг хамруулна. Хамгийн багадаа суурь гэмт хэрэг нь тогтоосон гэмт хэргийн төрлүүд дэх зүйл анги тус бүрийг хамарсан байна¹⁰.
- 3.3 Босго аргачлал¹¹ эсвэл босго аргачлалыг багтаасан холимог аргачлал ашигладаг улс орнуудын хувьд суурь гэмт хэрэг нь хамгийн багадаа дараах бүх хэргийг хамарсан байх шаардлагатай. Үүнд:
- (a) Дотоодын хууль тогтоомжийн дагуу хүнд гэмт хэрэгт тооцогддог гэмт хэрэг;
 - (b) Ялын дээд хэмжээ нь нэг жилээс дээш хугацаагаар хорих шийтгэл оногдуулдаг гэмт хэргүүд;
 - (c) Ялын доод хэмжээ нь зургаан сараас дээш хугацаагаар хорих шийтгэл оногдуулдаг гэмт хэргүүд (хуулиндаа гэмт хэрэгт тооцогдох доод босго тавьдаг улс орнуудын хувьд).
- 3.4 МУ гэмт хэрэг нь мөнгөн дүнгээс нь үл хамааран шууд болон шууд бусаар гэмт хэрэг үйлдэн олсон бүх төрлийн хууль бус орлогод хамаарна.
- 3.5 Тухайн өмч хөрөнгө нь гэмт хэрэг үйлдэж олсон орлого гэдгийг тогтооход тухайн этгээд нь заавал мөнгө угаах суурь гэмт хэргээр яллагдсан байх шаардлагагүй.
- 3.6 Гэмт үйлдэл нь өөр улсад үйлдэгдсэнийг тухайн гэмт хэрэг үйлдэгдсэн улс нь гэмт хэрэгт тооцдог бол, хэрэв дээрх үйлдэл нь тухайн улсад үйлдэгдсэн бол суурь гэмт хэрэгт тооцогдох бол мөнгө угаах суурь гэмт хэрэгт хамруулна.
- 3.7 Дотоодын хууль тогтоомжийн үндсэн зарчимтай харшлаагүй бол МУ гэмт хэрэг нь суурь гэмт хэрэг үйлдсэн хувь хүнд хамаарна.
- 3.8 МУ гэмт хэргийг нотлоход шаардагдах мэдээллийг бодит, объектив нөхцөл байдлаас гаргаж авах боломжтой байх.
- 3.9 Үйлдсэн гэмт хэрэгт тохирсон, дахин үйлдэхээс сэргийлсэн шийтгэлийг МУ гэмт хэрэг үйлдсэн хувь хүнд оногдуулна.
- 3.10 Хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол (дотоодын хууль тогтоомжийн үндсэн зарчмын дагуу) иргэний болон захиргааны хариуцлага оногдуулна. Энэ нь олон төрлийн хариуцлага оноох боломжтой улс оронд иргэний эсвэл хуулийн

⁹ Гэмт хэргийн биет болон материаллаг шинж чанарын талаар анхаарах.

¹⁰ Зөвлөмж 3 нь улс орнуудыг "зохион байгуулалттай гэмт бүлэглэлт оролцох болон дарамтлах" гэсэн гэмт хэргийн зүйл анги тусгайлан үүсгэхийг шаарддаггүй. Энэ зүйл ангийг хамрахын тулд улс орнууд нь Палермогийн конвенцид заасан хоёр хувилбараас (гэмт хэргийн зүйл анги тусгайлан үүсгэх эсвэл хуйвалдаанд үндэслэсэн гэмт хэрэгт багтаах) аль нэгийг нь хангаж байхад хангалттай юм.

¹¹ Улс орнууд нь дараах зүйлст үндэслэн МУ гэмт хэргийн суурь гэмт хэргийг тодорхойлдог: (a) бүх гэмт хэрэг, (b) хүнд гэмт хэргийн зүйл анги эсвэл суурь гэмт хэрэгт оногдуулах хорих шийтгэлтэй холбоотой босго (босго аргачлал), (c) суурь гэмт хэргийн жагсаалт, (d) эдгээр аргуудыг холимог хэлбэр.

ФАТФ-ын зөвлөмжийн техникийн хэрэгжилт болон МУТСТ тогтолцооны үр дүнтэй байдлыг үнэлэх

этгээдэд хамаарах захиргааны журмаар давхар хариуцлага хүлээлгэхэд саад болох ёсгүй. Эдгээр арга хэмжээ нь хувь хүнийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх үндэс болохгүй байх. Бүх шийтгэл нь үйлдсэн гэмт хэрэгт тохирсон, дахин үйлдэхээс сэргийлсэн байх шаардлагатай.

- 3.11 Дотоодын хууль тогтоомжийн үндсэн зарчмын дагуу хориглоогүй бол МУ гэмт хэрэгт оролцсон, хамтран зохион байгуулсан, үйлдэхийг завдсан, дэмжлэг үзүүлсэн, нөхцөл бололцоогоор хангаж өгсөн, захиалсан, зөвлөгөө мэдээллээр хангасан үйлдлүүд нь гэмт хэрэгт тооцогдох шаардлагатай.

ЗӨВЛӨМЖ 4**ХӨРӨНГӨ ХУРААН АВАХ БОЛОН ТҮР ЗУУРЫН АРГА ХЭМЖЭЭ**

- 4.1 Улс орнууд нь гэмт хэрэгт сэжиглэгдэж байгаа этгээд эсвэл гуравдагч этгээдээс хуулийн дагуу дараах хөрөнгийг хураах арга хэмжээ авах эрхтэй байна. Үүнд:
- (a) Угаагдсан хөрөнгө;
 - (b) Орлого (тухайн орлогоос олсон орлого болон бусад үр ашиг), мөнгө угаах болон суурь гэмт хэрэгт ашигласан, ашиглахаар завдсан хэрэгсэл;
 - (c) Террорист үйлдэл эсвэл террорист үйл ажиллагаа, терроризмыг санхүүжүүлэх зорилгоор ашигласан, ашиглахаар завдсан үйл ажиллагаанаас олсон хөрөнгө;
 - (d) Үнийн дүнтэй тэнцэхүйц хөрөнгө.
- 4.2 Улс орнууд нь эрх бүхий байгууллагыг дараах үйл ажиллагаа явуулахад зориулсан хуулийн дагуу зөвшөөрөгдсөн арга хэмжээг авах эрхээр хангана. Үүнд:
- (a) Хураан авах хөрөнгийг олж тогтоох, тодорхойлох болон үнэлэх;
 - (b) Хураан авах хөрөнгийг арилжих, шилжүүлэх, устаж үгүй болохоос урьдчилан сэргийлэх зорилгоор хөрөнгийг царцаах, хурааж авах түр зуурын арга хэмжээ авах¹²;
 - (c) Улс орон нь хураан авах хөрөнгийг царцаах, битүүмжлэх, олж илрүүлэх боломжийг алдагдуулах үйлдэл гаргахгүй байх, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах;
 - (d) Тухайн нөхцөлд тохирсон шаардлагатай мөрдөн шалгах арга хэмжээ авах.
- 4.3 Хууль болон бусад арга хэмжээ нь гэм зэмгүй гуравдагч этгээдийн (bona fide) эрхийг хамгаалсан байх.
- 4.4 Улс орон нь царцаасан, битүүмжилсэн, хураан авсан хөрөнгийг зохицуулах, шаардлагатай бол захиран зарцуулах механизмтай байна.

¹² Улс орны хууль тогтоомжийн үндсэн зарчимд харшлаагүй тохиолдолд арга хэмжээ нь ex-parte нөхцлөөр эсвэл урьдчилан мэдэгдэхгүйгээр хураан авсан хөрөнгийг царцаах, битүүмжлэх эрх олгох ёстой.

ЗӨВЛӨМЖ 5**ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ГЭМТ ХЭРЭГ**

- 5.1 Улс орнууд нь Терроризмыг санхүүжүүлэхийн эсрэг конвенцийн¹³ дагуу ТС үйл ажиллагааг гэмт хэрэгт тооцно.
- 5.2 ТС гэмт хэрэг нь тухайн хөрөнгө бүтнээрээ эсвэл хэсэгчлэн а) террорист үйл ажиллагаа явуулахад; б) террорист байгууллага эсвэл террорист хувь хүн (тодорхой террорист үйл ажиллагаатай холбоогүй ч гэсэн)-нд зориулагдахыг мэдсээр байж ямар нэгэн арга замаар цуглуулсан, өгсөн, шууд болон шууд бусаар хөрөнгө бий болгосон хувь хүнд хамаарна.¹⁴
- 5.3 ТС гэмт хэрэг нь хууль ёсны болон хууль бус эх үүсвэрээс бий болсон бүх хөрөнгөд хамаарна.
- 5.4 ТС гэмт хэрэгт тооцохын тулд тухайн хөрөнгө нь а) террорист үйл ажиллагаа болон оролдлого; эсвэл б) тодорхой нэгэн террорист үйл ажиллагаатай холбоотой байх шаардлагагүй.
- 5.5 ТС гэмт хэргийг нотлоход шаардагдах зорилго, санаатай үйлдлийн талаарх дүгнэлтийг бодит, объектив нөхцөл байдлаас гаргаж авах боломжтой байх.
- 5.6 Гэмт хэрэгт тохирсон, дахин үйлдэхээс сэргийлсэн шийтгэлийг ТС гэмт хэрэг үйлдсэн хувь хүнд оногдуулна.
- 5.7 Терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэгт хуулийн этгээдийг хамруулах шаардлагатай. Хэрэв боломжгүй бол (дотоодын хууль тогтоомжийн суурь зарчмаас болж) иргэний болон захиргааны хариуцлага хүлээлгэх шаардлагатай. Тухайн оронд олон төрлийн хариуцлагын тогтолцоо байдаг бол хуулийн этгээдэд терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэгт холбогдуулан эрүүгийн хариуцлага хүлээлгэх нь иргэний болон захиргааны журмаар давхар хариуцлага хүлээлгэхээр хэрэг үүсгэхэд саад болох ёсгүй. Бүхий л ял шийтгэл нь тухайн гэмт хэрэгт тохирсон болон дахин үйлдэхээс сэргийлсэн байх шаардлагатай.
- 5.8 Дараах үйлдлүүдийг мөн гэмт хэрэгт тооцох шаардлагатай. Үүнд:
- (a) ТС гэмт хэрэг үйлдэхийг завдах,
 - (b) ТС гэмт хэрэг үйлдэх эсвэл ТС гэмт хэрэг үйлдэхийг завдахад хамтран оролцох,
 - (c) ТС гэмт хэрэг үйлдэх эсвэл ТС гэмт хэрэг үйлдэхийг завдахад бусдыг өдөөн хатгах эсвэл зохион байгуулах,
 - (d) Нэгдмэл зорилготой бүлэг хүмүүсийн нэг буюу түүнээс олон тооны ТС гэмт хэрэг үйлдэх болон үйлдэхийг завдахад хувь нэмэр оруулах¹⁵.
- 5.9 ТС гэмт хэрэг нь МУ гэмт хэргийн суурь гэмт хэрэгт тооцогдох шаардлагатай.

¹³ Терроризмыг санхүүжүүлэхийн эсрэг олон улсын конвенцийн 2 дугаар заалттай нийцэж байх ёстой.

¹⁴ Зөвхөн туслалцаа дэмжлэг үзүүлсэн, завдсан, хуйвалдсан зэрэг үндслэлээр ТС гэмт хэрэгт тооцох нь зөвлөмжийг биелүүлэхэд хангалтгүй юм.

¹⁵ Эдгээр хувь нэмэр нь зорилготойгоор хийгдсэн байх бөгөөд i) тус бүлэглэлийн ТС гэмт хэрэгт хүргэх зорилго болон үйл ажиллагааг дэмжих ; ii) тус бүлэглэл нь ТС гэмт хэрэг үйлдэхийг мэдсээр байж хувь нэмэр оруулсан байх ёстой.

ФАТФ-ын зөвлөмжийн техникийн хэрэгжилт болон МУТСТ тогтолцооны үр дүнтэй байдлыг үнэлэх

- 5.10 ТС гэмт хэрэг нь тухайн этгээдийн гэмт хэрэгт сэжиглэгдсэн улс орон нь террорист/ террорист байгууллага байрлаж байгаа эсвэл террорист үйл ажиллагаа үйлдэгдсэн/ үйлдэгдэж болзошгүй улс орноос өөр эсвэл ижил байхаас үл хамаарна.

ЗӨВЛӨМЖ 6**ТЕРРОРИЗМ БОЛОН ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ
ГЭМТ ХЭРЭГТЭЙ ХОЛБООТОЙ ЗОРИЛТОТ САНХҮҮГИЙН
ХОРИГ АРГА ХЭМЖЭЭНҮҮД**

Тодорхойлох, хориг арга хэмжээний жагсаалтад оруулах

6.1 НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн 1267/1989 ("Аль-Каида") болон 1988 хориг арга хэмжээний тогтоолуудын дагуу (цаашид "НҮБ-ын хориг арга хэмжээний тогтоол гэх) улс орнууд нь дараах арга хэмжээг авна. Үүнд:

- (a) Хувь хүн эсвэл хуулийн этгээдийг 1267/1989 болон 1988 оны хорооны хориг арга хэмжээний жагсаалтад оруулахаар санал болгох, эрх бүхий байгууллага эсвэл шүүх байгууллагыг тодорхойлно;
- (b) НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн холбогдох тогтоолуудад заасан хориг арга хэмжээний жагсаалтад оруулах шалгуурт үндэслэсэн жагсаалтад оруулах этгээдийг тодорхойлох механизмтай байна;
- (c) Хориг арга хэмжээний жагсаалтад оруулах санал гаргах эсэхийг тогтоохдоо "үндэслэлтэй" эсвэл "хангалттай үндэслэлтэй" гэдгийг баримтжуулан баталгаажуулах стандарттай байна. Жагсаалтад оруулах санал нь гэмт хэргийг мөрдөн шалгах үйл ажиллагаа явагдаж байгаа эсэхээс хамаарах ёсгүй;
- (d) Хориг арга хэмжээний жагсаалтад оруулахдаа холбогдох хороодын (1267/1989 хороо эсвэл 1988 хороо) баталсан журмыг мөрдөх бөгөөд стандарт маягтуудыг хэрэглэх;
- (e) Жагсаалтад оруулахаар санал болгож буй этгээдийн нэрний талаар шаардлагатай мэдээллээр аль болох бүрэн дүүрэн хангаж өгөх¹⁶, гэмт хэргийн дэлгэрэнгүй тайланг¹⁷ жагсаалтад оруулах болсон шалтгааны хамтаар гаргаж өгөх¹⁸, мөн (1267/1988 хороонд нэр санал болгож байгаа тохиолдолд) жагсаалтад оруулахаар санал өгсөн улс орны статусыг дэлгэж болох эсэхийг тодорхойлсон байх.

6.2 Улс орнууд НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн тогтоол 1373 тогтоолын дагуу дараах холбогдох арга хэмжээ авна. Үүнд:

- (a) НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн тогтоол 1373-т тусгасан тусгай шалгууруудын дагуу хувь хүн эсвэл байгууллагыг өөрийн улс орны санаачлагаар эсвэл өөр улсаас ирсэн холбогдох хүсэлтийг хянаж шалгасны үр дүнд шаардлагатай гэж үзсэн тохиолдолд жагсаалтад оруулахаар санал болгох эрх бүхий байгууллага эсвэл шүүх байгууллагыг тодорхойлох;

¹⁶ Тухайлбал хувь хүн, бүлэг, аж ахуйн нэгж, этгээдүүдийг зөв, баталгаатай таньж мэдэхэд хангалттай мэдээлэл мөн боломжтой хэмжээгээр Интерполд Тусгай Мэдэгдэл гаргахад шаардагдах мэдээлэл.

¹⁷ Гэмт хэргийн дэлгэрэнгүй тайланг гишүүн орны зүгээс холбогдох хороонд (1267/1989 хороо эсвэл 1988 хороо) өгөхдөө нууц гэж заасан хэсгээс бусад хэсэг нь хүсэлт гаргасан тохиолдолд гаргаж өгөх боломжтой байна.

¹⁸ Үүний дотор: хувь хүн, этгээд нь жагсаалтад оруулах санал өгөхөд шаардлага хангасан гэдгийг нотлох тодорхой мэдээлэл; мэдээллийн шинж чанар; дагалдах мэдээлэл болон батлах баримт бичиг; санал болгож буй этгээд болон одоогийн байдлаар жагсаалтад байгаа этгээд хооронд ямар нэгэн холбоо, хамаарал байгаа бол энэ талаарх бүхий л дэлгэрэнгүй мэдээлэл.

- (b) НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн тогтоол 1373-т заасан жагсаалтад оруулах шалгуурт үндэслэн жагсаалтад оруулах этгээдийг тодорхойлох механизмтай байх¹⁹;
- (c) Хүсэлт хүлээн аваад цаг алдалгүй тухайн хүсэлт нь шаардлага хангаж байгаа эсэх, тухайн үндэстний (үндэстэн дамнасан) тогтоосон зарчмуудын дагуу сэжиглэх "үндэслэлтэй" эсвэл "хангалттай үндэслэлтэй" байгаа эсэх болон НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн тогтоол 1373-т тусгасан жагсаалтад оруулах санал гаргах тусгай шалгууруудыг хангасан эсэхийг тодорхойлно;
- (d) Жагсаалтад оруулах санал гаргахдаа "үндэслэлтэй" эсвэл "хангалттай үндэслэлтэй" гэдгийг баримтжуулан баталгаажуулах стандартыг ашиглах²⁰. Жагсаалтад оруулах санал нь гэмт хэргийг мөрдөн шалгах үйл ажиллагаа явагдаж байгаа эсэхээс хамаарах ёсгүй;
- (e) Хөрөнгө царцаах механизмын дагуу авах арга хэмжээг хэрэгжүүлэхдээ бусад улс оронд хүсэлт гаргах тохиолдолд хэргийн талаар боломжит бүх мэдээлэл болон жагсаалтад оруулах саналын үндэслэлийг баталсан тусгай мэдээлэл өгөх;

6.3 Эрх бүхий байгууллага нь дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэх хуулиар олгогдсон эрх, холбогдох журам, заавар, механизмтай байна. Үүнд:

- (a) Сэжиглэх үндэслэлтэй, "хангалттай үндэслэлтэй" эсвэл хориг арга хэмжээний жагсаалтад оруулахад шаардлага хангасан гэж үзсэн хувь хүн, хуулийн этгээдийг тодорхойлохын тулд мэдээлэл цуглуулах, гаргуулж авах;
- (b) Тодорхойлогдсон болон хориг арга хэмжээний жагсаалтад оруулахаар судлагдаж буй хувь хүн, хуулийн этгээдийн эсрэг бие даасан хараат бус /ex parte/ арга хэмжээ авах;

Хөрөнгө царцаах

6.4 Улс орнууд нь зорилтот санхүүгийн хориг арга хэмжээнүүдийг хугацаа алдалгүй авах шаардлагатай²¹.

6.5 Улс орнууд дараах стандарт, журмын дагуу зорилтот санхүүгийн хориг арга хэмжээг хэрэглэх, хэрэгжүүлэх шүүх болон дотоодын эрх бүхий байгууллагыг томилно. Үүнд:

- (a) Улс орнууд нь хориг арга хэмжээний жагсаалтад орсон хувь хүн болон хуулийн этгээдийн хөрөнгийг хугацаа алдалгүй, урьдчилан мэдэгдэлгүйгээр царцаахыг шаардах эрхтэй;
- (b) Хөрөнгө царцаах зорилго нь дараах хөрөнгөд хамаарна (i) жагсаалтад орсон хувь хүн, хуулийн этгээдийн эзэмшиж буй болон хяналтад байгаа бүх мөнгөн болон бусад

¹⁹ Үүнд НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн шийдвэр 1373 (2001)-ийн хөрөнгө царцаах механизмын дагуу бусад улс орны эхлүүлсэн үйл ажиллагааг шалгаж үзэж шаардлагатай үед хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага, хүчин төгөлдөр журам, заавар болон механизмтай байх асуудал хамаарна.

²⁰ Улс орнууд нь хувь хүн, хуулийн этгээдийг жагсаалтад оруулахаар тодорхойлоход "үндэслэлтэй" эсвэл "хангалттай үндэслэлтэй" гэснийг тодорхойлох баримтуудын төрөл, хэмжээг заасан, мөн хөрөнгө царцаах механизмын дагуу үйл ажиллагаа эхлүүлэх өөрийн хууль зүйн стандарттай байна. Энэ нь хэрэг жагсаалтад оруулахаар өгсөн санал нь тухайн улс орны өөрийн эсвэл бусад улс орны санаачлагаар хийгдсэнээс үл хамаарна.

²¹ НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн шийдвэр 1373-ын хувьд цаг алдалгүй арга хэмжээ авах үүрэг нь улс орон нь өөрсдийн санаачилгаар эсвэл бусад улс орны хүсэлтээр холбогдох хууль зүйн зарчмын дагуу сэжиглэх үндэслэлтэй бөгөөд НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн шийдвэр 1373-т заасан шалгуурыг хангасан гэж үзсэн тохиолдолд бусад улс орны хүсэлтээр, үндэстэн дамнасан/үндэстний хэмжээнд арга хэмжээ авахтай холбоотой юм.

хөрөнгө; эдгээр нь зөвхөн тодорхой нэгэн террорист үйлдэл, завдал болон аюул заналхийлэлтэй холбоотой хөрөнгөөр хязгаарлагдахгүй, (ii) жагсаалтад орсон хувь хүн, хуулийн этгээдийн бүтнээр нь буюу тодорхой хувийг нь шууд болон шууд бусаар эзэмшиж эсвэл хяналтад буй хөрөнгө, (iii) жагсаалтад орсон хувь хүн, хуулийн этгээдийн шууд болон шууд бусаар эзэмшиж эсвэл хяналтад буй хөрөнгөнөөс үүссэн хөрөнгө, (iv) жагсаалтад орсон хувь хүн, хуулийн этгээдийн нэрийн өмнөөс эсвэл зааврын дагуу үйл ажиллагаа явуулж буй хувь хүн, хуулийн этгээдийн хөрөнгө;

(c) НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн тогтоолуудын дагуу тусгай зөвшөөрөлтэй, тусгай эрх олгогдсон эсвэл өөр байдлаар мэдэгдсэнээс бусад нөхцөлд улс орнууд нь өөрсдийн харьяат эсвэл²² өөрсдийн хууль зүйд захирагдаж буй хуулийн этгээдэд мөнгөн болон бусад хөрөнгө, эдийн засгийн эх үүсвэр, санхүүгийн болон бусад холбогдох үйлчилгээгээр жагсаалтад орсон хувь хүн, хуулийн этгээд; жагсаалтад орсон хувь хүн, хуулийн этгээдийн шууд болон шууд бусаар эзэмшиж эсвэл хянаж буй хуулийн этгээд; жагсаалтад орсон хувь хүн, хуулийн этгээдийн нэрийн өмнөөс эсвэл зааврын дагуу нь үйл ажиллагаа явуулж буй хувь хүн, хуулийн этгээдийг шууд болон шууд бусаар, бүтнээр эсвэл хэсэгчлэн хангахыг хориглох шаардлагатай;

(d) Улс орнууд нь жагсаалтад орсон этгээдийн талаар санхүүгийн салбарт болон СББМҮҮ нарт цаг алдалгүйгээр мэдээлэл дамжуулах, мөн зорилгод хөрөнгийг хадгалж байж болзошгүй СББМҮҮ нар гэх мэт санхүүгийн байгууллага болон хувь хүмүүст хөрөнгө царцаах механизмын дагуу арга хэмжээ авах үүргийн талаар тодорхой зааварчилгаа өгөх механизмтай байх шаардлагатай;

(e) Улс орнууд нь санхүүгийн байгууллага болон СББМҮҮ нарыг гүйлгээ хийх оролдлого болон хөрөнгө царцаасан, эсвэл НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн тогтоолуудын хориглох шаардлагын дагуу авсан аливаа арга хэмжээний талаар эрх бүхий байгууллагад мэдээлэхийг шаардах шаардлагатай;

(f) Улс орнууд нь Зөвлөмж 6-д заасан үүргээ биелүүлэхдээ гэм буруугүй гуравдагч этгээдийн эрх (bona fide)-ийг хамгаалах механизмтай байх шаардлагатай.

Жагсаалтаас гаргах, царцаасан хөрөнгийг чөлөөлөх, царцаасан хөрөнгө болон бусад хөрөнгийг ашиглах эрх олгох

6.6 Улс орнууд нь хориг арга хэмжээний жагсаалтад оруулах шалгуур нөхцөл үгүй болсон тохиолдолд хувь хүн, хуулийн этгээдийг жагсаалтаас гаргах, царцаасан хөрөнгийг суллах талаар олон нийтэд танигдаж мэдэгдсэн журамтай байх шаардлагатай. Үүнд:

(a) НҮБ-ын хориг арга хэмжээний тогтоолуудын дагуу жагсаалтад орсон хувь хүн, хуулийн этгээдийг улс орны дүгнэлтийн дагуу жагсаалтад орох шалгуур нөхцөл үгүй болсон тохиолдолд НҮБ-ын холбогдох хороонд тус хувь хүн, хуулийн этгээдийг жагсаалтаас хасах хүсэлт гаргах журам. Эдгээр журам болон шалгуурууд нь 1267/1989 хороо эсвэл 1988 хорооны баталсан журмуудтай нийцсэн байх шаардлагатай²³;

(b) НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн 1373 тогтоолын дагуу хориг арга хэмжээний жагсаалтад орсон хувь хүн, хуулийн этгээдийг жагсаалтад орох шалгуур нөхцөл үгүй

²² зөвхөн энэ тохиолдолд "эсвэл" гэдэг нь улс орон нь өөрсдийн харьяат болон өөрсдийн хууль зүйд захирагдаж буй этгээдэд аль алинд нь хориглоно гэсэн утгатай болно.

²³ 1267/1989 хорооны журмууд нь НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн шийдвэр 1730, 1735, 1822, 1904, 1989, 2083-д болон уламжлан гарсан бусад шийдвэрүүдэд тусгагдсан. 1988 хорооны журмууд нь НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн шийдвэр 1730, 1735, 1822, 1904, 1989, 2082-д болон уламжлан гарсан бусад шийдвэрүүдэд тусгагдсан

болсон тохиолдод жагсаалтаас хасах болон царсаасан хөрөнгийг суллах эрх бүхий байгууллага, журам, механизм;

(с) НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн 1373 тогтоолын дагуу хориг арга хэмжээний жагсаалтад орсон хувь хүн, хуулийн этгээдийн хувьд хүсэлт гаргасан тохиолдолд, шүүх болон бусад эрх бүхий бие даасан байгууллага жагсаалтад оруулах шийдвэрийг эргэн харах боломж олгох журам;

(d) НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн 1988 тогтоолын дагуу хориг арга хэмжээний жагсаалтад орсон хувь хүн, хуулийн этгээдийн хувьд 1988 хорооны түүнчлэн НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн 1970 тогтоолын дагуу байгуулсан Зохицуулалтын механизмын баталсан холбогдох заавар, журмын дагуу тогтоолыг эргэн харах явцыг хялбарчлах журам;

(e) "Аль Каида"-гийн хориг арга хэмжээний жагсаалтын хувьд НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн тогтоол 1904, 1989 болон 2082-ын дагуу НҮБ-ын Эрх бүхий төлөөлөгчийн газарт жагсаалтаас хасах хүсэлт гаргах боломж байгааг тухайн жагсаалтад орсон хувь хүн, хуулийн этгээдэд мэдэгдэх журам;

(f) Жагсаалтад орсон хувь хүн, хуулийн этгээдтэй ижил, төстэй нэртэй хувь хүн, хуулийн этгээдийн андуурагдан царцаасан хөрөнгийг тухайн хувь хүн, хуулийн этгээд нь жагсаалтад орсон хувь хүн, хуулийн этгээд биш гэдгийг баталсны дараа чөлөөлөх, нийтэд мэдээлэх журам;

(g) Улс орон нь хориг арга хэмжээний жагсаалтаас хасах, хөрөнгийг суллах тогтоолын талаар санхүүгийн салбар болон СББМҮҮ нарт цаг алдалгүйгээр мэдээлэл дамжуулах, мөн зорилтот хөрөнгийг хадгалж байж болзошгүй СББМҮҮ нар гэх мэт санхүүгийн байгууллага болон хувь хүмүүст жагсаалтаас хасах, хөрөнгийг суллах тогтоолын дагуу арга хэмжээ авах үүргийн талаар тодорхой зааварчилгаа өгөх механизмтай байх шаардлагатай.

6.7 Улс орнууд нь НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн 1452 тогтоол болон түүнээс урган гарсан тогтоолуудын дагуу зайлшгүй хэрэгцээний зардал, тодорхой төрлийн хураамж, үйлчилгээний хөлс төлөх болон төлөвлөгдөөгүй зардалд зориулсан хөрөнгийг зарцуулах эрх олгох шаардлагатай. Үүнтэй ижил үндэслэлээр улс орнууд нь НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн 1373 тогтоолын дагуу үндэстэн, (үндэстэн дамнасан) тогтоолоор хориг арга хэмжээний жагсаалтад орсон хувь хүн, хуулийн этгээдэд царцаасан хөрөнгийг ашиглах эрх олгох шаардлагатай.

ЗӨВЛӨМЖ 7**ҮЙ ОЛНООР ХӨНӨӨХ ЗЭВСЭГ ДЭЛГЭРҮҮЛЭХТЭЙ ХОЛБООТОЙ САНХҮҮГИЙН ЗОРИЛТОТ ХОРИГ АРГА ХЭМЖЭЭНҮҮД**

7.1 Улс орнууд нь НҮБ-ын дүрмийн 7 дугаар бүлэгт заасны дагуу НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн баталсан үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон түүнийг санхүүжүүлэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоохтой холбоотой тогтоолуудыг хэрэгжүүлэхийн тулд цаг алдалгүйгээр санхүүгийн зорилтот хориг арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх шаардлагатай²⁴.

7.2 Дараах стандарт, журмын дагуу улс орнууд нь зорилтот санхүүгийн хориг арга хэмжээг хэрэглэх, хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагыг хуулийн хүрээнд томилно. Үүнд:

- (a) Улс орнууд нь өөрийн улс орны бүх хувь хүн, хуулийн этгээдээс хориг арга хэмжээний жагсаалтад орсон хувь хүн, хуулийн этгээдийн мөнгөн болон бусад хөрөнгийг цаг алдалгүйгээр, урьдчилан мэдэгдэхгүйгээр царцаахыг шаардана;
- (b) Хөрөнгө царцаах үүрэг нь дараах хөрөнгөд хамаарна (i) жагсаалтад орсон хувь хүн, хуулийн этгээдийн эзэмшиж буй болон хяналтад байгаа бүх мөнгөн болон бусад хөрөнгө, эдгээр нь зөвхөн тодорхой нэгэн үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх үйлдэл, завдал болон аюул заналхийлэлтэй холбоотой хөрөнгөөр хязгаарлагдахгүй, (ii) жагсаалтад орсон хувь хүн, хуулийн этгээдийн бүтнээр нь буюу тодорхой хувийг нь шууд болон шууд бусаар эзэмшиж эсвэл хяналтад буй хөрөнгө, (iii) жагсаалтад орсон хувь хүн, хуулийн этгээдийн шууд болон шууд бусаар эзэмшиж эсвэл хяналтад буй хөрөнгөнөөс үүссэн хөрөнгө, (iv) жагсаалтад орсон хувь хүн, хуулийн этгээдийн нэрийн өмнөөс эсвэл зааврын дагуу үйл ажиллагаа явуулж буй хувь хүн, хуулийн этгээдийн хөрөнгө;
- (c) НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн тогтоолуудын дагуу тусгай зөвшөөрөлтэй, тусгай эрх олгогдсон эсвэл өөр байдлаар мэдэгдсэнээс бусад нөхцөлд улс орнууд нь өөрсдийн харьяат эсвэл өөрсдийн хууль зүйд захирагдаж буй хуулийн этгээдэд мөнгөн болон бусад хөрөнгө, эдийн засгийн эх үүсвэр, санхүүгийн болон бусад холбогдох үйлчилгээгээр, жагсаалтад орсон хувь хүн, хуулийн этгээдийг хангахыг хориглох шаардлагатай;
- (d) Улс орнууд нь жагсаалтад орсон этгээдийн талаар санхүүгийн салбарт болон СББМҮҮ нарт цаг алдалгүйгээр мэдээлэл дамжуулах, мөн зорилтот хөрөнгийг хадгалж байж болзошгүй СББМҮҮ гэх мэт санхүүгийн байгууллага болон хувь хүмүүст хөрөнгө царцаах механизмын дагуу арга хэмжээ авах үүргийн талаар тодорхой зааварчилгаа өгөх механизмтай байх шаардлагатай;
- (e) Улс орнууд нь санхүүгийн байгууллага болон СББМҮҮ нарыг гүйлгээ хийх оролдлого болон хөрөнгө царцаасан, эсвэл НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн тогтоолуудын хориглох шаардлагын дагуу авсан аливаа арга хэмжээний талаар эрх бүхий байгууллагад мэдээлэхийг шаардана;

²⁴ Зөвлөмж 7 нь үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх, санхүүжүүлэх гэмт хэрэгт санхүүгийн хориг арга хэмжээ авах талаарх одоогийн хэрэгжиж буй НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн бүх тогтоолууд, ирээдүйд уламжлан гарах тогтоол болон НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлөөс ирээдүйд гарах үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх, санхүүжүүлэх гэмт хэрэгт санхүүгийн хориг арга хэмжээ авах талаар гарах бүх тогтоолууд хамаарна. Энэ гарын авлага гарах үед (2013 оны 2 дугаар сар) үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх, санхүүжүүлэх гэмт хэрэгт санхүүгийн хориг арга хэмжээ авах талаарх НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн тогтоолууд нь: S/RES/1718(2006), S/RES/1737(2006), S/RES/1747(2007), S/RES/1803(2008), S/RES/1874(2009), S/RES/1929(2010) болно.

(f) Улс орнууд нь Зөвлөмж 7-д заасан үүргээ биелүүлэхдээ гэм буруугүй гуравдагч этгээдийн эрх (bona fide)-ийг хамгаалах механизмтай байх шаардлагатай.

7.3 Улс орнууд нь Зөвлөмж 7-гийн дагуу санхүүгийн байгууллага болон СББМҮҮ нар нь үүргээ хэрхэн биелүүлж байгааг хянах, хэрэгжилтийг хангах холбогдох хууль болон бусад арга хэрэгсэлтэй байх шаардлагатай. Хууль болон бусад арга хэрэгслийн дагуу хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлж байгаа бол иргэний, захиргааны болон эрүүгийн хариуцлага хүлээлгэдэг байх шаардлагатай.

7.4 Улс орнууд нь хориг арга хэмжээний жагсаалтад оруулах шалгуур нөхцөл үгүй болсон тохиолдолд Аюулгүйн Зөвлөлд хувь хүн, хуулийн этгээдийг жагсаалтаас хасах хүсэлт гаргах талаар олон нийтэд мэдээлсэн журамтай байх шаардлагатай²⁵. Үүнд:

(a) Жагсаалтад орсон хувь хүн, хуулийн этгээд Зохицуулалтын төвд НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн 1970 тогтоолын дагуу жагсаалтаас хасах асуудалд хамаарах жагсаалтаас хасах хүсэлт гаргах боломж олгох эсвэл Зохицуулалтын төвд шууд хандахыг мэдэгдэх;

(b) Жагсаалтад орсон хувь хүн, хуулийн этгээдтэй ижил төстэй нэртэй хувь хүн, хуулийн этгээдийн андуурагдан царцаасан хөрөнгийг тухайн хувь хүн, хуулийн этгээд нь биш гэдгийг баталсны дараа чөлөөлөх олон нийтэд танигдаж мэдэгдсэн журам;

(c) НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн тогтоол 1718 болон 1737 тогтоолд заасан хасагдах шалгуурууд биелсэн гэж улс орон дүгнэсэн тохиолдолд эдгээр тогтоолуудад заасан процессын дагуу хөрөнгө зарцуулах эрх олгох,

(d) Улс орнууд нь жагсаалтаас хасуулах, хөрөнгийг суллах тогтоолын талаар санхүүгийн салбарт болон СББМҮҮ нарт цаг алдалгүйгээр мэдээлэл дамжуулах мөн зорилтот хөрөнгийг хадгалж байж болзошгүй СББМҮҮ гэх мэт санхүүгийн байгууллага болон хувь хүмүүст жагсаалтаас хасуулах, хөрөнгийг суллах тогтоолын дагуу арга хэмжээ авах үүргийн талаар тодорхой зааварчилгаа өгөх механизмтай байх шаардлагатай.

7.5 Дансанд санхүүгийн зорилтот хориг арга хэмжээ авах тогтоол гарахаас өмнө хийгдсэн гэрээ, хэлэлцээр, хүлээсэн үүргийн хувьд:

(a) Улс орнууд нь НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн тогтоол 1718 эсвэл 1737-гийн дагуу битүүмжилсэн дансанд хүүгийн орлого болон санхүүгийн зорилтот хориг арга хэмжээ авах тогтоол гарахаас өмнө хийгдсэн гэрээ, хэлэлцээр, хүлээсэн үүргийн дагуу орлого орохыг зөвшөөрөх шаардлагатай бөгөөд эдгээр орлого нь мөн тухайн дансны бусад хөрөнгөтэй адил нөхцөлтэй, царцаагдсан байх шаардлагатай;

(b) НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн тогтоол 1737-ын дагуу царцаасан данснаас тухайн дансанд санхүүгийн зорилтот хориг арга хэмжээ авах тогтоол гарахаас өмнө хийгдсэн гэрээ, хэлэлцээр, хүлээсэн үүргийн дагуу төлбөр хийхэд дараах нөхцлүүд биелсэн тохиолдолд хориг арга хэмжээний жагсаалтад орсон хувь хүн, хуулийн этгээд нь саад болохгүй байна: (i) гэрээ, хэлэлцээр нь Аюулгүйн Зөвлөлийн холбогдох тогтоолуудад заасан хориглосон зүйлс, материал, тоног төхөөрөмж, бараа, технологи, туслалцаа, сургалт, санхүүгийн дэмжлэг, хөрөнгө оруулалт, брокерийн үйл ажиллагаа болон үйлчилгээтэй холбоогүй гэдгийг холбогдох улс орнууд нь тогтоосон, (ii) төлбөрийг НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн тогтоол 1737-ын дагуу жагсаалтад орсон хувь хүн, хуулийн

²⁵Эдгээр журам болон, шалгуурууд нь НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн шийдвэр 1730 (2006) болон уламжлан гарсан шийдвэрүүд, тэр дотроо эдгээр шийдвэрүүдийн үндсэн дээр байгуулагдсан Зохицуулах төвийн механизмын шийдвэрүүдийн дагуу НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн баталсан холбогдох заавар, журмуудтай зохицсон байх шаардлагатай.

этгээд шууд болон шууд бусаар хүлээн аваагүй гэдгийг холбогдох улс орнууд нь тогтоосон (iii) холбогдох улс орнууд нь 1737 хориг арга хэмжээний хороонд эдгээр төлбөрүүдийг хийх, хүлээн авах, талаар урьдчилан мэдэгдэл өгсөн эсвэл хөрөнгө, санхүүгийн эх үүсвэр, санхүүгийн хөрөнгө чөлөөлөх зөвшөөрөл олгох талаар зөвшөөрөл олгохоос 10 ажлын өдрийн өмнө мэдэгдсэн.

ЗӨВЛӨМЖ 8**ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГУУД (ТББ)**

8.1 Улс орнууд нь:

- (a) Терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаанд ашиглагдаж болох байгууллагууд, түүнчлэн ТББ-д хамаарах хууль, журмуудын зохистой байдлыг хянаж байх;
- (b) Дотоодын ТББ-ын салбарын үнэлгээ хийж байх эсвэл ТС болон терроризмыг дэмжсэн бусад үйл ажиллагаанд хамгийн ихээр өртөх магадлалтай ТББ-ын шинж чанар, төрлийг тогтоохын тулд тэдгээрийн үйл ажиллагаа, хэмжээ болон бусад шаардлагатай шинж чанарын талаарх мэдээллийг бүх боломжит эх сурвалжаас цаг алдалгүй авч чаддаг байх;
- (c) Шинэ мэдээ, мэдээллийн үндсэн дээр ТББ-ын салбар дахь террорист үйл ажиллагаатай холбогдох боломжийн талаар тогтмол үнэлгээ хийж байх шаардлагатай.

8.2 Улс орнууд нь ТС асуудлаар ТББ-ын салбарт хүрч ажиллах шаардлагатай.

8.3 Улс орнууд нь бүх ТББ-ын удирдлага, зохион байгуулалтын ил тод, шударга байдал, олон нийтийн итгэлийг нэмэгдүүлэх тодорхой бодлоготой байх шаардлагатай.

8.4 Улс орнууд нь (i) ТББ-ын салбарын хяналтанд байгаа хөрөнгийн ихээхэн хэсгийг хянадаг, (ii) салбарын гадаад үйл ажиллагааны ихээхэн хувийг эзэлдэг ТББ-д дараах стандарт, шаардлагуудыг тогтоох шаардлагатай. Үүнд:

- (a) Дараах мэдээлэлтэй байх: (i) өөрсдийн тодорхойлсон үйл ажиллагааны зорилго, зорилт, (ii) удирдах ажилтнууд, ТУЗ-ийн гишүүд гэх мэт өмчилж, хянаж, үйл ажиллагааг нь чиглүүлж буй хувь хүмүүсийн талаарх мэдээлэл. Энэ мэдээллийг ТББ-аас өөрөөс нь эсвэл бусад холбогдох эрх бүхий байгууллагаас олон нийт авах боломжтой байх шаардлагатай;
- (b) Орлого зарлагыг дэлгэрэнгүй байдлаар харуулах жилийн санхүүгийн тайлан гаргаж байх;
- (c) Бүх хөрөнгө нь бүртгэлтэй бөгөөд зарцуулалт нь тодорхойлсон үйл ажиллагааных нь зорилго, зорилтод нийцэж байгаа эсэхэд хяналт тавьж байх;
- (d) Тусгай зөвшөөрөлтэй эсвэл бүртгэлтэй байх²⁶;
- (e) "Хүлээн авагч болон холбогдох ТББ-аа таньж мэдэх" зарчмыг баримтлах;
- (f) Дотоод, гадаад гүйлгээний мэдээ, бүртгэл²⁷ болон (a),(b) -д заасан мэдээг хамгийн багадаа 5 жил хадгалах, эрх бүхий байгууллага шаардсан тохиолдолд гаргаж өгөхөд бэлэн байлгах.

8.5 Эрх бүхий байгууллага нь ТББ -ын 8.4-т заасан шаардлагуудыг хангаж байгаа эсэхэд хяналт тавьж байх шаардлагатай бөгөөд зөрчил гарсан тохиолдолд ТББ-д болон ТББ-ыг төлөөлж буй

²⁶ МУТС-тэй гэмцэх талаар тусгай зөвшөөрөл авах, бүртгүүлэх шаардлагагүй юм. Жишээ нь: зарим улс оронд ТББ нь татварын газар бүртгэлтэй байдаг бөгөөд татварын газар нь татвар төлөлтийн үүднээс (татварын хөнгөлөлт үзүүлэх, татвараас чөлөөлөх шаардлага хангаж буй эсэх) хянаж байдаг.

²⁷ Эдгээр мэдээ, бүртгэл нь ТББ-ын хөрөнгө нь зарласан үйл ажиллагааных нь зорилго, зорилтод нийцсэн байдлаар зарцуулагдаж байгааг баталж чадахуйц хэмжээнд дэлгэрэнгүй байх ёстой.

ФАТФ-ын зөвлөмжийн техникийн хэрэгжилт болон МУТСТ тогтолцооны үр дүнтэй байдлыг үнэлэх

хувь хүнд тохирсон, дахин үйлдэхээс сэргийлсэн шийтгэлийн арга хэмжээ авах боломжтой байх²⁸.

8.6 Эрх бүхий байгууллага нь ТББ-ыг судлах, шалгах зорилгоор дараах замаар мэдээлэл авах боломжтой байх. Үүнд:

- (a) ТББ-ын талаар шаардлагатай мэдээлэл авч болох байгууллагуудын дотоод хамтын ажиллагаа, уялдаа холбоо, мэдээлэл солилцоо;
- (b) Тухайн нэгэн ТББ-ын удирдлага, зохион байгуулалтын талаар (санхүүгийн болон төлөвлөлтийн мэдээлэл гэх мэт) бүрэн мэдээлэл авах боломж;
- (c) Тухайн нэгэн ТББ-ыг террорист байгууллагуудын хөрөнгө цуглуулах үйл ажиллагаанд нь халхавч болж байгаа, хөрөнгө царцаах арга хэмжээнээс зайлсхийхийн тулд ТС суваг болгон ашиглаж байгаа болон хууль ёсны үйл ажиллагаанд зарцуулагдах байсан хөрөнгийг террористууд болон террорист байгууллагуудад шилжүүлснийг нуух хэрэгсэл болгож байгаа гэж сэжиглэх үндэслэлтэй тохиолдолд урьдчилан сэргийлэх эсвэл мөрдөх ажиллагаа явуулахын тулд шаардлагатай мэдээллийг эрх бүхий байгууллагатай цаг алдалгүйгээр солилцох механизм.

8.7 Улс орнууд нь олон улсын ТС болон терроризмыг дэмжих бусад гэмт хэрэгт сэжиглэгдсэн тодорхой нэг ТББ-ын талаар мэдээлэл шаардсан хүсэлтэд хариу өгөх хуулийн этгээд болон зохицуулах журмыг тодорхойлох шаардлагатай.

²⁸ Эдгээр арга хэмжээ нь дансыг царцаах, торгууль ноогдуулах, тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох, бүртгэлээс хасах гэх мэт байж болно. Энэ нь ТББ болон түүнийг төлөөлж буй хувь хүнд шаардлагатай үед иргэний, захиргааны, эрүүгийн арга хэмжээ авахгүй байх шалтгаан болох ёсгүй.

ЗӨВЛӨМЖ 9**САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН НУУЦЛАЛТАЙ
ХОЛБООТОЙ ХУУЛЬ ТОГТООМЖ**

9.1 Санхүүгийн байгууллагуудын нууцлалтай холбоотой хууль нь ФАТФ-ын зөвлөмжүүдийг хэрэгжүүлэхэд саад болох ёсгүй²⁹.

²⁹ Анхаарал хандуулах гол зүйл нь эрх бүхий байгууллага нь МУТС-тэй тэмцэх үүргээ биелүүлэхэд шаардагдах мэдээллийг авч чадахгүй болох, олон улсын хэмжээнд болон улс орон дотроо эрх бүхий байгууллагууд мэдээлэл солилцох боломжгүй болох, Зөвлөмж 13, 16, 17-гийн шаардлагын дагуу санхүүгийн байгууллагууд хоорондоо мэдээлэл солилцох боломжгүй болох явдал юм.

ЗӨВЛӨМЖ 10**ХАРИЛЦАГЧИЙГ ТАНЬЖ МЭДЭХ³⁰ (ХТМ)**

10.1 Санхүүгийн байгууллагуудад нэргүй данс байлгах, эсвэл илэрхий хуурамч нэрээр нээсэн данс байлгахыг хориглосон байх шаардлагатай.

ХТМ ажиллагааг хэзээ хийх

10.2 Дараах тохиолдолд санхүүгийн байгууллагуудыг ХТМ арга хэмжээ авахыг шаардана. Үүнд:

- (a) Бизнес харилцаа тогтооход;
- (b) Нэг болон холбоотой хэд хэдэн гүйлгээний дүн нь босго дүн болох 15 000 ам.доллар/еврогоос дээш дүнтэй байвал;
- (c) Зөвлөмж 16 болон түүний тайлбарт тусгагдсан нөхцлөөр хийгдсэн нэг удаагийн шилжүүлэг хийхэд;
- (d) ФАТФ-ын зөвлөмжүүдэд тусгагдсан чөлөөлөлт, гүйлгээний босго дүнгээс үл хамааран МУТС байгаа гэсэн сэжиг төрсөн бол;
- (e) Харилцагчийн талаар өмнө нь авсан мэдээллийн тохиромжтой байдал, баталгаатай эсэхэд эргэлзсэн тохиолдолд.

Бүх харилцагчдын хувьд ХТМ үйл ажиллагаанд тавигдах шаардлага

10.3 Санхүүгийн байгууллагууд нь бүх харилцагчидаа (байнгын болон нэг удаагийн, хувь хүн, хуулийн этгээд) таньж мэдэх, харилцагчийг баталгаатай, найдвартай баримт бичиг болон хамааралгүй эх сурвалжаас мэдээлэл авч нотолж, шалгах үүрэгтэй байх шаардлагатай.

10.4 Санхүүгийн байгууллагууд нь харилцагчийг төлөөлж байгаа хувь хүн нь төлөөлөх эрхтэй эсэхийг шалгах, уг хувь хүний биеийн байцаалтыг шалгах, мөн эсэхийг тодорхойлох үүрэгтэй байх шаардлагатай.

10.5 Санхүүгийн байгууллагууд нь эцсийн өмчлөгчийг тодорхойлох, холбогдох мэдээлэл, баталгаатай эх сурвалжаас авсан мэдээлэлд үндэслэн эцсийн өмчлөгчийн мэдээллийг шалгаж, бүрэн таньж мэдэх үүрэгтэй байна.

10.6 Санхүүгийн байгууллагууд нь бизнесийн харилцаа тогтоохдоо уг харилцааны жинхэнэ зорилгыг ойлгож, шаардлагатай тохиолдолд мэдээлэл авах үүрэгтэй байх шаардлагатай.

10.7 Санхүүгийн байгууллагууд нь бизнесийн харилцаанд дараах ХТМ үйл ажиллагааг тогтмол явуулж байх үүрэгтэй. Үүнд:

- (a) Харилцагчтай бизнесийн харилцаа тогтоосноос хойш хийсэн гүйлгээнүүд нь түүний бизнес, эрсдэлийн байдал, шаардлагатай тохиолдолд санхүүгийн эх үүсвэрийн талаар санхүүгийн байгууллагад байгаа мэдээлэлтэй нийцэж байгаа эсэхэд маш нарийн шинжилгээ хийж байх;

³⁰ Санхүүгийн байгууллагууд ХТМ үйл ажиллагаа хийх шаардлагатай гэсэн үүргийг хуульд тусгаж өгөх шаардлагатай. Харин бусад тусгай шаардлагуудыг өөр арга замаар хэрэгжүүлэх боломжтой.

- (b) Хадгалагдаж буй бүртгэлийг, ялангуяа өндөр эрсдэлтэй харилцагчийн бүртгэлийг эргэн хянах арга замаар ХТМ үйл ажиллагаатай холбоотойгоор цуглуулсан баримт бичиг, мэдээлэл нь хоцрогдоогүй, хамааралтай байгаа эсэхийг баталгаажуулах.

Хуулийн этгээд болон эрх зүйн бусад зохицуулалт бүхий этгээдэд хамаарах ХТМ тусгай арга хэмжээ

10.8 Харилцагч нь хуулийн этгээд, эрх зүйн бусад зохицуулалт бүхий этгээд байх тохиолдолд санхүүгийн байгууллага нь харилцагчийн бизнесийн мөн чанар, эзэмшил болон удирдлагын бүтцийг таньж мэдэх үүрэгтэй байх шаардлагатай.

10.9 Харилцагч нь хуулийн этгээд, эрх зүйн бусад зохицуулалт бүхий этгээд байх тохиолдолд санхүүгийн байгууллага нь дараах мэдээлэл авч харилцагчийг таньж мэдэж, баталгаажуулах үүрэгтэй байна. Үүнд:

- (a) Нэр, үүсгэн байгуулагдсан хууль ёсны хэлбэр, оршин тогтнож буйг баталсан нотолгоо;
- (b) Хуулийн этгээд, эрх зүйн бусад зохицуулалт бүхий этгээдийг хянах, хязгаарлах эрх бүхий этгээд, мөн тухайн хуулийн этгээд, эрх зүйн бусад зохицуулалт бүхий этгээдийг удирдах албан тушаал хашиж буй хувь хүмүүсийн нэр;
- (c) Бүртгэлтэй албан байрны хаяг, хэрэв өөр бол бизнесийн үйл ажиллагаа явуулах байрны хаяг.

10.10 Харилцагч нь хуулийн этгээд³¹ байх тохиолдолд санхүүгийн байгууллага нь дараах мэдээлэл авч эцсийн өмчлөгчийг нь таньж мэдэж, баталгаажуулах үүрэгтэй байна. Үүнд:

- (a) Тухайн хуулийн этгээдийн хяналтын хувийг³² эзэмшдэг хувь хүний (хүмүүсийн)³³ хувийн мэдээлэл;
- (b) Хэрэв (a) заалтын хувьд хяналтын хувийг эзэмшдэг хувь хүн/хүмүүс нь эцсийн өмчлөгч/өмчлөгчид мөн эсэх талаар эргэлзээ байгаа бол эсвэл тодорхой хувь хүн хяналтыг гүйцэтгэдэггүй бол бусад арга замаар хяналт тавьж буй хувь хүн/хүмүүсийн (хэрэв байгаа бол) хувийн мэдээлэл;
- (c) Хэрэв (a) эсвэл (b) заалтын дагуу хувь хүн тогтоогдоогүй бол удирдах дээд албан тушаал хашиж байгаа хувь хүний хувийн мэдээлэл;

10.11 Харилцагч нь эрх зүйн бусад зохицуулалт бүхий этгээд байх тохиолдолд санхүүгийн байгууллага нь дараах мэдээлэл авч харилцагчийг таньж мэдэж, баталгаажуулах үүрэгтэй байх шаардлагатай. Үүнд:

³¹ Хэрэв харилцагч нь эсвэл компанийн хяналтын хувь эзэмшигч нь хөрөнгийн биржид бүртгэлтэй, эцсийн өмчлөгчийг нь ил тод гаргахуйц хэмжээнд тайлагнах (хөрөнгийн биржийн журам, хууль эсвэл бусад арга хэмжээний дагуу) үүрэг бүхий компани эсвэл ийм төрлийн компани ихэнх хувийг эзэмшдэг компани бол эдгээр компанийн хувь эзэмшигч болон эцсийн өмчлөгчийг тодорхойлох, баталгаажуулах шаардлагагүй. Баталгаажуулах мэдээ, баримтыг олон нийтэд ил тод бүртгэлийн сангаас, харилцагчаас эсвэл бусад найдвартай эх сурвалжаас авч болно.

³² Хяналтын хувь нь компанийн хувь эзэмшлийн бүтцээс хамаарна. Энэ нь ямар нэгэн босго хэмжүүрээр хэмжигдэж болно, жишээ нь компанийн тодорхой хувиас (ж.нь 25%) дээш хувь эзэмшиж буй хувь хүн.

³³ Хяналтын хувь нь олон хүнд тарж ямар нэгэн тодорхой хувь хүн (дангаар эсвэл хамтарч) хяналтыг гүйцэтгэдэггүй байж болно.

ФАТФ-ын зөвлөмжийн техникийн хэрэгжилт болон МУТСТ тогтолцооны үр дүнтэй байдлыг үнэлэх

(a) Итгэлцлийн хэлэлцээрийн итгэл хүлээгч, итгэл хүлээлгэгч, хамгаалагч (хэрэв байгаа бол), үр шим хүртэгч эсвэл үр шим хүртэгчийн бүлэг³⁴ болон тухайн итгэлцлийн хэлэлцээрийг бодитоор хянадаг (хяналтын сүлжээ болон эзэмших хэлбэрээр дамжуулж) хувь хүний хувийн мэдээлэл;

(b) Бусад хэлбэрийн эрх зүйн бусад зохицуулалт бүхий этгээдийн хувьд ижил төстэй, ойролцоо албан тушаалд байгаа хувь хүний хувийн мэдээлэл.

Амь насны даатгалын үр шим хүртэгчдэд хийх ХТМ үйл ажиллагаа

10.12 Харилцагч болон эцсийн өмчлөгч нартай холбоотой ХТМ үйл ажиллагаанаас гадна санхүүгийн байгууллагууд нь амь насны даатгалын үр шим хүртэгч болон бусад хөрөнгө оруулалттай холбоотой даатгалын үр шим хүртэгч нарын хувьд тэдгээр нь тодорхой болмогц дараах ХТМ үйл ажиллагаа явуулах шаардлагатай. Үүнд:

(a) Хувь хүн, хуулийн этгээд эсвэл эрх зүйн бусад зохицуулалт бүхий этгээд гэж тодорхойлогдсон харилцагчийн хувьд нэрийг тодорхой болгож авах;

(b) Шинж чанар, төрөл эсвэл бусад арга замаар тодорхойлогдсон харилцагчийн хувьд төлбөр хийгдэх үед таньж мэдэж болохуйц хангалттай мэдээлэл олж авах,

(c) Дээрх хоёр тохиолдол бүрт нь төлбөр хийгдэх үед харилцагчийг таних, тодруулах үйл ажиллагааг явуулах шаардлагатай.

10.13 Санхүүгийн байгууллагууд нь нэмэлт ХТМ үйл ажиллагаа шаардлагатай эсэхийг тодорхойлоход амь насны даатгалын үр шим хүртэгч нарыг эрсдэлийн нэг нөхцөл гэж авч үзэх шаардлагатай. Хэрэв санхүүгийн байгууллага нь хуулийн этгээд эсвэл хэлэлцээрийн тал нь илүү өндөр эрсдэлтэй гэж үзсэн бол ХТМ үйл ажиллагааг төлбөр хийгдэх үед эцсийн үр шим хүртэгчийг таних, тодруулах үйл ажиллагааг илүү өргөн хүрээнд хийх шаардлагатай.

Баталгаажуулалт хийх цаг хугацаа

10.14 Санхүүгийн байгууллагууд нь харилцагч болон эцсийн үр шим хүртэгчийг таньж мэдэх, тодруулах, батлах үйл ажиллагааг бизнесийн харилцааны турш болон нэг удаагийн гүйлгээ хийх бүрт хийж байх үүрэгтэй бөгөөд дараах нөхцөлд бизнесийн холбоо тогтоосны дараа тодруулах, батлах үйл ажиллагааг хийж дуусгаж болно. Үүнд:

(a) Бодитоор хэрэгжүүлэх боломжтой болсон үед;

(b) Бизнесийн хэвийн үйл ажиллагааг тасалдуулахгүй байх нь чухал бол,

(c) МУТС гэмт хэргийн эрсдэлийг үр дүнтэй удирддаг бол.

10.15 Санхүүгийн байгууллагууд нь харилцагчийг таньж мэдэх, батлах үйл ажиллагаа хийгдэхээс өмнө харилцагч нь бизнес харилцаагаа ашиглахаас сэргийлсэн эрсдэлийн удирдлагын журам заавартай байх хэрэгтэй.

Хуучин харилцагч нар

³⁴Санхүүгийн байгууллага нь итгэлцлэлийн гэрээний үр шим хүртэгчийн хувьд төлбөр хийгдэх үед эсвэл хуулийн дагуу эрхээ хэрэгжүүлэх үед нь тухайн хөрөнгө хүлээн авагчийг баталгаажуулах, тогтооход хангалттай мэдээлэл олж авах ёстой.

ФАТФ-ын зөвлөмжийн техникийн хэрэгжилт болон МУТСТ тогтолцооны үр дүнтэй байдлыг үнэлэх

10.16 Санхүүгийн байгууллагууд нь хуучин харилцагч нарын³⁵ хувьд бодит байдал болон эрсдэлийн түвшингээс хамаарч ХТМ үйл ажиллагаанд тавих шаардлага тогтоох бөгөөд эдгээр тогтсон харилцаандаа ХТМ үйл ажиллагаа хэзээ хийгдсэн, байгаа мэдээлэл нь хангалттай эсэх зэргээс хамаарч тохирсон цаг хугацаанд нь ХТМ үйл ажиллагаа явуулж байх үүрэгтэй.

Эрсдэл суурилсан аргачлал

10.17 Санхүүгийн байгууллагууд нь МУТС гэмт хэргийн эрсдэл өндөр байх тохиолдолд ХТМ нэмэлт үйл ажиллагаа явуулах үүрэгтэй.

10.18 Санхүүгийн байгууллагууд нь хялбаршуулсан ХТМ үйл ажиллагааг зөвхөн нарийвчилсан судалгааны үндсэн дээр улс орон эсвэл санхүүгийн байгууллага өөрөө эрсдэл багатай гэдэг нь тодорхойлогдсон үед хийх боломжтой байх шаардлагатай.

ХТМ үйл ажиллагааг хангалттай түвшинд гүйцэтгэх боломжгүй тохиолдолд

10.19 Санхүүгийн байгууллага нь ХТМ үйл ажиллагааны холбогдох арга хэмжээг биелүүлэх боломжгүй тохиолдолд:

- (a) Данс нээхгүй байх, бизнесийн харилцаа тогтоохгүй байх, гүйлгээ хийхгүй байх эсвэл бизнесийн харилцааг цуцлах үүрэг хүлээх,
- (b) Харилцагчтай холбоотойгоор сэжигтэй гүйлгээний тайлан (СГТ) бэлдэх асуудлыг бодолцож үзэх үүрэгтэй байна.

ХТМ үйл ажиллагаа болон сэжиг авахуулах

10.20 Хэрэв санхүүгийн байгууллага нь мөнгө угаах эсвэл терроризмыг санхүүжүүлж байгаа гэж сэжиглэх үндэслэл байгаа бөгөөд ХТМ үйл ажиллагаа явуулах нь харилцагчид сэжиг авахуулна гэж үзэж байгаа бол ХТМ үйл ажиллагаа явуулахгүй байхыг зөвшөөрөх шаардлагатай бөгөөд эдгээрийн оронд СГТ бэлдэж хүргүүлэх үүрэг хүлээнэ.

³⁵ Үндэстний хэмжээнд шинэ шаардлага хүчин төгөлдөр болсон үед бүртгэлтэй байгаа харилцагч нар.

ЗӨВЛӨМЖ 11**Баримт, материал хадгалалт³⁶**

11.1 Санхүүгийн байгууллагууд нь гүйлгээ хийгдсэнээс хойш хамгийн багадаа 5 жилийн хугацаанд дотоод болон гадаад гүйлгээний холбогдох шаардлагатай бүх баримт, материалыг хадгалах үүрэгтэй.

11.2 Санхүүгийн байгууллага нь харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагаагаар бүрдүүлэн авсан дансны баримт, материалууд, бизнесийн харилцаанаас үүдэлтэй бүх бичилт болон дүн шинжилгээний дүгнэлтийг, бизнесийн харилцаа дууссанаас хойш эсвэл зарим тохиолдлын гүйлгээ хийгдсэнээс хойш хамгийн багадаа 5 жилийн хугацаанд хадгалах шаардлагатай.

11.3 Гүйлгээний баримт, материал нь тухайлсан гүйлгээг эргэн харах, сэргээхэд хангалттай, шаардлагатай тохиолдолд гэмт хэргийг мөрдөн шалгах үйл ажиллагаанд нотолгоо болоход хангалттай байх шаардлагатай.

11.4 Санхүүгийн байгууллага нь эрх бүхий дотоодын байгууллагад харилцагчийн талаарх гүйлгээний бүх мэдээлэл баримтыг шуурхай гаргаж өгөх нөхцлийг хангах шаардлагатай.

³⁶ Санхүүгийн байгууллагаас харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааны хүрээнд олж авсан мэдээлэл, гүйлгээтэй холбоотой баримт бичгийг хадгалах зарчмыг хуулинд тусгах шаардлагатай.

ЗӨВЛӨМЖ 12**УЛС ТӨРД НӨЛӨӨ БҮХИЙ ЭТГЭЭДҮҮД (УТНБЭ)**

12.1 Санхүүгийн байгууллага нь Зөвлөмж 10-т заасан харилцагчийг таньж мэдэхээс гадна гадаадын улс төрд нөлөө бүхий этгээдтэй холбоотойгоор дараах арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай. Үүнд:

- (a) Харилцагч эсвэл эцсийн өмчлөгч нь УТНБЭ эсэхийг тогтоох эрсдэлийн удирдлагын тогтолцоог бүрдүүлсэн байх;
- (b) Тухайн бизнесийн харилцааг үүсгэхийн өмнө (эсвэл одоогийн харилцааг цаашид үргэлжлүүлэхдээ) дээд шатны удирдлагын зөвшөөрөл авдаг байх;
- (c) УТНБЭ гэж тодорхойлсон харилцагч болон эцсийн өмчлөгчийн эд хөрөнгө, мөнгөний эх сурвалжийг тогтооход боломжтой арга хэмжээг авах;
- (d) УТНБЭ-тэй холбоотой харилцаанд байнгын тусгайлсан хяналт тавих.

12.2 Санхүүгийн байгууллага нь Зөвлөмж 10-т заасан харилцагчийг таньж мэдэх арга хэмжээг авахаас гадна олон улсын байгууллагын өндөр дээд албан тушаалтан болон дотоодын УТНБЭ-тэй холбоотой дараах арга хэмжээг авах шаардлагатай. Үүнд:

- (a) Харилцагч эсвэл эцсийн өмчлөгч нь дээр дурдсан этгээд болох эсэхийг тодорхойлох боломжит арга хэмжээг авах;
- (b) Тухайн этгээдтэй тогтоосон бизнесийн харилцаа нь өндөр эрсдэлтэй тохиолдолд 12.1(b)-(d)-д заасан шалгуурыг хэрэгжүүлэх.

12.3 Санхүүгийн байгууллага нь 12.1 ба 12.2-д заасан шалгуурын холбогдох шаардлагыг бүх төрлийн УТНБЭ-ийн гэр бүлийн гишүүн эсвэл нэгдмэл сонирхолтой этгээдэд тавих шаардлагатай.

12.4 Санхүүгийн байгууллага нь амь насны даатгалын гэрээтэй холбоотойгоор үр шим хүртэгч, шаардлагатай бол үр шим хүртэгчийн эцсийн өмчлөгч нь УТНБЭ эсэхийг тогтоох зорилгоор боломжит арга хэмжээг авах шаардлагатай. Энэхүү арга хэмжээг даатгалын нөхөн төлбөр олгоход эцсийн байдлаар хэрэгжүүлсэн байна. Хэрвээ өндөр эрсдэлтэй гэж тодорхойлсон бол санхүүгийн байгууллага нь даатгалын нөхөн төлбөр төлөхөөс өмнө дээд шатны удирдлагад мэдэгдэх, даатгалуугчтай тогтоосон бизнесийн харилцааг бүхэлд нь тусгайлан нягтлах болон сэжигтэй гүйлгээний тайлангаар мэдээлэхийг харгалзан үзэх шаардлагатай.

ЗӨВЛӨМЖ 13**КОРРЕСПОНДЕНТ БАНКНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА**

13.1 Санхүүгийн байгууллага нь хил дамнасан корреспондент банкны үйл ажиллагаа болон бусад ижил төрлийн харилцаа холбоонд дараах арга хэмжээг авна. Үүнд:

- (a) Харилцагчийн бизнесийн үйл ажиллагааг бүрэн танихын тулд тухайн харилцагч байгууллагын талаар хангалттай мэдээлэл цуглуулах, олон нийтэд нээлттэй мэдээллээс тухайн байгууллагын нэр хүнд, МУТС талаар мөрдөн шалгах эсвэл аливаа хяналт шалгалтын албадлагын арга хэмжээ авахуулж байсан эсэх болон хяналт шалгалтын ямар түвшний тогтолцоотойг тодорхойлно;
- (b) Харилцагч байгууллагын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хяналтыг үнэлэх;
- (c) Шинээр харилцаа тогтоохын өмнө дээд шатны удирдлагаас зөвшөөрөл авах;
- (d) Байгууллага тус бүрийн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэхтэй холбоотой үүрэг хариуцлагыг ойлгох.

13.2 Санхүүгийн байгууллага нь “Дамжин өнгөрөх данс”-тай холбоотой тавигдаж буй шаардлагыг хангах зорилгоор харилцагч банкны талаар дараах арга хэмжээг авсан байх шаардлагатай. Үүнд:

- (a) Корреспондент банкны дансанд шууд холбогддог өөрийн харилцагчийн талаар “харилцагчийг таньж мэдэх” үүргийг хэрэгжүүлэх;
- (b) Харилцагч банкны хүсэлтээр корреспондент банк нь харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг дамжуулах боломжтой байх.

13.3 Санхүүгийн байгууллага нь бодитоор оршдоггүй банк буюу “халхавч банк”-тай харилцагч банкны харилцаагаа үргэлжлүүлэх болон шинээр харилцаа тогтоохыг хориглоно. Харилцагч санхүүгийн байгууллага нь тухайн байгууллагын дансыг “халхавч банк”-ны зорилгоор ашиглуулахгүй байх нөхцлийг бүрдүүлсэн байх тухай арга хэмжээ авна.

ЗӨВЛӨМЖ 14**МӨНГӨ БОЛОН ҮНЭ БҮХИЙ ЗҮЙЛ ШИЛЖҮҮЛЭХ
ҮЙЛЧИЛГЭЭ (МҮБЗШҮ) (MVTs)**

14.1 Мөнгө болон үнэ бүхий зүйл шилжүүлэх үйлчилгээ үзүүлэгч хувь хүн болон хуулийн этгээд нь тусгай зөвшөөрөлтэй эсвэл бүртгүүлсэн байх шаардлагатай³⁷.

14.2 Улс орнууд нь тусгай зөвшөөрөлгүй, бүртгэлгүйгээр МҮБЗШҮ эрхэлдэг хувь хүн, хуулийн этгээдийг илрүүлэх, гаргасан зөрчилтэй нь дүйцэхүйц, давтан үйлдэхээс сэргийлсэн шийтгэлийн арга хэмжээг авах шаардлагатай.

14.3 МҮБЗШҮ үзүүлэгч нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлийн хяналтад хамрагддаг байх шаардлагатай.

14.4 МҮБЗШҮ үзүүлэгчийн төлөөлөгч нар эрх бүхий байгуулагаас тусгай зөвшөөрөл авдаг, бүртгүүлдэг, эсвэл тухайн улс оронд үйл ажиллагаа явуулдаг МҮБЗШҮ үзүүлэгч нь өөрийн төлөөлөгчийн жагсаалтын сүүлийн үеийн мэдээллийг эрх бүхий байгууллага авах боломжоор хангасан байх шаардлагатай.

14.5 Төлөөлөгчөөр дамжуулж үйл ажиллагаа явуулдаг МҮБЗШҮ үзүүлэгч нь төлөөлөгчийг Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хөтөлбөрт хамруулдаг, тэдгээр нь уг хөтөлбөрийг хэрэгжүүлж байгааг хянадаг байх шаардлагатай.

³⁷ Улс орнууд нь мөнгө болон үнэ бүхий зүйл шилжүүлэх эрхтэй тусгай зөвшөөрөл авсан, бүртгүүлсэн санхүүгийн байгууллагад тусдаа зөвшөөрөл авах, бүртгүүлэх шалгуур тавих шаардлагагүй.

ЗӨВЛӨМЖ 15**ШИНЭ ТЕХНОЛОГИ**

15.1 Улс орнууд болон санхүүгийн байгууллагууд нь шинэ бүтээгдэхүүн, дамжуулалтын механизм бизнесийн дадал, шинэ болон өмнөх бүтээгдэхүүнд тохирсон технологийн хөгжлийг нэвтрүүлэхтэй холбоотойгоор үүсч болох МУТС аливаа эрсдэлийг тодорхойлж үнэлэх шаардлагатай.

15.2 Санхүүгийн байгууллага нь дараах арга хэмжээг авах шаардлагатай. Үүнд:

- (a) Дээр дурдсан бүтээгдэхүүн, туршлага, технологийг нэвтрүүлэхээс өмнө эрсдэлийн үнэлгээ хийх;
- (b) Эрсдэлийг удирдах, бууруулах зохистой арга хэмжээ авах.

ЗӨВЛӨМЖ 16**ЦАХИМ МӨНГӨН ШИЛЖҮҮЛЭГ***Шилжүүлэгч санхүүгийн байгууллага*

16.1 1000 ам.доллар/евро болон түүнээс дээш үнийн дүн бүхий хил дамнасан цахим мөнгөн шилжүүлэг нь дараах зүйлсийг агуулсан байхыг санхүүгийн байгууллагаас шаардана. Үүнд:

- (a) Шилжүүлэгчийн талаарх шаардлагатай, алдаагүй³⁸ мэдээлэл. Үүнд:
 - (i) Шилжүүлэгчийн нэр;
 - (ii) Гүйлгээг хийхэд дансны гүйлгээ ашигласан бол шилжүүлэгчийн тухайн дансны дугаар эсвэл данс байхгүй бол гүйлгээ дамжуулалтыг илрүүлэхэд ашиглагдах гүйлгээний тодруулгын онцгой дугаар;
 - (iii) Шилжүүлэгчийн хаяг, улсын үнэмлэхийн дугаар, харилцагчийн дугаар, төрсөн огноо, газар;
- (b) Хүлээн авагчийн мэдээлэл. Үүнд:
 - (i) Хүлээн авагчийн нэр;
 - (ii) Гүйлгээг хийхэд дансны гүйлгээ ашигласан бол хүлээн авагчийн тухайн дансны дугаар, эсвэл данс байхгүй бол гүйлгээ дамжуулалтыг илрүүлэхэд ашиглагдах гүйлгээний тодруулгын онцгой дугаар;

16.2 Нэг шилжүүлэгчээс эхтэй хэд хэдэн тусдаа, хил дамнасан цахим мөнгөн шилжүүлгийг багцлах байдлаар хүлээн авагчид шилжүүлж байгаа тохиолдолд багц файл нь шилжүүлэгчийн талаар шаардлагатай алдаагүй мэдээлэл, хүлээн авагч улсын дотоодод гүйлгээг хүлээн авагчийг илрүүлж болох бүрэн мэдээллийг агуулсан байхаас гадна санхүүгийн байгууллага нь шилжүүлэгчийн дансны дугаар эсвэл гүйлгээний тодруулгын онцгой дугаарыг хамт явуулах үүрэгтэй.

16.3 Хэрвээ улс орнууд нь шалгуур 16.1-т заасан нөхцлүүдэд доод босго тавьдаг бол санхүүгийн байгууллага тухайн босгоос бага дүнтэй (1000 ам.доллар/евроогоос хэтрээгүй) бүх хил дамнасан цахим мөнгөн шилжүүлэгт дараах зүйлсийг хавсаргасан байх шаардлагатай. Үүнд:

- (a) Шилжүүлэгчийн талаар шаардлагатай мэдээлэл. Үүнд:
 - (i) Шилжүүлэгчийн нэр;
 - (ii) Гүйлгээг хийхэд дансны гүйлгээ ашигласан бол шилжүүлэгчийн дансны дугаар эсвэл данс байхгүй бол гүйлгээ дамжуулалтыг илрүүлэхэд ашиглагдах гүйлгээний тодруулгын онцгой дугаар.
- (b) Хүлээн авагчийн мэдээлэл. Үүнд:
 - (i) Хүлээн авагчийн нэр;

³⁸ Алдаагүй гэдэг нь алдаагүй эсэхийг нь шалгаж, нотолсон мэдээллийг хэлнэ. Санхүүгийн байгууллага шилжүүлэгчийн талаар шаардлагатай мэдээллийн алдаагүй эсэхийг шалгасан байх шаардлагатай.

- (ii) Гүйлгээг хийхэд дансны гүйлгээ ашигласан бол хүлээн авагчийн тухайн дансны дугаар эсвэл данс байхгүй бол гүйлгээ дамжуулалтыг илрүүлэхэд ашиглагдах гүйлгээний тодруулгын онцгой дугаар.

16.4 Шалгуур 16.3-т заасан мэдээллийн алдаагүйг шалгахгүй байж болно. Харин санхүүгийн байгууллагаас мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх сэжигтэй гэж үзсэн бол харилцагчтай холбоотой мэдээллийг нягтлах шаардлагатай.

16.5 Дотоодын цахим мөнгөн шилжүүлгийн³⁹ хувьд, шилжүүлэгч санхүүгийн байгууллага нь цахим мөнгөн шилжүүлгийн мэдээллийг бусад арга замаар хүлээн авагч санхүүгийн байгууллага болон эрх бүхий байгууллагад гаргаж өгөх бололцоогүй бол дагалдах мэдээлэл нь хил дамнасан цахим цахим мөнгөн шилжүүлэгт агуулагдсан шилжүүлэгчийн талаар мэдээллтэй ижил мэдээллийг агуулсан байх шаардлагатай.

16.6 Дотоодын цахим мөнгөн шилжүүлгийн хувьд шилжүүлэгч санхүүгийн байгууллага нь мэдээллийг бусад арга замаар хүлээн авагч санхүүгийн байгууллага болон эрх бүхий байгууллагад гаргаж өгдөг бол зөвхөн дансны дугаар эсвэл гүйлгээний тодруулгын онцгой дугаар (энэ дугаар нь гүйлгээг шилжүүлэгч, хүлээн авагч талыг илрүүлэхэд хангалттай байна) байхад хангалттай. Шилжүүлэгч санхүүгийн байгууллага нь хүлээн авагч санхүүгийн байгууллага эсвэл эрх бүхий байгууллагаас хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 3 өдрийн дотор мэдээлэл гаргаж өгөх шаардлагатай. Хууль сахиулах байгууллага нь тухайн мэдээллийг нэн даруй гаргуулан авах албадлагын эрхтэй байна.

16.7 Шилжүүлэгч санхүүгийн байгууллага Зөвлөмж 11-ийн дагуу шилжүүлэгч болон хүлээн авагчтай холбоотой цуглуулсан бүх мэдээллийг хадгалах үүрэгтэй.

16.8 Цахим мөнгөн шилжүүлэг нь 16.1-16.7-д дээр тодорхойлсон нөхцлийг хангахгүй бол шилжүүлэгч санхүүгийн байгууллага уг цахим мөнгөн шилжүүлгийг гүйцэтгэхээс татгалзах шаардлагатай.

Дамжуулагч санхүүгийн байгууллага

16.9 Хил дамнасан цахим мөнгөн шилжүүлгийн хувьд дамжуулагч санхүүгийн байгууллага нь шилжүүлгийг дагалдаж байгаа шилжүүлэгч ба хүлээн авагчийн талаарх бүх мэдээллийг хадгалах шаардлагатай.

16.10 Техникийн хязгаарлагдмал байдал нь хил дамнасан цахим мөнгөн шилжүүлгийг дагалдаж байгаа шилжүүлэгч ба хүлээн авагчийн талаарх бүх мэдээллийг дотоодын холбогдох шилжүүлэгтэй хамтатгах боломжгүй нөхцөл үүсэж байвал дамжуулагч санхүүгийн байгууллага нь шилжүүлэгч байгууллагын болон бусад дамжуулагч байгууллагаас хүлээн авсан бүх мэдээллийн бичилтийг хамгийн багадаа 5 жил хадгалах шаардлагатай.

16.11 Дамжуулагч санхүүгийн байгууллага нь шилжүүлэгч эсвэл хүлээн авагчийн талаар шаардлагатай мэдээллийг агуулаагүй хил дамнасан цахим мөнгөн шилжүүлгийг тодорхойлохын тулд *Төлбөр тооцоог шууд хийх* үйл ажиллагаатай зохицсон боломжит арга хэмжээг авах шаардлагатай.

16.12 Дамжуулагч санхүүгийн байгууллага нь (а) шилжүүлэгч болон хүлээн авагчийн талаар шаардлагатай мэдээллийг агуулаагүй цахим мөнгөн шилжүүлгийг хэзээ гүйцэтгэх, татгалзах, түдгэлзүүлэх болон (б) цаашид авах арга хэмжээг тодорхойлох эрсдэлд суурилсан бодлого, журамтай байх шаардлагатай.

³⁹ Энэхүү нэр томъёо нь Европын холбооны хилийн дотор явагдсан цахим мөнгөн шилжүүлэгт мөн хамаарна. Цаашилбал, Европын дотоод зах зээл ба үүнд уялдсан хууль зүйн тогтолцоо нь Европын Эдийн засгийн бүс нутгийн гишүүдэд үйлчилнэ.

Хүлээн авагч санхүүгийн байгууллага

16.13 Шилжүүлэгч болон хүлээн авагчийн талаар шаардлагатай мэдээллийг агуулаагүй хил дамнасан цахим мөнгөн шилжүүлгийг тодорхойлохын тулд бодит цагийн мониторинг эсвэл үйл явдлын дараах мониторингийг багтаасан боломжит арга хэмжээг хүлээн авагч санхүүгийн байгууллага хэрэгжүүлэх шаардлагатай.

16.14 1000 ам.доллар/евро болон түүнээс дээш⁴⁰ хил дамнасан цахим мөнгөн шилжүүлгийн хувьд, хүлээн авагч санхүүгийн байгууллага нь хүлээн авагчийн мэдээлэл урьд нь баталгаажуулаагүй байсан бол үүнийг баталгаажуулах болон Зөвлөмж 11-ийн дагуу энэхүү мэдээллийг хадгалах шаардлагатай.

16.15 Хүлээн авагч санхүүгийн байгууллага нь (а) шилжүүлэгч болон хүлээн авагчийн талаар шаардлагатай мэдээлэл агуулаагүй цахим мөнгөн шилжүүлгийг хэзээ гүйцэтгэх, татгалзах, түдгэлзүүлэх болон (б) дагалдах зохистой арга хэмжээг тодорхойлох эрсдэлд суурилсан бодлого, журамтай байх шаардлагатай.

Мөнгө болон үнэ бүхий зүйл шилжүүлэх үйлчилгээ үзүүлэгч

16.16 МҮБЗШҮ үзүүлэгч шууд болон төлөөлөгчөөр дамжуулан үйл ажиллагаа явуулдаг улсад Зөвлөмж 16-ийн холбогдох бүх шаардлагыг дагаж мөрдөх шаардлагатай.

16.17 МҮБЗШҮ үзүүлэгч нь цахим мөнгөн шилжүүлгийн шилжүүлэгч ба хүлээн авагч хоёр талыг хоёуланг нь хянадаг тохиолдолд МҮБЗШҮ үзүүлэгч нь дараах арга хэмжээг авна. Үүнд:

- (a) Сэжигтэй гүйлгээний талаар мэдэгдэх эсэхийг тодорхойлохын тулд шилжүүлэгч ба хүлээн авагч хоёр талын бүх мэдээллийг авна;
- (b) Сэжигтэй цахим мөнгөн шилжүүлэг хийгдсэн аливаа улсад сэжигтэй гүйлгээг мэдэгдэх болон Санхүүгийн мэдээллийн албанд холбогдох гүйлгээний мэдээллийг бэлэн байлгах.

Санхүүгийн тодорхой хориг арга хэмжээний хэрэгжилт

16.18 Улс орнууд нь цахим мөнгөн шилжүүлгийн хүрээнд санхүүгийн байгууллагаас НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн 1267 ба 1373, уламжлан гарсан бусад шийдвэрүүдэд хамаарах тогтоол, терроризм, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох тухай НҮБ-ын Аюулгүй Зөвлөлийн холбогдох тогтоолд тусгагдсан үүргийн дагуу нэрлэсэн этгээд болон байгууллагатай гүйлгээ хийх хориглолтыг дагаж мөрдөх ба царцаах арга хэмжээ авах үйл ажиллагааг хангасан байхыг шаардана.

⁴⁰ Улс орнууд 1000 ам.доллар/евро болон түүнээс дээшгүй хил дамнасан мөнгөн шилжүүлэгт доод босгыг тогтоож болно. Хэдий тийм боловч босгоос хэтрэхгүй байгаа гадаад шилжүүлэгт шилжүүлэгчийн талаарх шаардлагатай, алдаагүй мэдээлэл багтсан байхыг шаардаж болно.

ЗӨВЛӨМЖ 17**ГУРАВДАГЧ ЭТГЭЭДЭД ТУЛГУУРЛАХ**

17.1 Хэрвээ санхүүгийн байгууллага нь Зөвлөмж 10 (харилцагчийн тодорхойлох, эцсийн өмчлөгчийн тодорхойлох, бизнесийн үйл ажиллагааны бодит байдлыг ойлгосон байх)-т заасан харилцагчийг таньж мэдэх арга хэмжээний (а)-(с)-г хэрэгжүүлэх, бизнесийн харилцаа эхлэхдээ гуравдагч санхүүгийн байгууллага ба СББМУҮ-д тулгуурлахаар бол харилцагчийг таньж мэдэх арга хэмжээний эцсийн хариуцлага нь гуравдагч этгээдэд түшиглэж байгаа тухайн санхүүгийн байгууллагад ногдох бөгөөд уг байгууллага дараах зүйлсийг хэрэгжүүлэх шаардлагатай. Үүнд:

- (a) Зөвлөмж 10-т заасан харилцагчийг таньж мэдэх арга хэмжээний (а)-(с)-тэй холбоотой хэрэгцээтэй мэдээллийг яаралтай олж авах;
- (b) Гуравдагч этгээдээс хүсэлт гаргасны үндсэн дээр цаг алдалгүйгээр мэдээлэл болон харилцагчийг таньж мэдэх шаардлагатай бусад холбогдох баримт бичгийн хуулбарыг авах нөхцлийг хангах;
- (c) Гуравдагч этгээд нь зохицуулалттай, хяналт шалгалтад хамрагддаг, мониторинг хийгддэг байхаас гадна Зөвлөмж 10, 11-ийн дагуу харилцагчийг таньж мэдэх ба баримт бичгийг хадгалах шаардлагыг дагаж мөрдөх арга хэмжээтэй байх нөхцлийг хангах.

17.2 Тавигдах шалгуур, нөхцлийг хангасан гуравдагч этгээд нь аль улсад оршиж байгаа эсэхийг тодорхойлохдоо улс орнууд нь тухайн улсын эрсдэлийн түвшингийн талаар мэдээлэлтэй байх шаардлагатай.

17.3 Нэг санхүүгийн нэгдэлд харьялагддаг, гуравдагч этгээдэд тулгуурласан санхүүгийн байгууллагыг холбогдох эрх бүхий байгууллага⁴¹ нь дээр дурдсан шалгуур нөхцлүүдийг дараах нөхцлүүдийг биелүүлсэн тохиолдолд шаардлага хангаж байна гэж үзнэ. Үүнд:

- (a) Санхүүгийн нэгдэл нь Зөвлөмж 10-12-т заасан харилцагчийг таньж мэдэх болон баримт бичиг хадгалах шаардлагыг биелүүлэхээс гадна Зөвлөмж 18-ын дагуу мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хөтөлбөртэй байх;
- (b) Тухайн хөтөлбөр болон шаардлагуудын хэрэгжилтэд эрх бүхий байгууллагаас нэгдлийн хэмжээнд хяналт тавьдаг;
- (c) Нэгдлийн мөнгө угаах, терроризм санхүүжүүлэхтэй тэмцэх бодлого нь өндөр эрсдэлтэй аливаа улс орны эрсдэлийг бууруулах арга хэмжээг агуулсан байна.

⁴¹ Зөвлөмж 17-д дурдсан холбогдох эрх бүхий байгууллага гэх нэр томъёонд 1/нэгдлийн бодлогын талаар ойлголттой бөгөөд нэгдлийг бүхэлд нь хянадаг дотоодын байгууллага болон 2/ салбар, харьяат этгээдүүдэд хамааралтай хүлээн авагч улсын байгууллагыг ойлгоно.

ЗӨВЛӨМЖ 18**ДОТООД ХЯНАЛТ БОЛОН ГАДААД ДАХЬ САЛБАР, ОХИН КОМПАНИ**

18.1 Санхүүгийн байгууллагууд нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэл болон бизнесийн хэмжээг харгалзан үзэж боловсруулсан мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх дараах зүйлсийг агуулсан дотоод бодлого, журам болон хяналтыг агуулсан хөтөлбөртэй байх шаардлагатай. Үүнд:

- (a) Удирдлагын түвшинд хэрэгжилтийг хангах тогтолцоо (удирдлагын түвшинд хэрэгжилтийн мэргэжилтэнг томилохыг оролцуулаад);
- (b) Ажилтан шинээр ажилд сонгон шалгаруулж авахад шаардлагатай өндөр стандарт бүхий журам;
- (c) Ажилтны давтан сургах хөтөлбөр;
- (d) Үйл ажиллагааг хянах хөндлөнгийн аудитын чиг үүрэг.

18.2 Санхүүгийн нэгдэл нь бүх салбар болон ихэнх хувь эзэмшдэг харьяа этгээдүүдэд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хөтөлбөрийг нэгдлийн хэмжээнд хэрэгжүүлэх шаардлагатай. Үүнд 18.1-т тодорхойлсон шалгуур үзүүлэлтийн арга хэмжээ болон доорх зүйлс багтана. Үүнд:

- (a) Харилцагчийг таньж мэдэх болон мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн удирдах зорилгоор мэдээлэл солилцох бодлого, журамтай байна;
- (b) Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх зорилгоор шаардлагатай бол салбар, харьяа этгээдүүдээс ирүүлэх гүйлгээний мэдээлэл, данс, харилцагч, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэхтэй холбоотой зүйл заалтууд, аудит, хэрэгжилтийн талаар нэгдлийн хэмжээнд нөхцлийг бүрдүүлсэн байх;
- (c) Солилцсон мэдээллийн нууцлал аюулгүй байдлыг шаардлагатай түвшинд ханган.

18.3 Тухайн салбар компаниуд байршиж байгаа гадаад улсын МУТСТ тогтолцоо өөрийн толгой компанийн байршиж байгаа улс орныхоос шаардлага нь сул бөгөөд тухайн орны хууль, эрх зүйн тогтолцоо зөвшөөрдөг тохиолдолд бусад орнуудад оршдог салбар, ихэнх хувь нь эзэмшилд байдаг охин компаниуд нь толгой компанийн улсад тавигддаг МУТСТ арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай.

Хэрвээ тухайн улс орны хууль, эрх зүйн тогтолцоо толгой компанийн улсад тавигддаг МУТСТ арга хэмжээг хэрэгжүүлэх боломжгүй тохиолдолд санхүүгийн нэгдэл нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг удирдах зохистой, нэмэлт арга хэмжээг хэрэглэж, үндсэн улсын хянан шалгагч нарт мэдэгдэх шаардлагатай.

ЗӨВЛӨМЖ 19**ӨНДӨР ЭРСДЭЛТЭЙ УЛС ОРНУУД**

19.1 Санхүүгийн байгууллага нь ФАТФ-аас зөвлөсөн тодорхой улс орнуудын хувь хүн, хуулийн этгээд (санхүүгийн байгууллага орно)-тэй тогтоох бизнес харилцаа, гүйлгээнд эрсдэлээс хамаарч нэмэлт таньж мэдэх арга хэмжээг авах шаардлагатай.

19.2 Улс орнууд нь (а) ФАТФ-аас зөвлөсөн, (б) ФАТФ-аас тусдаа зөвлөсөн тохиолдолд тухайн эрсдэлтэй уялдсан хариу арга хэмжээг авах боломжтой байх шаардлагатай.

19.3 Бусад улс орнуудын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцооны дутагдлын талаар санхүүгийн байгууллагад зөвлөгөө өгдөг арга механизмыг хэрэгжүүлсэн байх шаардлагатай.

ЗӨВЛӨМЖ 20**СЭЖИГТЭЙ ГҮЙЛГЭЭГ МЭДЭЭЛЭХ⁴²**

20.1 Хэрвээ санхүүгийн байгууллага нь аливаа хөрөнгийг гэмт үйлдлээс⁴³ гаралтай орлого байх мөн терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой гэж сэжиглэх эсвэл сэжиглэх үндэслэл байвал Санхүүгийн мэдээллийн албанд яаралтай мэдэгдэх шаардлагатай.

20.2 Санхүүгийн байгууллага нь гүйлгээний дүнгээс үл хамааран гүйлгээ хийхийг завдахыг оролцуулаад бүх сэжигтэй гүйлгээг мэдэгдэж байх шаардлагатай.

⁴² Сэжигтэй гүйлгээг мэдээлэх талаарх шаардлагыг хуулинд тусгах ёстой.

⁴³ Гэмт үйлдэл гэдэгт (а) тухайн улсын мөнгө угаах гэмт хэргийн суурь гэмт хэрэгт тооцогддог бүх гэмт хэрэг, үйлдэл эсвэл (b) хамгийн багадаа Зөвлөмж 3-т шаардсан урьдчилан тодорхойлсон гэмт үйлдэл гэж тооцогдох үйлдлүүд хамаарна.

ЗӨВЛӨМЖ 21**МЭДЭЭЛЛИЙГ ЗАДРУУЛАХ БОЛОН НУУЦЛАЛ**

21.1 Санхүүгийн байгууллага, түүний захирал, мэргэжилтэн, ажилтан нь Санхүүгийн мэдээллийн албанд сэжиглэх үндэслэлийг өөрийн итгэл үнэмшилээр мэдүүлсэн бол гэрээ, хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээгээр тодорхойлсон мэдээллийн нууцлалыг ил болгох, дамжуулах хориглолтыг зөрчсөний улмаас үүдэх эрүүгийн болон иргэний хариуцлагаас хуулиар чөлөөгдөж хамгаалагдах шаардлагатай. Энэхүү хамгаалалт нь мэдүүлэгч цаад гэмт хэргийн үйл ажиллагааны талаар тодорхой мэдэхгүй байх, гэмт хэрэг бодитоор гарсан эсэхээс үл хамааран үйлчлэх шаардлагатай.

21.2 Санхүүгийн байгууллага, түүний захирал, мэргэжилтэн, ажилтан нь сэжигтэй гүйлгээ болон холбогдох мэдээллийг Санхүүгийн мэдээллийн албанд өгсөн талаар бусдад мэдэгдэх явдлыг хуулиар хориглох шаардлагатай.

ЗӨВЛӨМЖ 22**САНХҮҮГИЙН БУС БИЗНЕС БОЛОН МЭРГЭЖЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧ НАР (СББМУҮ): ХАРИЛЦАГЧИЙГ ТАНЬЖ МЭДЭХ**

22.1 СББМУҮ нь дараах нөхцөлд зөвлөмж 10-т заасан харилцагчийг таньж мэдэх шаардлагыг дагаж мөрдөх шаардлагатай. Үүнд:

- (a) Казино – Харилцагч 3000 ам.доллар/евротой тэнцүү болон түүнээс дээш санхүүгийн гүйлгээ⁴⁴ хийх үед;
- (b) Үл хөдлөх хөрөнгийн зуучлагч – харилцагчийн өмнөөс үл хөдлөх хөрөнгө⁴⁵ худалдах, худалдан авах үйл ажиллагаанд оролцож байгаа үед;
- (c) Үнэт металл болон үнэт чулуун эдлэл арилжаалагчид – 15,000 ам.доллар/евротой тэнцүү болон түүнээс дээш бэлэн мөнгөний гүйлгээг харилцагчтай хийх үед;
- (d) Өмгөөлөгч, нотариатч, бусад бие даасан хуулийн мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч болон нягтлан бодогч нар харилцагчид зориулан дараах үйл ажиллагаатай холбогдуулж гүйлгээнд бэлтгэх, хийх үед. Үүнд:
 - Үл хөдлөх хөрөнгө худалдах, худалдан авах;
 - Мөнгөн хөрөнгө, үнэт цаас болон бусад хөрөнгийг удирдах;
 - Банкны, хадгаламжийн болон үнэт цаасны дансыг удирдах;
 - Компани үүсгэн байгуулах, үйл ажиллагааг нь явуулах болон удирдах зорилгоор хөрөнгө босгох/бүрдүүлэх;
 - Хуулийн этгээд болон байгууллага үүсгэн байгуулах, үйл ажиллагааг явуулах, удирдах болон бизнесийн хуулийн этгээдийг худалдан авах, худалдах.
- (e) Траст / итгэлцлийн үйлчилгээ/ болон компанийн үйлчилгээ үзүүлэгч нар харилцагчид зориулан гүйлгээнд бэлтгэх, гүйлгээ хийхэд дараах үйл ажиллагаатай холбогдуулж. Үүнд:
 - Хуулийн этгээдийг үүсгэн байгуулах төлөөлөгчөөр ажиллах;
 - Компанийн захирал, нарийн бичгийн дарга, нөхөрлөлийн хамтрагч, бусад хуулийн этгээдтэй холбоотой ижил албан тушаалтны хувиар ажиллах (эсвэл бусад этгээдийг ийм үйл ажиллагаа явуулахад зохион байгуулах);
 - Компани, нөхөрлөл эсвэл бусад хуулийн этгээд, тогтолцоонд бүртгэлтэй байр, бизнес хаяг, оршин байх газар, харилцагч болон захиргааны хаягийг бий болгох;
 - Шуурхай итгэлцлийн үйлчилгээний эсвэл хуулийн тогтолцооны бусад хэлбэрт ижил чиг үүрэг гүйцэтгэхэд итгэл хүлээлгэгч болох (бусад этгээдийг ийм үйл ажиллагаа явуулах талаар зохион байгуулах);

⁴⁴ Казинод ороход харилцагчийн биеийн байцаалтыг шалгах нь хангалттай байж болно. Улс орнууд казинод тодорхой харилцагчийг таньж мэдэх мэдээллийг казинод гүйлгээ хийж байгаа харилцагчтай холбож чаддаг байх шаардлагатай. “Санхүүгийн гүйлгээ” нь казиногийн чип, токеноор хийх мөрий тавьсан гүйлгээнд хамаагүй.

⁴⁵ Энэ нь үл хөдлөх хөрөнгийн зуучлагч Зөвлөмж 10-т заасан шаардлагуудыг тухайн хөрөнгийг худалдан авагч, худалдагчтай холбоотой дагаж мөрдөх ёстой гэж ойлгоно.

- Бусад этгээдийн өмнөөс нэрлэсэн хувьцаа эзэмшигчийн үүрэг гүйцэтгэх (бусад этгээдийг дээрх үйл ажиллагаа явуулах талаар зохион байгуулах).

22.2 Шалгуур 22.1-т заасан нөхцөл байдалд СББМҮҮ нь Зөвлөмж 11-т тодорхойлсон баримт бичиг хадгалах шаардлагыг дагаж мөрдөх шаардлагатай.

22.3 Шалгуур 22.1-т заасан нөхцөл байдалд СББМҮҮ нь Зөвлөмж 12-т тодорхойлсон улс төрд нөлөө бүхий этгээдийн талаарх шаардлагыг дагаж мөрдөх шаардлагатай.

22.4 Шалгуур 22.1-т заасан нөхцөл байдалд СББМҮҮ нь Зөвлөмж 15-т тодорхойлсон шинэ технологийн талаар шаардлагыг дагаж мөрдөх шаардлагатай.

22.5 Шалгуур 22.1-т заасан нөхцөл байдалд СББМҮҮ нь Зөвлөмж 15-т тодорхойлсон гуравдагч этгээдэд тулгуурлаж буй нөхцөлд тавигдах шаардлагыг дагаж мөрдөх шаардлагатай.

ЗӨВЛӨМЖ 23**СББМҮҮ: БУСАД АРГА ХЭМЖЭЭ**

23.1 Зөвлөмж 20-т заасан сэжигтэй гүйлгээг мэдээлэх шаардлага нь дараах нөхцөлд бүх СББМҮҮ-д хамааралтай байна. Үүнд:

- (a) Өмгөөлөгч, нотариатч, бусад хуулийн мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч болон нягтлан бодогч⁴⁶ нар харилцагчид болон тэдгээрийн нэрийн өмнөөс шалгуур 22.1 d⁴⁷-д заасан үйл ажиллагаатай холбоотой санхүүгийн гүйлгээ хийх үед;
- (b) Үнэт металл болон үнэт чулуун эдлэл арилжаалагчид– 15,000 ам.доллар/евротой тэнцүү болон түүнээс дээш бэлэн мөнгөний гүйлгээг харилцагчтай хийх үед,
- (c) Траст /итгэлцлийн үйлчилгээ/ болон компанийн үйлчилгээ үзүүлэгч нар харилцагч болон түүний нэрийн өмнөөс шалгуур 22.1 (e)-д тодорхойлсон үйл ажиллагаатай холбоотой гүйлгээнд орох үед.

23.2 Шалгуур 23.1-т заасан нөхцөл байдалд СББМҮҮ нь Зөвлөмж 18-д тодорхойлсон дотоод хяналтын шаардлагыг дагаж мөрдөх шаардлагатай.

23.3 Шалгуур 23.1-т заасан нөхцөл байдалд СББМҮҮ нь Зөвлөмж 19-д тодорхойлсон өндөр эрсдэлтэй улс орнуудад тавигдах шаардлагыг дагаж мөрдөх шаардлагатай.

23.4 Шалгуур 23.1-т заасан нөхцөл байдалд СББМҮҮ нь Зөвлөмж 21⁴⁸-т тодорхойлсон мэдээллийг задруулах болон нууцлалыг хадгалах шаардлагыг дагаж мөрдөх шаардлагатай.

⁴⁶ Хуульч, нотариатч, бусад хуулийн мэргэжилтэн, хууль зүйн бие даасан мэргэжилтэн гэж тооцогддог нягтлан бодогч нь аливаа мэдээллийг мэргэжлийн нууцлал болон албан үүргийнхээ дагуу эдлэх давуу бүрэн эрхийн зохицуулалтын хүрээнд олж авсан бол уг холбогдох мэдээллийг сэжигтэй гүйлгээгээр мэдэгдэх шаардлагад хамааруулж мэдэгдэхийг шаардахгүй. Улс орон бүр өөрсдөө өмгөөлөгчийн, мэргэжлийн нууцлал болон албан үүргийн дагуу эдлэх давуу эрхэд ямар асуудал хамаарахыг тогтооно. Энэ нь ерөнхийдөө өмгөөлөгч, нотариатч, хуулийн бусад мэргэжлийн үйлчилгээ эрхлэгч нар харилцагчаас болон тэдгээрээр дамжуулан (a) тухайн харилцагчийн хууль, эрх зүйн байдлыг тогтоох явцад; (b) тухайн харилцагчийг шүүх, захиргааны, арбитрагийн болон зуучлалын үйл явцад төлөөлөх болон өмгөөлөх явцад олж авсан мэдээлэл ордог.

⁴⁷ Хэрвээ улс орнууд нь хуульч, нотариатч, бусад хуулийн мэргэжилтэн, нягтлан бодогч сэжигтэй гүйлгээний мэдээллийг сайн дурын зохицуулалттай байгууллагад мэдэгдэхийг зөвшөөрдөг тохиолдолд тэдгээр байгууллага болон Санхүүгийн мэдээллийн албаны хооронд хамтын ажиллагааны хэлбэр тогтсон байх шаардлагатай.

⁴⁸ Хуульч, нотариатч, бусад хуулийн мэргэжилтэн, нягтлан бодогч нь харилцагчийг хууль бус үйлдэл хийхээс таслан зогсоох арга хэмжээ авсан тохиолдлыг харилцагчийн мэдээллийг задруулсанд тооцохгүй.

ЗӨВЛӨМЖ 24**ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ЭЦСИЙН ӨМЧЛӨГЧ⁴⁹ БОЛОН ИЛ ТОД БАЙДАЛ**

24.1 Улс орнууд нь (а) тухайн улсын хуулийн этгээдийн төрөл, хэлбэр, үндсэн онцлог болон (b) тэдгээр хуулийн этгээдийг үүсгэн байгуулах болон үндсэн болон эцсийн өмчлөгчийн талаар мэдээллийг олж авах, тайлбарлах журмыг тогтоож тодорхойлох механизмыг бүрдүүлсэн байх шаардлагатай. Тэрхүү мэдээлэл нь нийтэд ил тод байна.

24.2 Улс орнууд нь тухайн улсад үүсгэн байгуулж байгаа бүх төрлийн хуулийн этгээдтэй холбоотой мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг үнэлэх шаардлагатай.

Үндсэн мэдээлэл

24.3 Улс орнууд нь тухайн улсад үүсгэн байгуулагдах компаниудаас компанийн нэр, үүсгэн байгуулсныг гэрчлэх нотолгоо, хэлбэр ба эрх зүйн байдал, бүртгүүлсэн ажлын хаяг, үндсэн зохицуулалтын эрх хэмжээ болон захирлуудын жагсаалт зэргийг компанийн бүртгэлд бүртгүүлэхийг шаардах ёстой. Энэхүү мэдээлэл нийтэд ил тод байна.

24.4 Компаниуд нь шалгуур 24.3-т заасан мэдээллийг хадгалах болон хувьцаа эзэмшигч бүрийн хувьцааны тоо, хувьцааны төрөл (саналын эрхийн талаар)-ийг агуулсан хувьцаа эзэмшигч, гишүүдийн⁵⁰ бүртгэлийг хадгалах шаардлагатай. Энэхүү мэдээлэлийг компанийн бүртгэлд⁵¹ тусгасан тухайн улс дахь тодорхой газарт /байршил/ хадгална.

24.5 Улс орнууд нь шалгуур 24.3 ба 24.4-т заасан мэдээлэл алдаагүй бөгөөд тодорхой хугацаанд шинэчлэгддэг байх механизмтай байна.

Эцсийн өмчлөгчийн мэдээлэл

24.6 Улс орнууд нь эцсийн өмчлөгчийн талаарх мэдээллийг компани нь олж авдаг, тухайн улсад оршдог тодорхой байршилд бэлэн байлгадаг эсвэл эрх бүхий байгууллага хугацаа алдахгүйгээр мэдээлэл олж авахад зориулж дараах механизмаас нэг буюу түүнээс дээш аргыг хэрэглэх шаардлагатай:

- (а) Компанийн эцсийн өмчлөгчийн талаарх мэдээллийг олж авах ба сүүлийн үеийн байдлаар шинэчлэж байхыг компаниас болон бүртгэгчээс шаардах,

⁴⁹ Үнэлгээчид нь эдгээр шаардлагыг бүх төрлийн хуулийн этгээдэд үйлчилж байгаа эсэхийг үнэлэх шаардлагатай. Эдгээр шаардлагуудыг хэрхэн хэрэгжүүлж байгаа нь хуулийн этгээдийн төрлөөс хамаарч өөр өөр байж болно. Үүнд:

1. Компани – Зөвлөмж 24-т заасан арга хэмжээ нь компанид тусгайлан тавигдана.
2. Сан, Анстатт, хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөл- Улс орнууд тэдгээрийн ялгаатай хэлбэр, бүтцийг анхаарч компанид тавигддаг ижил шалгуурыг тавих шаардлагатай.
3. Бусад хэлбэрийг хуулийн этгээд- Улс орнууд тодорхой хэмжээний ил тод байдлыг хангах зорилгоор бусад хэлбэрийн хуулийн этгээдийн тэдгээрийн ялгаатай хэлбэр, бүтэц болон хэлбэр тус бүрийн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг тооцож үзэх шаардлагатай. Хамгийн багадаа бүх хуулийн этгээд нь ижил төрлийн үндсэн мэдээллийг хадгална.

⁵⁰ Хувьцаа эзэмшигч болон гишүүдийн бүртгэлийг нь компани өөрөө болоод компани хариуцлагыг нь хүлээж гуравдагч этгээдээр хөтлүүлж болно.

⁵¹ Хэрвээ компани нь эцсийн өмчлөлийн мэдээллийг тухайн улсад хадгалдаг, хүссэн цагт шуурхай гаргаж өгдөг бол компанийн хувьцаа эзэмшигч болон гишүүдийн бүртгэл тус улсад заавал байх шаардлагагүй.

- (b) Компанийн эцсийн өмчлөгчийн талаарх мэдээллийг олж авах боломжит арга хэрэгслийг хэрэглэх болон сүүлийн үеийн байдлаар шинэчилж байхыг компаниас шаардах,
- (c) Байгаа мэдээллийг ашиглах, доорхийг оролцуулаад: (i) Зөвлөмж 10 болон 22-ын дагуу санхүүгийн байгууллага, СББМҮҮ-ийн олж авсан мэдээлэл, (ii) Бусад эрх бүхий байгууллагад байгаа компанийн хуулийн болон эцсийн өмчлөгчийн талаарх мэдээлэл, (iii) Дээр дурдсан шалгуур 24.3-аар шаардсан компанид байгаа мэдээлэл, (iv) мэдээллийг ил тод байлгах шаардлага нь эцсийн өмчлөгчийг тодорхой болгоход хангалттай бол хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй компаниудын мэдээлэл зэрэг багтана.

24.7 Улс орнууд нь эцсийн өмчлөгчийн мэдээлэл алдаагүй бөгөөд аль болох сүүлийн үеийн байдлаар шинэчилсэн байхыг шаардах шаардлагатай.

24.8 Улс орнууд нь эцсийн өмчлөгчийг бүрэн хэмжээнд тодорхойлох зорилгоор эрх бүхий байгууллагатай компани нь хамтарч ажиллахыг дараах байдлаар шаардана. Үүнд:

- (a) Эцсийн өмчлөгчийн талаар үндсэн бүх боломжит мэдээллийг гаргаж өгөх ба цаашлаад эрх бүхий байгууллагуудад туслалцаа үзүүлэхээр үүрэг хүлээсэн тухайн улсад оршин суух нэг болон түүнээс дээш хувь хүмүүсийг компаниас⁵² томилох.
- (b) Эцсийн өмчлөгчийн талаар үндсэн бүх боломжит мэдээллийг гаргаж өгөх ба цаашлаад эрх бүхий байгууллагуудад туслалцаа үзүүлэхээр үүрэг хүлээсэн тухайн улс дахь СББМҮҮ-ийг компаниас томилохыг шаардах.
- (c) Тухайн улсаас тухайлан тодорхойлсон бусад дүйцэхүйц арга хэмжээг авах.

24.9 Дээр дурдсан бүх хувь хүн, эрх бүхий байгууллага, хуулийн этгээд болон компанийн (зохион байгуулагч, татан буулгагч эсвэл компанийг татан буулгахад оролцож буй бусад этгээдүүд) нь компани татан буугдсан эсвэл бусад байдлаар оршин тогтнохгүй болсон өдрөөс хойш хамгийн багадаа 5 жилийн хугацаанд эсвэл компани мэргэжлийн зуучлалын ба санхүүгийн байгууллагын харилцагч байхаа зогсоосон өдрөөс хойш хамгийн багадаа 5 жилийн хугацаанд мэдээлэл, баримт бичгийг хадгалах шаардлагатай.

Бусад шаардлага

24.10 Эрх бүхий байгууллага ялангуяа хууль сахиулах байгууллага нь холбогдох талуудын мэдэлд байгаа үндсэн болон эцсийн өмчлөлийн мэдээллийг цаг хугацаанд нь авахад шаардагдах эрх мэдэлтэй байна.

24.11 Хуулийн этгээд нь дамжуулах хувьцаа (bearer share) эсвэл түүнийг худалдан авах эрх гаргахыг зөвшөөрдөг улс орнуудын хувьд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх зорилгоор ашиглуулахгүй байх нөхцлийг хангах үүднээс дараах арга хэрэгслийг ашиглах шаардлагатай. Үүнд:

- (a) Дамжуулах хувьцаа эсвэл түүнийг худалдан авах эрх гаргахыг хориглох;
- (b) Дамжуулах хувьцаа эсвэл түүнийг худалдан авах эрхийг бүртгүүлсэн хувьцаа, хувьцаа худалдан авах эрхэд хөрвүүлэх (жн:, dematerialization замаар);

⁵² Компанийн ТУЗ ба гүйцэтгэх удирдлагын гишүүд компаниас тухайлсан зөвшөөрөл авах шаардлагагүй байж болно.

ФАТФ-ын зөвлөмжийн техникийн хэрэгжилт болон МУТСТ тогтолцооны үр дүнтэй байдлыг үнэлэх

- (c) Дамжуулах хувьцаа эсвэл түүнийг худалдан авах эрхийг зохицуулалттай санхүүгийн байгууллага ба мэргэжлийн зуучлагчийн эзэмшилд байхыг шаардах замаар тэдгээрийн шилжүүлгийг хязгаарлах;
- (d) Хувьцааны хяналтын багцыг эзэмшигч нь компанид мэдэгдэх болон компани тэдгээр этгээдийн мэдээллийг хадгалдаг байхыг шаардах,
- (e) Тухайн улсаас тодорхойлсон бусад арга хэрэгслийг хэрэглэх.

24.12 Хуулийн этгээд нэрлэсэн хувьцаа, нэрлэсэн захирлуудтай байх боломжтой улс орнуудын хувьд тэдгээрийг буруу замаар ашиглахгүй байхыг хангах дараах арга хэмжээнүүдийг авах шаардлагатай:

- (a) Нэрлэсэн хувьцаа эзэмшигч, захирлуудад тэдгээрийг нэр дэвшүүлсэн этгээдийн талаарх мэдээллийг компанид болон бүртгэлийн байгууллагад гаргаж өгөхийг шаардах бөгөөд энэхүү мэдээлэл нь бүртгэлд агуулагдаж байх шаардлагатай.
- (b) Компанийн бүртгэлд нэрлэсэн гэх статусыг тусгах, нэр дэвшүүлэгчийг тодорхойлох мэдээллийг хадгалахын тулд нэрлэсэн хувьцаа эзэмшигч болон захирлууд бүртгүүлдэг байх, тэрхүү мэдээллийг эрх бүхий байгууллагын хүсэлтээр гаргаж өгөхөд бэлэн байхыг шаардах.
- (c) Тухайн улсаас тодорхойлсон бусад арга хэрэгслийг хэрэглэх.

24.13 Тавигдсан шаардагуудыг дагаж мөрдөхгүй байгаа аливаа хуулийн болон хувь хүмүүст гаргасан зөрчилтэй нь дүйцэхүйц, давтан үйлдэхээс сэргийлсэн шийтгэлийн арга хэмжээг авна.

24.14 Улс орнууд нь гадаад хамтын ажиллагааны хүрээнд Зөвлөмж 37 ба 40-д тусгасны дагуу үндсэн болон эцсийн өмчлөгчийн талаар дараах мэдээллийг агуулсан мэдээллийг хугацаа алдахгүй гаргаж өгнө. Үүнд:

- (a) Компанийн бүртгэгчид байгаа үндсэн мэдээллийг гадаадын эрх бүхий байгууллагад гаргаж өгөх боломжоор хангах,
- (b) Хувьцаа эзэмшигчдийн талаарх мэдээллийг солилцох,
- (c) Гадаадын эрх бүхий байгууллагын нэрийн өмнөөс эцсийн өмчлөгчийн мэдээллийг олж авахын тулд дотоодын хууль тогтоомжийн дагуу эрх бүхий байгууллагын мөрдөн шалгах эрх хэмжээг ашиглах.

24.15 Улс орнууд нь үндсэн болон эцсийн өмчлөгчийн мэдээллийг олж авах хүсэлтийн хариу, гадаадад оршин суугаа эцсийн өмчлөгчийн байршлыг тогтоох талаар бусад улс орнуудын хүссэн хүсэлтийн дагуу үзүүлж байгаа тусалцааны чанарыг хянаж байх шаардлагатай.

ЗӨВЛӨМЖ 25**ЭРХ ЗҮЙН БУСАД ЗОХИЦУУЛАЛТ БҮХИЙ ЭТГЭЭДИЙН⁵³
ИЛ ТОД БАЙДАЛ БОЛОН ЭЦСИЙН ӨМЧЛӨГЧ**

25.1 Улс орнууд нь доорх зүйлсийг шаардах шаардлагатай. Үүнд:

- (a) Итгэл хүлээгч нь итгэл хүлээлгэгчийн тухайн мэдээлэл, хамгаалагч (байгаа бол), үр шим хүртэгч эсвэл үр шим хүртэгчдийн бүлэг болон итгэлцэлд эцсийн үр нөлөө бүхий удирдлагыг хэрэгжүүлж буй бусад хувь этгээдийг тодорхойлж алдаагүй, хангалттай, сүүлийн үеийн мэдээллийг улс орны хууль тогтоомжоор⁵⁴ зохицуулагддаг шуурхай итгэлцлийн зүгээс олж авч хадгална;
- (b) Хөрөнгө оруулалтын зөвлөгч, менежер, нягтлан бодогчид, татварын зөвлөгч зэрэг итгэлцэлд үйлчилгээ үзүүлэгч бусад зохицуулалттай төлөөлөгчийн талаарх үндсэн мэдээллийг тухайн улсын хуулиар зохицуулагддаг итгэл хүлээгч нь хадгалдаг байх;
- (c) Итгэлцлийн үйл ажиллагаагаа явуулахаа зогсоосноос хойш хамгийн багадаа 5 жилийн хугацаанд мэргэжлийн итгэлцэл нь дээрх мэдээллийг хадгалах шаардлагатай.

25.2 Энэхүү зөвлөмжийн дагуу хадгалах аливаа мэдээлэл нь алдаагүй, аль болох шинэчлэгдсэн болон тодорхой хугацаанд шинэчлэгддэг байхыг улс орнууд шаардах ёстой.

25.3 Тогтоосон босгоос дээш үнийн дүн бүхий тохиолдлын гүйлгээ болон бизнесийн харилцаа тогтоохдоо итгэл хүлээгч нь өөрийн статусыг санхүүгийн байгууллага ба СББМҮҮ-д мэдэгдэх арга хэмжээг авахыг улс орнууд шаардах шаардлагатай.

25.4 Итгэл хүлээгч нь итгэлцэлтэй⁵⁵ холбоотой аливаа мэдээллийг эрх бүхий байгууллагад дамжуулах эсвэл эцсийн өмчлөгчийн болон бизнес харилцааны нөхцлийн дагуу эзэмшин захирч байгаа итгэлцлийн хөрөнгийн талаарх мэдээллийг бизнесийн байгууллага СББМҮҮ-ийн хүсэлтээр дамжуулахыг хууль болон албадлагын арга хэмжээгээр хязгаарлах ёсгүй.

25.5 Эрх бүхий байгууллага, ялангуяа хууль сахиулах байгууллагад (a) эцсийн өмчлөгчийн мэдээлэл, (b) итгэл хүлээгчийн оршин байгаа газрын мэдээлэл, (c) бизнес харилцаатай эсвэл тохиолдлын чанартай гүйлгээ хийдэг итгэлцэлтэй холбогдсон санхүүгийн байгууллага болон СББМҮҮ нарын хадгалж удирддаг аливаа хөрөнгийн мэдээллийг эзэмшиж байгаа итгэлцэл болон бусад этгээдээс цаг тухайд нь гаргуулж авах бүрэн эрхийг олгосон байх шаардлагатай.

⁵³ Зөвлөмж 25-д заасан шаардлагууд нь итгэлцэлд тусгайлан хамаарна. Нэр томъёоны хэсэгт тодорхойлсон шуурхай итгэлцэлтэй холбоотой байхаар ойлгогдох ёстой. Ижил бүтэц, чиг үүрэгтэй хуулийн бусад эрх зүйн бусад зохицуулалт бүхий этгээдтэй холбоотойгоор улс орнууд ижил түвшний ил тод байдлыг хангах зорилгоор итгэлцэлд тавигддаг шаардлагыг мөн адил тавих ёстой. Хамгийн багадаа улс орнууд нь итгэлцэлд хамаарахаар тусгайлсантай ижил байдлаар мэдээлэл бүрдүүлж, уг мэдээллийг эрх бүхий байгууллагаас цаг хугацаанд нь олж авах болон алдаагүй, хуучраагүй байх нөхцлийг хангах ёстой.

⁵⁴ Улс орнуудыг итгэлцлийг хуулиар хүлээн зөвшөөрсөн байхыг шаардахгүй. Нийтлэг болон жишиг эрх зүйгээр ижилхэн нөлөөлөл агуулсан зохистой үүрэг трастад оногддог бол шалгуур 25.1, 25.2, 25.3, 25.4-т заасан шалгуурыг тусгах шаардлагагүй.

⁵⁵ Дотоодын эрх бүхий байгууллага болон Олон улсын хамтын ажиллагааны дагуу хүсэлт гаргасан бусад улсын эрх бүхий холбогдох байгууллага.

ФАТФ-ын зөвлөмжийн техникийн хэрэгжилт болон МУТСТ тогтолцооны үр дүнтэй байдлыг үнэлэх

25.6 Зөвлөмж 37, 40-д заасны дагуу итгэлцэл болон бусад эрх зүйн бусад зохицуулалт бүхий этгээдийн талаарх эцсийн өмчлөгч зэрэг мэдээлэлтэй холбоотой олон улсын хамтын ажиллагааг дараах байдлаар хурдан шуурхай зохион байгуулна. Үүнд:

- (a) Бүртгэгч эсвэл дотоодын бусад эрх бүхий байгууллагын мэдэлд байгаа үндсэн мэдээллийг гадаадын ижил төрлийн байгууллага авах нөхцлөөр хангах;
- (b) Итгэлцэл ба бусад эрх зүйн бусад зохицуулалт бүхий этгээдийн талаарх мэдээллийг дотооддоо солилцох;
- (c) Гадаадын эрх бүхий байгууллагын өмнөөс эцсийн өмчлөгчийн мэдээллийг олж авахын тулд эрх бүхий байгууллагын мөрдөх эрх хэмжээг дотоодын хуулийн дагуу ашиглах.

25.7 Улс орнууд нь (a) өөрсдийн холбогдох үүргийг гүйцэтгэж чадахгүй байгаа тохиолдолд хуулийн хариуцлага хүлээлгэх эсвэл (b) итгэлцэлтэй холбоотой хэм хэмжээг дагаж мөрдөхгүй бол⁵⁶ зөрчилтэй нь дүйцэхүйц давтан үйлдэхээс сэргийлсэн эрүүгийн, иргэний, захиргааны шийтгэл арга хэмжээг авах шаардлагатай.

25.8 Итгэлцэлтэй холбоотой 25.1-т дурдсан шалгуурын дагуу эрх бүхий байгууллагад мэдээллийг цаг хугацаанд нь гаргаж өгөөгүй бол зөрчилтэй нь дүйцэхүйц, давтан үйлдэхээс сэргийлсэн эрүүгийн, иргэний, захиргааны шийтгэлийн арга хэмжээтэй байхыг улс орнуудаас шаардана.

⁵⁶ Энэ нь зөвлөмжөөр тавигдсан бусад шаардлагуудыг дагаж мөрдөхгүй байхад оноох шийтгэлд нөлөөлөхгүй.

ЗӨВЛӨМЖ 26**САНХҮҮГИЙН
ЗОХИЦУУЛАЛТ****БАЙГУУЛЛАГУУДЫН****ХЯНАЛТ,**

26.1 Улс орнууд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэхэд тавигддаг шаардлагуудыг санхүүгийн байгууллагууд хэрхэн биелүүлж байгааг хянаж шалгах, зохицуулах үүрэг бүхий нэг буюу түүнээс дээш тооны хянан шалгах байгууллагыг томилох шаардлагатай.

Зах зээлд нэвтрэх

26.2 Үндсэн зарчмын дагуу санхүүгийн байгууллагууд тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа явуулах шаардлагатай. Мөн мөнгө болон үнэ бүхий зүйл шилжүүлэх үйлчилгээ, мөнгө болон валют солих үйлчилгээ үзүүлж буй бусад санхүүгийн байгууллагууд тусгай зөвшөөрөлтэй эсвэл бүртгүүлсэн байх шаардлагатай. Улс орнууд халхавч банк байгуулах болон дээрх банкны үйл ажиллагааг хүлээн зөвшөөрч баглахгүй.

26.3 Эрх бүхий байгууллагууд болон санхүүгийн хянан шалгагч нар нь гэмт этгээдүүд болон тэдгээртэй нэгдмэл сонирхолтой этгээдүүд санхүүгийн байгууллагын хяналтын буюу ихээхэн хувь хэмжээний багцыг эзэмших (эцсийн өмчлөгч болох) болон удирдлагыг гартаа авахаас сэргийлэхийн тулд хууль, эрх зүйн шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай.

Эрсдэлд суурилсан хяналт шалгалтын арга хэмжээ

26.4 Санхүүгийн байгууллагууд нь:

- (a) *Үндсэн зарчмыг хэрэгжүүлж буй санхүүгийн байгууллагуудын хувьд* – үндсэн зарчмууд⁵⁷-ын дагуу мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэхтэй холбоотой хяналт, зохицуулалтад хамрагдана мөн хамааралтай бол группын хэмжээнд нэгдсэн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэхтэй холбоотой хяналт, зохицуулалтад хамрагдана,
- (b) *Бусад бүх санхүүгийн байгууллагуудын хувьд* – Тухайн салбарын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлтэй нь уялдсан хяналт, зохицуулалтанд хамрагдана. Хамгийн багадаа үндэсний мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх шаардлагыг *мөнгө болон үнэ бүхий зүйл шилжүүлэх, мөнгө болон валют солих үйлчилгээ үзүүлж буй санхүүгийн байгууллагууд хэрхэн биелүүлж байгааг хянах, хэрэгжүүлэх тогтолцоо.*

26.5 Санхүүгийн байгууллагууд, нэгдлүүдийн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэхтэй холбоотой газар дээрх болон зайнаас тавих хяналт шалгалтын давтамж, хамрах хүрээг дараах зүйлст үндэслэн тодорхойлно. Үүнд:

- (a) Хянан шалгагч нь санхүүгийн байгууллага болон нэгдлүүдийн эрсдэлийн хамрах хүрээг үнэлж тодорхойлсны дагуу тэдгээрийн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэл, түүнтэй тэмцэх бодлого, дотоод хяналт болон дүрэм журам;
- (b) Тухайн улс орны мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэл;

⁵⁷ Мөнгө угаах, терроризмтэй тэмцэхтэй холбоотой үндсэн зарчмууд гэдэгт: Базелийн Хорооны Банкны Хяналт Шалгалт (БХБХШ)-ын Зарчмууд 1-3, 5-9, 11-15, 29; Олон Улсын Даатгалын Хянан Шалгагчдын Холбоо(ОУДХШХ)-ны Зарчмууд 1, 3-11, 18, 21-23, 25, Үнэт Цаасны Хорооны Олон Улсын Байгууллага(ҮЦХОУБ)-ын Зарчмууд 24, 28, 29, 31 болон А, В, С, D Үүрэг Хариуцлагууд. Үнэлгээ хийж буй үнэлгээчид тухайн улс орон эдгээр Үндсэн Зарчмуудыг дагаж мөрдөж байгаа эсэхийг үнэлгээндээ ашиглаж болно.

ФАТФ-ын зөвлөмжийн техникийн хэрэгжилт болон МУТСТ тогтолцооны үр дүнтэй байдлыг үнэлэх

- (с) Санхүүгийн байгууллага, нэгдлүүдийн шинж чанар, тодруулбал тэдгээрийн онцлог, тоо болон эрсдэлд суурилсан арга хэмжээний дагуух тэдэнд зөвшөөрсөн эрх мэдлийн хэр хэмжээ.

26.6 Санхүүгийн байгууллага, нэгдлүүдийн удирлагын болон үйл ажиллагааны түвшинд томоохон өөрчлөлт, ахиц дэвшил гарсан даруйд хянан шалгагч нар нь тухайн байгууллагын эрсдэлийн хамрах хүрээг үнэлсэн үнэлгээг дахин авч үзэх шаардлагатай.

ЗӨВЛӨМЖ 27**ХЯНАН ШАЛГАГЧДЫН ЭРХ МЭДЭЛ**

27.1 Хянан шалгагч нар нь санхүүгийн байгууллагуудыг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэхэд тавигдах шаардлагуудыг хэрхэн биелүүлж байгааг хянан шалгах, хэрэгжилтийг хангуулах эрхтэй байх шаардлагатай.

27.2 Хянан шалгагч нар нь санхүүгийн байгууллагуудад хяналт шалгалт хийх бүрэн эрх мэдэлтэй байх шаардлагатай.

27.3 Хянан шалгагч нар нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх шаардлагын хүрээнд хяналт шалгалт хийхтэй холбоотойгоор аливаа мэдээллийг шаардаж авах эрхтэй байна⁵⁸.

27.4 Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэхэд тавигдах шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд хянан шалгагч нар нь 35 дугаар зөвлөмжийн дагуу арга хэмжээ авах эрхтэй байна. Үүнд санхүүгийн байгууллагад захиргааны, санхүүгийн олон төрлийн арга хэмжээ авахаас гадна санхүүгийн байгууллагын тусгай зөвшөөрлийг түр хязгаарлах, түдгэлзүүлэх болон хүчингүй болгох зэрэг байх шаардлагатай.

⁵⁸ Хянан шалгагчийн шалгалт хийх зорилгын үүднээс мэдээлэл гаргуулж авах, мэдээлэлтэй танилцахад заавал шүүхийн шийдвэрийг шаардах ёсгүй.

ЗӨВЛӨМЖ 28**САНХҮҮГИЙН БУС БИЗНЕС БОЛОН МЭРГЭЖЛИЙН
ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧ НАР (СББМҮҮ)-ЫН ХЯНАЛТ
ЗОХИЦУУЛАЛТ**

Казино

28.1 Улс орнууд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх зорилгоор казиног зохицуулах болон түүнд тавих хяналттай байх шаардлагатай. Хамгийн багадаа:

- (a) Улс орнууд казиног тусгай зөвшөөрөлтэй байхыг шаардах ёстой;
- (b) Эрх бүхий байгууллагууд нь гэмт этгээдүүд болон тэдгээртэй нэгдмэл сонирхолтой этгээдүүд казиногийн хяналтын буюу ихээхэн хувь хэмжээний багцыг эзэмших (эцсийн өмчлөгч болох) болон удирдлагыг гартаа авах, үйл ажиллагааг зохицуулах эрх бүхий албан тушаалтан болохоос сэргийлэхийн тулд хууль, эрх зүйн шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай;
- (c) Казиног мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэхэд тавигдах шаардлагын биелүүлж байгаа эсэхэд хяналт тавих шаардлагатай;

Казиногоос бусад СББМҮҮ нар

28.2 Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэхэд тавигдах шаардлагуудыг СББМҮҮ нар биелүүлж байгаа эсэхийг хянах үүрэгтэй тусгай эрх бүхий байгууллага болон сайн дурын зохицуулалттай байгууллага (СДЗБ) байх шаардлагатай.

28.3 Улс орнууд СББМҮҮ нарт хамаарах бусад төрлийн байгууллагуудад мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх шаардлагын хэрэгжилтийг хянах системийг бий болгох хэрэгтэй.

28.4 Тусгай эрх бүхий байгууллага болон СДЗБ нь:

- (a) Хэрэгжилтийн биелэлийг хянаж шалгах зэрэг үйл ажиллагааг гүйцэтгэх хангалттай эрх мэдэлтэй байх шаардлагатай.
- (b) Гэмт этгээдүүд болон тэдгээртэй нэгдмэл сонирхолтой этгээдүүдэд СББМҮҮ нарын хяналтын буюу ихээхэн хувь хэмжээний багцыг эзэмших (эцсийн өмчлөгч болох), удирдлагыг гартаа авах болон мэргэжлийн хувьд аттестатчлагдахаас сэргийлэхийн тулд шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай.
- (c) Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэхэд тавигдах шаардлагуудыг биелүүлээгүй тохиолдолд 35 дугаар зөвлөмжийн дагуу авах шийтгэлийн арга хэмжээтэй байх шаардлагатай.

Бүх СББМҮҮ нар

28.5 СББМҮҮ нарын хяналт шалгалтыг эрсдэлийн мэдрэмж дээр үндэслэж хийж гүйцэтгэх шаардлагатай. Үүнд:

- (a) СББМҮҮ нарын онцлог шинж чанар, тухайлбал тэдгээрийн төрөлжилт, тоог харгалзан үзэж, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг ойлгосны үндсэн дээр мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хяналт шалгалтын давтамж, хамрах хүрээг тодорхойлох;

- (b) СББМҮҮ нарын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх дотоод хяналт, бодлого болон дүрэм журмуудын хангалттай эсэхийг үнэлэхдээ эрсдэлд суурилсан аргачлалын дагуу тэдгээрт олгогдсон эрх мэдлийн хэмжээ, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн хамрах хүрээг авч үзэх.

ЗӨВЛӨМЖ 29**САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЛИЙН АЛБА (СМА)**

29.1 Улс орнууд сэжигтэй гүйлгээний тайлан, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон суурь гэмт хэрэгтэй холбоотой бусад мэдээллийг хүлээн авч, дүн шинжилгээ хийж, шинжилгээний үр дүнг шилжүүлэх үүрэг бүхий үндэсний төв болох СМА-ыг байгуулах шаардлагатай⁵⁹.

29.2 СМА нь мэдээлэх үүрэгтэй этгээдээс ирүүлсэн дараах мэдээллийг хүлээн авах төв байгууллагын үүрэг гүйцэтгэнэ. Үүнд:

- (a) 20 болон 23 дугаар зөвлөмжид тусгасны дагуу мэдээлэх үүрэгтэй этгээдийн ирүүлэх сэжигтэй гүйлгээний тайлангууд;
- (b) Тухайн улсын хууль тогтоомжоор шаардсан бусад аливаа мэдээлэл (бэлэн мөнгөн гүйлгээний тайлангууд, бэлэн бус шилжүүлгийн тайлан болон бусад босго тогтоосон мэдүүлэг/мэдээлэл гэх мэт);

29.3 СМА нь:

- (a) Дүн шинжилгээг зохих ёсоор нь хийж шаардлагатай үед мэдээлэх үүрэгтэй этгээдээс ирүүлэх тайлангаас гадна бусад нэмэлт мэдээллийг гаргуулан авч ашиглах эрхтэй байх;
- (b) Үйл ажиллагаагаа зохих ёсоор гүйцэтгэхэд шаардагдах санхүүгийн, захиргааны болон хууль сахиулахтай холбоотой өргөн цар хүрээний мэдээлэлтэй танилцах⁶⁰.

29.4 СМА нь дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Үүнд:

- (a) Өөрт байгаа болон авч болох мэдээллийг ашиглан гол этгээдүүдийг тодорхойлох, тэдгээрийн явуулж буй үйл ажиллагаа, хийж буй гүйлгээг судлах, тухайн этгээдүүдийн хоорондын холбоо болон мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, түүнтэй холбоотой суурь гэмт хэргийг үйлдсэн эсэх, тухайн үйл ажиллагаанаас олсон орлого зэргийг тодорхойлох “Үйл ажиллагааны дүн шинжилгээ”-г хийх;
- (b) Өөрт байгаа болон бусад эрх бүхий байгууллагуудаас авч болох мэдээ мэдээллийг ашиглан мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх чиг хандлага, төлөв байдлыг тодорхойлох “Стратегийн дүн шинжилгээ”-г хийх.

29.5 СМА нь холбогдох эрх бүхий байгууллагуудын хүсэлтийн дагуу болон тогтмол байдлаар дүн шинжилгээний үр дүн, мэдээллийг шилжүүлэх боломжтой байх шаардлагатай. Тухайн мэдээллийг шилжүүлэхдээ зориулалтын, найдвартай, хамгаалагдсан сувгуудыг ашиглах шаардлагатай.

29.6 СМА нь дараах байдлаар мэдээллийг хамгаалах шаардлагатай. Үүнд:

⁵⁹ СМА-дын олон төрөл байдаг тул 29 дүгээр зөвлөмж нь тухайн улс орон тодорхой нэг төрлийг чөлөөтэй сонгоход хязгаарлалт тавилгүй бүгдэд нь эрх тэгш үйлчлэх заалт орсон.

⁶⁰ Үүнд нээлттэй буюу олон нийтийн эх сурвалжуудын бусад эрх бүхий байгууллагуудын цуглуулсан, эзэмшиж буй холбогдох мэдээлэл, өгөгдөл хийгээд шаардлагатай тохиолдолд бизнесийн байгууллагын мэдээллийг хамруулж үзэх ёстой.

ФАТФ-ын зөвлөмжийн техникийн хэрэгжилт болон МУТСТ тогтолцооны үр дүнтэй байдлыг үнэлэх

- (a) Мэдээллийг ашиглах, хадгалах, шилжүүлэх, хамгаалах, нэвтэрч танилцах зэрэгт тухайн мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг ханган ажиллахыг зохицуулах дүрэм, журамтай байх;
- (b) СМА-ны ажилтнууд нь нууцын зэрэглэлтэй мэдээлэлтэй харилцах, шилжүүлэхтэй холбоотой өөрсдийн үүрэг хариуцлагыг ухамсарлах, аюулгүй байдлын шаардлагыг хангасан байх;
- (c) Мэдээллийн технологийн систем болон мэдээллийн сан руу нэвтэрч ороход хязгаарлалттай байх.

29.7 СМА нь үйл ажиллагааны хувьд хараат бус, бие даасан байх шаардлагатай. Үүнд:

- (a) Тодорхой мэдээлэлд дүн шинжилгээ хийх, мэдээллийг шаардах, дамжуулах, шилжүүлэх зэрэг үйл ажиллагааг чөлөөтэй явуулах бүрэн эрх, боломжтой байх;
- (b) Дотоодын бусад эрх бүхий байгууллагууд, болон гадаадын байгууллагуудтай мэдээлэл солилцохдоо бие даан оролцох боломжтой байх;
- (c) Өөр эрх бүхий байгууллагын бүтэц бүрэлдэхүүнд хамаарч байгаа бол тухайн байгууллагын үйл ажиллагаанаас ялгарах үндсэн үйл ажиллагаатай байх;
- (d) Үйл ажиллагаагаа бие даан тогтвортой байдлаар мөн үйл ажиллагааны хараат бус байдлыг алдагдуулж болох улс төр, Засгийн Газар болон салбарын нөлөөлөл, хөндлөнгийн оролцооноос ангид байдлаар явуулах шаардлагатай нөөцтэй түүнийг захиран зарцуулдаг байх.

29.8 Аливаа улс орон нь СМА-ыг байгуулсан ч Эгмонт Группын гишүүн биш бол тухайн СМА нь Эгмонт Группын гишүүнчлэлд өргөдөл гаргах шаардлагатай. СМА нь Эгмонт Группт гишүүнээр элсэх тухай нөхцөл заагаагүй өргөдлөө илгээж, өргөдлийн процесст өөрөө бүрэн бие даан оролцоно.

ЗӨВЛӨМЖ 30**ХУУЛЬ САХИУЛАХ БОЛОН МӨРДӨН ШАЛГАХ
БАЙГУУЛЛАГУУДЫН ҮҮРЭГ**

30.1 МУТСТ үндэсний бодлого, дүрэм журмын хүрээнд мөнгө угаах, холбогдох суурь гэмт хэрэг болон терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийг зохих ёсоор шалгах үүрэг бүхий хууль сахиулах байгууллагууд байх шаардлагатай.

30.2 Суурь гэмт хэргийг мөрдөн шалгаж буй хууль сахиулах байгууллагууд нь МУТС холбоотой аливаа хэргийг “*санхүүгийн зэрэгцээ мөрдөн шалгалт/parallel financial investigation*”⁶¹ хийх замаар мөрдөн шалгах эрхтэй байх эсвэл тухайн гэмт хэрэг хаана үйлдэгдсэнээс үл хамаарч дээрх мөрдөн шалгалтыг хийдэг өөр байгууллага руу шилжүүлэн шалгуулах эрхтэй байна.

30.3 Гэмт хэрэг үйлдэж олсон орлогоор бий болсон гэж сэжиглэгдэж байгаа, хураан авч болох, хураан авбал зохих өмч хөрөнгийг цаг алдалгүй тодорхойлох, мөрдөн шалгах, царцаах болон битүүмжлэх эрх бүхий нэг буюу түүнээс дээш тооны байгууллагуудтай байх шаардлагатай.

30.4 Энэ 30 дугаар зөвлөмж нь хууль сахиулах байгууллага биш боловч суурь гэмт хэргийн санхүүгийн мөрдөн шалгалтад оролцдог эрх бүхий байгууллагуудад хамааралтай бөгөөд улс орнууд эдгээр байгууллагуудыг 30 дугаар зөвлөмжид заасан хүрээнд үйл ажиллагаагаа явуулах нөхцлөөр хангах шаардлагатай.

30.5 Хэрэв авлигатай гэмцэх эрх бүхий байгууллагууд нь 30 дугаар зөвлөмжийн дагуу авлигын гэмт хэрэгтэй холбоотой түүнээс үүдэн гарсан мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийг мөрдөн шалгах үүрэгтэй тохиолдолд мөн эд хөрөнгийг тодорхойлох, мөрдөн шалгах, царцаах болон битүүмжлэх бүрэн эрх мэдэлтэй байх шаардлагатай.

⁶¹ “*Санхүүгийн зэрэгцээ хяналт шалгалт*” гэж мөнгө угаах, терроризмын санхүүжилт, гэмт хэргүүдэд (уламжлалт) эрүүгийн мөрдөн шалгалт хийхийн зэрэгцээ мөн санхүүгийн мөрдөн шалгалт хийхийг хэлнэ.

“*Санхүүгийн мөрдөн шалгалт*” гэдэг нь (i) гэмт хэргийн сүлжээний цар хүрээ, хэмжээг тодорхойлох, (ii) гэмт хэргээс олсон орлого, террористуудын хөрөнгө болон бусад улсын мэдэлд хураан авбал зохих хөрөнгийг тодорхойлох, илрүүлэх, (iii) гэмт хэргийн шүүх ажиллагаанд хэрэглэж болох баримт нотолгоог боловсруулах зэрэг гэмт хэрэгтэй холбогдсон санхүүгийн үйл ажиллагааг мөрдөн шалгахыг хэлнэ.

ЗӨВЛӨМЖ 31**ХУУЛЬ САХИУЛАХ БОЛОН МӨРДӨН ШАЛГАХ
БАЙГУУЛЛАГУУДЫН ЭРХ МЭДЭЛ**

31.1 Мөнгө угаах, холбогдох суурь гэмт хэрэг, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийг мөрдөн шалгах эрх бүхий байгууллагууд нь эдгээр гэмт хэргийг мөрдөн шалгах, яллах болон холбогдох үйл ажиллагаанд ашиглах шаардлагатай бүхий л баримт бичиг, мэдээлэлд чөлөөтэй нэвтрэх эрхтэй байна. Үүнд:

- (a) Санхүүгийн байгууллагууд, СББМҮҮ нар болон бусад хувь хүн, хуулийн этгээдэд байгаа тайлан, мэдээллийг гаргуулах;
- (b) Хувь хүн болон орон байранд нэгжлэг хийх;
- (c) Гэрчийн мэдүүлэг авах;
- (d) Баталгаа, нотолгоог олж авах, хураах.

31.2 Мөрдөн шалгалт хийж буй эрх бүхий байгууллагууд нь мөнгө угаах, суурь гэмт хэрэг болон терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийг мөрдөн шалгах өргөн хүрээтэй арга техникийг ашиглах чадвартай байх шаардлагатай. Үүнд:

- (a) Гүйцэтгэх ажиллагаа;
- (b) Харилцаа холбооны хэрэгслийг чагнах;
- (b) Компьютерийн системд нэвтрэх;
- (c) Халхавч ажиллагаа.

31.3 Улс орнууд нь дараах механизмтай байх шаардлагатай. Үүнд:

- (a) Хувь хүн болон хуулийн этгээд ямар нэгэн дансыг эзэмшиж, хянаж байгааг цаг тухайд нь олж тогтоох;
- (b) Эрх бүхий байгууллагууд нь эзэмшигч этгээдэд урьдчилж мэдэгдэлгүйгээр хөрөнгийг тодорхойлох механизмтай байх.

31.4 Мөнгө угаах, холбогдох суурь гэмт хэрэг болон терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийг мөрдөн шалгах эрх бүхий байгууллагууд нь СМА-нд байгаа бүх холбогдох мэдээллийг авдаг байх шаардлагатай.

ЗӨВЛӨМЖ 32**БЭЛЭН МӨНГӨ ЗӨӨВӨРЛӨГЧИД****Үнэлгээчдэд өгөх зааварчилгаа:**

32 дугаар зөвлөмжийн тухайд үндэстэн дамнасан хуулийн харьяалалтай улсын хувьд үндэстнээс дээших түвшинд буюу үндэстнээс гаднах хил хязгаарыг давж байгаа хөдөлгөөнийг л зөвхөн хил дамнасан гэж үзнэ. Ийм зохицуулалтыг Хавсралт 1-т заасан нөхцлөөр улс үндэстэнгээс дээш түвшингээр үнэлнэ.

32.1 Улс орнууд хилээр тээвэрлэгдэн орж гарч байгаа валют, төлбөрийн хэрэгслүүдийг мэдүүлэх болон мэдээлэх системийг бий болгох хэрэгтэй. Аялагч этгээд өөрөө биедээ авч яваа эсвэл шуудан болон каргоогоор дамжуулан хил давуулан орж гарч буй бүх валютын урсгалд мэдүүлэх болон мэдээлэх систем шаардлагатай бөгөөд тээвэрлэлтийн төрлөөс шалтгаалж түүнд тохирсон системийг ашиглаж болно.

32.2 Мэдүүлгийн системд дээд хязгаар давсан буюу хамгийн ихдээ 15,000 ам.доллар/еврогийн үнийн дүнгээс хэтэрсэн валют болон төлбөрийн хэрэгслүүдийг хил давуулан биедээ авч явж буй бүх хүмүүс эрх бүхий байгууллагуудад үнэн зөв мэдүүлэг өгөх шаардлагатай. Улс орнууд дараах гурван төрлийн мэдүүлгийн системээс сонголт хийж болно. Үүнд:

- (a) Бүх зорчигчдод зориулсан бичгээр мэдүүлэх систем;
- (b) Дээд хязгаараас давсан үнийн дүн бүхий валют, төлбөрийн хэрэгслүүд авч явж буй зорчигчдод зориулсан бичгээр мэдүүлэх систем, эсвэл;
- (c) Бүх зорчигчдод зориулсан аман мэдүүлгийн систем.

32.3 Мэдээлэх системийн хувьд зорчигчид нь эрх бүхий байгууллагуудын шаардсаны дагуу үнэн зөв хариулт өгөх, зохих мэдээллээр хангах шаардлагатай байх боловч шууд аман болон бичгэн мэдүүлэг урьдчилан өгөх шаардлагагүй.

32.4 Валют болон төлбөрийн хэрэгслүүдийн талаар буруу мэдүүлсэн, мэдээлсэн, эсвэл огт мэдүүлэг, мэдээлэл өгөөгүйг олж тогтоосон тохиолдолд эрх бүхий байгууллагууд нь валют, төлбөрийн хэрэгслүүдийн гарал үүсэл, хэрэглэх гэж буй зориулалтын талаар тухайн этгээдээс нэмэлт мэдээлэл хүсэх, авах эрхтэй байх шаардлагатай.

32.5 Худал мэдүүлэг, мэдээлэл өгсөн этгээдүүдэд эрүүгийн, иргэний болон захиргааны гаргасан зөрчилтэй нь дүйцэхүйц, давтан үйлдэхээс сэргийлсэн шийтгэлийн арга хэмжээг авах шаардлагатай.

32.6 Мэдүүлэх/мэдээлэх системээр олж авсан мэдээллийг (a) хил давуулсан сэжигтэй тээвэрлэлтийн тохиолдлын талаар СМА-нд мэдэгдэх систем, (b) өөр бусад арга замаар мэдүүлэг/мэдэгдлийг СМА-нд шууд өгөх арга замын аль нэгийг сонгон СМА-нд мэдээлж болно.

32.7 Дотоодын түвшинд 32 дугаар зөвлөмжийг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлаар гааль, цагаачлал болон бусад холбогдох эрх бүхий байгууллагуудын дунд хамтын ажиллагаа, харилцан уялдаа холбоог бий болгох шаардлагатай.

32.8 Эрх бүхий байгууллагууд нь дараах тохиолдолд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлсэн гэх баталгаа нотолгоо байгаа эсэхийг баталгаажуулахын тулд тухайн валют, төлбөрийн хэрэгслүүдийг тодорхой хугацаанд саатуулах, хориглох боломжтой байна. Үүнд:

ФАТФ-ын зөвлөмжийн техникийн хэрэгжилт болон МУТСТ тогтолцооны үр дүнтэй байдлыг үнэлэх

- (a) Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон суурь гэмт хэргийн сэжиг байгаа тохиолдолд;
- (b) Худал мэдүүлэг, мэдээлэл өгсөн тохиолдолд.

32.9 Улс орнууд 36-аас 40 дүгээр зөвлөмжийн дагуу мэдүүлэх/мэдээлэх системийн олон улсын хамтын ажиллагаа болон туслалцаа үзүүлэхэд боломжтой байдлыг хангасан байх шаардлагатай. Дээрх хамтын ажиллагааг дэмжихийн тулд доорх мэдээллийг хуримтлуулна⁶². Үүнд:

- (a) Тогтсон үнийн дээд хязгаараас давсан мэдүүлэг, мэдээлэл;
- (b) Худал мэдүүлэг, мэдээлэл өгсөн;
- (c) Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлсэн гэх сэжиг байгаа.

32.10 Мэдүүлэх/мэдээлэх системээр дамжуулж цуглуулсан мэдээллийг зохих ёсоор ашиглахад (i) улс орнуудын хоорондох бараа, үйлчилгээний худалдааны төлбөр, (ii) хөрөнгийн урсгал, хөдөлгөөний байдалд саад учруулахгүйгээр найдвартай, аюулгүй байдлаар зохион байгуулах шаардлагатай.

32.11 Мөнгө угаах холбогдох суурь гэмт хэрэг болон терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргтэй холбоотой валют, төлбөрийн хэрэгслүүдийг хил давуулан биетээр зөөвөрлөж буй этгээдэд (a) эрүүгийн, иргэний болон захиргааны гаргасан зөрчилтэй нь дүйцэхүйц, давтан үйлдэхээс сэргийлсэн шийтгэлийн арга хэмжээ авна (b) 4 дүгээр зөвлөмжийн дагуу тухайн валют, төлбөрийн хэрэгслүүдийг хураан авна.

⁶² Мэдээлэлд доод тал нь (i) мэдүүлсэн, мэдээлсэн болон бусад байдлаар мэдэгдсэн валют, төлбөрийн хэрэгслүүдийн үнийн дүн, (ii) уг этгээдийг тодорхойлох мэдээллийг багтаасан байх шаардлагатай.

ЗӨВЛӨМЖ 33**СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ**

33.1 Улс орнууд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцооны үр дүн, үр ашигтай байдалтай холбоотой асуудлаар иж бүрэн дэлгэрэнгүй статистикийн мэдээлэл хөтлөх шаардлагатай. Статистик нь дараах зүйлсээс бүрдсэн байвал зохино. Үүнд:

- (a) Хүлээн авсан болон шилжүүлсэн сэжигтэй гүйлгээний тайлангууд;
- (b) Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийг мөрдөн шалгалт, яллалт, шүүхээр шийдвэрлэсэн байдал;
- (c) Царцаасан, битүүмжилсэн, хураан авсан хөрөнгө;
- (d) Хамтын ажиллагааны хүрээд хийгдсэн эрх зүйн харилцан туслалцаа болон бусад олон улсын явуулсан болон хүлээн авсан хүсэлтүүд.

ЗӨВЛӨМЖ 34**ЗААВАРЧИЛГАА, ЭРГЭХ ХОЛБОО**

34.1 Эрх бүхий байгууллагууд, хянан шалгагчид, СДЗБ-ууд нь санхүүгийн байгууллагууд болон СББМҮҮ нарт мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэхэд чиглэсэн үндэсний арга хэмжээг хэрэгжүүлэх, сэжигтэй гүйлгээг олж илрүүлэх, мэдээлэхтэй холбоотой үйл ажиллагааг явуулахад нь туслалцаа үзүүлэх зааварчилгаа гаргаж, эргэх холбоогоор хангах шаардлагатай.

ЗӨВЛӨМЖ 35**ШИЙТГЭЛИЙН АРГА ХЭМЖЭЭ**

35.1 Улс орнууд 6 дугаар зөвлөмж, 8-аас 23 дугаар зөвлөмжүүдэд дурдсан мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх шаардлагуудыг хэрэгжүүлээгүй хувь хүмүүс болон хуулийн этгээдүүдэд гаргасан зөрчилтэй нь дүйцэхүйц, давтан үйлдэхээс сэргийлсэн эрүүгийн, иргэний болон захиргааны шийтгэлийн олон төрлийн арга хэмжээг бий болгосон байх шаардлагатай⁶³.

35.2 Шийтгэлийн арга хэмжээг зөвхөн санхүүгийн байгууллагууд, СББМҮҮ нарт төдийгүй тэдгээрийн захирлууд, дээд шатны удирдлагад оногдуулах боломжтой байвал зохино.

⁶³ Шийтгэлийн арга хэмжээг зөрчилд шууд болон шууд бусаар хэрэглэх боломжтой байх ёстой. Шаардлагыг тусгаж, тодорхойлсон баримт бичигт шийтгэлийн талаар дурдах шаардлагагүй бөгөөд энэ талаар өөр баримт бичигт дурдаж болно. Шаардлагууд болон холбогдох хориг арга хэмжээний хооронд илт тодорхой уялдаа холбоо байна.

ЗӨВЛӨМЖ 36**ОЛОН УЛСЫН БАРИМТ БИЧИГ**

36.1 Улс орнууд нь Венийн Конвенци, Палермогийн Конвенци, НҮБ-ын Авлигын эсрэг Конвенци (Меридагийн конвенци) болон Терроризмыг Санхүүжүүлэхтэй Тэмцэх Конвенцид нэгдэх шаардлагатай.

36.2 Улс орнууд Венийн Конвенци, Палермогийн Конвенци, Меридагийн Конвенци болон Терроризмыг Санхүүжүүлэхтэй Тэмцэх Конвенцийг бүрэн хэрэгжүүлэх шаардлагатай⁶⁴.

⁶⁴ Холбогдох зүйл заалтууд нь: Венийн Конвенци (3-11, 15, 17 болон 19-р зүйл), Палермогийн Конвенци (5-7, 10-16, 18-20, 24-27, 29-31, 34-р зүйл), Меридагийн Конвенци (14-17, 23-24, 26-31, 38, 40, 43-44, 46, 48, 50-55, 57-58-р зүйл) болон Терроризмыг Санхүүжүүлэхтэй Тэмцэх Конвенци (2-18-р зүйл).

ЗӨВЛӨМЖ 37**ЭРХ ЗҮЙН ХАРИЛЦАН ТУСЛАЛЦАА**

37.1 Улс орнууд нь мөнгө угаах, холбогдох суурь гэмт хэрэг болон терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийг мөрдөн шалгах, яллах болон шүүх ажиллагаатай холбогдсон өргөн хүрээний эрх зүйн харилцан туслалцааг түргэн шуурхай байдлаар үзүүлэх боломжийг бүрдүүлсэн хууль, эрх зүйн тогтолцоотой байх шаардлагатай.

37.2 Улс орнууд нь хүсэлтийг гүйцэтгэж шилжүүлэх төв захиргааны байгууллага эсвэл өөр албан ёсны тогтсон механизмыг ашиглах шаардлагатай. Эрх зүйн харилцан туслалцааны хүсэлтийг цаг тухай бүрт нь гүйцэтгэхэд зориулсан тодорхой үйл ажиллагааны шат дараалалтай байх хэрэгтэй. Хүсэлтийн явцыг хянахын тулд “Case management system” буюу “Хэргийн удирдлагын систем”-ийг хэрэгжүүлэх шаардлагатай.

37.3 Эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэхийг хязгаарлаж болохгүй бөгөөд үндэслэлгүй болон хэтэрхий хатуу нөхцөл тавихыг хориглоно.

37.4 Улс орнууд нь Эрх зүйн харилцан туслалцааны хүсэлтээс дараах тохиолдолд татгалзах ёсгүй. Үүнд:

- (a) Тухайн гэмт хэрэг нь санхүүгийн асуудлыг давхар хамарсан гэдэг ганц шалтгаанаар;
- (b) Холбогдох мэдээлэл нь хууль, эрх зүйн мэргэжлийн эрх, нууцлалд хамаарах нөхцлөөс бусад тохиолдолд санхүүгийн байгууллага болон СББМҮҮ нарын нууцлалын шаардлагатай холбоотойгоор татгалзах.

37.5 Улс орнууд нь мөрдөн шалгалт, байцаалтын шударга байдлыг хангахын тулд хүлээн авч буй Эрх зүйн харилцан туслалцааны хүсэлт болон түүнд агуулагдаж буй мэдээллийн нууцлалыг дотоодын хууль тогтоомжийн үндсэн зарчмуудын дагуу хадгалах шаардлагатай.

37.6 Эрх зүйн харилцан туслалцааны хүсэлтүүд нь албадлагын арга хэмжээтэй холбоогүй тохиолдолд улс орнууд харилцан гэмт хэрэгт тооцсоны үндсэн дээр (dual criminality) туслалцаа үзүүлнэ гэж нөхцөл шаардаж болохгүй.

37.7 Улс орнууд харилцан гэмт хэрэгт тооцсоны үндсэн дээр (dual criminality) Эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх шаардлагатай болсон тохиолдолд хоёр орон тус хэргийг нэг ижил ангиллын гэмт хэрэгт хамруулж үздэг, тухайн гэмт хэргийг тайлбарлахдаа нэг ижил нэр томъёо ашигладаг эсэхээс үл хамаарч тухайн үйлдлийг гэмт хэрэгт тооцсон нь шаардлагыг биелүүлсэн гэж үзэхэд хангалттай байна.

37.8 Хэрэв гадаадын шүүх болон хууль сахиулах байгууллагуудаас дотоодын ижил төстэй байгууллагуудад шууд хүсэлт гаргасан нь дотоодын тогтолцоонд нийцэж байвал 31 дүгээр зөвлөмжийн дагуу дотоодын эрх бүхий байгууллагууд нь эрх мэдэл, мөрдөн шалгах арга техникийн хүрээнд Эрх зүйн харилцан туслалцааны хүсэлтэд хариулж болно. Эдгээр эрх мэдэл, арга техникт дараах зүйлсийг хамруулан үзнэ. Үүнд:

- (a) Санхүүгийн байгууллагууд, бусад хувь хүмүүс, хуулийн этгээдүүдээс мэдээлэл, баримт бичиг, нотолгоо (санхүүгийн бүртгэл, тайланг хамарна) хайх, гаргуулах, авах болон гэрчийн мэдүүлэг авах зэрэг 31 дүгээр зөвлөмжид заасан бүрэн эрх;
- (b) Бусад өргөн цар хүрээний эрх мэдэл, мөрдөн шалгах арга техник.

ЗӨВЛӨМЖ 38**ЭРХ ЗҮЙН ХАРИЛЦАН ТУСЛАЛЦАА: ЦАРЦААХ, ХУРААН АВАХ**

38.1 Улс орнууд бусад улс орноос шаардсаны дагуу доор дурдсан хөрөнгүүдийг цаг алдалгүй царцаах, битүүмжлэх, хураан авах бүрэн эрхтэй байна. Үүнд:

Мөнгө угаах, суурь гэмт хэрэг болон терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргээс олсон болон холбоотой:

- (a) Эд хөрөнгө;
- (b) Орлого;
- (c) Ашиглагдсан хэрэгсэл;
- (d) Зарцуулахаар төлөвлөж буй хэрэгсэл;
- (e) Үнийн дүнтэй тэнцэхүйц эд хөрөнгө.

38.2 Дотоодын хууль тогтоомжийн үндсэн зарчмуудыг зөрчөөгүй бол гэмт этгээд нь нас барсан, оргон зайлсан, алга болсон болон танигдахгүй байгаа тохиолдолд улс орнууд нь өмчийг хураах шүүх ажиллагаанд “ял шийтгэлээс хамааралгүй/non-conviction” зарчмыг баримтлан хамтын ажиллагааны дагуу хүсэлтэд туслалцаа үзүүлэх, холбогдох түр арга хэмжээг авах эрхтэй байна.

38.3 Улс орнууд нь (a) бусад улс орнуудтай хамтарсан өмч хөрөнгийг битүүмжлэх, хураан авах үйл ажиллагааны зохицуулалттай, (b) царцаасан, битүүмжилсэн, хураан авсан хөрөнгийг удирдах, шаардлагатай тохиолдолд захиран зарцуулах механизмтай байх шаардлагатай.

38.4 Хууль сахиулах хамтын ажиллагааны үр дүнд хөрөнгийг шууд болон шууд бусаар хураан авсан бол бусад улс орнуудтай тухайн хөрөнгийг хуваалцах шаардлагатай.

ЗӨВЛӨМЖ 39**ГЭМТ ХЭРЭГТНИЙГ ШИЛЖҮҮЛЭХ**

39.1 Улс орнууд нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэгтэй холбоотой хэрэгтнийг шилжүүлэх хүсэлтийг үндэслэлгүй саатуулалгүйгээр гүйцэтгэх шаардлагатай. Улс орнууд нь:

- (a) Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэг нь тухайн гэмт хэрэгт холбогдсон этгээдийг гадаад улсад шилжүүлэх боломжтой гэмт хэрэг байна;
- (b) Шаардлагатай үед ач холбогдлыг нь эрэмбэлэн тодорхойлох зэргээр хэрэгтнийг шилжүүлэх хүсэлтийг цаг тухайд нь гүйцэтгэхэд зориулсан тодорхой процесс, “Хэргийн удирдлагын систем”-тэй байна.
- (c) Хүсэлтүүдийг гүйцэтгэх талаар үндэслэлгүй болон хатуу шаардлага тавих ёсгүй.

39.2 Мөн улс орнууд нь:

- (a) Өөрийн улсын иргэнийг шилжүүлж болно;
- (b) Эсвэл зөвхөн дан ганц иргэншилтэй холбоотой шалтгааны улмаас хэрэгтнийг шилжүүлэхгүй тохиолдолд хэрэгтнийг шилжүүлэн авахыг зорьж буй улс орны хүсэлтийг үндэслэж тус хүсэлтэд дурдсан хэргийг шүүх зорилгоор хэргийг эрх бүхий байгууллагуудад цаг алдалгүйгээр шилжүүлэх шаардлагатай.

39.3 Улс орнууд харилцан гэмт хэрэгт тооцсоны үндсэн дээр (dual criminality) гэмт хэрэгтнийг шилжүүлэх шаардлагатай болсон тохиолдолд хоёр орон тус хэргийг нэг ижил ангиллын гэмт хэрэгт хамруулж үздэг болон тухайн гэмт хэргийг тайлбарлахдаа нэг ижил нэр томъёо ашигладаг эсэхээс үл хамаарч тухайн үйлдлийг гэмт хэрэгт тооцсон нь шаардлагыг биелүүлсэн гэж үзэхэд хангалттай.

39.4 Дотоодын хууль тогтоомжийн үндсэн зарчмуудтай нийцэж байвал улс орнууд нь хэрэгтнийг шилжүүлэх хялбаршуулсан механизмтай байх шаардлагатай⁶⁵.

⁶⁵ Түр саатуулах этгээдийг зохих эрх бүхий байгууллагуудын хооронд хүсэлтийн дагуу шууд шилжүүлэх, зөвхөн шүүхийн тогтоол, баривчлах шийдвэрт үндэслэн гэмт этгээдүүдийг шилжүүлэх, гэмт хэрэгтэн шилжүүлэх албан ёсны үйл ажиллагаанаас татгалзсан этгээдүүдийг хялбаршуулсан арга хэмжээгээр шилжүүлэх гэх мэт.

ЗӨВЛӨМЖ 40**ОЛОН УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ БУСАД ХЭЛБЭРҮҮД***Ерөнхий зарчмууд*

40.1 Улс орнууд нь өөрсдийн эрх бүхий байгууллагууд мөнгө угаах, холбоотой суурь гэмт хэрэг болон терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэгтэй хамааралтай олон улсын өргөн цар хүрээний хамтын ажиллагааг түргэн шуурхай үзүүлэх нөхцлөөр хангах шаардлагатай. Мэдээлэл солилцох үйл ажиллагааг хүсэлтийн дагуу болон сайн дураар гэсэн аль ч хэлбэрээр явуулах боломжтой байх шаардлагатай.

40.2 Эрх бүхий байгууллагууд нь:

- (a) Хамтын ажиллагааг хангах хууль, эрх зүйн үндэслэлтэй байх шаардлагатай;
- (b) Хамтын ажиллагааны хамгийн үр дүнтэй арга замуудыг ашиглах эрхтэй байх шаардлагатай;
- (c) Хүсэлтүүдийг гүйцэтгэж шилжүүлэх хялбаршуулсан найдвартай гарц, механизм, сувагтай байх шаардлагатай;
- (d) Хүсэлтүүдийг ач холбогдлоор эрэмбэлэх болон цаг тухайд нь гүйцэтгэхэд зориулсан тодорхой үйл ажиллагааны шат дараалалтай байх;
- (e) Хүлээн авсан мэдээллийг хамгаалах тодорхой системтэй байх.

40.3 Эрх бүхий байгууллагуудад хамтран ажиллахад хоёр болон олон талт гэрээ хэлэлцээрийн зохицуулалт шаардлагатай бол аль болох олон тооны гадаадын ижил төстэй байгууллагуудтай цаг тухай бүрт нь хэлэлцэн зөвшилцөж, гарын үсэг зурах шаардлагатай.

40.4 Хүсэлт гаргаж буй эрх бүхий байгууллагууд нь туслалцаа авсан ижил төстэй байгууллагуудад олж авсан мэдээллийн ашиглалт болон мэдээллийн ашиг тусын талаар хүсэлтийн дагуу цаг тухайд нь мэдэгдэж, эргэх холбоогоор хангаж байна.

40.5 Улс орнууд нь туслалцаа болон мэдээлэл солилцох тал дээр үндэслэлгүй, зүй бусаар хязгаарлах нөхцөл тавих ёсгүй. Тодруулбал эрх бүхий байгууллагууд нь дараах үндэслэлээр туслалцаа хүссэн хүсэлтийг няцаах ёсгүй. Үүнд:

- (a) Хүсэлт нь санхүүгийн асуудлыг давхар хамарсан гэж үзсэн;
- (b) Санхүүгийн байгууллага болон СББМҮҮ нар нь харилцагчийн нууцлалыг хамгаалахыг хуулиар шаардсан (хайж буй холбогдох мэдээлэл нь хууль, эрх зүйн мэргэжлийн эрх, нууцлалд хамаарах нөхцөлд байгаа тохиолдлыг оруулахгүй);
- (c) Хүсэлт авсан улс оронд шалгалт, мөрдөн байцаалт болон шүүх ажиллагаа явагдаж байгаа (хэрэв туслалцаа нь тухайн шалгалт, мөрдөн байцаалт болон шүүх ажиллагаанд саад болохооргүй бол);
- (d) Хүсэлт гаргаж буй эрх бүхий байгууллагын онцлог болон статус (иргэний, захиргааны, хууль сахиулах г.м) нь гадны ижил төстэй эрх бүхий байгууллагын онцлогоос өөр байх.

ФАТФ-ын зөвлөмжийн техникийн хэрэгжилт болон МУТСТ тогтолцооны үр дүнтэй байдлыг үнэлэх

40.6 Хүсэлтэд хариу өгсөн эрх бүхий байгууллагаас урьдчилан зөвшөөрөл олгоогүй бол эрх бүхий байгууллагуудын солилцсон мэдээллийг зөвхөн тухайн зорилгоор, мэдээлэл хайж болон өгч буй хүрээнд нь эрх бүхий байгууллагууд ашиглаж байгаа эсэхийг хянаж зохицуулах системийг улс орнууд бүрдүүлэх шаардлагатай.

40.7 Эрх бүхий байгууллагууд нь нууцлал, мэдээллийг хамгаалахтай холбоотой хоёр талын үүрэг хариуцлагыг ухамсарлаж, солилцсон мэдээлэл, хамтын ажиллагааны аливаа хүсэлтийн зохих нууцлалыг хадгалах шаардлагатай. Эрх бүхий байгууллагууд солилцсон мэдээллийн нууцлал нь хамгийн багадаа дотоодын эх сурвалжаас хүлээн авсан ижил төстэй мэдээллийн нууцлалыг хамгаалах түвшинтэй ижил байх шаардлагатай. Хүсэлт гаргаж буй эрх бүхий байгууллага нь мэдээллийг нууцлалыг хамгаалж чадахгүй тохиолдолд мэдээллээр хангахаас татгалзах эрхтэй.

40.8 Эрх бүхий байгууллагууд нь гадны байгууллагуудын нэрийн өмнөөс дотооддоо байцаалт хийх үед дотоодын ижил түвшний шалгалтаар олж авах боломжтой бүх мэдээллийг гадны эрх байгууллагуудтай солилцох шаардлагатай.

СМА-д хоорондын мэдээлэл солилцоо

40.9 СМА-д нь мөнгө угаах, холбоотой суурь гэмт хэрэг болон терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийн асуудлаар хамтран ажиллах хууль, эрх зүйн хангалттай орчин, нөхцөлд ажиллах шаардлагатай⁶⁶.

40.10 СМА нь хүсэлтийн дагуу болон боломжтой үедээ гадны СМА-даас өгсөн мэдээллийн ашиглалт, өгсөн мэдээлэлд үндэслэж хийж гүйцэтгэсэн дүн шинжилгээний үр дүнгийн талаар хариу мэдэгдэж, эргэх холбоогоор хангах шаардлагатай.

40.11 СМА-д нь дараах мэдээллийг солилцох эрхтэй байна. Үүнд:

- (a) 29 дүгээр зөвлөмжийн дагуу СМА-дын шууд болон шууд бус байдлаар хүлээн авдаг, авах боломжтой аливаа мэдээлэл;
- (b) Харилцан мэдээлэл солилцох хамтын ажиллагаатай дотоодын байгууллагуудаас шууд болон шууд бус байдлаар хүлээн авдаг, авах боломжтой аливаа мэдээлэл.

Санхүүгийн хянан шалгагчдын хоорондох мэдээлэл солилцоо⁶⁷

40.12 Санхүүгийн хянан шалгагч нар нь олон улсын стандартын дагуу гадны байгууллагуудын шинж чанар, статусаас үл хамааран мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх чиглэлийн хяналт шалгалтын мэдээллийг солилцох хууль, эрх зүйн тогтолцоотой байх шаардлагатай.

40.13 Санхүүгийн хянан шалгагч нар нь тус тусын хэрэгцээ шаардлагад нийцүүлж гадны ижил төстэй санхүүгийн хянан шалгагч нартай дотоодод гаргах боломжтой мэдээлэл болон санхүүгийн байгууллагуудын эзэмшиж буй мэдээллийг солилцох боломжтой байх шаардлагатай.

40.14 Санхүүгийн хянан шалгагч нар нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх зорилгоор нэг ижил групп хамаарч буй санхүүгийн байгууллагуудыг хамтран хариуцаж байгаа

⁶⁶ СМА-д нь гадаадын СМА-ыг ямар төрлийн (захиргааны, хууль сахиулах, шүүх, эсвэл бусад) байхаас үл хамааран хамтран ажиллах боломжтой байх шаардлагатай.

⁶⁷ Энэ нь эрх бүхий байгууллага болох санхүүгийн хянан шалгагч нарт хамаарах бөгөөд үүнд СДЗБ-ын санхүүгийн хянан шалгагч нарыг оруулахгүй.

бусад хянан шалгагч нартай дараах төрлийн мэдээлэл солилцох боломжтой байх шаардлагатай. Үүнд:

- (a) Дотоодын зохицуулалтын тогтолцоо болон санхүүгийн салбарын ерөнхий мэдээлэл зэрэг зохицуулалтын мэдээлэл;
- (b) Үндсэн зарчмуудыг хэрэгжүүлж буй хянан шалгагч нарт зориулсан санхүүгийн байгууллагын бизнесийн үйл ажиллагаа, эцсийн өмчлөгч, удирдлага, эрүүл зохистой байдал зэрэг зөвлөх мэдээлэл;
- (c) Санхүүгийн байгууллагуудын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх дотоод дүрэм журам, бодлого, харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагаа, харилцагчийн хувийн хэрэг, данс болон гүйлгээний хуулга зэрэг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх мэдээлэл;

40.15 Санхүүгийн хянан шалгагч нар нь нэг ижил групп хамаарч буй санхүүгийн байгууллагуудад үр дүнтэй хяналт шалгалт хийхийн тулд гадны ижил төстэй санхүүгийн хянан шалгагч нарын өмнөөс шалгалт хийх, тохиромжтой гэж үзвэл тухайн улс оронд өөрсдөө хяналт, шалгалт хийх боломжоор хангах хэрэгтэй.

40.16 Хүсэлт гаргаж буй санхүүгийн хянан шалгагч нь мэдээллийг задруулах, тайлагнах хуулийн үүрэг хариуцлага хүлээгээгүй бол хүсэлтэд хариулсан санхүүгийн хянан шалгагч нарын урьдчилсан зөвшөөрөлд үндэслэж мэдээллийг цааш нь дамжуулах, хяналт шалгалтын болон хяналт шалгалтын бус зорилгоор тухайн мэдээллийг ашиглана. Дээрх тохиолдолд хүсэлт гаргасан санхүүгийн хянан шалгагч нь ийм үүрэг хариуцлагыг биелүүлэх болсоноо нэн даруй нөгөө талдаа мэдэгдэх шаардлагатай.

Хууль сахиулах байгууллагуудын хоорондох мэдээлэл солилцоо

40.17 Гүйцэтгэх болон мөрдөн шалгах үйл ажиллагааны зорилгоор хууль сахиулах эрх бүхий байгууллагууд нь мөнгө угаах, холбоотой суурь гэмт хэрэг болон терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэгтэй холбогдолтой орж ирсэн орлого, арга хэрэгслүүдийг тодорхойлоход ашиглагдах дотооддоо байгаа мэдээллээр гадны ижил төстэй байгууллагуудыг хангах, хоорондоо мэдээлэл солилцох боломжтой байна.

40.18 Түүнчлэн хууль сахиулах эрх бүхий байгууллагууд нь гадаадын ижил төстэй байгууллагуудын өмнөөс мэдээлэл олж авах, мөрдөн байцаалт явуулахын тулд дотоодын хууль тогтоомжийн хүрээнд олгосон эрх мэдэл, мөрдөн шалгах арга техник зэргийг ашиглах боломжтой байх шаардлагатай. Интерпол, Европол, болон Еврожаст болон улс орнуудын хоорондох гэрээ хэлэлцээр зэрэг хууль сахиулах үйл ажиллагаа, хамтын ажиллагааны дүрэм журам нь хүсэлт авсан хууль сахиулах байгууллагын зүгээс оногдуулж болох аливаа хязгаарлалт, хоригийг зохицуулах шаардлагатай.

40.19 Хууль сахиулах байгууллагууд нь хамтарсан мөрдөн шалгалтын баг байгуулан ажиллах боломжтой байх бөгөөд шаардлагатай бол хамтарсан мөрдөн шалгалт хийхийн тулд хоёр талт болон олон талт гэрээ хэлэлцээрийг байгуулах шаардлагатай.

Ижил төстэй бус байгууллагуудын хоорондох мэдээлэл солилцоо

40.20 Улс орнууд нь дээр дурдсан холбогдох зарчмуудын хүрээнд ижил төстэй бус эрх бүхий байгууллагуудын хооронд шууд бусаар мэдээлэл солилцох зөвшөөрлийг олгох хэрэгтэй⁶⁸. Шууд

⁶⁸ Мэдээллийг шууд бус солилцох гэдэг нь хүсэлт хүлээн авсан байгууллагад мэдээлэл нь дотоод гадаадын нэг буюу түүнээс дээш тооны эрх бүхий байгууллагуудаар дамжин ирэхийг хэлнэ. Мэдээлэл солилцох,

ФАТФ-ын зөвлөмжийн техникийн хэрэгжилт болон МУТСТ тогтолцооны үр дүнтэй байдлыг үнэлэх

бус байдлаар мэдээлэл хүсч буй холбогдох эрх бүхий байгууллага нь ямар зорилготой болох, хүсэлтийг хэний өмнөөс гаргаж байгаагаа байнга ил тод, ойлгомжтой тайлбарлах шаардлагатай.

мэдээллийг ашиглуулах асуудал нь хүсэлт хүлээн авсан улс орны нэг буюу түүнээс дээш эрх бүхий байгууллагуудын эрх мэдэл, зөвшөөрлөөс хамаарах болно.

ҮР ДҮНТЭЙ БАЙДЛЫН ҮНЭЛЭХ

Шууд хэрэгжилт 1

МӨНГӨ УГААХ, ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖЛҮҮЛЭХ ЭРСДЭЛИЙГ ОЙЛГОДОГ, ШААРДЛАГАТАЙ ҮЕД МӨНГӨ УГААХ, ТЕРРОРИЗМ БОЛОН ҮЙ ОЛНООР ХӨНӨӨХ ЗЭВСЭГ ДЭЛГЭРҮҮЛЭХИЙГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ ЧИГЛЭЛЭЭР ҮНДЭСНИЙ ХЭМЖЭЭНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЗОХИОН БАЙГУУЛДАГ БАЙХ.

Үр дүнтэй системийн шинж чанар

Улс орнууд нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг зохих хэмжээнд ойлгон тодорхойлж, үнэлснээр эдгээр эрсдэлийг бууруулах арга хэмжээг дотоодын бодлогодоо уялдуулан нийцүүлсэн байна. Энэ нь эрх бүхий болон бусад холбогдох байгууллагууд өргөн хүрээний найдвартай мэдээллийн эх сурвалж болон эрсдэлийн үнэлгээнд суурилан мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх бодлого, үйл ажиллагааг боловсруулан ач холбогдлоор нь эрэмбэлж тухайн бодлого, үйл ажиллагааг нэвтрүүлэх тохиромжтой арга замыг сонгохыг хэлнэ. Мөн холбогдох эрх бүхий байгууллагууд нь үй олноор хөнөөх зэвсгийг дэлгэрүүлэх үйл ажиллагааг санхүүжүүлэхтэй тэмцэх бодлого, арга хэмжээний тал дээр хамтран ажиллаж, эдгээр бодлого, арга хэмжээг харилцан уялдуулна. Үүний үр дүнд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг их хэмжээгээр бууруулна. Энэ шууд хэрэгжилт нь ерөнхийдөө 1, 2, 33 болон 34 дүгээр зөвлөмжүүд хамааралтай.

Үнэлгээчдэд өгөх зааварчилгаа:

- 1) Үнэлгээчдээс улс орны эрсдэлийг нарийвчлан судалж үнэлэхийг шаардахгүй. Харин эрсдэлийн үнэлгээний үндэс шалтгааны талаарх ойлголтон дээрээ үндэслэж эрх бүхий байгууллагууд нь эдгээр бодлого боловсруулах, эрсдэлийг бууруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэхдээ эрсдэлийн талаар олж авсан ойлголтоо хэрхэн сайн ашиглаж байгаа дээр төвлөрөх шаардлагатай.
- 2) Үнэлгээчид нь бусад шууд хэрэгжилтийг үнэлэхдээ өөрсдийн олж авсан дүгнэлт мэдээллийг ашиглах шаардлагатай. Гэхдээ үнэлгээчид нь үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх үйл ажиллагааг санхүүжүүлэхтэй тэмцэх арга хэмжээний зохицуулалт, хамтын ажиллагаатай холбоотой дүгнэлтээ зөвхөн 11 дүгээр шууд хэрэгжилтийг үнэлэхэд ашиглах бөгөөд энэ нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэхтэй холбоотой бусад шууд хэрэгжилт (2-оос 10 дугаар шууд үр дүн)-ийг үнэлэхэд ашиглагдахгүй.

Хэрэгжилт хангагдсан эсэхийг тодорхойлох Үндсэн асуудлууд

- 1.1 Тухайн улс орон нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг хэр сайн ойлгосон байна вэ?
- 1.2 Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үндэсний бодлого болон үйл ажиллагаа нь эдгээр тодорхойлсон эрсдэлүүдийг хэр хамарсан байна вэ?
- 1.3 Өндөр эрсдэлтэй тохиолдолд нэмэлт арга хэмжээ, эсвэл бага эрсдэлтэй тохиолдолд хялбаршуулсан арга хэмжээг авч хэрэгжүүлснийг тайлбарлахад эрсдэлийн үнэлгээний үр дүнг хэрхэн зөв ашиглаж байна вэ?
- 1.4 Эрх бүхий байгууллагууд, СДЗБ-уудын зорилт, үйл ажиллагаа нь шинэчлэгдэж байдаг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үндэсний бодлого болон холбогдох тодорхойлсон эрсдэлтэй хэр нийцэж байна вэ?

1.5 Эрх бүхий байгууллага, СДЗБ-ууд нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх болон шаардлагатай бол үйл олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх бодлого болон арга хэмжээг боловсруулан хэрэгжүүлэх тал дээр ямар хүрээнд хамтран ажиллаж, хэр уялдаа холбоотой байна вэ?

1.6 ФАТФ-ын стандартуудыг мөрдөх шаардлагатай санхүүгийн байгууллага, СББМҮҮ нар болон бусад салбарууд нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх талаарх улс орны эрсдэлийн үнэлгээний холбогдох үр дүнгийн талаар хэр зэрэг ойлголттой болсон байна вэ?

a) Үндсэн асуудлуудын талаар дүгнэлт хийхэд тусламж болох мэдээллийн жишээ

1. Улс орнуудын өөрсдийн эрсдэлийг үнэлсэн үнэлгээ (хийсэн болон олон нийтэд танилцуулсан/мэдээлсэн үнэлгээний төрөл г.м).

2. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх бодлого, стратеги (мэдээлсэн/олон нийтэд танилцуулсан мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх бодлого, стратеги, захирамж болон дээд түвшний эрх баригчдын болон улс төрийн түвшин дэх үүрэг, оролцоо, амлалт г.м).

3. Хувийн салбар болон холбогдох эрх бүхий байгууллагуудад чиглэсэн үйл ажиллагаа (эрсдэлийн үнэлгээний холбогдох дүгнэлтийн талаарх товч тойм, удирдамж, эрсдэлийн үнэлгээг хөгжүүлэх бодлого, хууль тогтоомж, баримт бичиг болон бусад бодлогын баримт бичгийн талаар өгсөн зөвлөгөөний давтамж, холбоо хамаарал г.м).

b) Үндсэн асуудлуудын талаар дүгнэлт хийхэд дэмжлэг болох тусгай хүчин зүйлсийн жишээ

4. Эрсдэлийн үнэлгээний дүгнэлтийг боловсруулах, хянах болон үнэлэхэд ашиглагдаж буй ямар аргачлал, хэрэгсэл, мэдээлэл байна вэ? Ашиглаж буй мэдээ мэдээлэл нь хэр өргөн, цогц хүрээг хамарсан байна вэ?

5. Стратегийн санхүүгийн мэдээлэл, дүн шинжилгээ, судалгаа, удирдамж чиглэл нь хэр үр дүнтэй байна вэ?

6. Эрсдэлийг үнэлэхэд ямар эрх бүхий байгууллагууд болон холбогдох талууд (санхүүгийн байгууллагууд болон СББМҮҮ нар)-ыг хамруулж байна вэ? Эдгээр талууд нь үндэсний түвшинд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг үнэлэхэд ямар хувь нэмрээ оруулж байна вэ, оролцоо нь ямар үе шатанд байна вэ?

7. Эрсдэлийн үнэлгээг цаг тухайд нь хийж байна уу, тогтмол хянаж байна уу, томоохон үйл явдал, ахиц дэвшил (шинэ аюул заналхийлэл болон чиг хандлага зэрэг)-д дээрх үнэлгээ нь уян хатан байна уу?

8. Улс оронд тулгарч буй мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх аюул заналхийлэл, сул тал болон бодит нөхцөл байдалд эрсдэлийн үнэлгээ нь хэр үндэслэлтэй нийцэж байна вэ? Шаардлагатай үед бусад найдвартай эх сурвалжуудын тодорхойлсон эрсдэлийг харгалзан авч үзэж байна уу?

9. Эрх бүхий байгууллагуудын бодлого нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой хувьсан өөрчлөгдөж байгаа эрсдэлүүдэд хариу үйлдэл үзүүлж байна уу?

10. Эрх бүхий байгууллагууд нь бодлого боловсруулах болон үйл ажиллагааны аль түвшинд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх (шаардлагатай бол үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх үйл ажиллагааг санхүүжүүлэх)-тэй тэмцэх бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх, энэ талаар үндэсний хэмжээнд хамтран ажиллаж, бодлогоо уялдуулан зохицуулахад ямар

ФАТФ-ын зөвлөмжийн техникийн хэрэгжилт болон МУТСТ тогтолцооны үр дүнтэй байдлыг үнэлэх

механизм ашиглаж байна вэ? Тус механизм буюу тогтолцоонд нь бүх холбогдох эрх бүхий байгууллагуудыг хамруулсан байгаа юу?

11. Дотоодын хамтын ажиллагаа, зохицуулалтад зориулж эрсдэлийн үнэлгээг хийхэд хангалттай нөөц бололцоо, мэдлэг чадвар байна уу?

Шууд хэрэгжилт 2

Олон улсын хамтын ажиллагаа нь гэмт хэрэгтэн болон тэдний хөрөнгийн талаар шаардлагатай мэдээ, санхүүгийн мэдээлэл болон нотлох баримтыг олох боломж олгодог байх.

Үр дүнтэй системийн шинж чанар

Бусад улсаас ирсэн мэдээлэл, туслалцаа хүссэн хүсэлтэд цаг алдалгүй хэрэгцээтэй хариу өгдөг байх. Эрх бүхий байгууллага нь дараах хүсэлтэд хариулна. Үүнд:

- Гэмт этгээдүүдийг олж илрүүлэх, шилжүүлэн өгөх;
- Мөнгө угаах, холбоотой суурь гэмт хэрэг болон терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэгтэй холбоотой хөрөнгийг илрүүлэх, царцаах, битүүмжлэх, хураан авах, мэдээлэл өгөх;

Гэмт этгээд болон тэдний хөрөнгийг мөрдөхийн тулд эрх бүхий байгууллага нь олон улсын хамтын ажиллагааг ашиглана. Үүний үр дүнд тухайн улс гэмт хэрэгтнүүдийн үйл ажиллагаа явуулах, хууль бус орлогоо байршуулах таатай нөхцөлтэй орны тооноос хасагдахад хүргэнэ.

Энэ шууд хэрэгжилт нь Зөвлөмж 36-40 болон Зөвлөмж 9, 24, 25, 32-ын зарим заалтад хамааралтай.

Үнэлгээчдэд өгөх зааварчилгаа:

Үнэлгээчид нь шууд хэрэгжилтийг үнэлэхдээ олон улсын хамтын ажиллагааг хэрэгжүүлэхдээ холбогдох эрх бүхий байгууллагууд ямар тодорхой үүрэгтэй оролцож байгаа, бусад ШХ (ялангуяа ШХ3, ШХ5, ШХ6-ШХ10)-д хэрхэн нөлөөлж байгааг, дотооддоо илрүүлсэн хэрэгтэй холбоотой гадаад хамтын ажиллагааг шаардлагатай үед хэрхэн ашиглаж байгааг оролцуулан дүгнэнэ.

Хэрэгжилт хангагдсан эсэхийг тодорхойлох Үндсэн асуудлууд

- 2.1. Олон улсын хамтын ажиллагааны олон төрлийн хүсэлтэд хэрхэн цаг алдалгүйгээр хэрэгцээтэй хариуг өгсөн бэ? Өгсөн хариу нь шаардлага хангаж байсан эсэх?
- 2.2. Тухайн улс нь олон улсыг хамарсан МУТС болон түүнтэй холбоотой суурь гэмт хэрэгт холбогдолтой гэмт үйлдэлд хэрэгцээтэй үед хэрхэн цаг алдалгүй олон улсын хамтын ажиллагааг хүссэн байна вэ?
- 2.3. Эрх бүхий байгууллагууд МУТСТ зорилгоор санхүүгийн, хяналт шалгалтын, хууль хяналтын байгууллагуудын болон бусад мэдээлэл шаардлагатай үед, хугацаа алдалгүй солилцох бусад хэлбэрийн олон улсын хамтын ажиллагааг хэрхэн ашиглаж байна вэ?
- 2.4. Эрх бүхий байгууллагууд МУТСТ зорилгоор санхүүгийн, хяналт шалгалтын, хууль хяналтын байгууллагуудын болон бусад мэдээлэл шаардлагатай үед, хугацаа алдалгүй солилцох бусад хэлбэрийн олон улсын хамтын ажиллагаанд хэрхэн хариу өгч (тохиолдын хариу өгөхийг оруулаад) байна вэ?
- 2.5. Хувь хүн, хуулийн этгээдийн тухай ерөнхий болон эцсийн өмчлөгчийн мэдээллийг хүссэн гадаад улсаас ирсэн хамтын ажиллагааны хүсэлтэд эрх бүхий байгууллагууд ямар хэлбэрээр хариу өгч байна вэ?

а) Үндсэн асуудлуудын талаар дүгнэлт хийхэд тусламж болох мэдээллийн жишээ

1. Хэрэгтэн шилжүүлэх, эрх зүйн харилцан туслалцаа болон бусад хэлбэрийн олон улсын хамтын ажиллагааг хүссэн болон хариу өгсөн байдлын талаар нотлох баримт (жн: эрх бүхий байгууллагуудын (Төв байгууллага, СМА, хянан шалгах, хууль сахиулах байгууллагууд) явуулсан төрөл бүрийн хүсэлтийн тоо, хүлээн авсан хүсэлтийн тоо, хариулсан хүсэлтийн тоо, татгалзсан хүсэлтийн тоо, хариу өгсөн хугацаа, хүсэлтийг ач холбогдлоор нь ангилсан байдал, тохиолдлын байдлаар мэдээлэл солилцсон байдал г.м.)

2. Бусад улс оронтой хамтран ажиллах гэрээ хэлэлцээрийн төрөл, тоо (хоёр талт болон олон талт ХОСБ, гэрээ, харилцан мэдээлэл солилцох хэлбэр болон бусад хамтын ажиллагааны хэлбэрүүд).

3. Олон улсын хамтын ажиллагааны хүрээнд (а) хүлээн авсан хүсэлт болон (б) амжилттай биелүүлсэн (санхүүгийн мэдээллийг/нотлох баримтыг ашигласан (хүлээн авсан, явуулсан байдал кэйсээс шалтгаалан) байдал, гадаадын холбогдох талын нэрийн өмнөөс болон хамтран хийсэн мөрдөн шалгалт, МУТС гэмт хэрэгт холбоотой гэмт этгээдүүдийг/сэжигтнийг шилжүүлсэн жишээ).

4. Явуулсан мөрдөн шалгалт, ялгалт, хөрөнгө хураан авалт болон буцаалт/хуваасан байдлын талаар мэдээлэл (жн: МУТС холбоотой явуулсан мөрдөн шалгалт, ялгалтын тоо, гадаад хамтын ажиллагааны хүрээнд царцаасан, хураан авсан хөрөнгийн тоо, хэмжээ (шүүхээр шийтгэгдээгүй байхад хураан авсан хөрөнгийн тоо), хөрөнгө буцаасан, хуваасан хөрөнгийн хэмжээ).

b) Үндсэн асуудлуудын талаар дүгнэлт хийхэд дэмжлэг болох тусгай хүчин зүйлсийн жишээ

5. Холбогдох байгууллагууд нь ирсэн хүсэлт, хүсэлтийн дагуу авч хэрэгжүүлэх арга хэмжээний үйл явц (жн: мөрдөн шалгах үед), мэдээлэл солилцоход ямар нууцлал, аюулгүй байдлын арга хэмжээг хэрэгжүүлж байна вэ?

6. Эрх бүхий байгууллагуудад туслалцаа хүссэн хүсэлт хүлээн авах, үнэлэх болон ач холбогдол өгөх ямар механизм (“Case management system” буюу “Хэргийн удирдлагын систем”-ийг оруулаад) хэрэглэж байна вэ?

7. Ямар шалтгааны улмаас туслалцаа хүссэн хүсэлтэд татгалзсан эсвэл хариу өгөх боломжгүй байсан бэ?

8. Эрх бүхий байгууллагууд туслалцаа хүссэн хүсэлтийг гаргах, үнэлэх болон ач холбогдол өгөх ямар механизм (“Case management system” буюу “Хэргийн удирдлагын систем”-ийг оруулаад) хэрэглэж байна вэ?

9. Эрх бүхий байгууллагууд мэдээлэл хүсч байгаа талд туслалцаа хүссэн хүсэлтийг ойлгож, зөв үнэлж, ач холбогдолтой алдаагүй хариу мэдээлэл өгөх үйл явцыг хэрхэн хангаж байна вэ?

10. Тус улс орон нь шүүх эрх мэдлийн харьяалал, мэдээллийн хүсэлтийн чанар муу байх зэрэг асуудлыг мэдээлэл хүсч байгаа болон хүлээн авсан улс оронтой хэрхэн эерэг хэлбэрээр зохицуулан шийдэж байна вэ?

11. Эрх бүхий байгууллагууд нь олон улсын хамтын ажиллагаа хүсч байгаа талд холбогдох шаардлагатай албан тушаалтны болон биелүүлэх шаардлагын тухай мэдээллийг ил тод, ойлгомжтой тодорхой байлгах ямар арга хэмжээ авч байна вэ?

12. Хуулийн дагуу өөрийн улсын иргэнийг гадаад улс руу шилжүүлэх боломжгүй үед түүнийг цаг алдалгүй яллах ямар арга хэмжээ авдаг вэ?

13. Бусад улс орны хүсэлтийн дагуу хураан авсан хөрөнгийг удирдах, буцаах ямар арга хэмжээ, зохицуулалт байдаг вэ?

ФАТФ-ын зөвлөмжийн техникийн хэрэгжилт болон МУТСТ тогтолцооны үр дүнтэй байдлыг үнэлэх

14. Олон улсын хамтын ажиллагаанд саад болдог хууль, эрх зүйн, үйл ажиллагааны эсвэл шүүхийн (хэт өндөр харилцан гэмт хэрэгт (dual criminality) тооцох шалгуур тавих) ямар нэгэн асуудал байна уу?

15. Эрх бүхий байгууллагууд нь ямар түвшинд шууд харилцагч биш талтай шууд бусаар мэдээлэл солилцож байна вэ?

16. Олон улсын хамтын ажиллагаа шаардсан хүсэлтийг (a) хүлээн авах, боловсруулах, зохион байгуулах болон хариулахад, (b) цаг хугацаанд нь зохион байгуулаттай хүсэлт гаргах хангалттай нөөцтэй байна уу?

Шууд хэрэгжилт 3

Хянан шалгагч нар санхүүгийн байгууллага болон СББМҮҮ нарыг шаардлагатай түвшинд эрсдэлээс нь хамааруулан МУТСТ үүргээ хэрхэн биелүүлж байгааг хянадаг, зохицуулдаг байх.

Үр дүнтэй системийн шинж чанар

Санхүүгийн байгууллагууд болон бусад холбогдох салбаруудад мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг бууруулах зорилготой хяналт шалгалт, мониторингийг доорх байдлаар гүйцэтгэнэ. Үүнд:

- Гэмт хэрэгтнүүд болон тэдний нэгдмэл сонирхолтой этгээдүүдийг санхүүгийн байгууллага эсвэл СББМҮҮ нарын удирдлагын үйл ажиллагаанд оролцох, хяналт тавих, эцсийн өмчлөгч байхаас сэргийлэх;
- МУТС тэмцэх эрсдэлийн удирдлага алдаатай, хангалтгүй мөн МУТС-тэй холбоотой зөрчил илэрсэн тохиолдолд алдаа дутагдлыг илрүүлж арилгуулах, торгох зэрэг арга хэмжээг авч байх.

Хянан шалгагч⁶⁹ нь МУТС-тэй тэмцэх шаардлагыг дагаж мөрдөх зааварчилгаа, зөвлөмжийг санхүүгийн байгууллага болон СББМҮҮ нарт өгдөг байх шаардлагатай. Тодорхой хугацааны дараа хяналт шалгалт нь МУТС тэмцэх чиглэлийн хэрэгжилтийн түвшинг сайжруулж улмаар гэмт хэрэгтнүүдийн санхүүгийн болон санхүүгийн бус үйлчилгээний салбарууд ялангуяа мөнгө угаах өндөр эрсдэлтэй салбаруудыг ашиглаж мөнгө угаах оролдлого буурна.

Энэхүү шууд хэрэгжилт нь юуны өмнө Зөвлөмж 14, 26, 28, 34, 35 болон Зөвлөмжийн 1, 40-ийн зарим заалтад хамааралтай болно.

Үнэлгээчдэд өгөх зааварчилгаа:

Үнэлгээчид нь олон улсын хамтын ажиллагаатай холбоотой мэдээллийг (санхүүгийн бүлгийн түвшин гэх мэт) авч үзэхдээ энэхүү богино хугацааны үр дүнтэй холбоотой ажилд ямар хянан шалгагч оролцож буйг харгалзан үзэх хэрэгтэй.

Хэрэгжилт хангагдсан эсэхийг тодорхойлох Үндсэн асуудлууд

3.1 Гэмт хэрэгтэн, нэгдмэл сонирхолтой этгээдүүдийг санхүүгийн байгууллага болон СББМҮҮ-д эцсийн өмчлөгч байх болон удирдлагад оролцохоос сэргийлж эрх бүхий байгууллага болон хянан шалгагч нь тусгай зөвшөөрөл олгох, бүртгэл болон хяналт шалгалт хийх явцыг хэр сайн хэрэгжүүлж байна вэ? Энэхүү зөвшөөрөл болон бүртгэлийн шаардлагатай холбоотой зөрчлийг хэр сайн илрүүлж байна бэ?

3.2 Хянан шалгагч нь МУТС тэмцэх эрсдэлийн ойлголтыг санхүүгийн болон бусад салбарт бүхэлд нь, төрөл бүрийн салбарт, байгууллагууд болон нэг этгээдэд хэрхэн үнэн зөв тогтоож, хангалттай тодорхойлж чаддаг эсэх.

3.3 Эрсдэлийг бууруулах зорилгоор хянан шалгагч нь эрсдэлд мэдрэмтгий байдалд үндэслэж санхүүгийн байгууллага болон СББМҮҮ нарт МУТС тэмцэх шаардлагыг хэрэгжүүлж байгаад хяналт шалгалт болон мониторинг хийх ямар арга хэмжээ авч байна вэ?

3.4 Амьдрал дээр зөрчлийг арилгуулах арга хэмжээ нь үр нөлөөтэй, үйлдсэн зөрчилтэй нь дүйцэхүйц, гэмт хэрэг давтан үйлдэхээс сэргийлсэн байгаа эсэх?

⁶⁹ “Хянан шалгагчид” нь үр дүнтэй байдлыг үнэлэх зорилгоор СДЗБ-ыг хамруулсан.

ФАТФ-ын зөвлөмжийн техникийн хэрэгжилт болон МУТСТ тогтолцооны үр дүнтэй байдлыг үнэлэх

3.5 Хянан шалгагч нь санхүүгийн байгууллага, СББМҮҮ нарт шаардлагыг хэрэгжүүлэх үүрэгт ямар нөлөө үзүүлж, арга хэмжээ авч чадаж байна вэ?

3.6 Хянан шалгагч нь санхүүгийн байгууллага болон СББМҮҮ нарт МУТС-тэй тэмцэх үүрэг болон эрсдэлийн тухай хэр сайн ойлголт өгч байна вэ?

а) Үндсэн асуудлуудын талаар дүгнэлт хийхэд тусламж болох мэдээллийн жишээ

1. Санхүүгийн байгууллага, СББМҮҮ, албан бус буюу зохицуулалтгүй салбаруудын хэмжээ, бүрэлдэхүүн, бүтэц (*жн: санхүүгийн байгууллагын тоо, төрөл (мөнгө болон үнэт зүйлс шилжүүлэх үйлчилгээ багтана) СББМҮҮ нар нь ангилал бүрт тусгай зөвшөөрөл эсвэл бүртгэлтэй, санхүүгийн үйл ажиллагааны төрөл, (хил дамнасан г.м) харьцангуй хэмжээ, салбарын ач холбогдол нөлөө, салбарт эзлэх хувь*).

2. МУТС-тэй тэмцэхтэй холбоотой хяналт шалгалтын эрсдэлийн загвар, гарын авлага, удирдамж (*Жн: хяналт хариуцсан ажилтнуудад зориулсан үйл ажиллагааны гарын авлага, МУТС тэмцэх хяналт/хяналтын арга барилыг харуулсан хяналттай холбоотой сурталчилгааны материал, сайн муу туршиллагууд, сэдэвчилсэн судалгаа, жилийн тайлан*).

3. МУТС тэмцэх асуудлаар СМА болон бусад эрх бүхий байгууллага, салбарын түвшинд байгуулсан хяналтын оролцоотой холбоотой мэдээлэл (*Жн: удирдамж, сургалтаар хангах, уулзалт зохион байгуулах, санхүү, СББМҮҮ нарын харилцаа холбоог дэмжих*).

4. Хяналт шалгалтын тухай мэдээлэл (*Жн: хяналт шалгалтын (газар дээрх болон зайнаас) давтамж, хамрах хүрээ, чиглэл; зөрчлийн шинж чанар, хэрэгжүүлсэн арга хэмжээ болон торгууль шийтгэл (Жн: засч залруулах арга хэмжээ, сануулга, торгууль), МУТС тэмцэх журмыг хэрэгжүүлээгүй тохиолдолд оногдуулсан шийтгэл болон залруулгын арга хэмжээг авснаар МУТС тэмцэх ажиллагаа нь сайжирсан тухай мэдээллүүд*).

б) Үндсэн асуудлуудын талаар дүгнэлт хийхэд дэмжлэг болох тусгай хүчин зүйлсийн жишээ

5. Тухайн улс оронд халхавч банк байгуулагдах, үйл ажиллагаа явуулах, эдгээрээс урьдчилан сэргийлэх ямар арга хэмжээ авч байна вэ?

6. “Зохистой үйл ажиллагаа”-ны тест эсвэл үүнтэй төстэй шалгуурыг санхүүгийн байгууллага, СББМҮҮ нарын дээд удирлага, их хэмжээний хувь эсвэл хяналтын багцыг эзэмшдэг болон аттестатчлагдсан этгээдүүдээс шаарддаг эсэх?

7. Хянан шалгагч нар нь хяналт шалгалт болон мониторинг хийлгэж байгаа аж ахуйн нэгж, салбаруудынхаа МУТС тэмцэх эрсдэлийг үнэлэхдээ ямар арга хэмжээг ашигладаг вэ? Хэр давтамжтай эрсдэлийн хяналт хийгддэг мөн ямар учраас хийгддэг вэ (жн: удирдлага эсвэл бизнесийн үйл ажиллагаанд өөрчлөлт орсон үед)?

8. МУТС тэмцэх үүргээ (терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой тавьсан хориг арга хэмжээнүүд болон үүнтэй холбоотой ФАТФ-аас шаардсан арга хэмжээнүүдийг оролцуулаад) санхүүгийн байгууллага (санхүүгийн бүлэг орно) болон СББМҮҮ нар хэрхэн биелүүлж байгааг хяналт шалгалтын ямар арга хэмжээ болон хэрэгслээр зохицуулагдаж вэ? Энэ нь албан ёсны санхүүгийн тогтолцоог ашиглахад хэр их дэмжлэг болж байна вэ?

9. Санхүүгийн байгууллага (санхүүгийн бүлэг орно) болон СББМҮҮ нарын эрсдэлийн төрөл нь газар дээрх болон зайнаас хяналт тавих шалгалтын давтамж, хамрах хүрээтэй хэрхэн нийцэж байна вэ?

10. МУТСТ асуудлаар (санхүүгийн бүлгийн МУТС эрсдэлийн удирдлагыг оролцуулаад) хянан шалгагч болон бусад эрх бүхий байгууллага хоорондын хамтын ажиллагааны түвшин ямар

ФАТФ-ын зөвлөмжийн техникийн хэрэгжилт болон МУТСТ тогтолцооны үр дүнтэй байдлыг үнэлэх

байна вэ? Ямар тохиолдолд хянан шалгагч нар нь МУТС-тэй тэмцэх асуудлаар бусад эрх бүхий байгууллагатай мэдээлэл солилцож байна вэ (Зах зээлд нэвтрэх асуудал гэх мэт)?

11. МҮБЗШҮ эрхлэгч нарыг хэрхэн тодорхойлж, тусгай зөвшөөрөл, бүртгэл, хяналт шалгалт болон шийтгэлийн арга хэмжээг авдаг вэ?

12. МУТСТ чиглэлээр хяналт мониторингд хамрагдах салбарын хэмжээ, эрсдэлийн түвшин болон хэцүү асуудлаас хамаараад МУТС-тэй тэмцэхэд хангалттай нөөц бололцоо хянан шалгагчид байгаа эсэх?

13. Санхүүгийн хянан шалгагч нь МУТС-тэй тэмцэх асуудлаар зүй бус нөлөөлөлд автахгүй үйл ажиллагааны бие даасан байдлыг баталгаажуулах ямар арга хэмжээ хэрэгжүүлдэг вэ?

Шууд хэрэгжилт 4

Санхүүгийн байгууллага, СББМҮҮ нар нь эрсдэлээс хамаарсан МУТСТ урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч хэрэгжүүлж, сэжигтэй гүйлгээг мэдээлдэг байх.

Үр дүнтэй системийн шинж чанар

Санхүүгийн байгууллага болон СББМҮҮ нар нь МУТС эрсдэлийн мөн чанар, түвшинг ойлгож, МУТС тэмцэх бодлого боловсруулж хэрэгжүүлэх (бүлгийн хэмжээний бодлого), дотоод хяналт, эрсдэлийг бууруулах зохистой хөтөлбөр боловсруулах, харилцагчийг таньж мэдэх, үйлчлүүлэгчдийг баталгаажуулах арга хэмжээ авах (эцсийн өмчлөгчийг оролцуулаад), байнгын хяналт тавих, сэжигтэй гүйлгээг зохих ёсоор илрүүлж мэдээлэх мөн бусад МУТС-тэй тэмцэх шаардлагыг дагаж мөрдөх шаардлагатай. Энэ нь эцэстээ аж ахуйн нэгжийн мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг бууруулна.

Энэ шууд хэрэгжилт нь юуны өмнө Зөвлөмжийн 9-23 болон Зөвлөмж 1, 6, 9-ийн зарим заалтад хамааралтай болно.

Үнэлгээчдэд өгөх зааварчилгаа:

Үнэлгээчид нь санхүүгийн байгууллага болон СББМҮҮ нарын үйл ажиллагаанд нарийвчилсан хяналт тавих албагүй ч нотлох баримтын үндсэн дээр эсвэл хянан шалгагчтай ярилцлага хийх замаар, СМА, санхүүгийн байгууллага, СББМҮҮ нар нь МУТС эрсдэлд өртөж болзошгүй эсэхээ хангалттай үнэлж чадаж байгаа эсэх, ойлгож байгаа эсэх; тэдний бодлого, журам, дотоод хяналт нь дээрх эрсдэлийг зохистой шийдвэрлэж байгаа эсэх, зохицуулалтын шаардлагууд оновчтой хэрэгжиж байгаа эсэх (сэжигтэй гүйлгээний тайлан гэх мэт) дээр анхааран ажиллах шаардлагатай.

Хэрэгжилт хангагдсан эсэхийг тодорхойлох Үндсэн асуудлууд

4.1 Санхүүгийн байгууллага болон СББМҮҮ нар нь МУТС эрсдэл болон МУТС тэмцэх үүргээ хэр сайн ойлгож байна вэ?

4.2 Санхүүгийн байгууллага болон СББМҮҮ нар нь эрсдэлд тохирсон эрсдэлийг бууруулах зохистой арга хэмжээг хэрхэн сайн авч байна вэ?

4.3 Санхүүгийн байгууллага болон СББМҮҮ нар нь харилцагчийг таньж мэдэх (ХТМ), мэдээллийг хадгалах арга хэмжээ хэрхэн сайн хэрэгжүүлдэг вэ (эцсийн өмчлөгч болон байнгын хяналтын мэдээлэл гэх мэт)? Ямар түвшинд ХТМ мэдээлэл дутуу байгаа нөхцөлд гүйлгээ хийхээс татгалздаг вэ?

4.4 Санхүүгийн байгууллага болон СББМҮҮ нар нь доор дурдсан: (а) Улс төрд нөлөө бүхий этгээд (б) Корреспондент банк (в) Шинэ технологи (г) Шилжүүлгийн журам (д) Терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой санхүүгийн хориг арга хэмжээ авах (е) ФАТФ-аас зарласан өндөр эрсдэлтэй орноор тодорхойлсон зэрэг нөхцлүүдэд нэмэгдүүлсэн болон тусгай арга хэмжээг ямар түвшинд авч байна вэ?.

4.5 Санхүүгийн байгууллага болон СББМҮҮ нар нь гэмт хэргийн орлого, терроризмыг дэмжих санхүүжилтын үйл ажиллагаанд ашиглаж болзошгүй хөрөнгийг сэжигтэй гэж тайлагнах үүргээ хэрхэн биелүүлж байна вэ? Мэдээлэл алдагдахаас урьдчилан сэргийлэх практик арга хэмжээ нь юу байна вэ?

4.6 Санхүүгийн байгууллага болон СББМҮҮ нар (санхүүгийн бүлэг хамарна) нь МУТС тэмцэх шаардлагыг хангах дотоод хяналт, журмыг хэр сайн хэрэгжүүлж, дагаж мөрдөж байна вэ?

ФАТФ-ын зөвлөмжийн техникийн хэрэгжилт болон МУТСТ тогтолцооны үр дүнтэй байдлыг үнэлэх

Байгууллагуудад хэрэгжилтэд саад болж байгаа эрх зүйн болон зохицуулалтын ямар шаардлага байна вэ (Жн: санхүүгийн нууцлал)?

а) Үндсэн асуудлуудын талаар дүгнэлт хийхэд тусламж болох мэдээллийн жишээ

1. Санхүүгийн байгууллага, СББМҮҮ, албан бус/хяналтгүй салбарын хэмжээ болон бүтэц бүрэлдэхүүн зэрэг бүтцийн хүчин зүйлс (жн: санхүүгийн байгууллагын төрөл болон тоо (МУБЗШҮ оролцуулан), СББМҮҮ нарын салбар тус бүрт тусгай зөвшөөрөлтэй, бүртгэлтэй байх, санхүүгийн үйл ажиллагааны төрөл (хил дамнансан гэх мэт); салбарын зах зээлд эзлэх хувь хэмжээ, ач холбогдол, салбарын бодит байдал зэрэг).

2. Эрсдэл (төлөв байдлыг оролцуулаад) болон хэрэгжилтийн ерөнхий түвшинтэй холбоотой мэдээлэл (Жн: МУТС тэмцэх дотоод бодлого, журам, хөтөлбөр, чиг хандлага, төлөв, типологийн тайлан).

3. Хэрэгжилтийн зөрчлийн жишээнүүд (Санхүүгийн байгууллага, СББМҮҮ нарыг урвуулан ашигласан типологи, дүн шинжилгээ хийсэн хэргүүдийн жишээ)

4. Санхүүгийн байгууллага болон СББМҮҮ нарын хэрэгжилтийн тухай мэдээлэл (МУТС тэмцэх дотоод биелэлт, түүний давтамж болон хяналтын үр дүн; зөрчлийн мөн чанарыг тодорхойлж засч залруулах арга хэмжээг авах эсвэл шийтгэлийн арга хэмжээ; МУТС тэмцэх сургалтын чанар, давтамж; МУТС тэмцэх зориулалтаар үнэн зөв, бүрэн гүйцэд ХТМ мэдээллийг эрх бүхий байгууллагад өгөх арга хэмжээнд зарцуулж буй цаг хугацаа; МУТС тэмцэх зорилгоор үнэн зөв, бүрэн гүйцэд ХТМ мэдээллийг эрх бүхий байгууллагад өгөх арга хэмжээнд зарцуулж буй хугацаа; ХТМ мэдээлэл хангалтгүй байсны улмаас данс нээх/ үүсгэсэн харилцааг цуцалсан мөн шаардлагатай мэдээлэл хангалтгүйн улмаас цахим мөнгөн шилжүүлэг хийхээс татгалзсан зэрэг жишээнүүд байна).

5. Үндэсний хууль тогтоомжийн дагуу сэжигтэй гүйлгээг болон бусад мэдээллийг тайлагнах. (Жн: ирүүлсэн сэжигтэй гүйлгээний тайлангийн тоо, холбогдох гүйлгээний утга; төрөл бүрийн салбарын сэжигтэй гүйлгээний тайлангийн тоо болон эзлэх хувь; МУТС эрсдэлд харгалзах сэжигтэй гүйлгээний тайлангийн баримт бичгийн төрөл, шинж чанар болон чиг хандлага; сэжигтэй гүйлгээний тайлан гаргахаас өмнө сэжигтэй гүйлгээг судлах, бусад арга хэмжээ авах дундаж хугацаа).

б) Үндсэн асуудлуудын талаар дүгнэлт хийхэд дэмжлэг болох тусгай хүчин зүйлсийн жишээ

6. Өндөр эрсдэлтэй харилцагч (шаардлагатай бол бууруулсан), бизнесийн харилцаа, гүйлгээ, бүтээгдэхүүн болон улс орны эрсдэлийг хэрхэн тодорхойлж ямар арга замаар зохицуулж байна вэ?

7. МУТС тэмцэх арга хэмжээнүүд нь санхүүгийн албан ёсны системийг ашиглахад төвөг учруулж байна уу? Санхүүгийн албан ёсны салбарын хүртээмжийг сайжруулахад ямар арга хэмжээ авч байна вэ?

8. ХТМ нэмэгдүүлсэн эсвэл онцгой арга хэмжээ нь төрөл бүрийн салбар/байгууллага, бие даасан байгууллагын хувьд МУТС эрсдэлээс нь хамаараад ямар ялгаатай байна вэ? Олон улсын санхүүгийн бүлэг болон дотоодын байгууллагуудын хэрэгжилтийн харьцуулсан түвшин ямар байна вэ?

9. Гуравдагч этгээдээр ХТМ үйл явцыг хийлгэх цар хүрээ нь хэр их байна вэ? Мөн хяналтыг хэр сайн хэрэгжүүлж байна вэ?

10. Санхүүгийн байгууллага, бүлэг болон СББМҮҮ нар нь МУТС-тэй тэмцэх хэрэгжилтийн чиг үүрэг бүхий этгээдэд нэвтрэх боломжийг хэр сайн олгож байна вэ?

11. Санхүүгийн байгууллага, бүлэг болон СББМҮҮ нарын дотоод бодлого нь дараах зүйлсийг цаг тухайд нь хянах боломж бололцоо олгож байна уу: (i) Төвөгтэй, хэвийн бус гүйлгээ (ii) Сэжигтэй байж болзошгүй гүйлгээний тайланг СМА-нд мэдээлэх (iii) Алдаатай ангилсан гүйлгээ болон сэжигтэй гүйлгээний тайлан нь сэжигтэй гүйлгээтэй холбоотой бүрэн гүйцэд, үнэн зөв, хангалттай мэдээллийг хэр хэмжээнд агуулж чадаж байна вэ?
12. Эрсдэлийг үнэлэх, бодлогын хэрэгжилтийг хангах, хариу арга хэмжээ авах МУТС эрсдэлийг бууруулах систем болон хяналтыг хэрхэн тогтоож байна вэ?
13. МУТС-тэй тэмцэх бодлого болон хяналтыг дээд түвшний удирдлага мөн ажилтнуудад хэрхэн мэдээлж байна вэ? Санхүүгийн байгууллага болон СББМҮҮ нар нь МУТС-тэй холбоотой зөрчил гаргасан тохиолдолд засч залруулах болон шийтгэлийн ямар арга хэмжээ авч байна вэ?
14. Санхүүгийн байгууллага болон СББМҮҮ нар нь МУТС эрсдэлийн үнэлгээг тогтмол хийж, шинэчилж байна уу?
15. Санхүүгийн байгууллага болон СББМҮҮ нар нь байгууллагын хэмжээ, бүтэц, өөрийн үйл ажиллагаа болон эрсдэлийн төрөлд тохирсон МУТС-тэй тэмцэх бодлого, хяналтыг хэрэгжүүлэх хангалттай нөөц бололцоотой байна уу?
16. Санхүүгийн байгууллага болон СББМҮҮ нарт туслах зорилгоор сэжигтэй гүйлгээ илрүүлэх, тайлагнахтай холбоотой эргэх холбоог хэр сайн хэрэгжүүлж байна вэ?

Шууд хэрэгжилт 5

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх хууль бус үйлдлээс хуулийн этгээд болон эрх зүйн бусад зохицуулалт бүхий этгээдийг урьдчилан сэргийлсэн, эрх бүхий байгууллага нь тэдгээрийн эцсийн өмчлөгчийн тухай мэдээллийг саадгүй авах боломжтой байх.

Үр дүнтэй системийн шинж чанар

Дараах арга хэжээнүүд нь:

- Хуулийн этгээд болон эрх зүйн бусад зохицуулалт бүхий этгээдийг гэмт хэргийн зорилгоор ашиглахаас урьдчилан сэргийлэх;
- Хуулийн этгээд болон эрх зүйн бусад зохицуулалт бүхий этгээдийг хангалттай ил тод болгох;
- Эцсийн өмчлөгчийн алдаагүй мэдээллийг хангаж, цаг тухайд нь шинэчилж, мэдээлэл авах боломжтой байлгах.

Үндсэн мэдээлэл нь олон нийтэд нээлттэй бөгөөд эцсийн өмчлөгчийн мэдээлэл нь эрх бүхий байгууллагуудад нээлттэй байна. Эдгээр арга хэмжээг зөрчсөн этгээдэд үр дүнтэй нөлөөлөх, гаргасан зөрчилтэй нь дүйцэхүйц, давтан үйлдэхээс сэргийлсэн шийтгэлийн арга хэмжээг оногдуулна. Энэ нь гэмт хэрэгтнүүдэд МУТС зорилгоор хуулийн этгээд болон эрх зүйн бусад зохицуулалт бүхий этгээдийг урвуулан ашиглах боломжгүй болгох юм.

Энэ шууд хэрэгжилт нь юуны өмнө Зөвлөмжийн 24, 25 болон Зөвлөмжийн 1, 10, 37, 40-ийн зарим заалтад хамааралтай.

Үнэлгээчдэд өгөх зааварчилгаа:

Энэ шууд хэрэгжилтийг хэрэгжүүлэх явцад эрх бүхий байгууллага нь олон улсын хамтын ажиллагааны түвшинд бий болсон ололтуудыг харгалзан үзэх шаардлагатай. Үүнд хуулийн этгээд болон бусад эрх зүйн бусад зохицуулалт бүхий этгээдийн мэдээллийг тодорхойлох, солилцох (эцсийн өмчлөгчийн мэдээллийг оролцуулаад) зэрэг асуудлаар эрх бүхий байгууллага нь зохих дэмжлэг, туслалцаа үзүүлэх багтана.

Хэрэгжилт хангагдсан эсэхийг тодорхойлох Үндсэн асуудлууд

5.1 Тухайн улсад хуулийн этгээд, эрх зүйн бусад зохицуулалт бүхий этгээдийн үүсгэн байгуулалт болон төрлийн тухай ямар мэдээлэл олон нийтэд нээлттэй байдаг вэ?

5.2 Холбогдох эрх бүхий байгууллага нь тухайн улсад хуулийн этгээдийг МУТС-нд ашиглах, өртөж болзошгүй эмзэг байдлыг хэр сайн ойлгож, тодорхойлж, үнэлж байна вэ?

5.3 МУТС зорилгоор хуулийн этгээд болон эрх зүйн бусад зохицуулалт бүхий этгээдийг ашиглахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрхэн хэрэгжүүлж байна вэ?

5.4 Ямар түвшинд холбогдох эрх бүхий байгууллагууд нь тухайн улс оронд байгуулагдсан төрөл бүрийн хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн алдаагүй, хангалттай мэдээллийг цаг тухайд нь авч чадаж байна вэ?

5.5 Ямар түвшинд холбогдох эрх бүхий байгууллагууд нь эрх зүйн бусад зохицуулалт бүхий этгээдийн эцсийн өмчлөгчийн алдаагүй, хангалттай мэдээллийг цаг тухайд нь авч чадаж байна уу?

ФАТФ-ын зөвлөмжийн техникийн хэрэгжилт болон МУТСТ тогтолцооны үр дүнтэй байдлыг үнэлэх

5.6 Мэдээллийн шаардлагыг хангаж чадахгүй байгаа этгээдийн эсрэг үр дүнтэй нөлөөлөх, гаргасан зөрчилтэй нь дүйцэхүйц, давтан үйлдэхээс сэргийлсэн шийтгэлийн арга хэмжээг хэр үр дүнтэй авч хэрэгжүүлж байна вэ?

а) Үндсэн асуудлуудын талаар дүгнэлт хийхэд тусламж болох мэдээллийн жишээ

1. Хуулийн этгээд болон эрх зүйн бусад зохицуулалт бүхий этгээдийн төрөл, хэлбэр болон нөхцөл байдлын мэдээлэл.

2. Хууль сахиулах болон холбогдох бусад эрх бүхий байгууллагын туршлага (Жн: мэдээллийн шаардлагыг зөрчсөн үйлдэлд оногдуулсан шийтгэлийн түвшин; эцсийн өмчлөгчийн мэдээллийг хаанаас, хэрхэн, авч болох (итгэл хүлээгч, итгэл хүлээлгэгч, хамгаалагч болон үр шим хүрэгч нар орно).

3. Хуулийн этгээд болон эрх зүйн бусад зохицуулалт бүхий этгээдийг урвуулан ашигласан жишээ, типологи (Жн: гэмт хэрэг мөрдөн шалгах явцад хуулийн этгээд болон эрх зүйн бусад зохицуулалт бүхий этгээдийг МУТС-д ашиглаж байгааг нотолсон нотолгоог олж авсан давтамж; хууль бус үйлдэлд ашиглагдаж байсан хуулийн этгээдийг татан буулгасан, үйл ажиллагааг таслан зогсоосон байдал гэх мэт).

4. Ерөнхий болон эцсийн өмчлөгчийн мэдээллийн эх сурвалж (Тухайлбал, санхүүгийн байгууллага, СББМҮҮ нарын авах боломжтой олон нийтийн мэдээллийн төрөл; компанийн бүртгэл эсвэл компанид өөрт нь хадгалагдаж буй мэдээллийн төрөл гэх мэт).

5. Хуулийн этгээд болон эрх зүйн зохицуулалтыг байгуулах, удирдахад хяналт тавьдаг этгээдийн /Gatekeeper/ үүрэг, оролцоо (Жн: компанийн үйлчилгээ үзүүлэгч мэрэгжилтэн, нягтлан бодогч, хуульч, эрх зүйчид зэрэг).

6. Бусад мэдээлэл (Жн: эрх зүйн бусад зохицуулалт бүхий этгээдэд байдаг тухай мэдээлэл; бусад орны хүсэлтээр ирсэн эцсийн өмчлөгчийн үндсэн мэдээлэлд хариу өгсөн байдал (эерэг болон сөрөг); үзүүлсэн тусалцааны чанарт хяналт тавьсан байдал).

б) Үндсэн асуудлуудын талаар дүгнэлт хийхэд дэмжлэг болох тусгай хүчин зүйлсийн жишээ

7. Хуулийн этгээд (Эзэмшигчийн хувьцаа, хувьцааны баталгаа, нэрлэсэн хувьцаа эзэмшигчид болон захирлууд гэх мэт) болон эрх зүйн бусад зохицуулалт бүхий этгээдийн ил тод байдлыг сайжруулах ямар арга хэмжээ авч байгаа вэ?

8. Эрх бүхий байгууллага нь хуулийн этгээдийн үндсэн болон эцсийн өмчлөлийн сүүлийн үеийн алдаагүй мэдээллийг хадгалж байх шаардлагыг биелүүлж байгааг хэрхэн хянаж байна вэ? Мэдээллийн бүрдүүлэлт, хяналт, баталгаажуулалт, шалгалт хийгдэж байна уу?

9. Хуулийн этгээдийн бүртгэл болон эцсийн өмчлөгчийн үндсэн мэдээллийн өөрчлөлтийг цаг тухайд нь алдаагүй эсэхийг зохих ёсоор шалгаж, дээрх асуудалд хангалттай хугацаа зарцуулдаг эсэх? Шаардлагатай тохиолдолд дээрхтэй төстэй зохицуулалтыг эрх зүйн бусад зохицуулалт бүхий этгээдэд цаг тухайд нь гүйцэтгэж чадаж байна уу?

10. Санхүүгийн байгууллага болон СББМҮҮ нар нь хуулийн этгээдийн болон эрх зүйн бусад зохицуулалт бүхий этгээдийн үндсэн болон эцсийн өмчлөгчийн талаар алдаагүй сүүлийн үеийн мэдээллийг авах боломжтой юу? Санхүүгийн байгууллага болон СББМҮҮ нарт итгэл хүлээгч нь ямар хэмжээний мэдээллийг өгдөг вэ?

11. Холбогдох эрх бүхий байгууллагууд нь зохистой арга хэмжээ хэрэгжүүлэх хангалттай нөөц боломжтой юу?

Шууд хэрэгжилт 6

Эрх бүхий байгууллага нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх үйлдлийг шалгахдаа санхүүгийн мэдээлэл болон бусад холбогдох мэдээллийг зүй зохистой ашигладаг байх.

Үр дүнтэй системийн шинж чанар

Эрх бүхий байгууллага нь мөнгө угаах, суурь гэмт хэрэг болон терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийг мөрдөн шалгахдаа олон төрлийн санхүүгийн мэдээлэл болон бусад төрлийн холбогдох мэдээллийг цуглуулж ашигладаг. Эдгээр мэдээлэл нь алдаагүй сүүлийн үеийн байх шаардлагатай бөгөөд эрх бүхий байгууллага нь уг мэдээллийг ашиглан дүн шинжилгээ хийж хөрөнгө тодорхойлох болон илрүүлэх, үйл ажиллагааны шинжилгээг боловсруулах нөөц боломж, чадавхитай байна.

Энэ шууд хэрэгжилтийн үр дүн нь юуны өмнө Зөвлөмж 29-32 болон Зөвлөмж 1, 2, 4, 8, 9 34, 40-ийн заалтад хамааралтай.

Үнэлгээчдэд өгөх зааварчилгаа:

1) Энэхүү шууд хэрэгжилт нь СМА-ны сэжигтэй гүйлгээний тайлан болон бусад мэдээлэлд хийдэг дүн шинжилгээний үйл ажиллагаа мөн эрх бүхий байгууллага нь СМА-ны мэдээлэл, бусад санхүүгийн холбогдох мэдээллийг⁷⁰ ашиглах асуудал багтана.

2) Үнэлгээчид нь уг хэсгийн шууд хэрэгжилтийг үнэлэхдээ олон улсын хамтын ажиллагааны холбогдох үр дүн, эрх бүхий байгууллагын оролцоог харгалзан үзэх хэрэгтэй. Үүнд: СМА болон хууль сахиулах байгууллагууд нь гадаад улс орны хамтрагч байгууллагуудаас санхүүгийн, хууль сахиулахын болон бусад мэдээллийг авч чадаж байгаа мөн мэдээлэл авахыг оролдож байгаа үйл ажиллагааны цар хүрээг харгалзан үзэх шаардлагатай.

Хэрэгжилт хангагдсан эсэхийг тодорхойлох Үндсэн асуудлууд

6.1 Санхүүгийн мэдээлэл болон бусад холбогдох мэдээлэлд үндэслэн мөнгө угаах, холбогдох суурь гэмт хэрэг болон терроризмын санхүүжүүлэхтэй холбоотой гэмт хэргээс олсон орлогыг илрүүлж, мөрдөн шалгах ажиллагаанд эд мөрийн баримт болгон ашиглаж байгаа цар хүрээ ямар байна вэ?

6.2 Эрх бүхий байгууллага нь ажил үүргээ гүйцэтгэхэд дэмжлэг болохуйц алдаагүй мэдээллийг агуулсан тайланг (сэжигтэй гүйлгээний тайлан, мөнгө болон төлбөрийн хэрэгслүүдийн тайлан) хүлээн авч эсвэл хүсэлт гарган авч буй цар хүрээг тодорхойлно уу?

6.3 СМА-ны дүн шинжилгээ болон шилжүүлсэн мэдээлэл нь эрх бүхий холбогдох байгууллагын үйл ажиллагааны хэрэгцээ шаардлагад хэрхэн дэмжлэг үзүүлж байна вэ?

6.4 СМА болон бусад эрх бүхий байгууллагууд нь мэдээлэл солилцох болон санхүүгийн мэдээлэл авах хамтын ажиллагааг хэр сайн хэрэгжүүлж байна вэ? СМА болон эрх бүхий

⁷⁰ Энэхүү мэдээллийн эх үүсвэрт сэжигтэй гүйлгээний тайлан, хил дамнасан мөнгөн тэмдэгт болон төлбөрийн хэрэгслүүд шилжүүлэхтэй холбоотой мэдээлэл/тайлан, хууль сахиулахтай холбоотой мэдээлэл, гэмт хэрэгтнүүдийн бүртгэл, хяналт шалгалт, зохицуулалтын мэдээлэл, компанийн бүртгэлийн мэдээлэл зэрэг орно. Тодорхой нөхцөлд бэлэн мөнгөний гүйлгээний тайлан, гадаад валютын гүйлгээний тайлан, мөнгөн гуйвуулгын гүйлгээний тайлан, гадаад улс орны хөрөнгийн биржийг оролцуулаад төрийн байгууллагын мэдээлэл, татварын байгууллага, үр шим хүртэгчийн талаарх мэдээлэлтэй байгууллага, ашгийн бус байгууллага зохицуулах газрын мэдээлэл, харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагаа, гүйлгээний бүртгэл зэрэг заавал мөрдөх ёстой дүрэм журмаар санхүүгийн байгууллага болон СББМҮҮ нараас олж авч болохуйц мэдээлэл болон олон нийтэд нээлттэй мэдээлэл багтана.

байгууллага нь солилцсон болон ашигласан мэдээллийн нууцлалыг хэрхэн хангаж ажиллаж байна вэ?

а) Үндсэн асуудлуудын талаар дүгнэлт хийхэд тусламж болох мэдээллийн жишээ

1. Хууль сахиулах болон бусад эрх бүхий байгууллагын туршлага (*Жн: санхүүгийн мэдээлэл, бусад боломжтой мэдээллийг мөрдөн шалгах ажиллагааны арга хэрэгсэл болгон ашиглаж байгаа байдал, давтамж*).

2. СМА болон эрх бүхий бусад байгууллага хоорондын хамтын ажиллагаа болон санхүүгийн мэдээлэл ашиглалт (*Санхүүгийн мэдээлэл шилжүүлсэн/солилцсон статистик; мөнгө угаах, холбогдох суурь гэмт хэрэг болон терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэг, хөрөнгө тодорхойлох, илрүүлэх мөрдөн шалгах ажиллагаа, хэрэг шийдвэрлэлтэд санхүүгийн мэдээллийг ашигласан кейсүүд гэх мэт*).

3. Сэжигтэй гүйлгээний тайлангийн мэдээлэл (*Сэжигтэй гүйлгээний тайланд дүн шинжилгээ хийсэн тоо; Сэжигтэй гүйлгээний тайлангийн мэдээллийн чанар; эрх бүхий байгууллагын илрүүлсэн сэжигтэй гүйлгээг мэдээлээгүй зөрчлийн давтамж; мэдээлэл задруулсан тохиолдлууд. Сэжигтэй гүйлгээний тайланг тайлагнах тухай мэдээллийг Зөвлөмж 4-ийн шууд хэрэгжилт хэсгээс тодруулан харна уу*).

4. Санхүүгийн мэдээ мэдээллүүд (*валют төлбөрийн хэрэгслүүдийн тайланг хүлээн авсан болон түүнд дүн шинжилгээ хийсэн тоо; хууль сахиулах болон бусад эрх бүхий байгууллага нь бусад байгууллага, санхүүгийн байгууллага, СББМҮҮ нараас хүлээн авдаг, нэвтрэх эрхтэй байдаг бусад төрлийн мэдээлэл гэх мэт*).

5. Бусад баримт бичиг (*Сэжигтэй гүйлгээний тайлан болон бусад санхүүгийн мөрдөн шалгах ажиллагааны зааварчилгаа, санхүүгийн мэдээллийг ашиглан боловсруулсан типологи*).

б) Үндсэн асуудлуудын талаар дүгнэлт хийхэд дэмжлэг болох тусгай хүчин зүйлсийн жишээ

6. СМА нь сэжигтэй гүйлгээний тайлангийн дүн шинжилгээ, ач холбогдлыг нэмэгдүүлэхдээ нэмэлт мэдээллийг олж авч, ашиглаж байна уу? СМА нь дүн шинжилгээнийхээ нягт нямбай байдлыг хангаж байна уу?

7. Эрх бүхий байгууллага нь сэжигтэй гүйлгээний тайлангийн мэдээлэл болон бусад санхүүгийн мэдээллийг үйл ажиллагааны дүн шинжилгээг хийхдээ хэр сайн ашиглаж байна вэ?

8. СМА нь эрх бүхий байгууллагаас өгсөн эргэх холбоо, болон типологийн мэдээлэл болон үйл ажиллагааны туршлагыг өөрийн үйл ажиллагаанд хэр сайн нэвтрүүлж ажиллаж байна вэ?

9. Санхүүгийн байгууллага болон СББМҮҮ болон бусад мэдээлэх үүрэгтэй этгээдээс эрх бүхий байгууллагад холбогдох мэдээллийг бүрэн гүйцэд цаг тухайд нь мэдээлэх зорилгоор авсан арга хэмжээ байна уу? Мэдээлэлд нэвтрэхтэй холбоотой саад бэрхшээл байна уу?

10. Сэжигтэй гүйлгээний тайлан нь бүрэн гүйцэд, алдаагүй, хангалттай мэдээллийг агуулсан байж чадаж байна уу?

11. Эрх бүхий байгууллагууд нь санхүүгийн мэдээллийг сайжруулахад мэдээлэх үүрэгтэй этгээдийг (СМА-ны хамрах хүрээг оруулаад) хэрхэн хянаж, хамтран ажиллаж байна вэ?

12. Эрх бүхий байгууллагууд нь өөрийн чиг үүргийг хэрэгжүүлэх хангалттай эх үүсвэртэй байна уу (*санхүүгийн мэдээлэл цуглуулах, боловсруулах, мэдээллийн технологийн шийдэл, нууцлалыг хангах арга хэрэгслүүд багтана*)?

ФАТФ-ын зөвлөмжийн техникийн хэрэгжилт болон МУТСТ тогтолцооны үр дүнтэй байдлыг үнэлэх

13. СМА нь МУТС-тэй тэмцэх асуудлаар зүй бус нөлөөлөлд автахгүй өөрийн үйл ажиллагааны бие даасан байдлыг хангаж ажиллаж чадаж байна уу?

Шууд хэрэгжилт 7

Мөнгө угаахтай холбоотой үйлдэл болон гэмт хэрэгт мөрдөн шалгах үйл ажиллагаа явагддаг болон буруутай этгээдүүдэд үр нөлөөтэй, үйлдсэн зөрчилтэй нь дүйцэхүйц, гэмт хэрэг давтан үйлдэхээс сэргийлсэн хариуцлага хүлээлгэдэг байх.

Үр дүнтэй системийн шинж чанар

Мөнгө угаах үйл ажиллагаа ялангуяа хамгийн их ашиг орлого бий болгодог гэмт хэргүүд нь шалгагдаж, гэмт хэрэгтнүүдийг амжилттай яллаж, шүүх нь үр нөлөөтэй, үйлдсэн гэмт хэрэгт нь дүйцэхүйц, гэмт хэрэг давтан үйлдэхээс сэргийлсэн шийтгэлийг гэмт хэрэгтнүүдэд оногдуулдаг байна. Үүнд: гэмт хэрэгт санхүүгийн зэрэгцээ мөрдөн шалгалтыг явуулах (Parallel financial investigation), суурь гэмт хэрэг нь өөр улс оронд үйлдэгдсэн болон мөнгө угаах гэмт хэргийг дангаар нь мөрдөн шалгах, яллах багтана. Тогтолцооны бүрэлдэхүүн хэсгүүд (мөрдөн байцаалт, ялалт, шүүхийн шийдвэр болон шийтгэлийн арга хэмжээ) нь харилцан уялдаатай ажиллаж, мөнгө угаах эрсдэлийг бууруулах шаардлагатай. Улмаар илрүүлэлт, шүүхийн шийдвэр, ял шийтгэл нь гэмт хэрэг үйлдэж болзошгүй хүмүүсийг ашиг олдог гэмт хэрэг үйлдэх, мөнгө угаах гэмт хэрэг үйлдэхээс сэргийлэх болно.

Энэ шууд хэрэгжилт нь Зөвлөмж 3, 30 дугаар болон Зөвлөмж 1, 2, 32, 39, 40-ийн зарим заалтад хамааралтай болно.

Үнэлгээчдэд өгөх зааварчилгаа:

Энэ шууд хэрэгжилтийг үнэлэх явцад эрх бүхий байгууллагын оролцож буй олон улсын хамтын ажиллагааны түвшинд бий болсон холбогдох ололтуудыг харгалзан үзэх шаардлагатай. Үүнд хуулийн этгээд болон эрх зүйн бусад зохицуулалт бүхий этгээдийн мэдээллийг тодорхойлох, солилцох (эцсийн өмчлөгчийн мэдээллийг оролцуулаад) зэрэг асуудлаар эрх бүхий байгууллага нь хил дамнасан мөнгө угаах гэмт хэрэгт зохих дэмжлэг, туслалцааг гадаадын хамтрагч байгууллагаас эрэлхийлэх багтана.

Хэрэгжилт хангагдсан эсэхийг тодорхойлох Үндсэн асуудлууд

7.1 Мөнгө угааж байж болзошгүй хэргийг ямар нөхцөл байдалд, хэр сайн илрүүлж, мөрдөн шалгаж чадаж байна вэ (зэрэгцээ санхүүгийн мөрдөн шалгалтыг оруулаад)?

7.2 Шалгагдаж, яллагдаж байгаа мөнгө угаах үйл ажиллагааны төрлүүд тухайн улсад тулгар байгаа аюул заналхийлэл, эрсдэлийн мэдээлэл, үндэсний МУТС-тэй тэмцэх бодлоготой хэр сайн нийцэж байна вэ?

7.3 Мөнгө угаах гэмт хэргийн олон төрлийн хэлбэрүүдээр гэмт хэрэгтнүүдийг хэр сайн яллаж чадаж байна вэ (Үүнд, гадаадад үйлдсэн суурь гэмт хэргүүд, гуравдагч этгээдээр мөнгө угаах, мөнгө угаах гэмт хэргийг дангаар нь яллах багтана)?

7.4 Мөнгө угаах гэмт хэргээр шийтгэгдсэн хувь хүн болон хуулийн этгээдэд оногдуулсан ял шийтгэл нь үр нөлөөтэй, үйлдсэн гэмт хэрэгтэй нь дүйцэхүйц, гэмт хэрэг давтан үйлдэхээс сэргийлсэн байж чадаж байна уу? Үүний цар хүрээг нь тодорхойлно уу?

7.5 Мөнгө угаах хэргээр мөрдөн шалгах ажиллагаа гүйцэтгэж байгаа хэдий ч тодорхой шалтгааны улмаас мөнгө угаах зүйл ангиар яллах боломжгүй тохиолдолд улс орнууд нь бусад ямар эрүүгийн хариуцлагын арга хэмжээг авч байна вэ? Жич: эдгээр бусад хэлбэрийн арга хэмжээ нь мөнгө угаах гэмт хэргийг яллах, ял шийтгэл оногдуулахын ач холбогдлыг бууруулах эсвэл орлох хувилбар байж болохгүй.

а) Үндсэн асуудлуудын талаар дүгнэлт хийхэд тусламж болох мэдээллийн жишээ

1. Мөрдөн шалгах ажиллагаа, хэрэг хянасан байдал, яллалт, шийтгэл оногдуулсан туршлага болон жишээнүүд (*Хангалттай нотлох баримтгүйн улмаас мөрдөн шалгахгаас татгалзсан хэргүүд; тухайн улс орны мөнгө угаахтай холбоотой мөрдөн шалгасан, ял шийтгэл оногдуулсан төвөгтэй, томоохон хэргүүд; дотоодын болон хил дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийг амжилттай илрүүлсэн тохиолдлууд, мөнгө угаах гэмт хэрэгт мөнгө угаах зүйл ангийн оронд бусад зүйл ангиар ялласан хэргүүд*).

2. Мөнгө угаах хэргийн мөрдөн шалгах ажиллагаа, хэрэг хянасан байдал, яллалт, шийтгэлийн тухай мэдээлэл (*Мөнгө угаахтай холбоотой мөрдөн шалгах ажиллагаа болон ял шийтгэлийн тоо; прокурорт болон шүүхэд шилжүүлсэн хэргийн хувь хэмжээ; гуравдагч этгээдийн мөнгө угаасан хэрэг, бие даасан гэмт хэрэг, өөрийнхөө үйлдсэн гэмт хэргийн ашиг орлогыг угаасан хэрэг болон гадаадад үйлдсэн суурь гэмт хэргийг мөнгө угаах зүйл ангиар ялласан хэргийн тоо болон хувь хэмжээ; мөнгө угаах гэмт хэрэгт оногдуулсан ял шийтгэлийн түвшин; мөнгө угаах зүйл ангиар шийдвэрлэсэн хэрэг болон бусад суурь гэмт хэрэг шийдвэрлэлтийн хувь хэмжээ*).

б) Үндсэн асуудлуудын талаар дүгнэлт хийхэд дэмжлэг болох тусгай хүчин зүйлсийн жишээ

3. Мөнгө угаасан үйлдлийг (дор хаяж бүх томоохон ашиг орлого олох, шунахайн сэдэлтэй гэмт хэрэгтэй холбоотой) тодорхойлох, эхлүүлэх, мөрдөн шалгах ач холбогдлоор нь ангилах (жижиг, том эсвэл төвөгтэй хэргүүд болон дотоодын болон гадаадын гэмт хэрэгт анхаарал хандуулах) ямар арга хэмжээ авдаг вэ?

4. Эрх бүхий байгууллагууд нь мөнгө угаах гэмт хэргийн мөрдөн шалгах үйл ажиллагаанд шаардлагатай санхүүгийн болон бусад мэдээллийг ямар цаг хугацаанд олж авах, нэвтрэх боломжтой байдаг вэ?

5. Их хэмжээний ашиг орлого бий болгодог гэмт хэргийг мөрдөн шалгахдаа ямар хэмжээнд хамтарсан, нэгдсэн баг (олон салбарыг хамарсан мөрдөн байцаалтын нэгж гэх мэт) болон бусад мөрдөн шалгах техник (гэмт хэрэгт холбоотой этгээдийг илрүүлэхийн тулд мөнгө хураах ажиллагааг хойшлуулах, түдгэлзүүлэх) хэрэглэдэг вэ?

6. Цаг хугацаанд нь мөнгө угаах хэргийг шүүх хуралдаанд болон яллах ажиллагаанд хэрхэн бэлтгэдэг вэ?

7. Ямар нөхцөлд мөнгө угаах гэмт хэргийн хөндлөнгийн (indicative) шинж тэмдэг, нотлох баримт байгаа тохиолдолд байцаан шийтгэх ажиллагааг үргэлжлүүлэх шаардлаггүй гэж үздэг вэ?

8. Ямар тохиолдолд мөнгө угаах гэмт хэргийг (i) суурь гэмт хэрэгтэй холбоотой хамтатган (гадаадад үйлдсэн суурь гэмт хэргийг оруулаад) (ii) бие даасан гэмт хэрэг гэж ялладаг вэ?

9. Эрх бүхий байгууллагууд нь эрх зүйн үндсэн зарчмаа баримтлан мөнгө угаах гэмт хэргийг мөрдөн шалгахгаас эхлээд, нотлох баримт цуглуулах, прокурор хянах, шүүхэд шилжүүлэх, шүүн таслах хүртэлх үйл явцад хоорондоо хэрхэн харилцдаг вэ?

10. Мөнгө угаах гэмт хэргийг байцаан шийтгэх, яллах, шүүхээр шийдвэрлэхэд хүндрэл саад учруулдаг мөрдөн шалгах ажиллагаа, байцаан шийтгэх эсвэл шүүхийн үйл явцын хүчин зүйлс байна уу?

11. Эрх бүхий байгууллага нь мөнгө угаахтай холбоотой эрсдэлээ зохистой удирдах, үйл ажиллагаагаа явуулах хангалттай нөөц бололцоотой (санхүүгийн мөрдөн шалгах арга хэрэгслийг оруулаад) байна уу?

12. Мөнгө угаах хэргийг мөрдөн шалгах тусгай нэгж/ажилтнууд байна уу? МУ хэргийг мөрдөн шалгахад тэргүүлэх зэргийн хэргийг хэрхэн тодорхойлдог, эөөц, эх үүсвэрээ хэрхэн хуваарилдаг вэ?

Шууд хэрэгжилт 8

Гэмт хэргээс олсон орлого болон үйлдэхэд ашиглагдсан хэрэгсэл зэргийг хураан авдаг байх.

Үр дүнтэй системийн шинж чанар

Гэмт хэргэгчнүүдээс гэмт хэргийнх нь (дотоод, гадаад) ашиг орлого, үйлдэхэд ашиглагдсан хэрэгсэл эсвэл түүнтэй тэнцэх эд хөрөнгийг хураан авдаг байх (цаг тухайд нь хөрөнгө хураах түр зуурын болон байнгын арга хэмжээ авах). Хөрөнгө хураах үйл ажиллагаанд эрүүгийн, иргэний, захиргааны хэргийн журмаар хөрөнгө хураах, хил дамнасан мэдүүлэгт худал мэдүүлсэн, мэдээлснээс эд хөрөнгийг хураах, хураагдсан хөрөнгийг чөлөөлөх үйл ажиллагаа багтана (шүүхийн журмаар). Тухайн улс орон нь битүүмжилсэн эсвэл хураасан хөрөнгийг удирдан зохицуулж, хураан авсан хөрөнгийг холбогдох оронд буцаан олгох буюу тодорхой хувиар хуваан авдаг. Үүний үр дүнд гэмт хэрэг үйлдэх ашиггүй болж суурь гэмт хэрэг болон мөнгө угаах гэмт хэрэг буурна.

Энэ шууд хэрэгжилтийн нь юуны өмнө Зөвлөмж 1, 4, 32 болон Зөвлөмж 30, 31, 37, 38, 40-ийн зарим заалтад хамааралтай.

Үнэлгээчдэд өгөх зааварчилгаа:

Энэ шууд хэрэгжилтийг үнэлэх явцад эрх бүхий байгууллагын оролцож буй олон улсын хамтын ажиллагааны түвшинд бий болсон холбогдох ололтуудыг харгалзан үзэх шаардлагатай. Үүнд хууль сахиулах болон прокурорын байгууллага нь гэмт хэргийн хил дамнасан ашиг орлого болон үйлдэхэд ашиглагдсан хэрэгсэлтэй холбоотой зохих дэмжлэг, туслалцааг гадаадын хамтрагч байгууллагаас эрэлхийлэх багтана.

Хэрэгжилт хангагдсан эсэхийг тодорхойлох Үндсэн асуудлууд

8.1 Гэмт хэргийн ашиг орлого, үйлдэхэд ашиглагдсан хэрэгсэл болон түүнтэй тэнцэх үнэ цэнэ бүхий эд хөрөнгийг хураахыг бодлогын гол чиглэл болж байна уу?

8.2 Эрх бүхий байгууллага нь гадаад болон дотоодод үйлдэгдсэн суурь гэмт хэрэг болон гадаад улс орон руу шилжүүлсэн ашиг орлогыг оролцуулаад гэмт хэргээс олсон ашиг орлого, үйлдэхэд ашиглагдсан хэрэгсэл, түүнтэй тэнцэх үнэ цэнэ бүхий эд хөрөнгийг хэр үр дүнтэй хураан авч (эх орон руу нь буцаах, хуваах болон хохирлыг барагдуулах орно) байна вэ?

8.3 Хил/гааль болон бусад эрх бүхий байгууллагын мэдээлээгүй/худал мэдүүлсэн, мэдэгдсэн хил дамнасан мөнгөн тэмдэгт болон төлбөрийн хэрэгслүүдийг хураан авах үйл ажиллагаа нь үр нөлөөтэй, үйлдсэн хэрэгтэй нь дүйцэхүйц, давтан үйлдэхээс сэргийлсэн байж чадаж байна уу

8.4 Хөрөнгө хураах үйл ажиллагааны үр дүн нь МУТС эрсдэлийн үнэлгээ, үндэсний МУТС-тэй тэмцэх бодлого, тэргүүлэх зорилтыг хэр сайн тусгаж байна вэ?

а) Үндсэн асуудлуудын талаар дүгнэлт хийхэд тусламж болох мэдээллийн жишээ

1. Хөрөнгө хураах үйл ажиллагааны туршлага болон жишээнүүд (*хамгийн өндөр ач холбогдолтой хэргүүд; тухайн улс орны хөрөнгө хураах шийдвэрийн төрлүүд; гэмт хэргээс олсон ашиг орлогыг угаах арга өөрчлөгдөж буй хандлага, төлөв байдал*).

2. Хөрөнгө хураахтай холбоотой мэдээлэл (*хөрөнгө хураасан эрүүгийн хэргийн тоо; хөрөнгө хураах үйл ажиллагаа хэрэгжүүлсэн гэмт хэргийн төрлүүд; гэмт хэргээс олсон ашиг орлого, үйлдэхэд ашиглагдсан хэрэгсэл, үүнтэй тэнцэх үнэ цэнэ бүхий хөрөнгийн хэмжээ, үнэлгээ, дотоод гадаадын гэмт хэрэг, эрүү эсвэл иргэний журмаар шийдвэрлэсэн тус тус ангилсан*

ФАТФ-ын зөвлөмжийн техникийн хэрэгжилт болон МУТСТ тогтолцооны үр дүнтэй байдлыг үнэлэх

байдал (эрүүгийн ял шийтгэл дээр тулгуурлаагүй хөрөнгө хураалт); худал эсвэл мэдүүлээгүй хил дамнасан мөнгөн тэмдэгт болон төлбөрийн хэрэгслүүдийг хураасан байдал болон түүний үнэлгээ; гэмт хэргээс олсон орлогыг битүүмжилсэн эсвэл царцаасан хөрөнгийн үнэлгээ, хэмжээ, хөрөнгө хураах шийдвэрийн хувь хэмжээ эсвэл үнэлгээ).

3. Бусад холбогдох мэдээлэл (*битүүмжилсэн/царцаасан гэмт хэргийн гаралтай хөрөнгийн хэмжээ; гэмт хэргээс олсон ашиг орлогоор хохирогчийн хохирлыг нөхөн барагдуулсан байдал болон хэмжээ, эсвэл гадаад улс орон руу буцаасан, хуваасан ашиг орлого*).

б) Үндсэн асуудлуудын талаар дүгнэлт хийхэд дэмжлэг болох тусгай хүчин зүйлсийн жишээ

4. Эрх бүхий байгууллагууд нь гэмт хэргээс олсон ашиг орлого болон үйлдэхэд ашиглагдсан хэрэгсэлтэй холбоотой ямар арга хэмжээ, арга барил баримталж (их хэмжээний ашиг орлого олдог гэмт хэрэг, дотоодод үйлдэгдээгүй гадаадын улс орон руу шилжүүлсэн хөрөнгийг оруулаад) байна вэ?

5. Холбогдох удирдлага нь мөрдөн шалгах үйл ажиллагааны эхний шатанд гэмт хэргийн хөрөнгө хураах зорилгоор санхүүгийн мөрдөн шалгах ажиллагааг эхлүүлэх шийдвэрийг хэрхэн гаргадаг вэ?

6. Холбогдох эрх бүхий байгууллага нь гэмт хэргийн ашиг орлого, үйлдэхэд ашиглагдсан хэрэгсэл, үүнтэй тэнцэх үнэ цэнэ бүхий эд хөрөнгийг хэр сайн тодорхойлж, илрүүлдэг вэ? Хөрөнгө алдагдах, үрэгдэхээс сэргийлсэн түр зуурын арга хэмжээ нь хэр сайн нөлөөтэй байна вэ (хөрөнгө царцаах эсвэл битүүмжлэх гэх мэт)?

7. Улс орон нь МУТС-тэй холбоотой болон суурь гэмт хэрэгт хамааралтай гэж сэжиглэж байгаа хил дамнасан мөнгөн тэмдэгт болон төлбөрийн хэрэгслийг худал/алдаатай мэдэгдсэн, мэдээлснийг илрүүлэх, хураан авах ямар арга хэмжээ авч байна вэ?

8. Хураан авсан/битүүмжилсэн хөрөнгийн үнэ цэнийг хадгалах, захиран зарцуулах ямар арга хэмжээ хэрэгжүүлж байна вэ?

9. Гэмт хэргээс олсон ашиг орлого, үйлдэхэд ашиглагдсан хэрэгсэл, үүнтэй тэнцэх үнэ цэнэ бүхий эд хөрөнгийг тодорхойлход дэмжлэг үзүүлж буй болон саад болж буй мөрдөн шалгах, байцаан шийтгэх, шүүхийн үйл ажиллагааны ямар хүчин зүйлс байна вэ?

10. Холбогдох эрх бүхий байгууллага нь зохих үүргээ гүйцэтгэхэд хангалттай нөөц бололцоотой байна уу?

Шууд хэрэгжилт 9

Терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой үйлдэл болон гэмт хэрэгт мөрдөн шалгах үйл ажиллагаа явуулдаг байх, буруутай этгээдүүдэд үр дүнтэй нөлөөлөх, гаргасан зөрчилтэй нь дүйцэхүйц, давтан үйлдэхээс сэргийлсэн хариуцлага хүлээлгэдэг байх.

Үр дүнтэй системийн шинж чанар

Терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаа нь мөрдөн шалгагдаж, гэмт хэрэгтэнг шүүхэд шилжүүлж, шүүх нь хэрэгтнүүдэд үйлдсэн гэмт хэрэгтэй нь дүйцэхүйц, гэмт хэрэг давтан үйлдэхээс сэргийлсэн ял шийтгэлийг оногдуулдаг. Тодорхой нөхцөлд терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийг тусад нь авч үзэн, санхүүгийн мөрдөн шалгах ажиллагаа нь терроризмын эсрэг мөрдөн шалгах ажиллагаанд дэмжлэг болж эрх бүхий байгууллагууд нь хоорондоо үр дүнтэй хамтран ажилладаг. Системийн бүрэлдэхүүн хэсгүүд нь (мөрдөн шалгах, байцаан шийтгэх, яллах, ял шийтгэл оногдуулах) терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг бууруулах зорилтын хүрээнд оновчтой ажилладаг. Улмаар илрүүлэлт, яллах, шийтгэл хүлээлгэх өндөр магадлал нь терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагааг бууруулахад нөлөөлнө.

Энэ шууд хэрэгжилт нь юуны өмнө Зөвлөмж 5, 30, 31, 39 болон Зөвлөмж 1, 2, 32, 37, 40-ийн зарим заалтад хамааралтай.

Үнэлгээчдэд өгөх зааварчилгаа:

1. Энэхүү шууд хэрэгжилтэд үнэлгээ өгөхөд зарим асуудлууд нь тухайн улс орны хувьд нууцын зэрэглэлтэй асуудал бөгөөд үнэлгээчдэд ил болгох боломжгүй материалууд (үндэсний аюулгүй байдлын үүднээс цуглуулсан мэдээлэл гэх мэт) байж болзошгүйг үнэлгээчид анхаарах хэрэгтэй.
2. Үнэлгээчид нь энэхүү богино хугацааны үр дүнг үнэлэхдээ эрх бүхий байгууллага оролцож байгаа олон улсын хамтын ажиллагааны холбогдох үр дүнг авч үзэх хэрэгтэй. Хууль сахиулах болон прокурорын байгууллага нь терроризмыг санхүүжүүлэх хил дамнасан хэргүүдэд гадаадын хамтрагч талуудаас зохих дэмжлэг, туслалцаа эрэлхийлж байгаа түвшинг хамруулна.

Хэрэгжилт хангагдсан эсэхийг тодорхойлох Үндсэн асуудлууд

- 9.1 Терроризмыг санхүүжүүлэх ямар төрлийн үйл ажиллагааг (хөрөнгө цуглуулах, шилжүүлэх, ашиглах гэх мэт) мөрдөн байцааж, гэмт хэрэгтнүүдэд ял оногдуулж байна вэ? Энэ нь улс орны терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн үзүүлэлттэй нийцэж байна уу?
- 9.2 Терроризмыг санхүүжүүлэх хэргүүдийг хэр сайн илрүүлж, мөрдөн шалгаж байна вэ? Терроризмыг санхүүжүүлэгч этгээдийн тодорхой үүрэг оролцоог мөрдөн байцаалтад ямар хэмжээнд тодорхойлж чадаж байна вэ?
- 9.3 Терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийн мөрдөн шалгах ажиллагааг терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үндэсний стратеги, мөрдөн шалгах ажиллагааны тактикт хэрхэн нэвтрүүлж, ашиглаж байна вэ (террорист этгээдүүд, террорист байгууллага болон терроризмыг дэмжигч сүлжээг тодорхойлох, жагсаалтад оруулах гэх мэт)?
- 9.4 Терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэгт ялагдсан иргэн болон хуулийн этгээдэд оногдуулсан ял шийтгэл болон арга хэмжээ нь үр нөлөөтэй, үйлдсэн гэмт хэрэгтэй нь дүйцэхүйц, гэмт хэрэг давтан үйлдэхээс сэргийлсэн байж чадаж байна уу?
- 9.5 Терроризмыг санхүүжүүлэх зүйл ангиар яллах боломжгүй тохиолдолд терроризмыг санхүүжүүлэхийг таслан зогсоох эрүүгийн, захиргааны болон бусад ямар төрлийн эрх зүйн арга хэмжээг авч энэ нь зорилтот үр дүнд хэрхэн хүрч чадаж байна вэ?

а) Үндсэн асуудлуудын талаар дүгнэлт хийхэд тусламж болох мэдээллийн жишээ

1. Терроризмыг санхүүжүүлэх мөрдөн шалгах ажиллагаа болон яллах туршлага, жишээнүүд (*терроризмыг санхүүжүүлэх мөрдөн байцаалт нь терроризмын эсрэг мөрдөн шалгах ажиллагаа болон яллах ажиллагаанд дэмжлэг үзүүлсэн тохиолдол; дотоод, гадаадын террористууд болон террорист бүлэглэлийг анхааралдаа авч, яллаж шийтгэсэн эсвэл таслан зогсоосон томоохон хэргүүд; терроризмыг санхүүжүүлэх түвшин, арга барилд ажиглагдсан чиг хандлага; гэмт хэргийн бусад ялалт эсвэл арга хэмжээг терроризмыг санхүүжүүлэх ял шийтгэлийн оронд ашигласан байдал*).

2. Терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийг мөрдөн шалгах, байцаан шийтгэх, яллах болон шүүхээр шийдвэрлэсэн үйл ажиллагааны мэдээлэл (*терроризмыг санхүүжүүлэх мөрдөн шалгах, байцаан шийтгэх ажиллагааны тоо; терроризмыг санхүүжүүлэх зүйл ангиар прокурорт шилжүүлж буй хэргийн хувь харьцаа, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийг байцаан шийтгэх ажиллагаа болон оногдуулсан ял шийтгэлийн төрлүүд (салангид гэмт хэрэг, гадаад, дотоодын террорист этгээдүүд); терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэгт оногдуулсан ял шийтгэлийн түвшин; бусад гэмт хэрэгтэй терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэгт оногдуулж буй ял шийтгэлийг харьцуулсан байдал; таслан зогсоох арга хэмжээний төрөл ба түвшин*).

б) Үндсэн асуудлуудын талаар дүгнэлт хийхэд дэмжлэг болох тусгай хүчин зүйлсийн жишээ

3. Терроризмыг санхүүжүүлэх хэргийг цаг алдалгүй мөрдөн шалгах, томоохон аюул заналхийллийг таслан зогсоох зорилгоор уг хэргүүдийг илрүүлэх, мөрдөн шалгах, ач холбогдлоор нь ангилахтай холбоотой ямар арга хэмжээг авч байна вэ?

4. Эрх бүхий байгууллага нь терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийг мөрдөн шалгах, яллах шаардлагатай санхүүгийн болон бусад мэдээллийг хэр хурдан олж авах болон нэвтрэх боломжтой байдаг вэ?

5. Терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэгт яллах үйл ажиллагааг үргэлжлүүлэхгүй байх шийдвэрийг гаргахад харгалзан үздэг үндсэн асуудлууд нь юу вэ?

6. Эрх бүхий байгууллагууд нь терроризмыг санхүүжүүлэх тодорхой аюул заналхийлэл, чиг хандлагын эсрэг тусгай үйл ажиллагааны төлөвлөгөө эсвэл стратегийг ямар хэмжээнд хэрэгжүүлдэг вэ? Энэ нь үндэсний МУТС-тэй тэмцэх бодлого, стратеги болон эрсдэлтэй хэрхэн нийцдэг вэ?

7. Хууль сахиулах байгууллага, СМА, терроризмтэй тэмцэх нэгж болон бусад аюулгүй байдал болон тагнуулын асуудал хариуцсан байгууллагууд нь энэ шууд хэрэгжилтийн үр дүнд хүрэх зорилгоор хэрхэн хамтарч, уялдаа холбоотой ажилладаг вэ?

8. Терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийг мөрдөн байцаах, яллах, шүүхээр шийдвэрлэхэд саад болдог мөрдөн шалгах, яллах, шүүх үйл ажиллагаатай холбоотой саад, бэрхшээл учирч байна уу?

9. Эрх бүхий байгууллага нь үйл ажиллагааг гүйцэтгэх буюу зохих ёсоор терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг бууруулахад хангалттай нөөц бололцоотой байна уу?

10. Терроризмыг санхүүжүүлэх асуудлаар тусгайлан ажилладаг мөрдөн шалгах ажилтан/нэгж байгаа юу? Нөөц бололцоог хуваалцаж буй тохиолдолд терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийг хэрхэн ач холбогдлоор нь ангилдаг вэ?

Шууд хэрэгжилт 10

Террорист, террорист байгууллага болон терроризмыг санхүүжүүлэгч нарыг хөрөнгө мөнгө цуглуулах, шилжүүлэх, ашиглахаас урьдчилан сэргийлэх, хууль бус үйл ажиллагаанд ТББ-ыг урвуулан ашиглах боломжгүй болгох.

Үр дүнтэй системийн шинж чанар

Террорист, террорист байгууллага болон терроризмыг дэмжигч сүлжээнүүдийг илрүүлж, террорист үйл ажиллагааны нөөц, санхүүгийн эх үүсвэр, арга хэрэгсэл, дэмжлэг болох зүйлсийг тэднээс салгаж авдаг байна. Үүнд НҮБ-ын Аюулгүйн Зөвлөл болон холбогдох үндэсний болон бүс нутгийн хориг арга хэмжээний журмаар тодорхойлсон этгээд болон аж ахуйн нэгжид санхүүгийн хориг арга хэмжээг зохистой хэрэгжүүлэх багтана. Түүнчлэн улс орнууд нь терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн талаар зохих ойлголттой байж эрсдэлийг бууруулах зорилгоор холбогдох, тохирох арга хэмжээг авна. Үүнд мөн террористуудын хөрөнгө босгох, шилжүүлэх зорилгоор урвуулан ашиглаж болзошгүй аж ахуйн нэгж болон арга хэрэгслийг хамгаалах урьдчилан сэргийлэх асуудал орно. Улмаар энэ нь терроризмын санхүүжилтийн урсгалыг бууруулж, террорист үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх юм.

Энэ шууд хэргжилт нь юуны өмнө Зөвлөмж 1, 4, 6, 8 дугаар болон Зөвлөмж 14, 16, 30, 32, 37, 38, 40-ийн зарим заалтад хамаарна.

Үнэлгээчдэд өгөх зааварчилгаа

Энэхүү богино хугацааны үр дүнг үнэлэх явцад олон улсын хамтын ажиллагааны түвшинд эрх бүхий байгууллагын оролцох явцад бий болсон холбогдох ололтуудыг харгалзан үзэх ёстой.

Хэрэгжилт хангагдсан эсэхийг тодорхойлох Үндсэн асуудлууд

10.1 Улс орон нь санхүүгийн хориг арга хэмжээг хэр сайн хэрэгжүүлж байна вэ? Үүнд (i) НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн 1267 тогтоол болон холбогдох бусад тогтоолууд (ii) НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн 1373 тогтоол (Үндэсний эсвэл бүс нутгийн түвшинд тухайн улсын өөрийн санаачилгаар эсвэл судалгаа шинжилгээ хийсний дараа бусад улсын хүсэлтээр хэрэгжүүлэх)

10.2 Тухайн улс нь террористуудад урвуулан ашиглуулах эрсдэлтэй ТББ-д чиглэсэн, олон нийтэд хандсан сурталчилгаа болон хяналтын арга хэмжээг ТББ-ын хууль ёсны үйл ажиллагааг тасалдуулахгүйгээр хэрхэн явуулж байна вэ ?

10.3 Террорист, террорист байгууллага болон терроризмыг санхүүжүүлэгчдийн ТС үйл ажиллагаатай холбоотой хөрөнгө болон арга хэрэгслийг хураан авч чадаж байна уу? (эрүүгийн, иргэний болон захиргааны журмаар)?

10.4 Дээрх арга хэмжээ нь терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн ерөнхий үзүүлэлттэй хэр нийцэж байна вэ?

а) Үндсэн асуудлуудын талаар дүгнэлт хийхэд тусламж болох мэдээллийн жишээ

1. Хууль сахиулах байгууллага, СМА болон терроризмтэй тэмцэх байгууллагын туршлага (*терроризмыг санхүүжүүлэгч нь хөрөнгө босгох, хөрөнгө шилжүүлэх өөр арга барил судалж байгааг илэрхийлсэн чиг хандлага; террорист байгууллага нь тухайн оронд хөрөнгө босгоход хүндрэл учирч буйг нотлох тагнуулын/бусад эх сурвалжийн мэдээ мэдээлэл гэх мэт*).

2. Таслан зогсоосон арга хэмжээ болон хөрөнгө хураасан байдлын жишээ (*террорист, террорист байгууллагууд болон терроризмыг санхүүжүүлэгчийг хөрөнгө босгох, шилжүүлэх, ашиглахаас урьдчилан сэргийлсэн, хөрөнгийг битүүмжилсэн/хураасан томоохон жишээнүүд*;

ТББ-ыг террористууд урвуулан ашигласныг мөрдөн шалгасан, таслан зогсоосон байдал гэх мэт).

3. Санхүүгийн тодорхой хориг арга хэмжээний мэдээлэл (НҮБ-ын Аюулгүйн Зөвлөл эсвэл бусад эрх бүхий этгээдийн шийдвэрийн дагуу санхүүгийн хориг арга хэмжээнд орсон этгээд болон данс; хоригийн жагсаалтад оруулсан байдал (НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн 1373 тогтоолын дагуу); битүүмжилсэн хөрөнгө, цуцалсан гүйлгээ; хувь хүмүүсийг жагсаалтад оруулахад зарцуулсан хугацаа; жагсаалтад оруулсны дараа хөрөнгө царцаах арга хэмжээг хэрэгжүүлсэн хугацаа гэх мэт).

4. ТББ-ын хяналт болон мониторингийн мэдээлэл (ТББ-ын салбарт мониторинг, үнэлгээ хийж буй давтамж (эрсдэлийн үнэлгээ ороод); терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлийн үйл ажиллагаа, типологитой холбоотой үйл ажиллагаанд ТББ-ын салбарыг хамруулсан болон хурч ажилласан давтамж (заавар, журам багтана); ТББ-д авсан засаж, залруулах болон шийтгэврийн арга хэмжээ гэх мэт).

б) Үндсэн асуудлуудын талаар дүгнэлт хийхэд дэмжлэг болох тусгай хүчин зүйлсийн жишээ

5. Санхүүгийн зорилтот хориг арга хэмжээг хойшлуулалгүй хэрэгжүүлэх үйл ажиллагааг тухайн улс орон хэрхэн хангаж ажилласан бэ? Жагсаалтад оруулсан мэдээллийг санхүүгийн байгууллага, СББМҮҮ нарт болон олон нийтэд цаг тухайд нь хэрхэн мэдээлдэг вэ?

6. Хэрэгжилтийн явц болон механизм нь хэр сайн хэрэгжиж байна вэ? Үүнд (i) хоригийн жагсаалтад оруулах этгээдийг тодорхойлох (ii) битүүмжлэх/битүүмжлэлээс чөлөөлөх (iii) жагсаалтаас гаргах/хасах (iv) хөнгөлөлт эдлүүлэх орно. Үүнтэй холбоотой мэдээллийг хэр сайн цуглуулж байна вэ?

7. Террористуудын санхүүгийн гүйлгээг царцааж, урьдчилан сэргийлэхэд тухайн улс нь НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн тогтоол 1267 болон 1373-ын дагуу олгосон арга хэрэгслийг хэр хэмжээнд ашиглаж чадаж байна вэ?

8. Хоригийн жагсаалтад орсон этгээдийн хөрөнгийг зөвшөөрсөн арга хэмжээнд ашиглахыг батлах болон тусгай зөвшөөрөл олгох тогтолцоо нь НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн холбогдох тогтоолын (НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн 1452 тогтоол гэх мэт) тавигддаг шаардлагыг хэр сайн хангаж байна вэ?

9. Холбогдох эрх бүхий байгууллага нь террористуудын хөрөнгийг хэрхэн анхааралдаа авч ажиллаж байна вэ? Хөрөнгө илрүүлэх болон санхүүгийн мөрдөн шалгах ажиллагаа, түр зуурын арга хэмжээ (царцаах, битүүмжлэх гэх мэт) нь дээрх үйл ажиллагаанд хэрхэн ашиглагдаж байна вэ?

10. ТББ-ын бүртгэл, тусгай зөвшөөрөл олгох түвшин ямар байна вэ? Террористуудад урвуулан ашиглуулж болзошгүй ТББ-ыг хянан шалгах, мониторинг хийх эрсдэлд суурилсан арга хэмжээг хэр сайн хэрэгжүүлж байна вэ? Мөн зохих урьдчилан сэргийлэх, мөрдөн шалгах, эрүүгийн, иргэний болон захиргааны арга хэмжээ, хамтын ажиллагааны механизмыг хэр сайн хэрэгжүүлж байна вэ?

11. ТББ нь эрсдэлээ ойлгож, террористуудын аюул заналхийллээс өөрийгөө хамгаалах арга хэмжээнд хэр сайн нийцэж ажиллаж байна вэ?

12. Террорист, террорист байгууллага болон терроризмыг санхүүжүүлэгчтэй холбоотой хөрөнгө тодорхойлох, илрүүлэх, хураан авах явцад хүндрэл учруулдаг эсвэл дэмждэг болдог мөрдөн шалгах, байцаан шийтгэх, шүүх үйл ажиллагааны ямар хүчин зүйлс байна вэ?

ФАТФ-ын зөвлөмжийн техникийн хэрэгжилт болон МУТСТ тогтолцооны үр дүнтэй байдлыг үнэлэх

13. Холбогдох эрх бүхий байгууллага нь зохих ёсоор ажлаа гүйцэтгэх эсвэл терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг бууруулахад хангалттай нөөц бололцоотой юу?

14. Нөөц бололцоог хуваалцаж буй тохиолдолд терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийг хэрхэн ач холбогдлоор нь ангилдаг вэ?

Шууд хэрэгжилт 11

НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн тогтоолд заасны дагуу үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх үйл ажиллагаатай холбоотой хувь хүн, этгээдүүдийг хөрөнгө цуглуулах, шилжүүлэх, ашиглахаас урьдчилан сэргийлэх.

Үр дүнтэй системийн шинж чанар

НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн хориг арга хэмжээний тогтоолд заасан үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх үйл ажиллагаатай холбоотой хувь хүн, этгээдүүдийг илрүүлдэг, нөөц эх үүсвэрээс нь салгадаг, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх үйл ажиллагааг санхүүжүүлэх мөнгө болон бусад хөрөнгө босгох, шилжүүлэх, ашиглахаас урьдчилан сэргийлдэг байна. Зорилтот санхүүгийн хориг арга хэмжээг цаг алдалгүй хэрэгжүүлж; хориг арга хэмжээг хэрэгжүүлэхгүй байхаас урьдчилан сэргийлэх хэрэгжилтийн хяналт тогтоож, үй олноор хөнөөх зэвсгийг дэлгэрүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаа, бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх зорилгоор холбогдох байгууллагуудын хооронд зохистой хамтын ажиллагаа, уялдаа холбоотой байна.

Энэ шууд хэрэгжилт нь Зөвлөмж 7 дугаар болон Зөвлөмж 2-ын зарим заалтад хамааралтай болно.

Хэрэгжилт хангагдсан эсэхийг тодорхойлох Үндсэн асуудлууд

11.1 НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх үйл ажиллагааг санхүүжүүлэхтэй холбоотой санхүүгийн хориг арга хэмжээг тухайн улс орон нь цаг тухайд нь хэр сайн хэрэгжүүлж байна вэ?

11.2 Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх үйл ажиллагаатай холбоотой хувь хүн, хуулийн этгээдийн (бусдын нэрийн өмнөөс болон бусад этгээдийн зааврын дагуу гүйцэтгэгч орно) мөнгө болон бусад хөрөнгийг ямар хэмжээнд илрүүлж, санхүүгийн гүйлгээ хийхээс хэрхэн урьдчилан сэргийлдэг вэ?

11.3 Санхүүгийн байгууллагууд болон СББМҮҮ нар нь үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх үйл ажиллагааг санхүүжүүлэхтэй холбоотой зорилтот санхүүгийн хориг арга хэмжээг хэрэгжүүлэх үүрэг хариуцлагаа хэрхэн мөрдөж, мэдээлэлтэй ажиллаж байна вэ?

11.4 Холбогдох эрх бүхий байгууллага нь санхүүгийн байгууллага болон СББМҮҮ нарыг үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх үйл ажиллагааг санхүүжүүлэхтэй холбоотой санхүүгийн хориг арга хэмжээг дагаж мөрдөж буйг хэрхэн хянаж, баталгаажуулж байна вэ?

а) Үндсэн асуудлуудын талаар дүгнэлт хийхэд тусламж болох мэдээллийн жишээ

1. Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх үйл ажиллагааг санхүүжүүлэхтэй холбоотой мөрдөн шалгах ажиллагаа, арга хэмжээний жишээ (*хориг арга хэмжээ зөрчсөнийг мөрдөн шалгасан байдал; албадлагын арга хэмжээ (царцаах эсвэл битүүмжилсэн) авсан эсвэл туслалцаа үзүүлсэн чухал жишээнүүд гэх мэт*).

2. Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх үйл ажиллагааг санхүүжүүлэхтэй холбоотой санхүүгийн хориг арга хэмжээний мэдээллийн тухай (*санхүүгийн хориг арга хэмжээ авсан хувь хүн, аж ахуйн нэгжийн данс; битүүмжилсэн хөрөнгө болон үл хөдлөх хөрөнгийн өртөг; иргэн, аж ахуйн нэгжийг хоригийн жагсаалтад оруулахад зарцуулсан хугацаа; НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн тогтоолын дагуу жагсаалтад оруулсан хувь хүн болон аж ахуйн нэгжийн хөрөнгө, үл хөдлөх хөрөнгийг царцаахад зарцуулсан хугацаа гэх мэт*).

3. Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх үйл ажиллагааг санхүүжүүлэхтэй холбоотой хяналт болон бусад холбогдох мэдээлэл (*санхүүгийн байгууллага болон СББМҮҮ нар нь санхүүгийн хориг арга хэмжээг хэрэгжүүлж байгаа эсэхийг хянах хяналт шалгалтыг хийж буй давтамж; оролцоог дэмжих болон олон нийтийг хамруулах үйл ажиллагааны давтамж; зааварчилгааны баримт бичиг; хориг арга хэмжээтэй холбоотой зөрчил гаргасан санхүүгийн байгууллага, СББМҮҮ нарт оногдуулсан шийтгэлийн түвшин*).

б) Үндсэн асуудлуудын талаар дүгнэлт хийхэд дэмжлэг болох тусгай хүчин зүйлсийн жишээ

4. Тухайн улс орон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх үйл ажиллагааг санхүүжүүлэхтэй холбоотой санхүүгийн хориг арга хэмжээний хэрэгжилтийг хэрхэн хангаж байна вэ? Жагсаалтад оруулах болон хүлээх үүргийг холбогдох салбарт нь цаг алдалгүй хэрхэн мэдээлж байна вэ?

5. Доорх холбогдох үйл явцыг хэр сайн хэрэгжүүлж байна вэ? Үүнд, (i) жагсаалтад оруулах (ii) царцаах/цуцлах, (iii) жагсаалтаас хасах (iv) хөнгөлөлт эдлүүлэх орно. Эдгээр нь НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн тогтоолын шаардлагыг хэр хэмжээнд хангаж байна вэ?

6. Царцаасан хөрөнгийг зохицуулах хувь хүн эсвэл хуулийн этгээдэд тодорхой зорилгын дагуу уг хөрөнгийг ашиглах зөвшөөрөл олгох тогтолцоо болон механизм нь хүний эрхийг дээдэлж царцаасан хөрөнгийг зүй бусаар ашиглахаас хэр сайн урьдчилан сэргийлж чадаж байна вэ?

7. Хориг арга хэмжээнээс зайлсхийхээс урьдчилан сэргийлэх ямар механизм байна вэ? Холбогдох эрх бүхий байгууллага нь санхүүгийн байгууллага, СББМҮҮ нарт зааварчилгаа өгч, тодорхой эргэх холбоогоор хангаж байна уу?

8. Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх үйл ажиллагааг санхүүжүүлэхтэй холбоотой НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн тогтоолтой холбоотой гэмт хэрэг, зөрчлийг мөрдөн шалгах үед холбогдох эрх бүхий байгууллага нь хуулийн этгээдийн (халхавч компани гэх мэт) ерөнхий болон эцсийн өмчлөгчийн талаар үнэн зөв мэдээллийг ямар хэмжээнд олж авах боломжтой байдаг вэ?

9. Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх асуудлаар НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн тогтоолтой холбогдох зорилтот санхүүгийн хориг арга хэмжээг зөрчсөн тухай тагнуулын болон бусад мэдээллийг эрх бүхий байгууллагууд нь хэрхэн солилцдог вэ?

10. Холбогдох эрх бүхий байгууллага нь ажлаа гүйцэтгэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх үйл ажиллагааг санхүүжүүлэх эрсдэлтэй тэмцэхэд хангалттай нөөц бололцоотой байна уу?

ХАВСРАЛТ 1:

УЛС ҮНДЭСТНЭЭС ГАДУУР ҮНЭЛЭХ

Хавсралт эцсийн байдлаар батлагдаагүй

ХАВСРАЛТ 2:**ХАМТЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАНГИЙН ЗАГВАР****Үнэлгээчдэд өгөх зааварчилгаа**

Энэ загварыг ФАТФ-ын 2013 оны аргачлалын дагуу үнэлгээг хийх, Хамтын үнэлгээний тайлан (ХҮТ)-г бэлтгэхэд ашиглана. Энэхүү загвар нь ХҮТ-гийн бүтэц, энэ хэсэгт оруулах ёстой мэдээлэл болон дүгнэлтүүдийг тодорхойлно.

Энэхүү загвар нь ХҮТ-д ямар мэдээлэл оруулах, ХҮТ-г хэрхэн бичих, шинжилгээ болон дүгнэлтүүдийг хэрхэн танилцуулахтай холбоотой үнэлгээчдэд зориулсан зааварчилгааг агуулна. Зөвлөмжүүдийг Calibri фонтоор бичиж, сүүдэрлүүлсэн байгаа. Зааварчилгаа нь ХҮТ-гийн эцсийн хувилбарт тусгагдахгүй.

Сүүдэрлүүлээгүй бичвэр (Бүлэг, хэсгүүдийн гарчиг болон бэлтгэсэн тэмдэглэл)-ийг тайлангийн эцсийн хувилбарт (дөрвөлжин хашилтад) оруулна.

Үнэлгээчид нь ХҮТ-гийн эцсийн хувилбар 100-аас доош хуудастай байх ёстой гэдгийг анхаарна уу (техникийн хавсралтын хамт 60-аас доош хуудастай). Бүлгүүдийн хэмжээний хувьд урьдчилан тогтоосон хязгаарлалт байхгүй бөгөөд үнэлгээчид тухайн улсын нөхцөл байдлаас хамаарч тодорхой асуудалд их эсвэл бага анхаарал хандуулж болно. Гэвч үнэлгээчид нь ХҮТ-г хэтэрхий олон хуудастай болгохгүй байх тал дээр анхаарлаа хандуулах ёстой бөгөөд шаардлагатай тохиолдолд дүн шинжилгээг засахад бэлэн байх хэрэгтэй. Эцсийн тайлангийн тэнцвэрийг алдагдуулахгүй байх үүднээс үнэлгээчид нь Зөвлөмж тус бүрийн техникийн хэрэгжилтийг нэг хуудасны талаас хэтрүүлэлгүй 1-2 бүлэг болгон дүгнэлт гаргахыг зорино. Тайлагнах мэдээлэл багатай эсвэл огт мэдээлэлгүй асуудлуудын тухай маш товч бичиж болно. (“биелүүлсэн” гэсэн зэрэглэлтэй Зөвлөмжүүдийн хувьд техникийн хэрэгжилтийг тайлбарласан нэг өгүүлбэр бичихэд хангалттай).

Товч дүгнэлт нь Хамтын үнэлгээ тус бүрийн хурлын хэлэлцүүлэгт ашиглахад болон үнэлүүлж буй улсын сайд, хууль тогтоогч, бодлого боловсруулагч нарт тодорхой дүгнэлт болон зөвлөмжөөр хангахад зориулагддаг. Тиймээс дүгнэлт нь 5 хуудаснаас хэтрэхгүй хэмжээтэй байх бөгөөд үнэлгээчид нь асуудлуудыг сонгох болон танилцуулахдаа энэ хэсэгт дурдсан зааварчилгааг дагах нь чухал. Шаардлагатай үед, тухайлбал үнэлгээ нь ФАТФ-ын Зөвлөмжүүдийг хэрхэн тайлбарлахтай холбоотой ерөнхий асуултад хариулт өгөх тохиолдолд хурлын хэлэлцүүлгийн асуултанд ашиглагдах тусдаа бичиг баримтыг бэлтгэсэн байх шаардлагатай ч үүнийг танилцуулсан товч дүгнэлтийн нэг хэсэг гэж үзэхгүй. Бүлэг 2-т тусгагдсан үнэлгээчдэд өгөх зааварчилгаа нь Зөвлөмж тус бүрийн техникийн хэрэгжилт болон хэрэгжилт тус бүрийн үр дүнтэй байдлын шинжилгээг танилцуулах, бүлэг тус бүрийн дүгнэлтийг тайлбарлахад зориулагдсан.

Агуулга

ТОВЧ ДҮГНЭЛТ	118
А. Эрсдэл болон ерөнхий нөхцөл байдал	118
В. Гол анхаарах зүйлс	118
С. Нэн түрүүнд хэрэгжүүлэх арга хэмжээ	119
ФАТФ-ын Зөвлөмжүүдийн хэрэгжилтийн хүснэгт	120
Шууд хэрэгжилтийн үр дүнтэй байдлын хүснэгт	122
[УЛС]-ЫН ХАМТЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН	123
Өмнөх үг	123
1. МӨНГӨ УГААХ БОЛОН ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭРСДЭЛ БОЛОН ОРЧИН НӨХЦӨЛ	124
1.1 Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлүүд.....	124
1.2. Бодит байдал.....	124
1.3 Бүрэлдэхүүн хэсгүүд.....	124
1.4 Ерөнхий нөхцөл байдалд нөлөөлөх хүчин зүйлс.....	125
1.5 Өндөр эрсдэл бүхий асуудлуудыг тодорхойлох	125
2. ҮНДЭСНИЙ МӨНГӨ УГААХ БОЛОН ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ БОДЛОГО БОЛОН УЯЛДАА ХОЛБОО	125
2.1 Ерөнхий мэдээлэл болон орчин нөхцөл.....	125
2.2 <i>Техникийн хэрэгжилт (3.1, 3.2, 3.33)</i>	126
2.3 <i>Үр дүнтэй байдал: Шууд хэрэгжилт 1 (Эрсдэл, бодлого болон уялдаа холбоо)</i>	126
2.4. <i>Холбогдох үндэсний мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх бодлого болон уялдаа холбооны зөвлөмжүүд</i>	127
3. ХУУЛЬ ЗҮЙН ТОГТОЛЦОО БОЛОН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АСУУДЛУУД.....	127
3.1 <i>Ерөнхий мэдээлэл болон орчин нөхцөл</i>	127
3.2 <i>Техникийн хэрэгжилт (3.3, 3.4, 3.29-32)</i>	128
3.3 <i>Үр дүнтэй байдал: Шууд хэрэгжилт 6 (Санхүүгийн тагнуул)</i>	128
3.4 <i>Үр дүнтэй байдал: Шууд хэрэгжилт 7 (Мөнгө угаах гэмт хэргийг мөрдөн шалгах болон яллах)</i>	128
3.5 <i>Үр дүнтэй байдал: Шууд хэрэгжилт 8 (Хураан авах)</i>	128
3.6 <i>Хууль, эрх зүйн тогтолцоо болон үйл ажиллагааны асуудлуудтай холбоотой зөвлөмжүүд</i>	128
4. ТЕРРОРИЗМ БОЛОН ҮЙ ОЛНООР ХӨНӨӨХ ЗЭВСГИЙН ДЭЛГЭРҮҮЛЭХИЙГ САНХҮҮЖҮҮЛЭХ.....	128
4.1 <i>Ерөнхий мэдээлэл болон орчин нөхцөл</i>	129
4.2 <i>Техникийн хэрэгжилт (3.5-8)</i>	129
4.3 <i>Үр дүнтэй байдал: Шууд хэрэгжилт 9 (Терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийг мөрдөн шалгах болон яллах)</i>	129
4.4 <i>Үр дүнтэй байдал: Шууд хэрэгжилт 10 (Терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх болон санхүүгийн хориг арга хэмжээ)</i>	129
4.5 <i>Үр дүнтэй байдал: Шууд хэрэгжилт 11 (Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй холбоотой санхүүгийн хориг арга хэмжээ)</i>	129
4.6 <i>Терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй холбоотой зөвлөмжүүд</i>	129
5. УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭ.....	130
5.1 <i>Ерөнхий мэдээлэл болон орчин нөхцөл</i>	130
5.2 <i>Техникийн хэрэгжилт (R.9-23)</i>	130
5.3 <i>Үр дүнтэй байдал: Шууд хэрэгжилт 4 (Урьдчилан сэргийлэх арга хэмжээ)</i>	131
5.4 <i>Урьдчилан сэргийлэх арга хэмжээтэй холбоотой зөвлөмжүүд</i>	131
6. ХЯНАЛТ ШАЛГАЛТ	131
6.1 <i>Ерөнхий мэдээлэл болон орчин нөхцөл</i>	131
6.2 <i>Техникийн хэрэгжилт (3.26-28, 3.34, 3.35)</i>	131

6.3 Үр дүнтэй байдал: Шууд хэрэгжилт 3 (Хяналт шалгалт)	132
6.4 Хяналт шалгалттай холбоотой зөвлөмжүүд	132
7. ХУУЛИЙН ЭТГЭЭД БОЛОН БУСАД ЭТГЭЭДҮҮД	132
7.2 Техникийн хэрэгжилт (3.24, 3.25)	132
7.3 Үр дүнтэй байдал: Шууд хэрэгжилт 5 (Хуулийн этгээд болон этгээдүүд)	132
7.4 Хуулийн этгээд болон бусад этгээдүүдтэй холбоотой зөвлөмжүүд	132
8. ОЛОН УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА	132
8.1 Е Ерөнхий мэдээлэл болон орчин нөхцөл	133
8.2 Техникийн хэрэгжилт (3.36-40)	133
8.3 Үр дүнтэй байдал: Шууд хэрэгжилт 2 (Олон улсын хамтын ажиллагаа)	133
8.4 Олон улсын хамтын ажиллагаатай холбоотой зөвлөмжүүд	133

ТОВЧ ДҮГНЭЛТ

Энэхүү тайлан нь [үнэлэгдэж буй улсын нэр]-ын [огноо]-нд газар дээрх шалгалтын үед хэрэгжиж буй мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх арга хэмжээнүүдийн дүгнэлт бөгөөд тухайн [улс]-ын ФАТФ-ын 40 Зөвлөмжүүдийг хэрэгжүүлсэн байдал болон мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцооны үр дүнтэй байдлын түвшинг үнэлж тогтолцоог хэрхэн сайжруулах талаарх зөвлөмжүүдийг агуулна.

А. Эрсдэл болон ерөнхий нөхцөл байдал

Энэ хэсэг нь тухайн улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлтэй байдал болон орчин нөхцлийн товч дүгнэлт (1-2 бүлэг дүгнэлт)-ийг агуулах бөгөөд тухайн улсын дотоод болон олон улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлүүдэд хандах хандлага, хамгийн их эрсдэлтэй асуудлууд болон салбаруудыг авч үзнэ. Үнэлгээчид нь тухайн улсын өөрийн эрсдэлийн үнэлгээгээр тодорхойлоогүй бодит эрсдэлүүд болон өөрсдийн эрсдэлийн түвшинг ялгаатай гэж үзэж байгаа хэсгийг тэмдэглэх ёстой.

В. Гол анхаарах зүйлс

Хэрэгжилт болон үр дүнтэй байдлын ерөнхий түвшин

Үнэлгээчид нь хэрэгжилт болон үр дүнтэй байдлын түвшинд үндэслэн тухайн улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх нөхцөл байдлын талаар маш товч ойлголтыг өгөх ёстой.

Үнэлгээчид нь ФАТФ-ын Зөвлөмжийн техникийн хэрэгжилтийн ерөнхий түвшинг товч дүгнэж тодорхой давуу болон сул тал бүхий хэсгүүдийг тэмдэглэх ёстой. Мөн үнэлгээчид нь хамгийн сүүлийн Хамтын үнэлгээнээс хойш гарсан өөрчлөлт, ахиц дэвшил болон өмнөх үнэлгээгээр өгсөн биелэгдээгүй үйл ажиллагааг цохон тэмлэглэх ёстой.

Үнэлгээчид нь мөн тухайн улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцооны үр дүнтэй байдлын ерөнхий түвшинг товч дүгнэх ёстой. Үүнд тухайн улсын үр дүнтэй байдлын ерөнхий түвшний тайлбарыг оруулах бөгөөд (тодорхой чиг хандлага ажиглагдаж байвал) томоохон сэдвүүдийн хувьд үр дүнтэй байдлын түвшинг дурдаж болно.

В.1 [Асуудлын нэр– жн: Яллах үйл ажиллагааны үр дүнтэй байдал]

Гол анхаарах зүйлст үнэлгээчдийн илрүүлсэн гол асуудлуудыг оруулна. Үүнд: тухайн улсын өндөр эрсдэлтэй, орчин нөхцлийн болон бусад асуудлууд; тухайн улсын сайн хэрэгжүүлж байгаа хэсгүүд, онцлог, шинэ механизм хэрэгжүүлж байгаа эсэх; үр дүнтэй байдлыг хэрэгжүүлэхэд гарч буй дутагдал (холбогдох техникийн сул талуудыг хамруулна) болон техникийн хэрэгжилтийг хангаагүй чухал хэсгүүд зэрэг орно. Тодорхой Зөвлөмжүүд болон хэрэгжилттэй шууд хамааралгүй, энэ хэсэгт дурдагдаагүй асуудлууд боловч мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцооны төлөвт нөлөөлөхүйц нийтлэг, тогтолцооны хүчин зүйлсүүд байх боломжтой.

Үр дүн болон асуудлын тоо нь улс бүрийн хувьд ялгаатай байдаг боловч ерөнхийдөө товч дүгнэлтэд 5-7 чухал асуудлуудыг хөндсөн байх хэрэгтэй. Үнэлгээчид нь асуудал тус бүрийн хувьд тухайн асуудлын мөн чанар, хэрэгжилт болон үр дүнд нөлөөлөх байдал, авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний тухай товч дүгнэлт гаргах ёстой. Тайлбар нь уншиж буй хүний хувьд асуудлууд болон үнэлгээчдийн дүгнэлтийг ойлгоход хангалттай, нарийвчилсан мэдээлэл агуулах ёстой. Гэхдээ үүнд бүрэн шинжилгээг оруулах, үнэлгээчдийн дүгнэлт, сэрэмжлүүлгийг зөвтгөх, шүүмжлэлүүдийг няцаах ёсгүй. Асуудал тус бүрийн тухай хуудасны талаас хэтрүүлэлгүй бичих бөгөөд нэмэлт мэдээлэлтэй бол товч дүгнэлтэд бус тайлангийн үндсэн

хэсэгт оруулбал зохино. Асуудлыг тайлбарласны дараа үнэлгээчид нь ХҮТ-гийн үндсэн хэсэг дэх холбогдох мэдээллийн холбоосыг оруулах ёстой.

B.2 [Асуудлын нэр...]

С. Нэн түрүүнд хэрэгжүүлэх арга хэмжээ

Тайлан нь тухайн улсын нэн тэргүүнд хэрэгжүүлбэл зохих арга хэмжээнүүдийн жагсаалтыг агуулах ёстой. Үүнд:

- Үнэлгээчид нь тухайн улсын хувьд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоогоо сайжруулахын тулд **нэн түрүүнд хэрэгжүүлэх ёстой арга хэмжээнүүдийг тодорхойлох ёстой**. Эдгээр нь үр дүнтэй байдлыг сайжруулах техникийн хэрэгжилттэй холбоотой болон бүтцийн эсвэл хоорондоо хамааралтай асуудлуудыг шийдвэрлэхэд чиглэсэн байж болно.
- **Үнэлгээчид нь авах шаардлагатай арга хэмжээ** ба тухай арга хэмжээг нэн түрүүнд хэрэгжүүлэх шалтгааныг тайлбарлах ёстой (Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцооны суурь үндэс юм).
- Энд **тодорхойлогдсон арга хэмжээнүүд** гол судлах асуудлуудтай байдаг ч үргэлж тийм байх албагүй. Тухайлбал үнэлгээчид нь гол судлах асуудлуудад оруулаагүй хэд хэдэн сул талуудад хамааралтай нэг арга хэмжээг тодорхойлох тохиолдол гарч болно.
- **Нэн түрүүнд хэрэгжүүлэх арга хэмжээний** жагсаалт нь 1 хуудаснаас хэтрэхгүй байх ёстой.
- Богино хугацаанд эсвэл харьцангуй бага зардлаар үр дүнд хүрч болохуйц **арга хэмжээг үнэлгээчид санал болгож байгаа** бол үүнийг тодруулж тэмдэглэх ёстой.

ФАТФ-ын Зөвлөмжүүдийн хэрэгжилтийн хүснэгт

ФАТФ-ын Зөвлөмжүүдийн хэрэгжилт		
Зөвлөмж	Зэрэглэл	Зэрэглэлд нөлөөлж буй хүчин зүйлс
1. Эрсдэлийг үнэлэх, эрсдэлд суурилсан аргачлалыг хэрэгжүүлэх нь	[C]	<ul style="list-style-type: none"> Энэхүү хүснэгт нь зэрэглэл болон зэрэглэл тус бүртэй холбоотой бүх хүчин зүйлсийн дүгнэлтийг агуулах ёстой.
2. Үндэсний хамтын ажиллагаа болон уялдаа холбоо	[LC]	
3. Мөнгө угаах гэмт хэрэг	[PC]	
4. Хөрөнгө хураан авах болон түр зуурын арга хэмжээ	[NC]	
5. Терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэг		
6. Терроризм болон терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэгтэй холбоотой зорилтот санхүүгийн хориг арга хэмжээнүүд		
7. Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхтэй холбоотой санхүүгийн зорилтот хориг арга хэмжээнүүд		
8. Төрийн бус байгууллагууд		
9. Санхүүгийн байгууллагын нууцлалтай холбоотой хууль тогтоомж		
10. Харилцагчийг таньж мэдэх		
11. Баримт, материал хадгалалт		
12. Улс төрд нөлөө бүхий этгээдүүд (утнбэ)		
13. Корреспондент банкны үйл ажиллагаа		
14. Мөнгө болон үнэ бүхий зүйл шилжүүлэх үйлчилгээ		
15. Шинэ технологи		
16. Цахим мөнгөн шилжүүлэг		
17. Гуравдагч этгээдэд тулгуурлах		
18. Дотоод хяналт болон гадаад дахь салбар, охин компани		
19. Өндөр эрсдэлтэй улс орнууд		
20. Сэжигтэй гүйлгээг мэдээлэх		
21. Мэдээллийг задруулах болон нууцлал		
22. СББМҮҮ: харилцагчийг таньж мэдэх		
23. СББМҮҮ: бусад арга хэмжээ		
24. Хуулийн этгээдийн эцсийн өмчлөгч болон ил тод байдал		

ФАТФ-ын зөвлөмжийн техникийн хэрэгжилт болон МУТСТ тогтолцооны үр дүнтэй байдлыг үнэлэх

25. Эрх зүйн бусад зохицуулалт бүхий этгээдийн ил тод байдал болон эцсийн өмчлөгч		
26. Санхүүгийн байгууллагуудын хяналт, зохицуулалт		
27. Хянан шалгагчдын эрх мэдэл		
28. СББМҮҮ-ын хяналт зохицуулалт		
29. Санхүүгийн мэдээллийн алба		
30. Хууль сахиулах болон мөрдөн шалгах байгууллагуудын үүрэг		
31. Хууль сахиулах болон мөрдөн шалгах байгууллагуудын эрх мэдэл		
32. Бэлэн мөнгө зөөвөрлөгчид		
33. Статистик мэдээлэл		
34. Зааварчилгаа, эргэх холбоо		
35. Шийтгэлийн арга хэмжээ		
36. Олон улсын баримт бичиг		
37. Эрх зүйн харилцан туслалцаа		
38. Эрх зүйн харилцан туслалцаа: царцаах, хураан авах		
39. Гэмт хэрэгтнийг шилжүүлэх		
40. Олон улсын хамтын ажиллагааны бусад хэлбэрүүд		

Шууд хэрэгжилтийн үр дүнтэй байдлын хүснэгт

Үр дүнтэй байдал		
Шууд хэрэгжилт	Түвшин	Зэрэглэлд нөлөөлж буй хүчин зүйлс
1. Эрсдэл, бодлого болон уялдаа холбоо	[маш өндөр]	<ul style="list-style-type: none"> Энэхүү хүснэгт нь дээрх хүснэгтийн адил хэрэгжилт тус бүртэй холбоотой бүх хүчин зүйлсийн дүгнэлтийг агуулах ёстой.
2. Олон улсын хамтын ажиллагаа	[өндөр]	
3. Хяналт шалгалт	[дунд]	
4. Урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүд	[бага]	
5. Хуулийн этгээдүүд болон эрх зүйн бусад зохицуулалт бүхий этгээдүүд		
6. Санхүүгийн мэдээлэл		
7. Мөнгө угаахыг мөрдөх болон яллах		
8. Эд хөрөнгө хураан авах		
9. Терроризмыг санхүүжүүлэхийг мөрдөн шалгах болон яллах		
10. Терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой урьдчилан сэргийлэх арга хэмжээ болон санхүүгийн хориг арга хэмжээ		
11. Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхтэй холбоотой санхүүгийн хориг арга хэмжээ		

[УЛС]-ЫН ХАРИЛЦАН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Өмнөх үг

Энэхүү тайлан нь [үнэлэгдэж буй улсын нэр]-ын газар дээрх шалгалтын үед хэрэгжиж буй мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх арга хэмжээнүүдийн дүгнэлт бөгөөд [улс]-ын ФАТФ-ын 40 Зөвлөмжүүдийг хэрэгжүүлсэн байдал болон мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцооны үр дүнтэй байдлын түвшинг үнэлж тогтолцоог хэрхэн сайжруулах талаарх зөвлөмжүүдийг агуулна.

Энэхүү дүгнэлтийг ФАТФ-ын 2012 оны Зөвлөмж дээр суурилан 2013 оны аргачлалыг ашиглан бэлтгэсэн. Дүгнэлт нь [улс]-ын бэлтгэсэн мэдээлэл болон үнэлгээний багийн тухайн [улс]-д [огноо]-нд айлчлалын үеэр цуглуулсан мэдээлэлд үндэслэсэн.

Үнэлгээг [үнэлгээчдийн нэрс, харьяалагдах байгууллагуудын жагсаалт, тэдгээрийн ажил үүрэг тухайлбал хуулийн мэргэжилтэн г.м] [ФАТФ-ын Нарийн бичгийн дарга нарын газрын ажилтнуудын нэрс зэрэг бүрэлдэхүүнтэй] үнэлгээний баг гүйцэтгэсэн. Тайланг [хянагчдын нэрсийн жагсаалт] хянав.

[Улс] нь 2004 оны ФАТФ-ын аргачлалын дагуу [огноо]-нд ФАТФ-ны Харилцан үнэлгээнд хамрагдаж байсан. [Огноо]-ны үнэлгээ [болон [огноо]-ны үнэлгээний дараах тайлан] нь нийтлэгдсэн бөгөөд үүнийг [цахим хаяг]-руу хандан үзэх боломжтой. [Улс]-ын нөхцөл байдалд болон ФАТФ-ын Зөвлөмжүүдийн шаардлагуудад төдийлөн өөрчлөлт гараагүй хэсгийн тухай товч тайлбарлахын тулд өмнөх дүгнэлтэд тусгагдаж, тайлангийн агуулгад орсон хоорондоо холбоо бүхий нарийвчилсан шинжилгээг энэ удаагийн дүгнэлтэд оруулахгүй.

Харилцан үнэлгээгээр [улс] нь [...] Зөвлөмжийг биелүүлсэн, [...] Зөвлөмжийг ихэнхдээ биелүүлсэн, [...] Зөвлөмжийг хэсэгчлэн биелүүлсэн, [...] Зөвлөмжийг биелүүлээгүй гэж дүгнэгдлээ. [Улс] нь Үндсэн болон Гол 16 Зөвлөмжийн [...] -ийг “биелүүлсэн” болон “ихэнхдээ биелүүлсэн” гэж үнэлэгдлээ. [Тухайн улсын Харилцан үнэлгээний дараах ажиглалтын процессийн статус, өмнө нь ажиглалтын процесд орж байсан эсэх, орж байсан огноо, мөн ажиглалтын хугацаа нь дууссан эсэх, дууссан хугацаа болон дууссан шалтгаан (Тухайлбал: тухайн улс бүх Үндсэн болон Гол 16 Зөвлөмжийн хувьд болон шийдэгдээгүй асуудлуудын хувьд “ихэнхдээ биелүүлсэн” гэсэн үнэлгээ авсан.) Мөн үнэлгээчид тухайн улсын Үндсэн болон Гол 16 Зөвлөмжүүдээс “ихэнх талаар хэрэгжүүлсэн” гэсэн үнэлгээ хараахан авч чадаагүй Зөвлөмжүүдийг дурьдах ёстой.]

1. МӨНГӨ УГААХ БОЛОН ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭРСДЭЛ БОЛОН ОРЧИН НӨХЦӨЛ

Энэ хэсэг тухайн улсын газар нутгийн хэмжээ, газар зүйн байрлал, хүн ам, ДНБ болон төрийн байгууллагын тогтолцоо зэрэг ерөнхий нөхцөл байдлын талаар маш товчхон тайлбараар эхлэх ёстой.

Энэхүү хэсэгт үнэлгээнд нөлөөлж буй газар зүйн байрлал болон шүүх засаглалын асуудлуудыг дурдах хэрэгтэй (Хэрэв ХҮТ нь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх ялгаатай дэглэмтэй газар нутаг, бүсүүдийг хамарч байвал эсвэл тухайн улс нь хэд хэдэн улсыг нэгтгэсэн хуулийн тогтолцооны гишүүн байх үед).

1.1 Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлүүд

Энэ хэсэгт тухайн улсад тулгарч буй мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх аюул заналхийлэл болон эрсдэлүүдийг тодорхойлно. Үүнд аргачлалын оршил хэсэгт заасны дагуу тухайн улсын өөрсдийн эрсдэлийн үнэлгээнд дурдсан гол аюул заналхийлэл болон бусад холбогдох мэдээллийг оруулна. Үүнд дараах зүйлсийг хамруулна:

- Тухайн улс дахь орлого олдог гэмт хэргийн түвшин болон учир шалтгаан;
- Тухайн улсын хууль бус (бусад улсад үйлдэгдсэн гэмт хэрэгтэй холбоотой) хөрөнгийн хил дамнасан шилжүүлэгт нээлттэй байдлын түвшин болон хууль бус бараа тээвэрлэх ба хууль бусаар мөнгө шилжүүлэхэд дамжин өнгөрөх цэгийн үүрэг гүйцэтгэх боломж;
- Тухайн улсын терроризмыг санхүүжүүлэх аюул заналхийлэл (Үүнд: тухайн улсад идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа террорист бүлэг байгаа эсэх, өөр улсад үйл ажиллагаа явуулж байгаа террорист бүлгийг санхүүжүүлэхэд тухайн улсыг ашиглах) болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхэд өртөмтгий байдалтай холбоотой бүхий л боломжит мэдээлэл;
- Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхэд өртөмтгий байдал зэрэг эрсдэлүүд болон үр дагаварууд орно.

1.2. Бодит байдал

Энэ хэсэгт тухайн улсын эдийн засаг, санхүүгийн, СББМҮҮ нарын салбарын хэмжээ болон ерөнхий бүтцийн талаарх мэдээллийг оруулна. Төрөл бүрийн санхүүгийн байгууллагууд болон СББМҮҮ нар болон тэдгээрийн үйл ажиллагааны ач холбогдолтой байдал, тухайн улсын санхүүгийн, СББМҮҮ нарын салбарын олон улсын түвшин дэх үүрэг (тухайлбал: тухайн улсын бүс нутгийн санхүүгийн төв, олон улсын санхүүгийн төв, компани байгуулах болох бүртгэх төв эсэх), мөн тухайн улсын санхүүгийн болон СББМҮҮ нарын салбарын чухал шинжүүдийг онцлох хэрэгтэй. Энэ хэсэгт аргачлалын удиртгал хэсэгт дурдсанчлан бодит байдалд нөлөөлөх бусад чухал хүчин зүйлсийг тэмдэглэнэ. Энэ хэсэгт зөвхөн товч дүгнэлтийг бичнэ – нарийн мэдээллийг тайлангийн 5.1 (а) хэсэгт оруулна.

1.3 Бүрэлдэхүүн хэсгүүд

Үнэлгээчид нь тухайн улсад мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үр дүнтэй тогтолцооны гол бүрдэлдэхүүн хэсгүүд байгаа талаар тэмдэглэх ёстой (аргачлалын удиртгалын 9 дүгээр бүлэгт заасны дагуу).

Хэрэв мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үр дүнтэй тогтолцооны тулгуур хүчин зүйлс байхгүй эсвэл хөгжил нь сул байгаа гэсэн сэжиг төрсөн тохиолдолд үнэлгээчид нь

ФАТФ-ын зөвлөмжийн техникийн хэрэгжилт болон МУТСТ тогтолцооны үр дүнтэй байдлыг үнэлэх

эдгээр хэсгүүдийг тодруулж тэмдэглэх ёстой. Үнэлгээчид нь эдгээр хүчин зүйлс байгаа талаар ерөнхий дүгнэлтэд хүрэх албагүй.

1.4 Бусад хүчин зүйлс

Үнэлгээчид нь тухайн улсын мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх арга хэмжээний үр дүнтэй байдалд харьцангуй их нөлөө үзүүлж болзошгүй хүчин зүйлсийн талаар бичих ёстой. Үүнд: мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоо болон үүнийг хэрэгжүүлж байгаа байгууллагуудын үйл ажиллагаа явуулж буй хугацаа болон уг ажлыг явуулахад хангалттай чадвартай байдал, авлига, санхүүгийн хүртээмжтэй байдлын асуудлуудыг авч үзнэ.

1.5 Харьцангуй өндөр эрсдэл бүхий асуудлуудыг тодорхойлох

Үнэлгээчид нь үнэлгээний үйл явцад нарийн судлах зорилгоор харьцангуй өндөр эрсдэл бүхий асуудал болон хэсгүүдийг илрүүлэхэд чиглэсэн бүхий л шинжилгээний үр дүнг танилцуулах ёстой. Үүнд тухайн асуудлыг өндөр эрсдэлтэй гэж үзэх шалтгаан (үүнийг үнэлгээнд хамрагдаж байгаа улсын талаас эсвэл үнэлгээчид нь санал болгосон эсэх) болон үнэлгээний үйл явцад эдгээр асуудалд хэрхэн илүү анхаарал хандуулснаа тэмдэглэх ёстой. Мөн үнэлгээчид нь харьцангуй бага эрсдэлтэй гэж үзэж буй асуудлуудыг тэмдэглэнэ.

2. ҮНДЭСНИЙ МӨНГӨ УГААХ БОЛОН ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ БОДЛОГО БОЛОН УЯЛДАА ХОЛБОО

Гол анхаарах зүйлс

Үнэлгээчид нь энэхүү бүлгийн товч дүгнэлт гаргаж, хамгийн чухал үр дүнгүүдийг тодруулан тэмдэглэх ёстой.

2.1 Ерөнхий мэдээлэл болон нөхцөл байдал

(a) Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стратегийн тойм

Энэ хэсэгт Засгийн газрын баримталж буй мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үндсэн бодлого болон зорилгуудыг дурдана. Энэ зорилгын дагуу Засгийн газрын зорилтууд болон чухалчилж байгаа зүйлсийг тайлбарлах бөгөөд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стратегид нөлөөлж болох өргөн хүрээний бодлогын зорилтуудыг (тухайлбал, санхүүгийн хүртээмжтэй байдал) тэмдэглэнэ. Мөн энэ хэсэгт үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх үйл ажиллагааг санхүүжүүлэхтэй тэмцэх холбоотой бүхий л зорилго болон бодлогыг тайлбарлана.

(b) Байгууллагуудын тогтолцоо

Энэ хэсэг бол Засгийг газрын мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх бодлогыг боловсруулж хэрэгжүүлдэг яамд, агентлаг болон бусад эрх бүхий байгууллагуудын тойм юм. Үнэлгээчид нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх үүрэгтэй байгууллага бүрийн үндсэн үүрэг хариуцлагыг товч тайлбарлах ёстой. Үнэлгээчид нь сүүлийн ХҮТ-аас хойш байгууллагын тогтолцоонд орсон томоохон өөрчлөлтүүд болон эдгээр өөрчлөлтүүдийг шалтгааныг тэмдэглэх ёстой.

(c) Хамтын ажиллагаа болон уялдаа холбоо

Үнэлгээчид нь тухайн улсын ашиглаж буй мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх бодлогын хөгжилд туслах хамтын ажиллагаа болон уялдаа холбооны механизмыг тайлбарлах ёстой.

(d) Тухайн улсын эрсдэлийн үнэлгээ

Энэ хэсэгт тус Улсын Эрсдэлийн Үнэлгээний бэлтгэл ажилд зориулсан арга хэмжээнүүдийг тайлбарлах ёстой. Үүнд эрсдэлийн үнэлгээний даалгавар, бүтэц зохион байгуулалт (ганцаарчилсан үнэлгээ эсвэл бүсийн/салбарын үнэлгээнд суурилсан), бэлтгэсэн байдал, ашигласан мэдээллийн төрөл болон үйл явцын чанартай байдлын талаар үнэлгээчдийн гаргасан дүгнэлтийг оруулна.

Үнэлгээчид нь үнэлгээний дүгнэлтүүдийн оновчтой байдал болон оновчтой биш гэж үзэж байгаа хэсгүүд, үнэлгээнд ороогүй ч чухал гэж үзэж буй бусад эрсдэлүүд болон эрсдэлийн хүчин зүйлсийг тэмдэглэх шаардлагатай. Үнэлгээчид нь эдгээр нэмэлт эрсдэлүүдийг илрүүлсэн тохиолдолд юунд суурилж дээрх дүгнэлт гаргасан болон үүний баталгаа болгон ашигласан найдвартай мэдээллийн эх сурвалжийг дурдах шаардлагатай.

Энэхүү хэсэгт эдгээр эрсдэлийн үнэлгээнүүд тухайн улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стратеги болон бодлогуудад хэрхэн нөлөөлсөн тухай тэмдэглэх шаардлагатай.

2.2 Техникийн хэрэгжилт (Зөвлөмж.1, 2, 33)

Зөвлөмж 1 – Эрсдэлийг үнэлэх, эрсдэлд суурилсан аргачлалыг хэрэгжүүлэх нь

Үнэлгээчид нь тухайн улсын хувьд Зөвлөмж 1-ийн хэрэгжсэн байдлын ерөнхий түвшинг товч дүгнэж, чухал дутагдлыг дурдаж (ач холбогдол багатай, техникийн хувьд хэрэгжээгүй бол техникийн хавсралтад авч үзнэ), **үнэлгээг тэмдэглэх** шаардлагатай. Бүх хүчин зүйлсийн шинжилгээг энэ хэсэгт оруулахгүй бөгөөд үүнийг тусад нь техникийн хавсралтад оруулна. Үнэлгээчид нь шинэ, түгээмэл биш эсвэл өөр шинжээрээ сайн хэрэгжсэн техникийн шаардлага болон үйл ажиллагааг онцлон тэмдэглэж болно. Үнэлгээчид нь бусад Зөвлөмжүүдийн хэрэгжсэн байдлыг тогтоохдоо үүнтэй адил аргачлалыг дагах шаардлагатай. Эцсийн тайланг хэмжээний хувьд зохимжтой байлгах үүднээс үнэлгээчид нь зөвлөмж бүрийн хувьд хэрэгжсэн байдлыг 1 хуудасны тал хэсгээс хэтрэхгүй 1-2 бүлэгт багтаахыг зорих шаардлагатай.

Зөвлөмж 2 – Үндэсний хамтын ажиллагаа болон уялдаа холбоо

Зөвлөмж 33 – Статистик мэдээлэл

2.3 Үр дүнтэй байдал: Шууд хэрэгжилт 1 (Эрсдэл, бодлого болон уялдаа холбоо)

Энэ хэсэгт үнэлгээчид нь Шууд хэрэгжилт 1-ийн шинжилгээг оруулна. Эхний бүлэгт тухайн улсын үнэлгээнд нөлөөлж буй эрсдэл болон нөхцөл байдлын тухай ерөнхий мэдээллийг бичнэ.

Мөн энэ хэсэгт үнэлгээчид нь тухайн улсын үр дүнтэй тогтолцооны шинжүүдийг агуулж байгаа талаар ерөнхий сэтгэгдлээ дүгнэсэн байх шаардлагатай.

Үнэлгээчид нь Үндсэн асуудлууд бүрийн хувьд хийсэн шинжилгээгээ тэмдэглэх шаардлагатай. Үнэлгээчид нь энэ хэсгийн бүтцийг бага зэрэг өөрчлөх боломжтой. Зарим Шууд хэрэгжилтийн хувьд бүх үндсэн асуудлуудыг ээлж дарааллаар нь авч үзэж болно. Бусад шууд хэрэгжилтийн хувьд (тухайлбал ШХ.4) шинжилгээг салбар бүрийн хувьд оруулах, эсвэл (тухайлбал ШХ.7) шинжилгээг Шууд хэрэгжилтийн хамрах үйл явцыг бүрэлдэхүүн хэсэг тус бүрийн хувьд алхам

алхмаар тайлбарлах нь зүйтэй. Үнэлгээчид нь аль ч бүтцийн төрлийг баримталсан, бүх үндсэн асуудлыг авч үзэж, **тэдгээрийн хувьд гаргасан бүх ерөнхий дүгнэлтүүдийг тодруулан тэмдэглэх шаардлагатай.**

Үнэлгээчид нь ашигласан баримт болон мэдээллийн эх үүсвэрийг тэмдэглэх шаардлагатай (тухайлбал, Шууд хэрэгжилтийн (а) ба (b) хэсгүүдэд тэмдэглэсэн эх сурвалжууд). Үнэлгээчид нь аргачлалд заасан бүх мэдээллийг ашиглах албагүй ч энэ хэсэгт өөрсдийн дүгнэлтэд бодитоор нөлөөлсөн мэдээлэл болон баримтуудыг дурдах шаардлагатай. Мөн шинжилгээний үр дүнтэй байдалд нөлөөлж буй хэрэгжсэн байдлын асуудлыг бичиж тэмдэглэх шаардлагатай.

Энэ хэсгийн төгсгөлд үнэлгээчид нь Шууд хэрэгжилтийн хувьд гаргасан ерөнхий дүгнэлтээ бичих шаардлагатай. Үүнд: үнэлгээнд орж буй улс тухайн хэрэгжилтэд хүрч байгаа түвшин болон дүгнэлтэд нөлөөлсөн гол шалтгаануудыг бичнэ. Үр дүнтэй байдлын ерөнхий түвшин нь дараах зүйлсийг харгалзан үзсэн байх шаардлагатай: (а) үндсэн асуудлууд, (b) үүнтэй холбоотой бүхий л хэрэгжсэн байдлын асуудал эсвэл хэрэгжээгүй байдал, (c) эрсдэл болон ерөнхий хүчин зүйлс, (d) бусад холбогдох Шууд хэрэгжилтийн үр дүнтэй байдал. Үр дүнтэй байдлын түвшин нь холбогдох Зөвлөмжийн хэрэгжсэн байдлаас нэлээд зөрүүтэй байх тохиолдолд үнэлгээчид нь дүгнэлтийнхээ шалтгааныг тодорхой зааж өгөх шаардлагатай. Үнэлгээчдийн дүгнэлтүүд голчлон тайлбарласан шинжтэй байх бөгөөд тодорхой үр дүнд хүрсэн эсвэл хүрээгүй шалтгааныг тайлбарласан байх шаардлагатай. **Энэ хэсгийн төгсгөлд үнэлгээчид нь үр дүнтэй байдлын үнэлгээгээ бичнэ.**

Үнэлгээчид нь энэхүү ерөнхий хандлагыг баримтлан бусад Шууд хэрэгжилтийн үр дүнтэй байдлын шинжилгээг танилцуулна.

2.4. Үндэсний мөнгөн угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх бодлого болон уялдаа холбооны талаар өгөх зөвлөгөө

Энэ хэсэгт тухайн улс нь ФАТФ-ын Зөвлөмжүүдийн хэрэгжүүлэлт болон үр дүнтэй байдлыг хэрхэн сайжруулах тухай чухал нэн түрүүнд хэрэгжүүлэх шаардлагатай зөвлөмжийг бичнэ. Энэ хэсэгт үнэлгээчид нь ХҮТ-ийн энэ бүлэгт авч үзсэн Шууд хэрэгжилт болон Зөвлөмжүүдтэй холбоотой зөвлөгөөг оруулна. Тиймээс үнэлгээчид нь хэд хэдэн Шууд хэрэгжилт, Зөвлөмжийн заалтуудыг хамарсан техникийн хэрэгжээгүй байдал болон үр дүнтэй байдлын практик асуудлуудад чиглэсэн арга хэмжээнүүдийг авч үзэн ямар арга хэмжээ илүү чухал болохыг тодорхойлох шаардлагатай.

Үнэлгээчид нь тухайн зөвлөгөө **ямар Зөвлөмжийн заалт болон Шууд хэрэгжилтэд холбоотой болохыг** тодорхой зааж өгөх шаардлагатай. Үнэлгээчид нь ХҮТ-ийн бусад бүлгийн хувьд зөвлөгөө боловсруулахдаа энэхүү аргачлалыг баримтална.

3. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ТОГТОЛЦОО БОЛОН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АСУУДЛУУД

Гол анхаарах зүйлс
Үнэлгээчид нь энэ бүлгийн товч дүгнэлт гаргаж, хамгийн чухал үр дүнгүүдийг тодруулан тэмдэглэх шаардлагатай.

3.1 Ерөнхий мэдээлэл болон нөхцөл байдал

(a) *Хууль, эрх зүйн тогтолцоо болон гэмт хэрэг*

Энэ хэсэгт тухайн улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хууль зүйн тогтолцооны товч дүгнэлтийг оруулна. Тогтолцооны бүрдэл хэсэг бүрийн нарийн тайлбар болон шинжилгээг оруулах шаардлагагүй, үүнийг техникийн хавсралтад оруулах эсвэл үүнийг өмнөх Харилцан үнэлгээний үед эсвэл холбогдох тайланд хангалттай сайн тайлбарласан байж болно

(Тэр үеэс хойш холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт ороогүй бол). Энэ хэсэгт дараах мэдээллийг оруулна. Үүнд:

1. Мөнгө угаах үйлдлийг гэмт хэрэгт тооцох хууль, эрх зүйн үндэс
2. Суурь гэмт хэрэгт тооцох арга зам
3. Гэмт хэргийн замаар олсон орлогыг хураан авах хууль, эрх зүйн үндэс
4. Тухайн улсын сүүлийн Харилцан үнэлгээний тайлангаас хойш хууль зүйн тогтолцоонд орсон томоохон өөрчлөлтүүд эсвэл өмнө нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үнэлгээний хувьд шинжилгээ хийж байгаагүй зүйлс (Тухайлбал харилцан үнэлгээний дараах ажиглалтын тайлан эсвэл ОУВС-ийн FSAP)

3.2 Техникийн хэрэгжилт (Зөвлөмж 3, 4, 29-32)

Мөнгө угаах болон хураан авах хураах

Зөвлөмж 3 – Мөнгө угаах гэмт хэрэг

Зөвлөмж 4 – Хөрөнгө хураан авах болон түр зуурын арга хэмжээ

Үйл ажиллагааны болон хууль сахиулах байгууллага

Зөвлөмж 29 – Санхүүгийн мэдээллийн алба

Зөвлөмж 30 – Хууль сахиулах болон мөрдөн шалгах байгууллагуудын үүрэг

Зөвлөмж 31 - Хууль сахиулах болон мөрдөн шалгах байгууллагуудын эрх мэдэл

Зөвлөмж 32 – Бэлэн мөнгө зөөвөрлөгчид

3.3 Үр дүнтэй байдал: Шууд хэрэгжилт 6 (Санхүүгийн мэдээлэл)

Энэхүү Шууд хэрэгжилт нь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаатай холбоотой. Үнэлгээчид нь мөнгө угаах эсвэл терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой бүхий л асуудлыг энд тэмдэглэх шаардлагатай.

3.4 Үр дүнтэй байдал: Шууд хэрэгжилт 7 (МУ-ыг мөрдөн шалгах, яллах)

3.5 Үр дүнтэй байдал: Шууд хэрэгжилт 8 (Хөрөнгө хураан авах)

3.6 Хууль зүйн тогтолцоо болон үйл ажиллагааны асуудалтай холбоотой зөвлөгөө

4. ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ БОЛОН ҮЙ ОЛНООР ХӨНӨӨХ ЗЭВСЭГ ДЭЛГЭРҮҮЛЭХИЙГ САНХҮҮЖҮҮЛЭХ

Энэ бүлэг нь терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй холбоотой Зөвлөмж болон Шууд хэрэгжилтийн үнэлгээг агуулна. Өмнөх бүлэгт авч үзсэн хуулийн болон үйл ажиллагааны арга хэмжээнүүд нь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэхтэй хамааралтай байсан.

Гол анхаарах зүйлс

Үнэлгээчид нь энэхүү бүлгийн товч дүгнэлт гаргаж, хамгийн чухал үр дүнгүүдийг тодруулан тэмдэглэх шаардлагатай.

4.1 Ерөнхий мэдээлэл болон нөхцөл байдал

Энэ хэсэг нь тухайн улсын терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх хууль, эрх зүйн тогтолцооны тухай товч дүгнэлтийг агуулах шаардлагатай. Тогтолцооны бүрдэл хэсэг бүрийн нарийн тайлбар болон шинжилгээг оруулах шаардлагагүй, үүнийг техникийн хавсралтад оруулах эсвэл өмнөх Харилцан үнэлгээний үед эсвэл Харилцан үнэлгээний дараах ажиглалтын тайланд хангалттай сайн тайлбарласан байж болно (тэр үеэс хойш холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт ороогүй бол). Энэ хэсэгт дараах мэдээллийг оруулна. Үүнд:

1. Терроризмыг санхүүжүүлэхийг гэмт хэрэгт тооцох хууль, эрх зүйн үндэс
2. (i) терроризм болон терроризмыг санхүүжүүлэх, (ii) үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхтэй холбоотой санхүүгийн хориг арга хэмжээ авах хууль, эрх зүйн үндэс
3. Терроризм, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй холбоотой бусад нэмэлт хууль тогтоомж болон эрх үүрэг
4. Тухайн улсын сүүлийн Харилцан үнэлгээний тайлангаас хойш хууль зүйн тогтолцоонд орсон томоохон өөрчлөлтүүд эсвэл өмнө нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үнэлгээний хувьд шинжилгээ хийж байгаагүй зүйлс (Тухайлбал харилцан үнэлгээний дараах ажиглалтын тайлан эсвэл ОУВС-ийн FSAP)

4.2 Техникийн хэрэгжилт (Зөвлөмж 5-8)

Зөвлөмж 5 – Терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэг

Зөвлөмж 6 – Терроризм болон терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой зорилтот санхүүгийн хориг арга хэмжээнүүд

Зөвлөмж 7 – Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхтэй холбоотой зорилтот санхүүгийн хориг арга хэмжээнүүд

Зөвлөмж 8 – Төрийн бус байгууллагууд

4.3 Үр дүнтэй байдал: Шууд хэрэгжилт 9 (Терроризмыг санхүүжүүлэхийг мөрдөх болон яллах)

Үнэлгээчид нь Шууд хэрэгжилт 9 болон 10-ыг дүгнэхдээ Шууд хэрэгжилт 6-ийн үнэлгээнд суурилсан терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой бүх санхүүгийн мэдээллийн асуудлыг оруулсан байх шаардлагатай.

4.4 Үр дүнтэй байдал: Шууд хэрэгжилт 10 (Терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ болон санхүүгийн хориг арга хэмжээ)

4.5 Үр дүнтэй байдал: Шууд хэрэгжилт 11 (Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй холбоотой санхүүгийн хориг арга хэмжээ)

4.6 Терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй холбоотой зөвлөгөө

5. УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

Гол анхаарах зүйлс

Үнэлгээчид нь энэхүү бүлгийн товч дүгнэлт гаргаж, хамгийн чухал үр дүнгүүдийг тодруулан тэмдэглэх шаардлагатай.

5.1 Ерөнхий мэдээлэл болон нөхцөл байдал

(a) Санхүүгийн салбар болон СББМҮҮ

Энэ хэсэгт санхүүгийн салбар болон СББМҮҮ нарын салбарын хэмжээ болон бүтцийг тодорхойлно. Энд олон төрлийн санхүүгийн байгууллага болон СББМҮҮ-ийн ач холбогдол, үйл ажиллагаа, эзлэх хувийг тэмдэглэнэ. Тухайн улсын санхүүгийн болон СББМҮҮ-ийн салбарын олон улсын түвшин дэх үүрэг (тухайлбал: тухайн улс нь бүс нутгийн санхүүгийн төв, олон улсын санхүүгийн төв, компани байгуулах болох бүртгэх төв эсэх)-ийн тухай бичиж, тухайн улсын санхүүгийн болон СББМҮҮ-ийн салбарын чухал шинжүүдийг онцлох хэрэгтэй. Тухайн улс дахь санхүүгийн болон СББМҮҮ-ийн төрөл болон гол шинжүүд, байгууллагын төрөл бүрийн тоо, тус салбар болон түүнд харьяалагдах байгууллагуудын ач холбогдолтой байдалтай холбоотой мэдээллийг дүгнэх шаардлагатай.

(b) Урьдчилан сэргийлэх арга хэмжээ

Энэ хэсэгт санхүүгийн байгууллагууд болон СББМҮҮ нарт мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үүрэг хүлээлгэж буй гол хууль тогтоомжууд, үүнийг хэрэгжүүлэх хуулийн (эсвэл албадагын шинжтэй бусад) арга хэрэгслүүд болон энэхүү хариуцлагын хамрах хүрээг тэмдэглэнэ. Үнэлгээчид нь мөнгө угаах, терроризмын санхүүжүүлэхтэй тэмцэх үүрэг хариуцлагын хувьд ямар нэг асуудал илрүүлбэл энэ хэсэгт бичих шаардлагатай.

(c) Эрсдэлд суурилсан чөлөөлөлт эсвэл урьдчилан сэргийлэх арга хэмжээг нэмэгдүүлэх

Тухайн улс тодорхой салбар эсвэл үйл ажиллагааг эдгээр шаардлагаас чөлөөлсөн бол үүнийг энэ хэсэгт тэмдэглэнэ. Энэхүү чөлөөлсөн байдал нь Зөвлөмж 1-т заасан шаардлагад нийцэж байгаа эсэх болон тухайн улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн үнэлгээний дагуу хийгдсэн байгаа эсэхийг Үнэлгээчид нь тодорхойлох шаардлагатай.

Тухайн улс эрсдэлийн үнэлгээнд суурилан ФАТФ-ын зөвлөмжүүдэд тусгагдаагүй нэмэлт салбарт мөнгө угаах болон терроризмээс сэргийлэх арга хэмжээ авахыг шаардсан бол үүнийг мөн энэ хэсэгт тэмдэглэнэ.

5.2 Техникийн хэрэгжилт (Зөвлөмж 9-23)

Зөвлөмж 9 – Санхүүгийн байгууллагын нууцлалтай холбоотой хууль тогтоомж

Зөвлөмж 10 - Харилцагчийг таньж мэдэх

Зөвлөмж 11 - Баримт, материал хадгалалт

Тусгай үйлчлүүлэгч болон үйл ажиллагааны нэмэлт арга хэмжээ

Зөвлөмж 12 - Улс төрд нөлөө бүхий этгээдүүд

Зөвлөмж 13 - Корреспондент банкны үйл ажиллагаа

ФАТФ-ын зөвлөмжийн техникийн хэрэгжилт болон МУТСТ тогтолцооны үр дүнтэй байдлыг үнэлэх

Зөвлөмж 14 - Мөнгө болон үнэ бүхий зүйл шилжүүлэх үйлчилгээ (МҮБЗШҮ)

Зөвлөмж 15 - Шинэ технологи

Зөвлөмж 16 – Цахим мөнгөн шилжүүлэг

Гуравдагч этгээдэд тулгуурлах, дотоод хяналт болон санхүүгийн бүлгүүд

Зөвлөмж 17 - Гуравдагч этгээдэд тулгуурлах

Зөвлөмж 18 - Дотоод хяналт болон гадаад дахь салбар, охин компани

Зөвлөмж 19 - Өндөр эрсдэлтэй улс орнууд

Сэжигтэй гүйлгээг мэдээлэх

Зөвлөмж 20 - Сэжигтэй гүйлгээг мэдээлэх

Зөвлөмж 21 - Мэдээллийг задруулах болон нууцлал

Санхүүгийн бус бизнес болон мэргэжилийн үйлчилгээ үзүүлэгч нар

Зөвлөмж 22 - СББМҮҮ: Харилцагчийг таньж мэдэх

Зөвлөмж 23 - СББМҮҮ: бусад арга хэмжээ

5.3 Үр дүнтэй байдал: Шууд хэрэгжилт 4 (Урьдчилан сэргийлэх арга хэмжээ)

5.4 Урьдчилан сэргийлэх арга хэмжээний зөвлөгөө

6. ХЯНАЛТ ШАЛГАЛТ

Гол анхаарах зүйлс

Үнэлгээчид нь энэхүү бүлгийн товч дүгнэлт гаргаж, хамгийн чухал үр дүнгүүдийг тодруулан тэмдэглэх шаардлагатай.

6.1 Ерөнхий мэдээлэл болон нөхцөл байдал

1. Үнэлгээчид нь санхүүгийн, СББМҮҮ болон сайн дурын зохицуулалттай байгууллагыг хянаж шалгах байгууллагуудын зохион байгуулалт, зохицуулалт хянан шалгагч нарын үүрэг, хариуцлага нөөц бололцоо эрх үүргийг тодорхойлох шаардлагатай.

6.2 Техникийн хэрэгжилт (Зөвлөмж 26-28, 34, 35)

Зөвлөмж 26 – Санхүүгийн байгууллагуудын хяналт, зохицуулалт

Зөвлөмж 27 – Хянан шалгагчдын эрх мэдэл

Зөвлөмж 28 – СББМҮҮ нарын хяналт, зохицуулалт

Зөвлөмж 34 – Зааварчилгаа, эргэх холбоо

Зөвлөмж 35 – Шийтгэлийн арга хэмжээ

6.3 Үр дүнтэй байдал: Шууд хэрэгжилт 3 (Хяналт шалгалт)**6.4 Хяналт шалгалтын зөвлөгөө****7. ХУУЛИЙН ЭТГЭЭД БОЛОН ЭРХ ЗҮЙН БУСАД ЗОХИЦУУЛАЛТ БҮХИЙ ЭТГЭЭД****(a) Хуулийн этгээдүүдийн тойм**

Энэ хэсэгт тухайн улсад байгуулах боломжтой хуулийн этгээдүүдийн төрөл болон ерөнхий шинжүүдийг дурдана. Мөн энэ хэсэгт эдгээр байгууллагуудын тоо, улсын хэмжээнд болон санхүүгийн болон СББМҮҮ-ийн салбарт эзлэх хувийг тодорхой зааж өгөх шаардлагатай.

Энэ хэсэгт хуулийн этгээдүүд болон тэдгээрийг байгуулах, бүртгэх, хянах эрх бүхий байгууллагуудын (эдгээр байгууллага оршин байгаа тохиолдолд) институцийн тогтолцооны тухай бичнэ.

(b) Эрх зүйн бусад зохицуулалт бүхий этгээдийн тойм

Энэ хэсэгт тухайн улсад байгуулах боломжтой эрх зүйн бусад зохицуулалт бүхий этгээд (ЭЗБЗБЭ)-ийн төрөл, тэдгээрийн үндсэн шинж болон байгууллагын тогтолцооны (хуулийн хэлцлүүд байгуулах, бүртгэх, хянах эрх бүхий байгууллагуудын (эдгээр байгууллага оршин байгаа тохиолдолд)) тайлбарыг агуулна. Мөн энэ хэсэгт эдгээр байгууллагуудын тоо, улсын хэмжээнд болон санхүүгийн ба СББМҮҮ-ийн салбарт эзлэх хувийн жинг тодорхой зааж өгөх шаардлагатай.

(c) Хуулийн этгээд болон ЭЗБЗБЭ-ийн олон улсын нөхцөл байдал

Энэ хэсэгт тухайн улсын хуулийн этгээд болон ЭЗБЗБЭ-ийг олон улсын түвшинд ажиглаж нөхцөл байдлын тухай бичнэ. Тухайн улсын хуулийн этгээд болон ЭЗБЗБЭ-ийг үүсгэх болон бүртгэх олон улсын төвийн үүрэг гүйцэтгэх байдал (зөвхөн хууль харьяаллыг ашиглах зорилгоор ч байсан хамаагүй) мөн гадаад улсад бүртгэгдсэн хуулийн этгээд болон ЭЗБЗБЭ-үүд тухайн улсад үйл ажиллагаа явуулж хөрөнгө эзэмшиж байгаа нөхцөл байдлын тухай мэдээлэл оруулна.

7.2 Техникийн хэрэгжилт (Зөвлөмж 24, 25)

Зөвлөмж 24 – Хуулийн этгээдийн эцсийн өмчлөгч болон ил тод байдал

Зөвлөмж 25 - Эрх зүйн бусад зохицуулалт бүхий этгээдийн эцсийн өмчлөгч болон ил тод байдал

7.3 Үр дүнтэй байдал: Шууд хэрэгжилт 5 (Хуулийн этгээд болон эрх зүйн бусад зохицуулалт бүхий этгээд)**7.4 Хуулийн этгээд болон эрх зүйн бусад зохицуулалт бүхий этгээдийн талаар өгөх зөвлөгөө****8. ОЛОН УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА****Гол анхаарах зүйлс**

Үнэлгээчид нь энэхүү бүлгийн товч дүгнэлт гаргаж, хамгийн чухал үр дүнгүүдийг тодруулан тэмдэглэх шаардлагатай.

8.1 Ерөнхий мэдээлэл болон нөхцөл байдал

Үнэлгээчид нь тухайн улсад тулгарч байгаа олон улсын МУТС эрсдэл болон аюул заналхийллийн шинж чанарыг товч тайлбарлах бөгөөд үүндээ тухайн улсыг бусад улсад үйлдэгдсэн гэмт хэргийн орлогыг угаахад ашиглах боломж болон тухайн улсын нутаг дэвсгэрт үйлдэгдсэн гэмт хэргийн орлогыг бусад улсад угаах боломжийг авч үзнэ. Үнэлгээчид нь тухайн улстай МУТС талаар холбоотой бусад улс орнуудыг боломжийнхоо хэмжээнд илрүүлэх шаардлагатай. Энэ нь Бүлэг 1-т тайлбарласан эрсдэл болон аюул заналхийллийн ерөнхий тайлбартай давхцах ёсгүй.

Мөн энэ хэсэгт олон улсын хамтын ажиллагаанд зориулсан байгууллагын тогтолцооны тухай мэдээлэл агуулна (Жн: эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх үүрэг бүхий төв байгууллага).

8.2 Техникийн хэрэгжилт (Зөвлөмж 36-40)

Зөвлөмж 36 – Олон улсын баримт бичиг

Зөвлөмж 37 – Эрх зүйн харилцан туслалцаа

Зөвлөмж 38 - Эрх зүйн харилцан туслалцаа: Царцаах, хураан авах

Зөвлөмж 39 – Гэмт хэрэгтнийг шилжүүлэх

Зөвлөмж 40 – Олон улсын хамтын ажиллагааны бусад хэлбэрүүд

8.3 Үр дүнтэй байдал: Шууд хэрэгжилт 2 (Олон улсын хамтын ажиллагаа)

8.4 Олон улсын хамтын ажиллагааны зөвлөгөө

ТЕХНИКИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ХАВСРАЛТ

1. Энэ хавсралт нь [улс]-ын ФАТФ-ын 40 Зөвлөмжийн хэрэгжилтийн түвшний дэлгэрэнгүй шинжилгээг агуулна. Үүнд тухайн улсын эрсдэлтэй байдлын талаар тайлбар оруулаагүй бөгөөд зөвхөн Зөвлөмж тус бүрийн техникийн шинж чанарын шинжилгээг бичнэ. Үүнийг Харилцан үнэлгээний тайлангийн хамт унших шаардлагатай.

2. ФАТФ-ын зөвлөмж болон зохицуулалтын хууль тогтоомжид өөрчлөлт ороогүй тохиолдолд [огноо]-нд явагдсан өмнөх Харилцан үнэлгээний тайлангийн дүн шинжилгээг үзэх холбоосыг тусгана. Тус тайланг [цахим хаяг]-ийн дагуу үзэх боломжтой.

2. УЛСЫН МӨНГӨ УГААХ, ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ БОДЛОГО БОЛОН УЯЛДАА ХОЛБОО

Зөвлөмж 1 – Эрсдэлийг үнэлэх, эрсдэлд суурилсан аргачлалыг хэрэгжүүлэх нь

3. Зөвлөмж бүрийн хувьд эхний бүлэгт шинэ шинжилгээ хэрэгтэй асуудлууд болон өмнөх нь хийгдсэн шинжилгээг үзэж болох асуудлуудын холбоосыг зааж өгнө. Үүнд:

1. Боломжтой бол өмнөх Харилцан үнэлгээний тайлангийн дагуу өгөгдсөн үнэлгээ болон илрүүлсэн гол сул талууд
2. Харилцан үнэлгээний дараах ажиглалтын тайланд тухайн улс өөрийн сул талаа залруулах зорилгоор ямар арга хэмжээ авсан талаарх дүгнэлт
3. 2004 оны аргачлалтай холбоотой ФАТФ-ын шинэ шаардлагууд
4. Тухай улсын холбогдох хууль тогтоомж, зохицуулалт болон бусад хүчин зүйлсийн гол өөрчлөлтүүд.

4. *Шалгуур 1.1* – Шалгуур тус бүрийг гол төлөв 1 бүлэгт авч дүгнэнэ.

5. Хэрэв өмнө нь нэг ба хэд хэдэн шалгуурыг авч үзсэн бөгөөд холбоотой хууль тогтоомж болон бусад хэрэгжилтийг хангах хэрэгсэлд өөрчлөлт ороогүй бол үнэлгээчид нь өмнөх шинжилгээний тайланг давтан бичих шаардлагагүй. Харин тэдгээр дүгнэлтүүдийг нэгтгэн, дэлгэрэнгүй шинжилгээг тайлбарласан тайлангийн холбоосыг (бүлэг, зүйл заалтыг дугаарын хамт) зааж өгөх шаардлагатай. Эдгээр холбоос нь зөвхөн ХҮТ, ОУВС-ийн FSAP болон олон нийтэд тараасан Харилцан үнэлгээний дараах ажиглалтын тайланг холбогдох үнэлгээний байгууллага нь үнэлж дүгнэсэн, баталсан бөгөөд үнэлгээчид шинжилгээ, дүгнэлтийг нь зөв гэж үзсэн тохиолдолд ашиглана.

6. *Шалгуур 1.2* – Үнэлгээчид нь тухайн шалгуурыг хангаж байгаа тухай өөрсдийн шинжилгээгээ энэ хэсэгт оруулна. Тухайн улсын нөхцөл байдал, ерөнхий мэдээлэл болон байгууллагын тогтолцооны тайлбарыг энэ хавсралтад биш үндсэн тайланд оруулна (үнэлгээчид нь үндсэн тайлангийн холбогдох хэсгийн холбоосыг зааж өгч болно).

7. Үнэлгээчид нь шаардлагатай тохиолдолд ялангуяа нийлмэл шалгуур эсвэл хэд хэдэн салбарт хамааралтай шалгуурын шинжилгээг илүү их дэлгэрэнгүй бичиж болно. Ийм тохиолдолд шинжилгээгээ хүснэгт хэлбэрээр танилцуулах нь тохиромжтой байж магадгүй. Хэдий тийм ч үнэлгээчид нь техникийн хавсралт бүхэлдээ 60 хуудаснаас хэтрэх ёсгүйг санах шаардлагатай.

Жинлэх болон дүгнэх

8. Үнэлгээчид нь дүгнэлтийн хэсэгт холбогдох техникийн хэрэгжилтийн үнэлгээ болон уг үнэлгээний шалтгааныг тэмдэглэх шаардлагатай. Тэд шалгуур тус бүр хэр зэрэг чухал болохыг

ФАТФ-ын зөвлөмжийн техникийн хэрэгжилт болон МУТСТ тогтолцооны үр дүнтэй байдлыг үнэлэх

тодорхой тайлбарлах шаардлагатай. Үүнд үндсэн ХҮТ-д дурдсанчлан тухайн улсын эрсдэл болон нөхцөл байдлын холбоосыг зааж өгнө. Бүлгийн төгсгөлд үнэлгээг **тод хар өнгөөр** бичнэ.

Зөвлөмж 2 – Үндэсний хамтын ажиллагаа болон уялдаа холбоо

Зөвлөмж 33 – Статистик мэдээлэл

3. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ТОГТОЛЦОО БОЛОН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АСУУДЛУУД

Зөвлөмж 3 – Мөнгө угаах гэмт хэрэг

Зөвлөмж 4 – Хөрөнгө хураах болон түр зуурын арга хэмжээ

Үйл ажиллагааны болон хууль сахиулах

Зөвлөмж 29 – Санхүүгийн мэдээллийн алба

Зөвлөмж 30 – Хууль сахиулах болон мөрдөн шалгах байгууллагуудын үүрэг

Зөвлөмж 31 - Хууль сахиулах болон мөрдөн шалгах байгууллагуудын эрх мэдэл

Зөвлөмж 32 – Бэлэн мөнгө зөөвөрлөгчид

4. ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ БОЛОН ҮЙ ОЛНООР ХӨНӨӨХ ЗЭВСЭГ ДЭЛГЭРҮҮЛЭХИЙГ САНХҮҮЖҮҮЛЭХ

Зөвлөмж 5 – Терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэг

Зөвлөмж 6 – Терроризм болон терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэгтэй холбоотой зорилтот санхүүгийн хориг арга хэмжээнүүд

Зөвлөмж 7 – Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхтэй холбоотой санхүүгийн зорилтод хориг арга хэмжээнүүд

Зөвлөмж 8 – Төрийн бус байгууллагууд

5. УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

Зөвлөмж 9 – Санхүүгийн байгууллагуудын нууцлалтай холбоотой хууль тогтоомж

Харилцагчийг таньж мэдэх болон мэдээллийг хадгалах

Зөвлөмж 10 - Харилцагчийг таньж мэдэх

Зөвлөмж 11 - Баримт, материал хадгалалт

Тусгай үйлчлүүлэгч болон үйл ажиллагааны нэмэлт арга хэмжээ

Зөвлөмж 12 - Улс төрд нөлөө бүхий этгээдүүд

Зөвлөмж 13 - Корреспондент банкны үйл ажиллагаа

Зөвлөмж 14 - Мөнгө болон үнэ бүхий зүйл шилжүүлэх үйлчилгээ

Зөвлөмж 15 - Шинэ технологи

ФАТФ-ын зөвлөмжийн техникийн хэрэгжилт болон МУТСТ тогтолцооны үр дүнтэй байдлыг үнэлэх

Зөвлөмж 16 - Цахим мөнгөн шилжүүлэг

Гуравдагч этгээдэд тулгуурлах, дотоод хяналт болон санхүүгийн бүлгүүд

Зөвлөмж 17 - Гуравдагч этгээдэд тулгуурлах

Зөвлөмж 18 - Дотоод хяналт болон гадаад дахь салбар, охин компани

Зөвлөмж 19 - Өндөр эрсдэлтэй улс орнууд

Сэжигтэй гүйлгээг мэдээлэх

Зөвлөмж 20 - Сэжигтэй гүйлгээг мэдээлэх

Зөвлөмж 21 - Мэдээллийг задруулах болон нууцлал

Санхүүгийн бус бизнес болон мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч нар

Зөвлөмж 22 - СББМҮҮ: Харилцагчийг таньж мэдэх

Зөвлөмж 23 – СББМҮҮ: бусад арга хэмжээ

6. ХЯНАЛТ ШАЛГАЛТ

Зөвлөмж 26 – Санхүүгийн байгууллагуудын хяналт, зохицуулалт

Зөвлөмж 27 – Хянан шалгагчдын эрх мэдэл

Зөвлөмж 28 – СББМҮҮ-ийн хяналт, зохицуулалт

Зөвлөмж 34 – Зааварчилгаа, эргэх холбоо

Зөвлөмж 35 – Шийтгэлийн арга хэмжээ

7. ХУУЛИЙН ЭТГЭЭД БОЛОН ЭРХ ЗҮЙН БУСАД ЗОХИЦУУЛАЛТ БҮХИЙ ЭТГЭЭД

Зөвлөмж 24 – Хуулийн этгээдийн эцсийн өмчлөгч болон ил тод байдал

Зөвлөмж 25 - Эрх зүйн бусад зохицуулалт бүхий этгээдийн эцсийн өмчлөгч болон ил тод байдал

8. ОЛОН УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА

Зөвлөмж 36 – Олон улсын баримт бичиг

Зөвлөмж 37 – Эрх зүйн харилцан туслалцаа

Зөвлөмж 38 - Эрх зүйн харилцан туслалцаа: Царцаах, хураан авах

Зөвлөмж 39 – Гэмт хэрэгтнийг шилжүүлэх

Зөвлөмж 40 – Олон улсын хамтын ажиллагааны бусад хэлбэрүүд

ФАТФ-ЫН ГАРЫН АВЛАГА

ФАТФ-аас гаргасан олон төрлийн гарын авлага, сайн туршлагын жишээнүүдийг доорх холбоосоор орж үзнэ үү:

www.fatf-gafi.org/documents/guidance/

САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА, СББМҮҮ НАРТ ШААРДЛАГА ТАВИХ ЭРХ ЗҮЙН ҮНДЭСЛЭЛ

1. Санхүүгийн байгууллага болон СББМҮҮ нарт тавигдах шаардлагыг а) хуульд тусгах (ФАТФ-ын Зөвлөмж 10, 11, 20-ын тусгай шаардлагуудыг үзнэ үү) эсвэл б) тухайн улс нь өөрийн нөхцөл байдалд тохируулан хууль эсвэл бусад хэрэгжилтийг хангах арга хэрэгслээр зохицуулж болно.

2. ФАТФ-ын Зөвлөмж 10, 11, 20-д дурдсан “хууль” гэж тухайн улсын Үндсэн хуулийн хүрээнд парламентийн үйл явц эсвэл түүнтэй адилтгах арга хэлбэрээр боловсруулж, баталсан заавал мөрдөх шаардлагатай, зөрчигсдөд шийтгэл оногдуулдаг эрх зүйн актыг хэлнэ. Хууль зөрчигсдөд оногдуулах шийтгэл нь үр нөлөөтэй, гаргасан зөрчилтэй нь дүйцэхүйц, гэмт хэрэг давтан үйлдэхээс сэргийлсэн байх шаардлагатай (Зөвлөмж 35). Хууль нь холбогдох шаардлагыг тавьж, тухайн улсын бүх газар нутагт заавал мөрдөх шаардлагатай шүүхийн шийдвэр хэмээх ойлголтыг агуулж байдаг.

3. “Хэрэгжилтийг хангах эрх зүйн баримт бичиг” гэж эрх бүхий байгууллагаас боловсруулсан, баталсан мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх заавал биелүүлэхийг шаардсан үг хэллэгтэй, зөрчигсдөд хариуцлага оногдуулах журам, заавар, удирдамж, зааварчилгаа, бусад баримт бичиг эсвэл механизмыг хэлнэ (Зөвлөмж 35-ыг үзнэ үү). Хууль зөрчигсдөд оногдуулах шийтгэл нь үр нөлөөтэй, гаргасан зөрчилтэй нь дүйцэхүйц, гэмт хэрэг давтан үйлдэхээс сэргийлсэн байх шаардлагатай (Зөвлөмж 35).

4. Баримт бичиг, механизмын шаардлагууд нь “хэрэгжилтийг хангах эрх зүйн баримт бичиг” гэж үзэхэд доорх хүчин зүйлсийг харгалзана. Үүнд:

(а) ФАТФ-ын Зөвлөмжтэй холбоотой шаардлагуудыг тодорхойлсон эсвэл тэдгээрийг бататгасан баримт бичиг, хэрэгсэл байх шаардлагатай бөгөөд шаардлагуудыг ойлгомжтой, тодорхой илэрхийлсэн байх хэрэгтэй. Тухайлбал:

(i) Аливаа үйл ажиллагаа нь гүйцэтгэвэл зохих эсвэл шаардлагатай гэдэг үг хэллэгийг ашигласан байвал үүнийг заавал биелүүлэх шаардлагатай гэж ойлгоно.

(ii) Зохицуулагч эсвэл зохицуулагдаж байгаа байгууллагын үйл ажиллагаанд шууд болон шууд бус хэлбэрээр шаардлага тавигдаж, уг шаардлагыг хэрэгжүүлж байвал энэхүү нөхцөлд “ингэх хэрэгтэй” */should/* гэсэн үг хэллэгийг заавал мөрдөх шаардлагатай гэж ойлгоно. “Ямарваа зүйлийг хийвэл зохимжтой, зөвлөж байна, харгалзан үзэх” */are encouraged, are recommended or should consider/* гэсэн хэллэгийг заавал мөрдвөл зохих гэж үзэхгүй байж болно. Бусад нөхцөлд сулавтар үг хэллэг ашиглавал энэ нь заавал мөрдөх шаардлагагүй гэсэн утга санаа илэрхийлнэ (тухайн улс нь өөрөөр шийдвэрлээгүй бол).

(b) Эрх бүхий байгууллага нь баримт бичиг/арга хэрэгслүүдийг боловсруулж баталсан байх шаардлагатай.

(c) Зөрчигсдэд үр нөлөөтэй, гаргасан зөрчилтэй нь дүйцэхүйц, гэмт хэрэг давтан үйлдэхээс сэргийлсэн шийтгэл оногдуулах шаардлагатай (ял шийтгэл нь шаардлагыг тавьж, бататгаж буй нэг бичиг баримт байх шаардлагагүй бөгөөд шаардлагууд болон шийтгэлийн хооронд тодорхой холбоо үүсгэж байгаа өөр бичиг баримтууд байж болно). Эдгээрт доорх зүйлсийг харгалзан үзнэ:

(i) Заавал мөрдөх шаардлагатай үүрэг хариуцлагаа биелүүлээгүй тохиолдолд үр нөлөөтэй, гаргасан зөрчилтэй нь дүйцэхүйц, гэмт хэрэг давтан үйлдэхээс сэргийлсэн олон төрлийн шийтгэлийн арга хэмжээнүүд байх хэрэгтэй.

(ii) Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх шаардлагыг дагаж мөрдөөгүй тохиолдолд оногдуулах шийтгэлийг шууд эсвэл шууд бус хэлбэрээр оноох боломжтой байх хэрэгтэй. Хэрэв мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх зөрчилтэй холбоотой ял шийтгэлийг шууд тодорхойлоогүй бол зохистой тогтолцоо, хяналт, аюулгүй болон тохиромжтой хэлбэрээр үйл ажиллагаа явуулаагүй зэрэг илүү өргөн цар хүрээний, шаардлагатай, холбоотой зөрчлийн шийтгэлийг ашиглаж болно. Ингэхдээ мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой нэг буюу түүнээс дээш шаардлагыг биелүүлээгүй нөхцөлд иж бүрэн хяналтаас илрүүлсэн дутагдлыг батлах шаардлагагүйгээр зохих шийтгэлийг оногдуулах боломжтой байх шаардлагатай.

(iii) Үр нөлөөтэй, гаргасан зөрчилтэй нь дүйцэхүйц, гэмт хэрэг давтан үйлдэхээс сэргийлсэн шийтгэлийн арга хэмжээнүүдийг практикт ашигласан эсэхтэй холбоотой хангалттай нотолгоо байгаа эсэх.

5. Бүх нөхцөлд санхүүгийн байгууллага, СББМҮҮ нар нь шаардлагуудыг биелүүлээгүй тохиолдолд оногдох шийтгэл болон шийтгэлийн хэлбэрийн талаар бүрэн, тодорхой ойлголттой байх хэрэгтэй.

НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР

Данснууд Accounts	Данс гэж санхүүгийн байгууллага болон харилцагч хоорондын бусад бизнесийн харилцааг хамааруулан ойлгоно.
Алдаагүй Accurate	Алдаагүй эсэхийг нь шалгаж баталгаажуулсан мэдээллийг хэлнэ.
Төлөөлөгч/Агент Agent	Зөвлөмж 14, 16-ын хүрээнд мөнгө болон үнэ бүхий зүйл шилжүүлэх үйлчилгээ үзүүлэгчийн нэрийн өмнөөс эсвэл уг үйлчилгээ үзүүлэгчийн зааварчилгаагаар үйлчилгээ үзүүлж буй хувь хүн, хуулийн этгээдийг Төлөөлөгч/Агент гэнэ.
Холбогдох эрх бүхий байгууллагууд Appropriate authorities	Холбогдох итгэмжлэгдсэн байгууллага, сайн дурын зохицуулалттай байгууллагууд зэргийг оролцуулаад эрх бүхий байгууллагыг хэлнэ.
Салбар ТББ-ууд Associate NPOs	Олон улсын ТББ-ын гадаад улс орон дахь салбарууд орно.
Багц шилжүүлэг Batch transfer	Санхүүгийн нэг байгууллага руу шилжүүлж буй олон тооны бие даасан гуйвуулгуудаас бүрдсэн багц гуйвуулгыг хэлнэ. Эюнэхүү шилжүүлэг нь эцсийн дүнд өөр өөр хүн рүү шилжүүлсэн/шилжүүлээгүй байж болно.
Төлбөрийн хэрэгслүүд Bearer negotiable instruments	Төлбөрийн хэрэгслүүдэд (<i>BNIs</i>) дараах хэрэгслүүд орно. Үүнд: аялагчийн чек, эзэмшигчийн хэлбэрээр байгаа, ямар нэгэн хязгаарлалтгүйгээр шилжүүлж болох, ямар нэгэн төлбөр хүлээн авагчид зориулсан, эзэмшил нь хүлээн авсан хүнд шууд шилждэг тохиролцоон дээр үндэслэсэн арга хэрэгслүүд /чек, вексель, мөнгөний ордер/. Мөн гарын үсэг зурсан хэрнээ хүлээн авагчийн нэр байхгүй бүрэн бус мөнгөний хэрэгслүүд орно /чек, вексель, мөнгөний ордер/.
Эзэмшигчийн хувьцаа Bearer shares	<i>Эзэмшигчийн хувьцаанд</i> - хуулийн этгээдийн өмчлөгч нь <i>хувьцаа эзэмшигчийн сертификатыг</i> эзэмшиж байгаа этгээд нь өмчлөгч болдог тохиролцооны арга хэрэгслүүд орно.
Эцсийн өмчлөгч Beneficial owner	Эцсийн өмчлөгч гэдэг нь хуулийн этгээдийг эзэмшдэг ⁷¹ болон/эсвэл түүний нэрийн өмнөөс гүйлгээ хийж буй харилцагч, хувь хүнийг ⁷² хянадаг этгээдийг хэлнэ. Хуулийн этгээд, бусад эрх зүйн бусад зохицуулалт бүхий этгээдэд үр дүнтэй эцсийн хяналтыг тогтоосон хувь хүнийг хэлнэ.
Үр шим хүртэгч Beneficiary	Үр шим хүртэгч гэдэг нь ФАТФ-ын зөвлөмжид авч үзэж буй асуудлаасаа хамааран өөр өөр утга санаа илэрхийлдэг: <ul style="list-style-type: none"> Итгэлцлийн хуулиар итгэлцлээс ашиг хүртэгч хувь хүн, этгээдийг үр шим хүртэгч гэдэг. Үр шим хүртэгч нь хувь хүн,

⁷¹ “Эцсийн өмчлөл эсвэл хяналт” болон “бодитоор хянадаг” гэж эзэмшил/хяналтыг эзэмших эрхийн хэлхээ эсвэл шууд хяналтаас бусад аргаар хяналт тавих хэлбэрээр хэрэгжүүлэхийг хэлнэ.

⁷² Энэхүү тодорхойлолтыг амь насны эсвэл бусад хөрөнгө оруулалттай холбоотой даатгалын бүтээгдэхүүний үр шим хүртэгчийн эцсийн өмчлөгчийг тодорхойлоход ашиглана.

хуулийн этгээд, бусад эрх зүйн бусад зохицуулалт бүхий этгээд байж болно. Бүх итгэлцлүүд нь (хандивын эсвэл хуулиар зөвшөөрөгдсөн хандивын бус итгэлцлүүд) тодорхой үр шим хүртэгч нартай байх шаардлагатай. Итгэлцлүүд нь заавал тодорхойлж болох эцсийн үр шим хүртэгчтэй байх шаардлагатай ч зарим итгэлцлүүд нь тодорхой этгээдэд үр шим хүртэх эрх үүстэл зөвхөн удирдлагыг хэрэгжүүлдэг эсвэл хөрөнгийг заасан хугацаа (хуримтлалын үе гэдэг) болтол өөр хүн хариуцаж болдог. Энэхүү хугацааг итгэлцлийн байнгын хүчинтэй нөхцлөөс хамааран уртасгаж болдог бөгөөд үүнийг ихэвчлэн итгэлцлийн гэрээслэлд дурдсан байдаг.

- Амь насны даатгал эсвэл бусад хэлбэрийн хөрөнгө оруулалттай холбоотой даатгалын бүтээгдэхүүний хувьд үр шим хүртэгч нь даатгалын тохиолдол учирсан үед тухайн даатгалын нөхөн төлбөрийг хүлээн авдаг хувь хүн, хуулийн этгээд, эрх зүйн бусад зохицуулалт бүхий этгээд, хүмүүсийн бүлэг байна.

Мөн ТББ-аас хандивын, хүмүүнлэгийн эсвэл бусад төрлийн тусламж дэмжлэг хүлээж авдаг хувь хүн эсвэл бүлэг этгээдийг хэлнэ.

Гуйвуулгыг шилжүүлэгч этгээд цахим мөнгөн гуйвуулгын хүлээн авагч хэмээн тодорхойлсон хувь хүн, хуулийн этгээд болон эрх зүйн бусад зохицуулалт бүхий этгээдийг мөн үр шим хүртэгч гэнэ.

<p>Хүлээн авагч санхүүгийн байгууллага</p> <p>Beneficiary Financial Institution</p>	<p>Шилжүүлэгч санхүүгийн байгууллагаас шууд буюу зуучлагч санхүүгийн байгууллагаар дамжуулан цахим мөнгөн шилжүүлэг хүлээн авч, хүлээн авагч/харилцагчид мөнгө/хөрөнгийг олгодог санхүүгийн байгууллагыг хэлнэ.</p>
<p>Эрх бүхий байгууллага</p> <p>Competent Authorities</p>	<p>Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиг үүрэгтэй бүх төрлийн байгууллагыг эрх бүхий байгууллага⁷³ гэнэ. Үүнд ялангуяа СМА; мөнгө угаах гэмт хэрэг, холбогдох суурь гэмт хэрэг, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийг мөрдөн шалгах, гэмт хэргийн хөрөнгийг царцаах/битүүмжлэх, хураан авах, мөрдөн шалгах, яллах, чиг үүрэгтэй холбогдох байгууллагууд; мөнгөн тэмдэгт болон төлбөрийн хэрэгслүүдийг /BNIs/ хил дамнаж тээвэрлэх мэдүүлэг/мэдээ хүлээн авдаг байгууллага; санхүүгийн байгууллага болон СББМҮҮ нарын МУТСТ шаардлагыг мөрдүүлэхэд хянан шалгах эсвэл хяналт тавих үүрэгтэй байгууллагууд тус тус багтана.</p>
<p>Хөрөнгө хураан авах</p> <p>Confiscation</p>	<p>Шүүх эсвэл эрх бүхий байгууллагын шийдвэрийн дагуу мөнгө болон бусад хөрөнгийг бүр мөсөн хураан авахыг хөрөнгө хураан авах гэнэ. Хөрөнгө хураан авах үйл явц нь шүүхийн эсвэл захиргааны үйл ажиллагааны дагуу мөнгө эсвэл хөрөнгийн эзэмших эрхийг төрд⁷⁴ шилжүүлдэг. Уг нөхцөлд, хувь хүн эсвэл</p>

⁷³ Үүнд хууль ёсны эрх мэдэлтэй төрийн бус санхүүгийн хянан шалгах эрх бүхий байгууллага орно.

⁷⁴ Үр дүнг үнэлэхэд “Хөрөнгө хураах” гэдэг нь илүү өргөн цар хүрээний хэрэглээтэй байна.

	хуулийн этгээд нь зарчмын хувьд тухайн хөрөнгө, мөнгийг хураалгах үедээ бүх эрхээ алддаг. Хөрөнгө албадан хураах шийдвэр нь ихэвчлэн хураасан хөрөнгийг хууль зөрчих үйл ажиллагаанд ашиглах гэж байсан эсвэл хууль бус үйл ажиллагаанаас гаралтай гэж эрүүгийн хэргийн ял шийтгэл эсвэл шүүхийн шийдвэрээр тогтоосонтой холбоотой үүсдэг.
Үндсэн зарчмууд Core Principles	Үндсэн зарчимд Банкны хяналт шалгалтын Базелийн хорооноос боловсруулсан Банкны хяналт шалгалтыг үр дүнтэй хийх үндсэн зарчим, Үнэт цаасны олон улсын хорооноос гаргасан Үнэт цаасны зохицуулалтын зорилт болон зарчмууд болон Даатгалын хянан шалгагч нарын олон улсын ассоциациас гаргасан Даатгалын хяналт шалгалтын зарчим багтана.
Корреспондент банк Correspondent Bank	Корреспондент банкны үйл ажиллагаа нь нэг банк (корреспондент банк) нь нөгөө респондент банкинд (үйлчилгээ хүлээн авагч банк) банкны үйлчилгээ үзүүлэхийг хэлнэ. Олон улсын томоохон банкууд нь дэлхийн өнцөг буланд орших мянга мянган банкуудын корреспондент банк болон ажилладаг. Респондент банкууд нь бэлэн мөнгөний менежмент (<i>жн</i> : төрөл бүрийн валютын хүү тооцогдох данснууд гэх мэт), олон улсын цахим мөнгөн шилжүүлэг, чекийн төлбөр тооцоо, дансаар төлбөр тооцоо хийх, валютын арилжааны үйлчилгээг оролцуулаад олон төрлийн үйлчилгээ үзүүлдэг.
Улс орон Country	ФАТФ-ын зөвлөмжид дурдсан улс орнууд гэдгээр улсын газар нутаг, юрисдикцийн бүс хоёуланг нь хэлнэ.
Нэгтгэсэн төлбөр тооцоо Cover Payment	Нэгтгэсэн төлбөр тооцоо гэж захиалагч санхүүгийн байгууллага нь төлбөрийн зааварчилгааг (мессеж) мөнгөн гуйвуулгын хамт хүлээн авагч санхүүгийн байгууллага руу шууд илгээхийг хэлэх бөгөөд ингэхдээ төлбөр тооцооны роутингийн зааварчилгааг нэг буюу түүнээс дээш зуучлагч санхүүгийн байгууллагаар дамжуулж болдог.
Гэмт үйлдэл Criminal activity	<i>Гэмт үйлдэл</i> гэдэгт: а) тухайн оронд мөнгө угаахын суурь гэмт хэрэгт тооцогдох бүх гэмт хэргийг хэлнэ, эсвэл б) хамгийн багадаа Зөвлөмж 3-ын шаардлагын дагуу тодорхойлсон суурь гэмт хэргийг хэлнэ.
Хил дамнасан цахим мөнгөн шилжүүлэг Cross-border wire transfer	Гуйвуулгын захиалагч болон хүлээн авагч санхүүгийн байгууллагууд нь өөр өөр улс орнуудад байрлах үед цахим мөнгөн шилжүүлэг хийхийг хэлнэ. Энэхүү нэр томъёог бүх төрлийн цахим мөнгөн шилжүүлэг хийхэд оролцогч санхүүгийн байгууллагын аль нэг нь өөр улсад байрлаж байх үед ч ашигладаг.
Мөнгөн тэмдэгт/валют Currency	Мөнгөн тэмдэгт/валют гэж эдийн засгийн арилжааны хэрэгсэл бөгөөд гүйлгээнд буй цаасан дэвсгэрт, зоосыг хэлнэ.
Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй холбогдох гэмт хэргийн ангиллууд	Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй холбогдох гэмт хэргийн ангилалд: <ul style="list-style-type: none"> • Зохион байгуулалттай гэмт бүлэгт оролцох болон дарамтлах

<p>Designated categories of offences</p>	<ul style="list-style-type: none"> • Терроризм, терроризмыг санхүүжүүлэх • Хүн худалдаалдах, цагаачдыг хууль бусаар хил давуулах • Бэлгийн мөлжлөг (хүүхдийн бэлгийн мөлжлөгийг оролцуулаад) • Хар тамхи болон сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэлийг хууль бусаар худалдах • Хууль бус зэвсгийн наймаа • Хулгайн болон бусад бараа бүтээгдэхүүний хууль бус худалдаа • Авлига, хээл хахууль • Залилан • Мөнгөн тэмдэгт хуурамчаар үйлдэх • Бараа, бүтээгдэхүүн хуурамчаар үйлдэх болон зохиогчийн эрхийг зөрчих • Байгаль орчны эсрэг гэмт хэрэг • Хүний амь нас бүрэлгэх, хүний хүнд гэмтэл учруулах • Хүн хулгайлах, хууль бусаар эрхийг нь боогдуулах, барьцаалах • Хулгай, дээрэм • Хууль бусаар хил нэвтрүүлэх (гааль болон нэмүү өртгийн албан татвартай холбоотой асуудал орно) • Татварын гэмт хэрэг (шууд болон шууд бус татварыг оролцуулаад) • Айлган сүрдүүлэх • Баримт бичгийг хуурамчаар үйлдэх • Далайн дээрэм • Худалдааны дотоод мэдээлэл ашиглах, үнэт цаасны зах зээлд хууль бус үйлдэл хийх
---	---

Тухайн улс орон нь энэ жагсаалтаас суурь гэмт хэрэгт хамруулахдаа гэмт хэргийн төрлөөр нь болон уг гэмт хэргийн бүрэлдэхүүний ямар элемент нь онц ноцтой гэмт хэрэг болгож буйг дотоодын хууль тогтоомжийн дагуу тодорхойлох хэрэгтэй.

<p>Санхүүгийн бус бизнес болон мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч нар (СББМҮҮ)</p> <p>Designated nonfinancial businesses and professions</p>	<p>Санхүүгийн бус бизнес болон мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч нар (СББМҮҮ)-т доорх багтана:</p> <ol style="list-style-type: none"> a) Казино⁷⁵ b) Үл хөдлөх хөрөнгийн зуучлагч нар c) Үнэт металлын арилжаа эрхлэгчид d) Үнэт чулууны арилжаа эрхлэгчид e) Хуульч, нотариатчид, бусад бие даасан хараат бус эрх зүйн мэргэжилтнүүд болон нягтлан бодогчид орох бөгөөд үүнд хувиараа ганцаараа ажилладаг хуульчид, хамтран ажиллагсад, мэргэжлийн компанид ажилладаг мэргэжилтнүүд орно. МУТСТ арга хэмжээнд хамрагддаг байх магадлалтай төрийн байгууллага, бусад төрлийн аж ахуйн нэгж, компаниудад ажилладаг “дотоод” мэргэжилтнүүдийг үүнд хамруулахгүй.
---	--

⁷⁵ ФАТФ-ын стандартад казино гэдэгт интернетээр болон усан онгоцон дээр үйл ажиллагаа явуулж буй бүх казиног хамруулан ойлгоно.

- f) Итгэлцэл болон компанийн үйлчилгээ үзүүлэгчид гэдэг нь гуравдагч этгээдэд доорх үйлчилгээ үзүүлдэг ФАТФ-ын зөвлөмжийн өөр хэсэгт хамрагдаагүй байгаа хувь хүн бизнесүүд багтана. Үүнд:
- Хуулийн этгээдийг үүсгэн байгуулахад мэргэжлийн үйлчилгээ үзүүлдэг
 - Компанийн захирал эсвэл нарийн бичгийн дарга, нөхөрлөлийн хамтрагч, бусад хуулийн этгээдтэй холбоотой ижил албан тушаалын үйлчилгээ үзүүлж байгаа (эсвэл өөр хүнээр дээрх албан тушаал эрхлэх нөхцөл бүрдүүлэх)
 - Компани, нөхөрлөл, бусад хуулийн этгээд эсвэл аливаа газар бүртгэлтэй албан тасалгаа, бизнесийн хаяг, харилцаа холбоо, захиргааны хаяг өгч буй этгээд
 - Экспресс трастын итгэл хүлээгч эсвэл эрх зүйн бусад зохицуулалт бүхий этгээдэд ижил үүрэг гүйцэтгэх (эсвэл өөр хүнээр дээрхи албан тушаал эрхлэх нөхцөл бүрдүүлэх)
 - Өөр хүний эзэмшдэг хувьцаанд төлөөний этгээд болон ажиллах (эсвэл өөр хүнээр дээрхи албан тушаал эрхлэх нөхцөл бүрдүүлэх).

Хоригийн жагсаалтад орсон хувь хүн, хуулийн этгээд

Designated person or entity

Хоригийн жагсаалтад орсон хувь хүн, хуулийн этгээд гэж:

- i. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Аюулгүйн зөвлөлийн 1267 (1999) тогтоолын дагуу байгуулагдсан хороо (цаашид 1267-ийн Хороо гэх) Аль Кайда бүлэгтэй холбоотой хувь хүн эсвэл түүнтэй холбоотой бүлэг, байгууллага, аж ахуйн нэгжүүд.
- ii. Аюулгүйн зөвлөлийн 1988 (2011) тогтоолын (цаашид 1988-ийн Хороо гэх) дагуу байгуулагдсан хорооны тодорхойлсон Афганистаны энх тайван, тогтвортой байдал, аюулгүй байдалд аюул учруулж болзошгүй Талибан бүлэгтэй холбоотой хувь хүн эсвэл түүнтэй холбоотой бүлэг, байгууллага, аж ахуйн нэгжүүд.
- iii. Аюулгүйн зөвлөлийн 1373 (2001) тогтоолын дагуу аливаа юрисдикц эсвэл бүс нутгийн юрисдикцийн тодорхойлсон аливаа хувь хүн, хуулийн этгээд, аж ахуйн нэгжүүд.
- iv. Аюулгүйн зөвлөлийн 1718 (2006) тогтоол болон түүнтэй холбоотой Аюулгүйн зөвлөлийн дараагийн тогтоол, хавсралтуудад дурдсан болон “Аюулгүйн зөвлөлийн 1718 (2006) тогтоол”-д (цаашид 1718-ийн Хоригийн Хороо гэх) хорооны тодорхойлсон санхүүгийн хориг арга хэмжээ авах шаардлагатай хувь хүн, хуулийн этгээд, аж ахуйн нэгжүүд.
- v. Аюулгүйн зөвлөлийн 1737 (2006) тогтоол болон түүнтэй холбоотой Аюулгүйн зөвлөлийн тогтоол, хавсралтуудад дурдсан эсвэл 1737 тогтоол болон холбогдох тогтоолыг хэрэгжүүлэх “Аюулгүйн зөвлөлийн Хорооны 1737 (2006) дугаар тогтоолын 18 дугаар хэсэг”-ийн дагуу байгуулагдсан хорооны (цаашид 1737-ын Хоригийн хороо гэх) тодорхойлсон

	санхүүгийн хориг арга хэмжээ авах шаардлагатай хувь хүн, хуулийн этгээд, аж ахуйн нэгжүүд орно.
Жагсаалтад оруулах Designation	Жагсаалтад оруулах гэх нэр томъёо нь санхүүгийн хориг арга хэмжээнд хамрагдах хувь хүн ⁷⁶ эсвэл аж ахуйн нэгжийг тодорхойлохыг хэлэх бөгөөд доорх санхүүгийн хоригт хамааралтай. Үүнд: <ul style="list-style-type: none"> • Нэгдсэн Үндэстний Байгууллагын Аюулгүйн зөвлөлийн 1267 (1999) тогтоол болон холбогдох бусад тогтоолууд. • Аюулгүйн зөвлөлийн 1373 (2001) тогтоол, үүнд хориг арга хэмжээнд хамруулахаар тодорхойлсон хувь хүн болон хуулийн этгээд оруулах болсон шалтгаанаа олон нийтэд мэдэгдэх орно. • Аюулгүйн зөвлөлийн 1718 (2006) тогтоол болон үүнтэй холбоотой тогтоолууд. • Аюулгүйн зөвлөлийн 1737 (2006) тогтоол болон үүнтэй холбоотой тогтоолууд. • Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй холбоотой санхүүгийн хориг арга хэмжээг оногдуулах Аюулгүйн зөвлөлөөс цаашид гаргах бүх тогтоолууд.
Дотоодын цахим мөнгөн шилжүүлэг Domestic Wire Transfer	Захиалагч болон хүлээн авагч санхүүгийн байгууллагууд нь нэг оронд оршиж байхад хийх цахим мөнгөн гуйвуулгыг хэлнэ. Энэхүү нэр томъёогоор төлбөр тооцооны мэдээлэл шилжүүлэх систем нь өөр өөр оронд байрлахаас үл хамааран зөвхөн нэг улсын газар нутагт хийгдэж буй хэлхээ холбоо бүхий мөнгөн гуйвуулгыг мөн хэлнэ. Европын Эдийн Засгийн Бүсийн ⁷⁷ хил дотор хийгдэж буй хэлхээ холбоо бүхий мөнгөн гуйвуулгыг дотоодын цахим мөнгөн шилжүүлэг гэж үзнэ.
Хэрэгжилтийг хангах хэрэгсэл Enforceable means	Хэрэгжилтийг хангах хэрэгсэлд МУТСТ шаардлагуудыг заавал мөрдөх шаардлагатай, зөрчигсдөд шийтгэл оногдуулахуйц үг хэллэгтэй эрх бүхий байгууллагаас гаргасан, баталсан журам, зааварчилгаа, заавар, бусад баримт бичиг эсвэл арга хэрэгслүүдийг хэлнэ. Зөрчигсдөд оногдуулах шийтгэл нь үр нөлөөтэй, үйлдсэн гэмт хэрэгт нь дүйцэхүйц, гэмт хэрэг давтан үйлдэхээс сэргийлсэн байх шаардлагатай (Зөвлөмж 35-ийг үзнэ үү).
Урьдчилан мэдэгэлгүй Ex Parte	Эрх нь хөндөгдөж буй талд урьдчилан мэдэгдэлгүйгээр, түүний оролцоогүйгээр хэргийн ажиллагааг явуулахыг урьдчилан мэдэгэлгүй гэнэ.
Экспресс траст Express trust	<i>Экспресс траст</i> гэдэг нь үүсгэн байгуулагчийн бий болгосон итгэлцлийг хэлэх бөгөөд ихэвчлэн итгэлцлийн гэрээслэл зэрэг бичгээр үйлдсэн бичиг баримт байдаг. Энэ төрлийн итгэлцэл нь үүсгэн байгуулагч этгээдийн итгэлцэл эсвэл үүнтэй төстэй эрх зүйн зохицуулалт үүсгэх тодорхой санаачлага эсвэл шийдвэрээс улбаалан үүсгээгүй хууль эрх зүйн үйл явцын журмаар байгуулсан итгэлцлээс ялгаатай юм (<i>жн</i> : контрактив итгэлцэл).

⁷⁶ Хувь хүн, хуулийн этгээд.

⁷⁷ Аливаа этгээд нь Зөвлөмж №16-ын хэрэгжилтийг тодорхойлох ажлын хүрээнд ФАТФ-ыг үндэсний юрисдикцээс илүү (*supra-national*) гэж тодорхойлуулж болно.

Худал мэдүүлэг False declaration	Тээвэрлэж буй мөнгөн тэмдэгт, төлбөрийн хэрэгслийн (BNIs) хэмжээг хуурамчаар мэдүүлэх эсвэл эрх бүхий байгууллагаас шаардсан бусад холбогдох тоон мэдээллийг мэдүүлэгт хуурамчаар мэдүүлснийг хэлнэ. Үүнд шаардлагатай нөхцөлд мэдүүлэг гаргаж өгөөгүй байх орно.
Худал мэдээлэх False disclosure	Тээвэрлэж буй мөнгөн тэмдэгт, төлбөрийн хэрэгслийн (BNI) хэмжээ/өртгийг хуурамчаар мэдээлэх эсвэл эрх бүхий байгууллагаас асуухад холбогдох тоон мэдээллийг худал мэдээлэхийг хэлнэ. Үүнд шаардлагатай нөхцөлд мэдээлээгүй байх орно.
Санхүүгийн бүлэг Financial group	<i>Санхүүгийн бүлэг гэж</i> толгой компани эсвэл бусад хэлбэрийн хуулийн этгээд нь бүлгийнхээ Үндсэн зарчмын хүрээнд бүхэлд нь хяналт, үйл ажиллагааны зохион байгуулалтыг хэрэгжүүлж, бүлгийн түвшинд МУТС-тэй тэмцэх бодлого, үйл явцад харьяалагдах салбар, нэгжүүддээ бүхэлд нь хяналт тавьдаг бүлэг юм.
Санхүүгийн байгууллага Financial institutions	Харилцагчид зориулан эсвэл харилцагчийг төлөөлөн дор дурдсан нэг буюу түүнээс дээш бизнесийн үйл ажиллагааг эрхэлдэг хувь хүн, хуулийн этгээдийг санхүүгийн байгууллага гэнэ. Үүнд: <ol style="list-style-type: none"> 1. Олон нийтээс хадгаламж болон бусад буцаан төлөгдөх хөрөнгө хүлээн авдаг⁷⁸ 2. Зээл⁷⁹ 3. Санхүүгийн лизинг⁸⁰ 4. Мөнгө болон үнэ бүхий зүйл шилжүүлэх⁸¹ 5. Төлбөр тооцооны хэрэгслүүд олгох болон түүний менежмент (<i>жн</i>: кредит, дебит картууд, чек, аялагчийн чек, мөнгөний ордер болон bankers' drafts, цахим мөнгө). 6. Санхүүгийн баталгаа, санхүүгийн батлан даалт 7. Арилжааг хийх: <ol style="list-style-type: none"> a. Мөнгөний зах зээлийн хэрэгслүүд (чек, төлбөр тооцоо, хадгаламжийн сертификат, санхүүгийн үүсмэл хэрэгслүүд гэх мэт) b. Валют арилжаа c. Валют, хүү болон индекстэй холбоотой хэрэгслүүд d. Шилжүүлж болох үнэт цаас e. Түүхий эдийн фьючерсийн худалдаа. 8. Үнэт цаас гаргахад оролцох болон үүнтэй холбоотой зүйлст санхүүгийн үйлчилгээ үзүүлэх 9. Хувийн болон нийтийн хөрөнгө удирдах 10. Бусад хүмүүсийн нэрийн өмнөөс бэлэн мөнгө эсвэл хөрвөх үнэт цаасыг хамгаалж хадгалах болон захиран зарцуулах

⁷⁸ Үүнд хувийн банкны үйлчилгээ орно.

⁷⁹ Үүнд хэрэглээний зээл; моргейжийн зээл; солих нөхцөлтэй эсвэл солих нөхцөлгүй факторинг; худалдааны гүйлгээний санхүүжилт /форфейтинг ороод/.

⁸⁰ Хэрэглээний бараа бүтээгдэхүүнтэй холбоотой санхүүгийн лизинг үүнд хамаарахгүй.

⁸¹ Мөнгө шилжүүлэхэд зөвхөн мессеж эсвэл бусад хэлбэрийн дэмжлэг үзүүлдэг хувь хүн, хуулийн этгээд орохгүй. Зөвлөмж №16-ийн тайлбарыг үзнэ үү.

	<p>11. Бусад хүмүүсийн нэрийн өмнөөс хөрөнгө, мөнгө удирдах хөрөнгө оруулалт хийх, менежментийг нь хариуцах</p> <p>12. Амь насны даатгал болон бусад хөрөнгө оруулалттай холбоотой даатгалын андеррайтерийн үйл ажиллагаа гүйцэтгэх, даатгуулах⁸²</p> <p>13. Мөнгө, гадаад валютын солих</p>
<p>Гадаадын хамтрагч байгууллага</p> <p>Foreign counterparts</p>	<p>Гадаад хамтын ажиллагаатай холбоотой ижил төрлийн үүрэг хариуцлага хүлээж, төстэй үйл ажиллагаа хэрэгжүүлдэг гадаадын эрх бүхий байгууллагыг гадаадын хамтрагч байгууллага гэх бөгөөд үүнд өөр үндсэн шинжтэй болон статустай гадаадын эрх бүхий байгууллагууд ч мөн багтана (<i>жн.</i>: тухайн улсаас хамаараад санхүүгийн салбарыг МУТСТ хяналт шалгалтыг иж бүрэн хяналт шалгалт хийх чиг үүрэгтэй хянан шалгагч эсвэл СМА-ны хяналт шалгалт хийдэг нэгж гүйцэтгэж болдог).</p>
<p>Царцаах</p> <p>Freeze</p>	<p>Хөрөнгө хураах болон түр зуурын арга хэмжээ (Зөвлөмж 4, 32, 38)-ний хүрээнд царцаах гэдэг нэр томъёо нь хөрөнгө царцаах механизмын дагуу эрх бүхий байгууллага, шүүхийн шийдвэрээр эсвэл битүүмжлэх, хураах шийдвэрийг эрх бүхий байгууллага гаргах хүртэл хугацааны туршид хүчин төгөлдөр байх хөрөнгө, тоног төхөөрөмж болон бусад хэрэгслийг шилжүүлэх, хувиргах, захиран зарцуулах, хөдөлгөхийг хорихыг царцаах гэнэ.</p> <p>Санхүүгийн хориг арга хэмжээ хэрэгжүүлэхтэй холбоотой Зөвлөмж 6, 7-ийн хүрээнд царцаах гэдэг нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын Аюулгүйн зөвлөл эсвэл холбогдох Аюулгүйн Зөвлөлийн тогтоол дээр үндэслэн хэрэгжүүлсэн эрх бүхий байгууллага, шүүхийн холбогдох хувь хүн эсвэл аж ахуйн нэгжийн эзэмшиж, захиран зарцуулж буй аливаа мөнгө болон хөрөнгийг хүчин төгөлдөр хугацааны туршид шилжүүлэх, хувиргах, захиран зарцуулах, хөдөлгөөнийг хорихыг царцаах гэнэ.</p> <p>Бүх тохиолдолд царцаасан гэмт хэргийн орлого, хэрэгслүүд, болон бусад хөрөнгө нь тэдгээрийг царцаах үед эрх нь хөндөгдөж байсан хувь хүн, хуулийн этгээдийн хөрөнгө хэвээр үлдэх бөгөөд эдгээр хөрөнгийг гуравдагч этгээд болон царцаах арга хэмжээ хийгдэхээс өмнө хувь хүн, эрх зүйн бусад зохицуулалт бүхий этгээдээр удирдуулж байсан бол үргэлжлүүлэн удирдуулах буюу улсын дотоодын хууль журмын дагуу зохицуулж болно. Царцаах үйл ажиллагааны хэсэг болгож улс орнууд нь тухайн хөрөнгө, тоног төхөөрөмж, үйлдэхэд ашиглагдсан хэрэгсэл, мөнгө болон бусад хөрөнгийг алдагдахаас хамгаалах үүднээс хяналтыг авахаар шийдвэрлэж болно.</p>
<p>Дотоодын хууль эрх зүйн тогтолцоо</p> <p>Fundamental principles of domestic law</p>	<p>Улсын эрх зүйн тогтолцоо, үндэсний хууль тогтоомж боловсруулах болон эрх мэдэл хэрэгжүүлэх ерөнхий тогтолцоог бүрдүүлж буй эрх зүйн үндсэн зарчмыг дотоодын хууль тогтоомжийн үндсэн зарчим гэнэ. Эдгээр үндсэн зарчмуудыг ихэвчлэн Үндсэн хууль эсвэл үүнтэй төстэй баримт бичиг, заавал мөрдөх шаардлагатай хуулийн тайлбар, үндэсний хууль, эрх зүйн тодорхойлох бүрэн эрхтэй хамгийн дээд шатны шүүхийн шийдвэрт тусгаж эсвэл</p>

⁸² Даатгалын компани болон даатгалын зуучлагчдад /агент, брокерууд/ хамаарна.

	илэрхийлсэн байна. Улс орноос хамааран өөр өөр байдаг ч үндсэн зарчмуудад хууль журмын дагуу шийдвэрлүүлэх эрх, нотлогдоогүй бол гэм буруугүйд тооцох, хувь хүний шүүхээр хамгаалуулах эрх орно.
Хөрөнгө Funds	Хөрөнгө гэдэгт янз бүрийн арга замаар олсон материаллаг болон материаллаг бус, бодит болон бодит бус, хөдлөх болон үл хөдлөх бүх төрлийн хөрөнгө орох бөгөөд хөрөнгийн эзэмшигч болон хувь хүртэхийг нотолж буй электрон, цахим ямар ч хэлбэрийн хууль, эрх зүйн баримт бичиг, хэрэгсэл орно.
Мөнгө болон бусад хөрөнгө Funds or other assets	Мөнгө болон бусад хөрөнгө гэдэгт янз бүрийн арга замаар олсон санхүүгийн хөрөнгө, эдийн засгийн нөөц бололцоо, бодит болон бодит бус, хөдлөх болон үл хөдлөх бүх төрлийн хөрөнгө орох бөгөөд хөрөнгийн эзэмшигч болон хувь хүртэхийг нотолж буй электрон, цахим ямар ч хэлбэрийн хууль, эрх зүйн баримт бичиг, хэрэгсэл, нотолж буй банкны зээл, аялагчийн чек, банкны чек, мөнгөний ордер, хувьцаа, үнэт цаас, бонд, drafts/драфт, аккредитив зэрэг эсвэл бусад үл хөдлөх хөрөнгөөс хуримтлагдаж буй бүх төрлийн хүү, ноогдол ашиг, бусад орлого орно.
Мэдээллийн эх сурвалж Identification data	Мэдээллийн эх сурвалжид бичиг баримт, тоон мэдээ, мэдээллийн найдвартай, хараат бус эх сурвалжийг хэлнэ.
Дамжуулагч санхүүгийн байгууллага Intermediary financial institution	Дамжуулагч санхүүгийн байгууллага гэж захиалагч, хүлээн авагч эсвэл бусад зуучлагч санхүүгийн байгууллагын нэрийн өмнөөс хэлхээ холбоо бүхий үргэлжилсэн эсвэл нэгтгэсэн төлбөр тооцооны гүйлгээг хүлээн авч, шилжүүлдэг санхүүгийн байгууллага юм.
Олон улсын байгууллага International organisations	Олон улсын байгууллагууд нь гишүүн улс орнуудын улс төрийн албан ёсны гэрээ хэлэлцээрийн дагуу байгуулагдсан бөгөөд тэдний оршин тогтнол нь гишүүн орнуудад хуулиар зөвшөөрөгдсөн, байрлаж буй улсдаа тухайн орны суурин байгууллагын нэгж биш гэсэн байдалтайгаар оршдог байгууллага юм. Олон улсын байгууллагын жишээнд Нэгдсэн Үндэстний Байгууллага болон Олон улсын далай тэнгисийн байгууллага зэрэг холбоотой байгууллага, Европын Зөвлөл, Европын холбооны байгууллага, Европын аюулгүй байдал хамтын ажиллагааны байгууллага, Америк тивийн орнуудын байгууллага зэрэг бүс нутгийн олон улсын байгууллага, НАТО зэрэг цэргийн олон улсын байгууллага, Олон улсын худалдааны байгууллага эсвэл Зүүн Өмнөд Азийн Орнуудын Холбоо зэрэг эдийн засгийн байгууллагууд ордог.
Хууль Law	Зөвлөмж 10, 11, 20-д заасан хууль гэдэг нь тухайн улсын үндсэн хуулийн хүрээнд Парламентын үйл явц эсвэл үүнтэй төстэй арга хэлбэрээр гаргасан эсвэл баталсан заавал мөрдөх шаардлагатай, зөрчигсдөд шийтгэл оногдууладаг эрх зүйн актыг хэлнэ. Зөрчигсдөд оногдуулах шийтгэл нь үр нөлөөтэй, үйлдсэн гэмт хэрэгт нь дүйцэхүйц, гэмт хэрэг давтан үйлдэхээс сэргийлсэн байх шаардлагатай (Зөвлөмж 35-ыг үзнэ үү). Хууль гэсэн ойлголтод холбогдох зүйлсийг тухайн орны нутаг дэвсгэр дээр заавал

	биелүүлэх шаардлага тавьсан хүчин төгөлдөр шүүхийн шийдвэр хамаарна.
Эрх зүйн бусад зохицуулалт бүхий этгээд Legal arrangements	Эрх зүйн бусад зохицуулалт бүхий этгээд гэж экспресс траст эсвэл бусад ижил төрлийн хууль, эрх зүйн зохицуулалтыг хэлнэ. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлийн ижил төстэй зохицуулалтад <i>fiducie, treuhand, fideicomiso</i> орно.
Хуулийн этгээд Legal persons	<i>Хуулийн этгээд</i> гэж санхүүгийн байгууллагатай байнгын үйлчлүүлэгчийн харилцааг үүсгэх, хөрөнгө эзэмших боломжтой хувь хүнээс бусад бүх төрлийн этгээдийг хэлнэ. Үүнд компани, корпораци, сан, <i>anstalt</i> , нөхөрлөл, холбоо болон эдгээртэй төстэй бусад аж ахуйн нэгжүүд орно.
Мөнгө угаах гэмт хэрэг Money laundering offence	<i>Мөнгө угаах гэмт хэрэг</i> гэдэгт зөвхөн үндсэн гэмт хэрэг/хэргүүдээс гадна нэмэлт гэмт хэргүүдийг хамруулж ойлгоно /Зөвлөмж 3-аас бусад тохиолдолд/.
Мөнгө болон үнэ бүхий зүйл шилжүүлэх үйлчилгээ Money or value transfer service	<i>Мөнгө болон үнэ бүхий зүйл шилжүүлэх үйлчилгээнд (МУБЗШҮ)</i> бэлэн мөнгө, чек, бусад төлбөрийн хэрэгслүүд эсвэл бусад үнэ бүхий хэрэгслүүдийг хүлээн авч, төлбөр хүлээн авагчид бэлэн мөнгөөр болон бусад хэрэгслээр харилцаа холбоо, мэдээлэл, шилжүүлэг, МУБЗШҮ-ийн харьяалагддаг төлбөр тооцооны клирингийн сүлжээг ашиглан төлбөр хийдэг санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчид орно. Энэ төрлийн үйлчилгээнд нэг буюу түүнээс дээш зуучлагчид оролцож болох бөгөөд эцсийн төлбөр тооцоог гуравдагч этгээдэд төлөхдөө шинэ төрлийн төлбөрийн арга хэрэгслийг ашиглаж болно. Заримдаа эдгээр үйлчилгээнүүд нь тодорхой газар зүйн бүс нутагт харьяалагдаж <i>hawala, hundi, fei-chen</i> зэрэг өөр өөрөөр нэрлэсэн байдаг.
Эрүүгийн ял шийтгэлгүйгээр хөрөнгө хураах Non-conviction based confiscation	<i>Эрүүгийн ял шийтгэлгүйгээр хөрөнгө хураах</i> гэдэг нь эрүүгийн ял шийтгэл шаардахгүйгээр эрүүгийн гэмт хэрэгт шүүхийн үйл ажиллагаар хөрөнгө хураахыг хэлнэ.
Төрийн бус байгууллага Non-profit organisations	Энэ нь хандив, шашин, соёл, боловсрол, нийгэм, нийгэмлэгийн зорилгоор эсвэл бусад төрлийн “сайн үйлс” үйлдэхэд голлон мөнгө цуглуулж, зарцуулдаг хуулийн этгээд, эрх зүйн бусад зохицуулалт бүхий этгээд, байгууллага юм.
Шилжүүлэгч санхүүгийн байгууллага Ordering financial institution	Мөнгөн гуйвуулгын хүсэлтийг үүсгэгчийн нэрийн өмнөөс хүлээн авсаны дараа цахим мөнгөн шилжүүлэг, шилжүүлгийг хийдэг санхүүгийн байгууллагыг хэлнэ.

Шилжүүлэгч Originator	<p>Тухайн данснаас мөнгө шилжүүлэхийг зөвшөөрч буй данс эзэмшигч эсвэл данс байхгүй үед цахим мөнгөн шилжүүлгийг хийлгэхээр шилжүүлэгч санхүүгийн байгууллагад захиалга үйлдэж буй хувь хүн буюу хуулийн этгээдийг хэлнэ.</p>
Payable-through accounts	<p>Энэ нь гуравдагч этдээд өөрийн нэрийн өмнөөс бизнес төлбөр тооцоог хийхэд шууд ашиглуулдаг корреспондент дансыг хэлнэ.</p>
Хил дамнасан биет тээвэрлэлт Physical crossborder transportation	<p>Нэг улсаас нөгөө улс руу мөнгөн тэмдэгт эсвэл төлбөрийн хэрэгслүүдийг (<i>BNIs</i>) биетээр тээвэрлэхийг хэлнэ. Энэхүү нэр томъёонд эдгээр төрлийн тээвэрлэлтийн хэлбэр багтана: 1. Хувь хүн эсвэл тухайн хүний тээвэрлэж буй ачаа тээш, тээврийн хэрэгсэлд зөөвөрлөх, 2. Контейнерт каргоогоор мөнгөн тэмдэгт төлбөрийн хэрэгслүүдийг (<i>BNIs</i>) тээвэрлэх, 3. хувь хүн эсвэл хуулийн этгээдээр дамжуулан мөнгөн тэмдэгт, төлбөрийн хэрэгслүүдийг (<i>BNIs</i>) шуудангаар тээвэрлэх.</p>
Улс төрд нөлөө бүхий этгээд Politically Exposed Persons (PEPs)	<p><i>Улс төрд нөлөө бүхий гадаадын этгээд</i> нь гадаадын улс оронд нийтийн албанд өндөр албан тушаал хашдаг эсвэл хашиж байсан байсан хүмүүс бөгөөд үүнд Төрийн эсвэл Засгийн газрын тэргүүн, нөлөө бүхий улс төрчид, Засгийн газар, шүүх, цэргийн өндөр алба хаагчид, төрийн өмчит компанийн өндөр албан тушаалтнууд, улс төрийн намуудын нөлөө бүхий албан хаагчид орно.</p>
	<p><i>Улс төрд нөлөө бүхий дотоодын этгээд</i> нь дотооддоо нийтийн албанд өндөр албан тушаал хашдаг эсвэл хашиж байсан хүмүүс бөгөөд үүнд Төрийн эсвэл Засгийн газрын тэргүүн, нөлөө бүхий улс төрчид, Засгийн газар, шүүх, цэргийн өндөр алба хаагчид, төрийн өмчит компанийн өндөр албан тушаалтнууд, улс төрийн намуудын нөлөө бүхий албан хаагчид орно.</p> <p><i>Олон улсын байгууллагад</i> өндөр албан тушаал хашдаг болон хашиж байсан хүмүүст захирлууд, дэд дарга нар, удирдах зөвлөл эсвэл үүнтэй төстэй албан тушаалтай удирдлагын түвшний менежмент хариуцсан гишүүд орно.</p>
Орлого Proceeds	<p>Улс төрд нөлөө бүхий этгээд гэдэг тодорхойлолтод дунд зэрэглэл эсвэл доод шатанд ажилладаг хүмүүс хамаарахгүй.</p>
Хөрөнгө Property	<p>Гэмт хэрэг үйлдэж шууд буюу шууд бус хэлбэрээр бий болсон эсвэл олж авсан бүх төрлийн хөрөнгийг хэлнэ.</p> <p><i>Хөрөнгө</i> гэж материаллаг эсвэл материаллаг бус, хөдлөх болон үл хөдлөх, бодит болон бодит бус бүх төрлийн хөрөнгө болон эдгээр хөрөнгийн эзэмших эрх эсвэл ашиг сонирхлыг илэрхийлж буй эрх зүйн баримт бичиг болон хэрэгслийг хэлнэ.</p>
Шаардлага хангахуйц цахим мөнгөн шилжүүлэг	<p>Зөвлөмж 16-ийн тайлбарын 5 дугаар хэсэгт дурдсан босго дүнгээс дээш дүнтэй хил дамнасан мөнгөн гуйвуулгыг хэлнэ:</p>

Qualifying wire transfers	<p>“Улс орнууд нь хил дамнасан мөнгөн гуйвуулгын доод талын босгыг (1000 Ам.доллар/Еврогоос илүүгүй) тогтоож болох бөгөөд ингэхдээ эдгээр шаардлагыг хангасан байна: 1000 ам.доллар/евро болон түүнээс дээш үнийн дүн бүхий хил дамнасан цахим мөнгөн шилжүүлэг нь дараах зүйлсийг агуулсан байхыг санхүүгийн байгууллагаас шаардана. Үүнд:</p> <p>(a) Улс орнууд нь санхүүгийн байгууллагуудаас энэ төрлийн шилжүүлэгт дараах зүйлсийг агуулсан байхыг шаардана: (i) Гуйвуулагчийн нэр, (ii). Хүлээн авагчийн нэр, (iii). Гуйвуулагч, хүлээн авагчийн дансны дугаар эсвэл гүйлгээний тодруулгын онцгой дугаар. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлсэн гэх сэжиг байхгүй тохиолдолд эдгээр мэдээллийг үнэн алдаагүй эсэхийг шалгах шаардлагагүй ч хэрэв сэжиг бүхий байвал санхүүгийн байгууллага нь харилцагчийн мэдээллийг шалгах шаардлагатай.</p> <p>(b) Улс орнууд нь орж ирж байгаа босго дүнгээс бага дүнтэй хил дамнасан цахим мөнгөн шилжүүлэгт мөн шилжүүлэгчийн мэдээллийг агуулахыг шаардаж болно.</p>
Зохистой арга хэмжээнүүд Reasonable Measures	Зохистой арга хэмжээ гэж мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлтэй дүйцэхүйц зохистой арга хэмжээнүүдийг хэлнэ.
Мөнгө угаах, терроризмын санхүүжүүлэхтэй холбоотой Related to terrorist financing or money laundering	Мөнгөн тэмдэгт, төлбөрийн хэрэгслүүд /BNIs/-тэй холбоотой хэрэглэгдэхдээ: (i) терроризм, террорист үйл ажиллагаа, террорист байгууллагыг санхүүжүүлэх, ашиглагдах, ашиглахаар завдсан, ашиглахаар төсөвлөсөн орлогыг, эсвэл (ii) мөнгө угаах болон суурь гэмт хэргээс угаасан ашиг орлого эсвэл эдгээр гэмт хэргийг үйлдэхэд ашигласан эсвэл ашиглах зорилготой арга хэрэгслүүд орно.
Шаардлагатай Required	Шаардлагатай мэдээллийн бүх элементүүд нь бүрэн бүтэн байх нөхцөл байдлыг илэрхийлнэ. Дэд зүйл 6(a), 6(b), 6(c)-д шилжүүлэгч /originator/ шаардлагатай мэдээллийг дурдсан. Дэд зүйл 6(d), 6(e) хүлээн авагчийн шаардлагатай мэдээллийг дурдсан байгаа.
Эрсдэл Risk	Эрсдэлийг дурдсан бүх нөхцөлд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг хамруулан дурдаж байгаа. Энэ үг хэллэгийг ойлгохдоо Зөвлөмж 1-ийн тайлбарыг давхар унших хэрэгтэй.
Хангалттай Satisfied	Тодорхой асуудлаар санхүүгийн байгууллага нь хангалттай арга хэмжээ авсан байх шаардлагын үед тухайн байгууллага нь өөрийн авсан арга хэмжээг эрх бүхий байгууллагад нотлох чадвартай байх ёстой.

Битүүмжлэх Seize	Битүүмжлэх гэдэг нэр томъёо нь эрх бүхий байгууллага эсвэл шүүхийн хөрөнгө царцаах механизмын үйл ажиллагааны үндсэн дээр хөрөнгийг шилжүүлэх, хувиргах, зарцуулах, хөдөлгөхийг хориглохыг хэлнэ. Царцаах үйл ажиллагаанаас ялгарах зүйл нь битүүмжлэх механизмаар эрх бүхий байгууллага эсвэл шүүх нь тухайн хөрөнгийн хяналтыг шилжүүлэн авдаг. Битүүмжилсэн хөрөнгө нь битүүмжлэх үед тухайн хөрөнгөд ашиг сонирхол нь хөндөгдөж буй иргэн эсвэл хуулийн этгээдийн хөрөнгө хэвээрээ үлддэг ч ихэвчлэн эрх бүхий байгууллага эсвэл шүүх нь битүүмжилсэн хөрөнгийн эзэмших, захирах эсвэл удирдлагыг хариуцдаг.
Сайн дурын зохицуулалттай байгууллага (СДЗБ) Self-regulatory body (SRB)	СДЗБ гэж тухайн мэргэжлийн гишүүдээс бүрдэж, уг мэргэжлийн (<i>жн.</i> : <i>хуульчид, нотариатчид, бусад хараат бус эрх зүйн эсвэл нягтлан бодогчийн мэргэжлүүд</i>) бүлгийг төлөөлж, мэргэжлээрээ ажиллаж буй хүмүүсийг гишүүнээр элсэх шалгуурыг тогтоож, тодорхой хяналт болон мониторингтой төстэй үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагыг хэлнэ. Энэ төрлийн байгууллагууд нь өндөр хэмжээний ёс зүй, ёс суртахууны жишгийг тухайн мэргэжлээр ажиллаж буй этгээдүүд сахин биелүүлэхтэй холбоотой журмыг хэрэгжүүлнэ.
Сериал төлбөр тооцоо Serial Payment	Шилжүүлэгч санхүүгийн байгууллагын хүлээн авагч байгууллага руу шууд эсвэл нэг буюу түүнээс дээш зуучлагч санхүүгийн байгууллагаар (<i>жн.</i> : корреспондент банк) дамжуулан цахим мөнгөн шилжүүлэг болон төлбөрийн мэдээлэл нь дэс дараалал бүхий гинжин төлбөр тооцоогоор явагдахыг сериал төлбөр тооцоо гэнэ.
Сетлор Settlor	<i>Settlers</i> гэдэг нь итгэмжлэлийн гэрээслэл эсвэл үүнтэй төстэй бусад зохицуулалтаар өөрийн хөрөнгийн эзэмшлийг итгэл хүлээгчид шилжүүлж буй хувь хүн эсвэл хуулийн этгээд юм.
Халхавч банк Shell bank	Халхавч банк гэж үйл ажиллагаа явуулж буй болон тусгай зөвшөөрлөө авсан тухайн оронд бодитоор оршдоггүй, үр дүнтэй нэгдсэн хяналт шалгалтыг хэрэгжүүлдэг санхүүгийн зохицуулалттай бүлэгт хамаардаггүй банкыг хэлнэ. Бодитоор орших гэдэг нь тухайн оронд байрлаж, зохистой удирдлага болон менежменттэй байхыг хэлнэ. Тухайн орон нутагт төлөөлөгч эсвэл доод түвшний ажилтан байх нь биетээр оршин тогтнож буйг илэрхийлж чадахгүй.
Хэрэгтэй Should	ФАТФ-ын зөвлөмжтэй нийцэж байгаа эсэхийг тодорхойлох зорилгоор хэрэгтэй <i>/should/</i> гэсэн үгийг ашиглахад энэ үгийг шаардлагатай <i>/must/</i> гэдэгтэй ижил утгатайгаар ойлгоно.
Төлбөр тооцоог шууд хийх Straight-through processing	Цахим хэлбэрээр гар ажиллагаа шаардагдахгүйгээр төлбөр тооцооны гүйлгээг шууд хийхийг хэлнэ.
Хянан шалгагчид Supervisors	Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх шаардлагатай санхүүгийн байгууллага СББМҮҮ нарыг үүргээ хэрхэн биелүүлж хянах үүрэгтэй эрх бүхий байгууллага (<i>"санхүүгийн хянан шалгагч"</i>)

	<p><i>нар</i>⁸³), эсвэл олон нийтийн бус байгууллагыг хянан шалгагчид гэнэ. Олон нийтийн бус байгууллага нь (зарим төрлийн СДЗБ хамаарна⁸⁴) санхүүгийн байгууллага, СББМҮҮ нарыг МУТСТ үүргээ хэрхэн биелүүлж байгаад хянан шалгалт хийх, биелүүлээгүй бол шийтгэлийн арга хэмжээ авах бүрэн эрхтэй байх хэрэгтэй. Эдгээр олон нийтийн бус байгууллагын хэрэгжүүлж буй үйл ажиллагааг нь хуулиар баталгаажуулж, үйл ажиллагаанд нь эрх бүхий байгууллага хяналт тавих хэрэгтэй.</p>
<p>Санхүүгийн хориг арга хэмжээ</p> <p>Targeted financial sanctions</p>	<p>Хоригийн жагсаалтад орсон хувь хүн болон этгээд нь шууд болон шууд бусаар мөнгө болон бусад эд хөрөнгийг хүртэхээс сэргийлэх зорилгоор хөрөнгө царцаах, хориглохыг санхүүгийн хориг арга хэмжээ гэнэ.</p>
<p>Террорист этгээд</p> <p>Terrorist</p>	<p>Террорист этгээд гэдэгт дараах хувь хүмүүс орно: (i) террорист үйл ажиллагааг шууд эсвэл шууд бусаар, ямар нэгэн аргаар, санаатай болон санамсаргүйгээр үйлдэх, үйлдэхийг завдах, (ii) террорист үйл ажиллагаанд хамсаатнаар оролцох, (iii) террорист үйл ажиллагааг зохион байгуулж эсвэл бусдыг зохион байгуулахад удирдан чиглүүлэх, (iv) нэгдмэл зорилготой хэсэг бүлэг хүмүүсийг террорист үйл ажиллагаа үйлдэхэд хувь нэмэр оруулсан, энэ оролцоо нь санаатай бөгөөд террорист үйл ажиллагааг дэмжихэд чиглэсэн эсвэл тухайн бүлэг хүмүүсийг террорист үйл ажиллагаа явуулах гэж байгааг мэдэж байсан хувь хүнийг хэлнэ.</p>
<p>Террорист үйл ажиллагаа</p> <p>Terrorist act</p>	<p>Террорист үйл ажиллагаа гэж:</p> <p>А. Дараах олон улсын гэрээ хэлэлцээрт гэмт хэрэг гэж тодорхойлсон үйлдлүүд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Агаарын хөлгийг хууль бусаар булаан авах үйлдлийг хориглох тухай конвенц /1970/, 2. Иргэний нисэхийн аюулгүй байдлын эсрэг хууль бус үйлдлийг хориглох тухай конвенц /1971/, 3. Олон улсын хамгаалалтанд байдаг хүмүүс, түүний дотор дипломат төлөөлөгчдийн эсрэг гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, шийтгэх тухай конвенц /1973/, 4. Хүн барьцаанд авахын эсрэг конвенц /1979/, 5. Үй олноор хөнөөх зэвсгийн материалыг хамгаалах тухай конвенц /1980/, 6. Иргэний нисэхийн аюулгүй байдлын эсрэг хууль бус үйлдлийг хориглох тухай конвенцийн нэмэлт Олон улсын иргэний нисэхэд үйлчилдэг нисэх буудал дахь хүч хэрэглэсэн хууль бус үйлдлийг хориглох тухай нэмэлт протокол /1988/, 7. Далайн навигацийн аюулгүй байдлын эсрэг хууль бус үйлдлийг хориглох тухай конвенц /2005/,

⁸³ ФАТФ-ын зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьдаг Үндсэн зарчмуудтай холбоотой хяналт шалгалт хийдэг хянан шалгагчид хамаарна.

⁸⁴ Үр дүнтэй байдлыг үнэлэх хүрээнд “хянан шалгагч” гэдэгт СДЗБ мөн хамаарна.

	<p>8. Эх газрын хормойд суурилуулах төхөөрөмжийн аюулгүй байдлын эсрэг хууль бус үйлдлийг хориглох тухай протокол /2005/,</p> <p>9. Үй олноор хөнөөх террорист үйлдлийг хориглох тухай ОУ-ын конвенц /1997/,</p> <p>10. Терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай олон улсын конвенц /1999/.</p>
	<p>Б. Зэвсэгт мөргөлдөөнд идэвхтэй оролцоогүй иргэд болон бусад хүмүүсийн амийг хөнөөх, биед нь хүнд гэмтэл учруулах үйлдэл нь зорилго болон агуулгаараа ард иргэдийг айлгах, төр засаг болон олон улсын байгууллагыг ямар нэгэн үйлдэл хийхэд хүргэх болон хийхээс татгалзуулахад чиглэсэн бусад үйлдэл.</p>
<p>Терроризмыг санхүүжүүлэх Terrorist financing</p>	<p>Террорист үйл ажиллагаа, террорист этгээд, террорист байгууллагыг санхүүжүүлэхийг <i>терроризмыг санхүүжүүлэх</i> гэнэ.</p>
<p>Терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэг Terrorist financing offence</p>	<p>Терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэгт зөвхөн анхдагч гэмт хэрэг/хэргүүдийг хамруулаад зогсохгүй дам/ancillary гэмт хэргийг хамруулан ойлгоно (Зөвлөмж 4-өөс бусад нөхцөлд).</p>
<p>Террорист байгууллага Terrorist organisation</p>	<p><i>Террорист байгууллага</i> гэж дараах үйлдлийг хийсэн бүх террорист бүлгийг хамруулж ойлгоно: 1. Террорист үйл ажиллагааг шууд эсвэл шууд бусаар, ямар нэгэн аргаар, санаатай болон санамсаргүйгээр үйлдэх, үйлдэхийг завдах, 2. Террорист үйл ажиллагаанд хамсаатнаар оролцох, 3. Террорист үйл ажиллагааг зохион байгуулах эсвэл бусдыг зохион байгуулахад удирдан чиглүүлэх, 4. Нэгдмэл зорилготой хэсэг бүлэг хүмүүсийг террорист үйл ажиллагаа үйлдэхэд хувь нэмэр оруулсан, энэ оролцоо нь санаатай бөгөөд террорист үйл ажиллагааг дэмжихэд чиглэсэн эсвэл тухайн бүлэг хүмүүсийг террорист үйл ажиллагаа явуулах гэж байгааг мэдэж байсан.</p>
<p>Гуравдагч этгээд Third parties</p>	<p>Зөвлөмж 6, 7-ийн хүрээнд гуравдагч этгээдэд санхүүгийн байгууллага болон СББМҮҮ нар орох бөгөөд гуравдагч этгээд нь үүгээр хязгаарлагдахгүй.</p> <p>Гуравдагч этгээд гэдэгт хяналт шалгалтад хамрагддаг, хяналтад байдаг болон Зөвлөмж 17-ийн шаардлагыг хангаж буй санхүүгийн байгууллага болон СББМҮҮ нар орно.</p>
<p>Итгэл хүлээгч Trustee</p>	<p>Итгэлцэл болон итгэл хүлээгчийг <i>Итгэлцлийг хүлээн зөвшөөрөх, тэдэнд үйлчлэх хууль, эрх зүйн тухай Гаагийн конвенцийн 2 дугаар зүйлд</i> зааснаар ойлгоно⁸⁵.</p>

⁸⁵ Гаагийн конвенцийн 2 дугаар зүйлд:

Уг конвенцийн хүрээнд “итгэлцэл” гэдэг ойлголт нь хувь хүн буюу итгэл хүлээгч нь үр шим хүртэгч эсвэл тодорхой зорилгын хүрээнд хөрөнгийг итгэл хүлээгчийн хяналтад оруулсан эрх зүйн харилцааг хэлнэ /хөрөнгө шилжүүлэх эсвэл нас барахад хөрөнгийг өвлөн авах/. Итгэлцэл нь доорх шинж чанартай байна:

	Итгэл хүлээгч нь төлбөр авч бизнесийн үйл ажиллагааг явуулж байгаа бол мэргэжлийн (тухайн улсын хууль тогтоомжоос хамааран хуульч эсвэл итгэлцлийн компани г.м.) эсвэл мэргэжлийн бус (гэр бүлийнхээ нэрийн өмнөөс шан харамжгүйгээр ажиллаж буй хүн г.м.) гэнэ.
Гүйлгээний тодруулгын онцгой дугаар Unique transaction reference number	Энэ нь тухайн цахим мөнгөн шилжүүлэгт ашиглагддаг төлбөр тооцооны систем эсвэл мэдээллийн системийн протоколын дагуу төлбөр тооцооны үйлчилгээ үзүүлэгчийн тодорхойлсон үсэг, цифр эсвэл ялгах тэмдэгийн нийлбэр юм.
Хоцрогдолгүйгээр, сааталгүйгээр Without delay	НҮБ-ын Аюулгүйн Зөвлөл эсвэл түүний холбогдох Хоригийн хорооноос (Хороо 1267, Хороо 1988, Хоригийн 1718 хороо эсвэл Хоригийн 1737 хороо) мэдэгдэл гаргаснаас хойш хэдхэн цагийн дотор холбогдох ажиллагааг хэрэгжүүлэхийг хоцрогдолгүйгээр, сааталгүйгээр гэж ойлгоно. S/RES/1373(2001)-ийн хүрээнд хоцрогдолгүйгээр, сааталгүйгээр гэдэг ойлголтыг тухайн хувь хүн эсвэл аж ахуйн нэгж нь терроризм эсвэл террорист байгууллагыг санхүүжүүлдэг гэдэгт сэжиглэх, итгэх үндэслэл байгаа гэсэн утга санааг илэрхийлдэг. Энэхүү хоёр тохиолдолд хоцрогдолгүйгээр, сааталгүйгээр гэдгийг терроризмыг санхүүжүүлдэг террорист, террорист байгууллагуудтай холбоотой мөнгө, бусад хөрөнгийг олж авах эсвэл ашиглах болон үй олноор хөнөөх зэвсгийн санхүүжүүлэхээс сэргийлэх шаардлага хэрэгцээний үндсэн дээр тэдний мөнгөн урсгалыг таслах, дунд нь саатуулах хэрэгцээ шаардлагын хүрээнд дэлхийн хэмжээнд нэгдмэл үйл ажиллагааг цаг алдалгүй хэрэгжүүлэх гэж ойлгоно.

- 1) Тухайн хөрөнгө нь итгэл хүлээгчийн хувийн өмчийн нэг хэсэг бус тусдаа хөрөнгө байдаг.
- 2) Итгэлцлийн хөрөнгө нь итгэл хүлээгчийн нэр дээр буюу итгэл хүлээгчийг төлөөлөх эрх бүхий өөр хүний нэр дээр байж болно.
- 3) Итгэл хүлээгч нь итгэлцлийн гэрээ болон хууль, эрх зүйн үндсэн дээр түүнд ноогдсон тусгай үүрэг хариуцлагын дагуу хөрөнгөд хариуцлага хүлээж, удирдах, захиран зарцуулах эрх, үүрэгтэй байна.

Итгэл хүлээгч нь тодорхой эрх мэдлээ авч үлдэх, итгэл хүлээгч нь үр шим хүртэгчийн эрх эдлэх боломжтой байх нь итгэлцлийн үйл ажиллагаанд харшлахгүй байж болно.